



Хууль зүй, дотоод
хэргийн яам



“Шүүх, эрх зүйн
шинэчлэлт” төсөл

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЭРХ ЗҮЙ

Гарын авлага

Боловсруулсан:

А. Дугармаа

Ж. Наранцацрал

Зөвлөх:

А. Дугармаа

*Энэхүү гарын авлагыг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас
хэрэгжүүлж буй Дэлхийн банкны “Шүүх, эрх зүйн шинэчлэлт”
төслийн хүрээнд боловсруулав.*

Улаанбаатар 2007

DDC
340.56
Д-627

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД
ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЭРХ ЗҮЙ

Гарын авлага

Хөтөлбөр боловсруулсан:

А.Дугармаа
Д.Цолмон
Ж.Наранцацрал

Хөтөлбөрийн зөвлөх:

Ц.Амарсайхан

Гарын авлага боловсруулсан:

Зөвлөх: **А.Дугармаа** (*Хууль зүйн магистр, докторант*)

Багийн гишүүд: **А.Дугармаа** (*Хууль зүйн магистр, докторант*)
Ж.Наранцацрал (*Хууль зүйн магистр, докторант*)

Хэвлэлийн хуудас: 19.2

Цаасны хэмжээ: B5

Хэвлэсэн он: 1200

Хэвлэсэн газар: "BCI" Хэвлэлийн компани

ISBN 978-99929-56-27-5



“ШҮҮХ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛТ” ТӨСЛИЙН ТУХАЙ

Хууль зүйн сургуулийн багш, оюутнуудад



*“Шүүх, эрх зүйн шинэчлэлт”
төслийн зохицуулагч
Д.ОЮУНЧИМЭГ*

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төсөл 2002 оноос хэрэгжээд дуусах шатандаа орж байна.

Энэ төслийн хүрээнд эрх зүйн дээд боловсролыг чанаржуулах чиглэлээр эхний шатны зарим ажлыг хийж дуусгалаа. Эдгээр ажлын үр дүн нь таны гар дээр очиж буй энэ гарын авлага юм. Бид энэ ажлыг зохион байгуулахдаа гадаадын зөвлөх гэхээсээ монголчууд бидний оюун ухаанд тулгуурлаж, дотоодын эрдэмтэн, багш нараар хийлгэсэн юм. Энэ номыг бүтээхэд хууль зүйн сургуулиудаас нэр хүндтэй, туршлагатай ахмад багш, нөгөө талаар идэвхтэй, санаачлагатай, хийж бүтээе, өөрийгөө боловсруулъя гэсэн эрмэлзэлтэй залуу багш нарыг баг болгон оролцуулсан юм. Энэ гарын авлагыг бүтээх явцад багш нар хамтран ажиллаж, бие биенээсээ харилцан суралцаж, цаашид судалгаа шинжилгээний ажил, эрх зүйн сургалтын шинэчлэлтийг хамтран хийхэд үр дүнд хүрнэ гэдгийг харуулсан болно.

Оюутанд зориулсан цогц гарын авлага (хичээлийн хөтөлбөр, тойм лекц) нь Монголд анх удаагаа гарч байгаа билээ. Оюутны гарын авлага нь тэдний судалж буй хичээлд хандах хандлагыг өөрчилж, “бэлэнчлэх” сэтгэлгээнээс ангижруулахад хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна.

Төсөл бол тодорхой хугацаанд хэрэгжээд дуусдаг жамтай. Харин төсөл хэрэгжүүлэх явцад танилцсан, хамтарч ажилласан багш нар цаашдаа өөрсдийгөө боловсруулах, сургалтынхаа арга барил, чанарыг сайжруулах чиглэлээр хийж эхэлсэн ажлаа үргэлжлүүлнэ гэдэгт найдаж байна.

Хичээлийн хөтөлбөр, оюутны гарын авлага бүтээхэд оролцсон 100 орчим эрдэмтэн, багш нар болон энэ ажлыг гардан зохион байгуулж, уялдаа холбоог нь хангах талаар идэвх зүтгэлтэй ажилласан төслийн ажилтан Б.Сарантуяад талархал илэрхийлье.

Үр дүнд чиглэсэн сургалтын хөтөлбөр



*“Шүүх, эрх зүйн шинэчлэлт”
төслийн зөвлөх
У. ТУЯА*

Оюутан залуус та бүхэнд их мэдлэгийг хуримтлуулах нь чухал уу, харин уг мэдлэгээ ашиглах чадвар, мэргэжлийн үнэт зүйлсийг эзэмших нь чухал уу. Аль замыг чухал гэж сонгосноос таны суралцах арга барил, цаашлаад сургалтад хандах хандлага тань тодорхойлогддог байна. Сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулахад ч энэ хоёр талаас авч үзэх хэрэгтэй болдог.

Бид 2003 оноос Дэлхийн банкны “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төслийн “Хууль зүйн бакалаврын боловсролыг сайжруулах” дэд төслийн хүрээнд энэхүү сургалтын хөтөлбөр, гарын авлагыг боловсруулахдаа дараах шаардлагыг харгалзсан бөгөөд оюутан таныг ч энэ тухай мэдэж сургалтын хөтөлбөр, гарын авлагаа ашиглахыг зөвлөж байна. Үүнд:

- ❖ Оюутан ямар зорилгоор уг хичээлийг судалж, ямар үр дүнд хүрэхээ мэдэж байх ёстой.
- ❖ Мэргэжлийн мэдлэг нь мэргэжлийн ур чадвар болон хөгжиж, үнэт зүйл болон төлөвшсөн байх нь чухал. Иймээс мэдээлэл болгоныг боловсруулах бие даалтын ажил оюутанд хэрэгтэй.

Гарын авлага боловсруулсан багийн гашууд



Авирмэдийн Дугармаа

МУИСХЗС-ийн Иргэний эрх зүйн тэнхимийн ахлах багш, Магистр, МУИС-ийн докторант

"Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй"

Ерөнхий анги. УБ, 1999 он. Хамтын бүтээл

"Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй" Тусгай анги. УБ, 2001 он.
Хамтын бүтээл

"Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй" Ерөнхий анги. УБ, 2004 он.
Хамтын бүтээл

"Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй" Тусгай анги. УБ, 2006 он.
Хамтын бүтээл

А.Дугармаа Тэр бүлийн эрх зүй". УБ, 2005 он.

А.Дугармаа "Гэр бүлийн эрх зүйн бодлого, төстийн хураамж". 2007 он.

"Иргэдийн эрх зүйн хөтөч" УБ, 2007 он Хамтын бүтээл /Нээлтэй нийгэм
хүрээлэнгийн санхүүжилтээр хэвлэгдсэн/

"Эрх зүйн хөтөч" /Арга зүй/ УБ, 2007 он Хамтын бүтээл /Нээлтэй нийгэм
хүрээлэнгийн санхүүжилтээр хэвлэгдсэн/

*"Монголын төр эрх зүй", "Хууль дээдлэх ёс", "Эрх зүй" сэтгүүлд иргэний
хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, гэр бүлийн эрх зүйн чиглэлээр эрдэм
шинжилгээний өгүүлэл, материал нийтлүүлсэн ба онол, практикийн эрдэм
шинжилгээний хуралд энэ чиглэлээр хэд хэдэн илтгэл тавьж хэлэлцүүлсэн.*



Жадамбын Наранцацрал

*Отгонтэнгэр Их Сургуулийн Бизнесийн эрх зүйн
тэнхимийн багш, /LLM/*

*МӨХ-ны гишүүн, өмгөөлөгч, нотариатч
Захиргааны шүүхийн сургагч багш*

Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөрийн сургагч багш

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй болон Эрүүгийн байцаан
шийтгэх эрх зүйн чиглэлээр мэргэшсэн

"Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй" /тайлбар схем/. Гарын авлага
УБ, 2003 он.

Иргэн, бизнесийн гарын авлага /хамтын бүтээл/. УБ, 2006 он.

Төр, захиргааны эрх зүй гарын авлага /хамтын бүтээл/. УБ, 2006 он.

Бизнесийн эрх зүй /хамтын бүтээл/. УБ, 2004 он.

Хуульчдын сонгон шалгаруулах сорилгын хураамж /хамтын бүтээл/. УБ, 2005 он.

Захиргааны хэргийн шүүх ажиллагаа /хамтын бүтээл/. УБ, 2007 он.



ӨМНӨХ ҮГ

“ИХШХШЭЗ-н хичээлийн гарын авлага” гэсэн энэхүү гарын авлагыг хууль зүйн их, дээд сургуулийн оюутнуудад зориулсан юм.

Оюутнууд иргэний хэргийг шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг хичээнгүйлэн судлах нь энэ хичээлийн талаар үндсэн мэдлэг олох, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомжийг хэрэглэх болон шүүхээс гарах баримт бичиг, шийдвэрт дүгнэлт хийх чадвартай болох, шүүхэд мэдүүлэх эрхийг мэтгэлцэх зарчмын үндсэн дээр хэрэгжүүлэх, хүний эрх, тэгш байдлыг хангах үзэл хандлага төлөвшихөд ач холбогдолтой юм.

Иймээс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн хичээлийн хөтөлбөрийн агуулга, ИХШХШЭЗ-н тогтолцооны дагуу энэхүү хичээлийн гарын авлагыг бичиж та бүхэнд толилуулж байгаадаа баяртай байна.

Энэхүү гарын авлага нь ИХШХШЭЗ-н хичээлийн хөтөлбөрт багтсан бүлэг, сэдвийг бүхэлд нь хамарсан ба сэдэв бүр зорилго, агуулга, бататгах хэсэг, эх сурвалжаас бүрдэнэ. Сэдвийн бататгал нь хяналтын асуулт, нэр томъёоны тайлбар, тойм, сорил, даалгаврын хэсэгтэй.

Оюутнууд та бүхэн сэдэв бүрийн зорилго, агуулгатай сайтар танилцаж, тухайн сэдвийн хүрээнд ямар мэдлэг, чадвар эзэмшиж, хандлага төлөвших шаардлагатайг мэдсэний дараа нэр томъёоны тайлбар, сэдвийн тоймыг судлах шаардлагатай юм.

Үүний дараа бататгах хэсгийн хүрээнд өгөгдсөн хяналтын асуулт, сорил, бодлогыг бие даан хийхийн зэрэгцээ сэдэв тус бүрт өгөгдсөн эх сурвалжийн хүрээнд даалгаврыг гүйцэтгэвэл зохино.

Энэхүү гарын авлагаас оюутан та бүхэн ИХШХШЭЗүйн онолын суурь мэдлэгийг эзэмшиж, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд онолын үүднээс дүгнэлт өгөх, аливаа маргаантай жшпээ баримтын бодит учир холбогдлыг тогтоох, холбогдох хуулийг хэрхэн хэрэглэх, шийдвэрлэх арга замыг тодорхойлох, баримт бичгийг боловсруулах зэрэгт амжилттай суралцаж, иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар илүү мэдлэг, чадвартай болно гэдэгт итгэлтэй байна.

А.Дугармаа

ГАРЧИГ

НЭГ. ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЭРХ ЗҮЙН ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

ИХШХШЭЗүйн хичээлийн тодорхойлолт	8
ИХШХШЭЗүйн хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө, цаг хуваарилал	10
ИХШХШЭЗүйн хичээлийн арга зүй	12
ИХШХШЭЗүйн хичээлийн үнэлгээ	23

ХОЁР. ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЭРХ ЗҮЙН ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

Нэгдүгээр бүлэг. ИХШХШЭЗҮЙН ҮНДСЭН АСУУДАЛ.....27

ИХШХШЭЗ-н зохицуулах зүйл, зохицуулалтын арга, эрх зүйн системд эзлэх байр суурь	27
ИХШХШ ажиллагааны ойлголт, төрөл, үе шат	31
ИХШХШЭ зүйн эх сурвалжийг танин мэдэхийн ач холбогдол.....	36
ИХШХША-ны хугацаа.....	41

Хоёрдугаар бүлэг. ИХШХШЭ ЗҮЙН ЗАРЧИМ.....46

ИХШХШЭ зүйн зарчмын ойлголт, ангилал, онцлог шинж	46
ИХШХШЭЗ-н тусгай зарчим.....	51

Гуравдугаар бүлэг. ИХШХШЭ ЗҮЙН ХАРИЛЦАА55

ИХШХШЭ зүйн харилцааны ойлголт, онцлог	55
Иргэний хэргийн оролцогчийн ойлголт, тэдгээрийн эрх, үүрэг.....	58
Бусдын эрхийг хамгаалж байгаа иргэн, хуулийн этгээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох нь. ИХШХША дахь төлөөлөл	64

Дөрөвдүгээр бүлэг. ХЭРГИЙН БА ШҮҮХИЙН Харьяалал71

Хэргийн харьяаллын ойлголт, төрөл. Шүүхийн харьяалал, ангилал.....	71
Шүүхийн харьяаллын онцлог, шүүхийн харьяалалтай холбогдуулан хийгдэх ажиллагаанууд	77

Тавдугаар бүлэг. НОТЛОХ БАРИМТ81

Нотлох баримтын ойлголт ангилал	81
Шүүхийн нотолгооны ойлголт, үе шат	86
Нотолгооны хэрэгсэл түүний төрөл	91



Зургаадугаар бүлэг. ИРГЭНИЙ ХЭРЭГ ҮҮСГЭХ	97
Иргэний хэрэг үүсгэх ажиллагаа, үр дагавар	97
Нэхэмжлэлийн тухай ойлголт, бүрдүүлбэр, төрөл, нэхэмжлэл гаргах журам	104
Шүүхийн зардал ба улсын тэмдэгтийн хураамж	110
Долоодугаар бүлэг. АНХАН ШАТНЫ ШҮҮХ ХУРАЛДААН	117
Анхан шатны шүүх хуралдаанд бэлтгэх үе шат	117
Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа	124
Анхан шатны шүүхийн шүүх хуралдааны онцлог, түүний дэг	129
Анхан шатны шүүхийн шийдвэр	136
Анхан шатны шүүхийн шүүх хуралдаан /Дүрд тоглох/	143
Наймдугаар бүлэг. ДАВЖ ЗААЛДАХ ЖУРМААР ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА	145
Давж заалдах шатны шүүхийн ойлголт, онцлог, давж заалдах шатны шүүхээр хэрэг хэлэлцэх ажиллагаа	145
Есдүгээр бүлэг. ХЯНАЛТЫН ЖУРМААР ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА	152
Хяналтын журмаар гомдол гаргах үндэслэл, журам, түүнийг хэлэлцэх ажиллагаа	152
Аравдугаар бүлэг. ГЭР БҮЛИЙН ХОЛБОГДОЛТОЙ ХЭРЭГ МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА	157
Шүүхийн журмаар гэрлэлт цуцлах ажиллагаа	157
Гэрлэлт цуцлах хэргийг шүүхээр шийдвэрлэх шүүх хуралдаан	165
Арван нэгдүгээр бүлэг. ОНЦГОЙ АЖИЛЛАГААНЫ ЖУРМААР ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА	168
Онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэгдэх хэргүүд, онцлог	168
Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг шүүхээс тогтоох нь ба бусад хэргүүдээс ялгагдах онцлог	177
Арван хоёрдугаар бүлэг. ГОМДЛООР ҮҮСЭХ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА	182
Гомдлоор үүсдэг хэргийн онцлог, хянан шийдвэрлэх ажиллагаа	182
Арван гуравдугаар бүлэг. ШИНЭЭР ИЛЭРСЭН НӨХЦӨЛ БАЙДЛЫН УЛМААС ХЭРЭГ ДАХИН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА	187
Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг дахин хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог	187

**НЭГ. ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЭРХ
ЗҮЙН ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР**

ИХШХШЭЗҮЙН ХИЧЭЭЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

ИХШХШЭЗ хичээлийн танилцуулга

Хичээлийн нэр:	<i>ИХШХШЭЗ</i>
Нийт цаг:	<i>64 цаг /36 цаг лекц, 28 цаг семинар/</i>
Кредит:	<i>3</i>
Аль семестрт үзэх:	<i>V</i>
Залгамж холбоо:	<i>Энэ хичээлийг Эрх зүйн онол, Үндсэн хуулийн эрх зүй, Иргэний эрх зүйн хичээлийн дараа, хөдөлмөрийн эрх зүй, бизнесийн эрх зүй, гэр бүлийн эрх зүй зэрэг хувийн эрх зүйн хичээлүүдтэй зэрэгцэн судалбал зохино.</i>

№	Заавал судалсан байх хичээл	Үндэслэл
1.	Эрх зүйн онол	Нийгмийн харилцааг зохицуулагч хэм хэмжээнүүд, тэдгээрээс эрх зүйн хэм хэмжээний онцлог шинжийг ялган, эрх зүй, хууль хоорондын харилцан хамаарлын талаар мэдсэн байх. Эрх зүй нь нийгмийн тодорхой төрлийн харилцааг зохицуулахдаа өөрийн гэсэн зохицуулах зүйл, арга, зарчимтай байх зэрэг онолын мэдлэгийг олж авсаны үндсэн дээр нэг салбар эрх зүйг бусад салбар эрх зүйгээс ялган тодорхойлох чадвартай болсон байх нь ИХШХШЭЗ Зүй хичээлийг салбар эрх зүй болохынх нь хувьд гүнзгийрүүлэн судлах суурь нь болох тул энэ хичээлийг юун түрүүнд судалсан байх нь зүйтэй.
2.	Үндсэн хуулийн эрх зүй	Аливаа салбар эрх зүйн үндсэн эх сурвалж болох Үндсэн хуулийн үзэл баримтлал, зарчмыг танин мэдсэнээр салбар эрх зүйг гүнзгийрүүлэн судлахад чухал тулгуур болно.
3.	Логик	Аливаа үзэгдэл, юмсын зүй тогтол, мөн чанар, тэдгээрийн харилцан хамаарлыг онолын түвшинд, категорчилсан байдлаар сэтгэлгээний олон аргаар танин мэдэх мэдлэг, чадварыг эзэмшсэн байх нь процессын эрх зүй хичээлийн агуулга, мөн чанар, хэрэгцээг хууль зүйн шинжлэх ухааны төвшинд үнэлэх төдийгүй, иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх хуулийн зохицуулалт, түүний үр нөлөө, хууль хоорондын харилцан хамаарал, хэрхэн систем болж буй талаарх өөрийн дүгнэлтийг өгөх, мөн процессын эрх зүйн аливаа хэм хэмжээг амьдралд хэрхэн зүй зохистойгоор хэрэгжүүлэх талаар задаргаа, дүгнэлт гаргахад арга зүй нь болдог тул уг хичээлийг судалсан байх нь зүйтэй.



4.	Иргэний эрх зүй	Иргэний эрх зүй хичээлийг судалснаар ИХШХШЭ Зүй хичээлийн ач холбогдол, мөн чанарыг танин мэдэхэд суурь нь болж өгнө. Материаллаг эрх зүй, процессын эрх зүйн хоорондын харилцан хамаарал, үндсэн зарчмын уялдааг гүнзгий ойлгож, хэрэглэх чадвартай болохын тулд заавал урьдчилан судалсан байх ёстой.
5.	Гадаад хэл	ИХШХШЭЗ хичээлийн лекцээр олсон мэдлэгийг бататган гүнзгийрүүлэх, бие даан суралцах, семинарын хичээлд бэлтгэх зэрэгт гадаад хэл дээр хэвлэгдсэн ном, сурах бичиг, гарын авлага, мэргэжлийн сонин сэтгүүл, интернэт сайтыг ашиглахад дөхөм болох тул гадаад хэлний хичээлийг судалсан байх шаардлагатай.

ИХШХШЭЗ хичээлийг судлах хэрэгцээ, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд "Монгол Улсын иргэн Монгол улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах эрхтэй" гэж заасан бөгөөд Иргэний хуульд "Шүүхээр хамгаалуулах" зарчим шинээр тусгалаа олсон билээ. Эдгээр эрхийг хэрэгжүүлэх гол салбар эрх зүй нь ИХШХШЭЗ юм.

ИХШХШЭЗ хичээлийн зорилго

Энэхүү хичээл нь ИХШХШЭ Зүйн зохицуулах зүйл, арга, зарчмын хүрээнд иргэний хэргийг шүүх хянан шийдвэрлэх ажиллагааны талаар үндсэн мэдлэг олгох, ИХШХШТухай хууль тогтоомжийг хэрэглэх, шүүхээс гаргасан шийдвэрт дүгнэлт хийх дадал чадвартай болгох, иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдоос зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, шүүхээр хамгаалуулах, шүүхэд мэдүүлэх эрхээ хэрэгжүүлэхэд нь хууль зүйн туслалцаа үзүүлэх, энэ ажиллагаанд хүний эрх, тэгш байдлыг хангах үзэл санаа хандлагатай болгон төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулна.

ИХШХШЭЗ хичээлийн зорилт

- Эрх зүйн тогтолцоонд ИХШХШЭЗ гүйцэтгэх үүргийг тодорхойлж сурах;
- ИХШХШЭ Зүй болон Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, захиргааны хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааны ялгаатай болон төсөөтэй талуудыг тодорхойлох;
- ИХШХШЭ Зүйн түүхэн хөгжилт, түүний үе шат, онцлогийг судлах, процессын эрх зүйн аливаа асуудлыг уламжлал, шинэчлэлийн хүрээнд авч үзэх;
- ИХШХШЭ Зүйн онолын суурь мэдлэг эзэмших; ИХШХШЭ Зүйн талаар өөрийн мэдлэгийг бүтээх;
- ИХШХШЭ Зүйн үндсэн ойлголт, зарчмуудыг тайлбарлаж, хэрэглэх мэдлэг, чадвар эзэмших;
- Асуудалд ИХШХШЭ Зүйн онолын үүднээс үнэлэлт, дүгнэлт өгөх чадвар эзэмших;
- Олж авсан мэдлэгээ практикт бүтээлчээр хэрэглэх, хууль хэрэглэх дадал чадварыг эзэмших.

**ИХШХШЭЗүйн хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө,
ЦАГИЙН ХУВААРИЛАЛТ**

№	Бүлэг	Цаг	Хичээлийн сэдэв	Хичээлийн хэлбэр, цаг	
				Лекц	семинар
1.	ИХШХШЭ Зүйн үндсэн асуудал	8	ИХШХШЭЗүйн зохицуулах зүйл, зохицуулах арга, эрх зүйн системд эзлэх байр суурь	2	
			ИХШХШ ажиллагааны ойлголт, төрөл, үе шат,	2	
			ИХШХШЭЗүйн эх сурвалжийг танин мэдэхийн ач холбогдол		2
			ИХШХША-ны хугацаа		2
2.	ИХШХШЭ Зүйн зарчим	4	ИХШХШЭЗүйн зарчмын ойлголт, ангилал, онцлог шинж	2	
			ИХШХШЭЗүйн тусгай зарчим		2
3.	ИХШХШЭ Зүйн харилцаа	6	ИХШХШЭЗүйн харилцааны ойлголт, онцлог	2	
			Иргэний хэргийн оролцогчийн ойлголт, тэдгээрийн эрх, үүрэг	2	
			Бусдын эрхийг хамгаалж байгаа иргэн, хуулийн этгээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох нь. ИХШХША дахь Төлөөлөл		2
4.	Хэргийн ба шүүхийн харьяалал	4	Хэргийн харьяаллын ойлголт, төрөл, шүүхийн харьяалал ангилал	2	
			Шүүхийн харьяаллын онцлог, шүүхийн харьяалалтай холбогдуулан хийгдэх ажиллагаанууд		2
5.	Нотлох баримт	6	Нотлох баримтын ойлголт, ангилалт	2	
			Нотолгооны хэрэгсэл, түүний төрөл		2
			Шүүхийн нотолгооны ойлголт, үе шат	4	
6.	Иргэний хэрэг үүсгэх	6	Иргэний хэрэг үүсгэх ажиллагаа, үр дагавар	2	
			Нэхэмжлэлийн ойлголт, бүрдүүлбэр, төрөл, нэхэмжлэл гаргах журам		2
			Шүүхийн зардал ба улсын тэмдэгтийн хураамж		2



7.	Анхан шүүх шатны хуралдаан	10	Анхан шатны шүүх хуралдаанд бэлтгэх үе шат	2	
			Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа		2
			Анхан шатны шүүхийн шүүх хуралдааны онцлог, дэг	2	
			Анхан шатны шүүхийн шүүх хуралдаан /дүрд тоглуулах/		2
			Анхан шатны шүүхийн шийдвэр	2	
8.	Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа	4	Давж заалдах гомдол гаргах журам, түүний хэлэлцэх ажиллагаа	2	
			Давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааны ажиллагаа /дүрд тоглох/		2
9.	Хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа	2	Хяналтын журмаар гомдол гаргах үндэслэл, журам, түүнийг хэлэлцэх ажиллагаа	2	
10.	Гэр бүлийн холбогдолтой хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа	4	Шүүхийн журмаар гэрлэлт цуцлах ажиллагаа, онцлог	2	
			Гэрлэлт цуцлах хэргийг шүүхээр шийдвэрлэх шүүх хуралдаан /дүрд тоглох/		2
11.	Онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа	4	Онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэгдэх хэргүүд, онцлог	2	
			Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг шүүхээс тогтоох нь, бусад шийдвэрлэх хэргүүдээс ялгагдах нь		2
12.	Гомдлоор хэлэлцэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа	2	Гомдлоор үүсдэг хэргийн онцлог, хянан шийдвэрлэх ажиллагаа	2	
13.	Шинээр илэрсэн нөхцөл байдал	2	Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг сэргээж дахин хянан хэлэлцэх ажиллагаа.		2
Нийт цаг			64	36	28

ИХШХШЭЗҮЙН ХИЧЭЭЛИЙН ЗААХ АРГА ЗҮЙ

ИХШХШЭЗ хичээлийн арга зүйд тавигдах шаардлага

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй хичээлийг судлах үндэслэл, зорилго, зорилттой уялдан уг хичээлийг заах арга зүйд дараах шаардлага тавигдана. Үүнд:

- Тухайн хичээлийн зорилгыг хангахуйц, түүний агуулгад тохирсон арга, хэлбэрийг сонгож хичээлээ заах
- Иргэний хэрэг хянан шийдвэрлэх эрх зүй хичээлээр оюутан шүүхэд иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа, түүний онцлог, хуульчлагдсан журмуудыг мэдэж, мэдлэгээ амьдралд хэрэглэх чадвар эзэмших нөхцөл боломжийг хангах
- Оюутан бүр жигд, идэвхтэй оролцох боломж, нөхцөлийг бүрдүүлэх
- Хичээлийн агуулга нь практикт түшиглэсэн байх

Мэдээлэл түгээх аргууд

Лекцийн арга /Lecture/

Лекцийн арга нь оюутанд өгөх сэтгэлгээний мэдлэг, ойлголтыг хангахад тохиромжтой тул Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тулгуур ойлголтуудыг тухайлбал, ИХШХШЭЗүйн ойлголт, харилцаа, эх сурвалж, зарчим зэрэг ойлголтуудыг лекцийн аргаар заах нь илүү үр дүнтэй.

Гэхдээ оюутанд их хэмжээний мэдлэгийг хүргэхийн тулд лекцийг явцад бичүүлдэг уламжлалт аргаас бүрмөсөн татгалзах нь зүйтэй. Хичээл зааж буй багш цуглуулсан мэдээлэлээ хураангуй хэлбэрт оруулан урьдчилан тараасан байвал зохино. Оюутан өөрөө хүсвэл уг хураангуй дээр чухал гэж үзсэн зүйлээ бичиж, тэмдэглэн авч болно. Багш ойлгоход нарийн төвөгтэй зүйлийг тайлбарлан таниулах болон олон цаг зарцуулан янз бүрийн эх сурвалж уншиж байж бий болох ёстой мэдлэгийг хүргэхийн тулд лекцийн аргыг ашиглах нь илүү тохиромжтой. Лекцийн хичээлд схем зураглал, бусад үзүүлэн таниулах материал өргөнөөр ашиглах нь цаг хэмнэх, оюутаны мэдээлэл хүлээж авах чадварыг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй хичээлийн ихэнх сэдвийг зөвхөн лекцийн аргаар заах нь төдийлөн тохиромжгүй. Учир нь өөрөө процесс шинжтэй журамлагдсан ойлголтууд учраас тохиолдолыг шинжлэх, хэлэлцүүлэг явуулах, дүрд тоглуулах, шалтгаан үр дагаврыг тодорхойлуулах зэрэг оролцооны бусад аргуудтай хослуулан ашиглах нь зүйтэй юм.

Лекцийн аргыг хэрэглэхэд анхаарах зүйлс:

- Хүн анхааралаа дунджаар 15-20 минутаас илүү төвлөрүүлж чаддаггүй тул лекцурт хугацаагаар үргэлжлэх ёсгүй бөгөөд боломжтой нөхцөлд сургалтын үр ашгийг дээшлүүлэх үүднээс хэлэлцүүлэг хийх, дүрд хувирах, тохиолдол шинжлэх, хүн бүр багш, зэрэг аргуудыг нэмж ашиглах нь зүйтэй.
- Хүн нэг зэрэг долоогоос илүүгүй мэдээллийг тогтоох боломжтой гэж судлаачид дүгнэсэн байдаг
- Багш ярихын хажуугаар үзүүлэн таниулах материал ашигласан тохиолдолд суралцагчдын тогтоох мэдээлэлийн хэмжээ 25 хүртэл хувиар нэмэгддэг бол заалгасан зүйлээ туршиж хэрэглэсэн нөхцөлд энэ үзүүлэлт 70 хувь хүртэл өсдгийг багш бүр анхаарах шаардлагатай.



Лекцийн аргаар хичээл заахдаа уг сэдвийн зорилго, бүтэц агуулгатай нийцүүлэн төлөвлөх шаардлагатай. Тухайлбал, хэвлэгдээгүй, нийтийн хүртээл болоогүй мэдээллийг дамжуулах олон эх сурвалжаас авсан мэдээллийг нэгтгэн дүгнэж оюутанд хүргэх зорилготой байх бөгөөд хамгийн чухал, хэрэгтэй, сонирхолтой гэсэн байдлаар ангилж аль болох хамгийн чухал хэсгийг оюутанд хүргэх нь зүйтэй.

Эвлүүлэгийн арга /Jacksaw/

Энэ арга нь оюутанд богино хугацаанд их хэмжээний мэдээлэл олж авах боломж олгодог ба лекцийг орлуулахад түүнийг ашигладаг.

Эвлүүлэгийн аргын зорилго нь оюутнууд бие биедээ заах, сургах боломж олгодог төдийгүй тухайн хичээлээр мэдээлэл олж авахад хүндрэлтэй тохиолдолд тайлбарлах, асуулт тавих бусадтай харилцах, сонсох чадварыг амьдралд хэрэглэхэд илүү үр дүнтэй.

Эвлүүлэгийн аргыг хэрэглэх үе шат:

- Багш шаарлагатай материалыг бэлтгэнэ
- Багш гэрийн багийг бүрдүүлнэ.
- Суралцагсад "мэргэжилтнүүдийн" багт шилжин мэдээлэл олж авна.
- Суралцагсад "гэрийн" багтаа эргэн ирж мэдээллээ солилцоно.
- Багш ойлгосон эсэх талаар хариу мэдээлэл авч, дүгнэнэ.

Хэрэгжүүлэх дараалал:

Зарим хичээл ээр суралцагчид их мэдээлэл олгох хэрэгтэй байдаг. Энэ тохиолдолд тухайн мэдээлэл, лекцийн агуулга болон бусад нэмэлт хэрэглэгдэхүүнүүдийг ажиллах багийн тоогоор хувааж бэлтгэсэн байна. Бэлтгэсэн материалаа дугтуйд хийж багуудад тарааж өгөхөд бэлдэнэ.

Мөн оролцогчдыг багт хуваахдаа ашиглах өнгийн цаасыг бэлдэнэ.

1. Эхлээд "гэрийн" багийг /1,2,3 -аар тоолуулан/ бүрдүүлнэ. Багийн гишүүн бүр өөр өнгийн цаастай байна. Жишээ нь: 1-р багт 5 гишүүн байгаа бол хүн бүрт өөр өөр өнгийн цаас байна. /улаан, цэнхэр, ногоон, шар, гэх мэт/
2. Гэрийн" багийн гишүүд одоо шинэ газар очиж, эрдэм сурч ирээд бие биедээ сурсан эрдмээ заах болно гэдгийг хэлээд гэрийн баг тус бүрт байгаа ижил өнгийн цаастай хүмүүсийг дахин шинэ баг үүсгэхийг хүснэ. Шинээр үүссэн баг бол "Мэргэжилтнүүдийн" баг бөгөөд энд та бүхэн шинэ юм мэдэж авах болно гэдгийг хэлнэ.
3. Мэргэжилтнүүдийн багуудад бэлтгэсэн ууттай материалуудыг өгч, ажиллах заавраар хангана.
 - а. Дүрүүдийг хуваарилах: хөтлөгч, цаг харагч, асуулт тавигч, томилно.
 - б. Тараасан ууттай материалыг уншиж ярилцах
 - в. Асуултанд хариулж буй оюутан бүр өгөгдсөн даалгаврыг ойлгосон гэдэгт итгэлтэй байхын тулд бусдаасаа асууна.
 - г. Багийн гишүүд өөрийн "гэрийн" багийнхандаа чухам юуг заахаа шийднэ.

Тэдэнд мэргэжилтэн болоход нь хангалтай хугацаа өгөх хэрэгтэй. Хэрэв уг материал хүнд бөгөөд бүрэн танилцахад хугацаа хэрэгтэй бол бүтэн нэг хичээл зориулна. Багш баг бүрт очиж материалаа ойлгож байгаа эсэх, гэрийнхэндээ очоод яаж тайлбарлах талаар ярилцаж туслах хэрэгтэй.

4. Суралцагчид “гэрийн” багтаа буцаж очно. Гэрийн” багт “Мэргэжилтнүүдийн” багаас нэг, нэг төлөөлөгч буцаж ирнэ. Өөрсдийн юу сурснаа багийн гишүүддээ нэг, нэгээрээ зааж өгнө. Материалын их бага, хүнд хөнгөнөөс шалтгаалаад дахиад нэг бүтэн хичээл шаардагдаж магадгүй.
5. Суралцагчдын ойлгосон эсэх талаар хариу мэдээлэл авах асуултууд бэлтгээд тэдний юу сурсныг дүгнэнэ. Мөн шаардлагатай нэмэлт мэдээллийг өгнө.

Хүн бүр багш /Each one teach one/

Бүлэг сэдвийг танилцуулахад болон сэдвийн агуулга, ухагдахуунуудыг дүгнэх, лекцийн агуулгыг хүргэхэд энэ аргыг гол төлөв хэрэглэнэ.

Зорилго: Сургалтын үйл явцад идэвхтэй оролцох болон бие биетэйгээ санаа бодлоо солилцоход оролцогчдод ихээхэн ач холбогддолтой болно. Энэ аргыг хэрэглэснээр хичээлийн үед заавал эзэмших ёстой агуулга болон ухагдахууны талаар ерөнхий ойлголт өгөх ба тэдний сонирхлыг өдөөж, асуулт тавихад хүргэнэ.

Хэрэгжүүлэх дараалал

- Лекцийн агуулга, мэдээллийг утгат хэсгээр нь хувааж, тарааж өгөх зорилгоор жижиг цаасан дээр бичиж бэлтгэнэ. Энэ нь таны сургалтанд оролцогчдын тоогоор байх ёстойг анхаарч оролцогч бүрт тараана.
- Оюутнууд мэдээллийг уншсаны дараа уг уншсан зүйлийнхээ агуулгыг ярих, зураглал бүдүүвчээр илэрхийлэх зэргээр бусдад түгээх бэлтгэлээ хийнэ. Энэ үед багш тусламж шаардлагатай хүн дээр очиж зөвлөгөө өгч тайлбарлаж болно
- Бэлтгэх хугацаа дууссаны дараа тэд мэдээллээ бие биедээ танилцуулж ангиа тойрон явна. Хүн бүр өөрт байгаа мэдээллээ танилцуулж, бусдаас мэдээлэл авч дуустал энэ ажил үргэлжилнэ. Зорилго нь бусадтай мэдээлэл солилцох буюу өөрт буй мэдээллээ бусдад тарааж шинэ мэдээлэл бусдаас олж авахад оршино.

Оролцооны аргууд

Шүүхээр хэрэг хянан хэлэлцэх ажиллагааны тодорхой жишээн дээр сургах арга /тохиолдол шинжлэх арга-Case method/

Тодорхой жишээ гэдэг нь шүүхээр шийдвэрлэгдсэн бодит хэрэг, зохиомол хийсвэр жишээ, шүүхийн практик, хууль хэрэглэгээг мэдэрч иргэний хэргийг шүүхэд хэрхэн шийдвэрлэдэг асуудлаар тодорхой ойлголт, мэдлэг өгөх, асуудалд олон талаас нь шүүмжлэлтэй, нухацтай хандах, шийдвэр гаргах хандлага төлөвшүүлэхэд чиглэгдэж ашиглагдах хэрэглэгдэхүүн юм.

Тохиолдол шинжлэх аргыг ИХШХША-гаа болон ЭБША-ны талаарх ойлголтуудыг бататгах, үнэлэлт, дүгнэлт өгөх, шийдвэр гаргуулах, процессын хэлбэрийг тогтоолгох, танин мэдүүлэх зорилгоор өрөн хэрэглэдэг. Сургалтын тохиолдлууд ихэвчлэн эх бичвэрийн хэлбэртэй байдаг боловч кино болон дүрс бичлэг, дуу хураагчид бичигдсэн зүйлс, дүр бүтээж тоглосон хэлбэрээр байж болно.

Зорилго: Сургалтын энэ арга нь суралцагчийг ямар нэг баримт хэргийн нөхцөл байдлын талаар асуулга тавих, тодорхой тохиолдолуудад ямар нь хамгийн чухал болохыг тодорхойлуулж, тэдгээрийг задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, эргүүлэн бодох боломж олгодог. Тохиолдлыг шинжлэх явцдаа суралцагчид шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тодорхой хэлбэрүүдийг танин мэдэж, хэрэг маргааны бодит байдлыг үнэлэх, шүүхийн шийдвэрт үнэлэлт дүгнэлт хийх, хууль хэрэглэх, дадал арга зүйтэй болох, уг хичээлийг сонирхон судлах идэвхийг өрнүүлэхэд энэ аргын зорилго оршино.



Тохиолдол шинжлэх аргыг яагаад хэрэглэдэг вэ?

- Дүгнэлт хийлгэх, шийдвэр гаргуулахын тулд
- Сэтгэн бодох боломжийг олгодог
- Суралцагчдын дотоод сэтгэлгээний дадлага чадварыг хөгжүүлж, бие дааж задлан шинжилгээ хийх, нэгтгэн бодох, шийдвэр гаргах үйлдэлд дасгана.
- Хүний сэтгэл хөдлөл, мэдрэмжийг таниулахын зэрэгцээ суралцагчдын дүрслэн бодох сонирхол төрүүлэх, сэтгэлгээг өдөөдөг.
- Танхимд суралцаж буй суралцагчдын бодит амьдралын туршлага, жишээтэй сэтгэлгээний хувьд холбоотой байх нөхцөлийг бүрдүүлнэ.
- Суралцагчдад мэдсэн сурсанаа хэрэглэх боломж олгохын зэрэгцээ ИХШХШЭЗүйн салбарт шинэлэг санаа, ойлголт, зарчмыг хөгжүүлэхэд нөлөөлнө.

Тохиолдлыг шинжлэх аргаар явуулах

Нэг: Шийдвэр гаргахад бэтгэх үе:

Аливаа шийдвэрийг гаргахад хангалттай сайн мэдээлэл, баримт нотолгоо цуглуулж боловсруулах хэрэгтэй байдаг. Үүний нэг адил тохиолдлыг шинжилж, шийдвэр гаргахын тулд бэлтгэл ажил хэрэгтэй. Үүнд:

- Тухайн тохиолдлыг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг өгөх, мэдээлэл өгөх олон янзын арга байдаг. Тухайлбал: уншуулах, бага хэмжээний лекц сонсгох, видео бичлэг үзэх гэх мэт.
- Тохиолдлыг уншуулах. Энэ үед оюутанд тохиолдлын шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааны эцсийн үр дүн, шийдвэрийг мэдээлэхгүй байх хэрэгтэй. Уг асуудлын бодит төгсгөлийг нилээд хожим авч үзэх болно
- Цаашдаа суралцагчдын анхаарлыг бодит баримтын учрыг олоход чиглүүлэх хэрэгтэй. Юуны түрүүнд тохиолдлын үйл явдгыг сайтар ойлгуулах нь чухал. Асуудалд хариу авах замаар тэдний ойлголтыг гүнзгийрүүлж болно

Тухайлбал, Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн үү, Маргааны оролцогч талуудыг тодорхойл, нотлох баримтанд үнэлэлт, дүгнэлт өг, энэ тохиолдолд хамгийн чухал нөхцөл байдал нь юу болох гэх мэт.

- Багшийн зүгээс өөрийн асуултыг боловсруулж суралцагчдад тавьж болно, эсвэл тэднээр өөрсдөөр нь ажиллуулж, асуулт боловсруулуулж ч болох юм. Ингэхдээ 2, 2-оор нь ажиллуулах бөгөөд нэг нь чухал баримт дээр товч дүгнэлт хийж байхад нөгөө нь асуултуудыг боловсруулан бэлтгэж байх юм.

Хоёр: Шийдвэр гаргах үе:

Суралцагчид хэрэгтэй мэдээллээ авч, тохиолдлыг хангалттай судалсны үндсэн дээр шийдвэр гаргах үйл ажиллагаанд орно. Тэдний шийдвэр гаргах үйл явцыг багш олон аргаар зохион байгуулж болно.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх эрх зүй нь шүүхээр хянан шийдвэрлэгддэг хэрэг маргаанаас жишээ авч практикаар байнга шалгагдаж байдаг учраас энэ хичээлийн гол заах арга нь тохиолдол шинжлэх арга юм. Энэ аргыг хэрэглэхийн тулд эхлээд оюутнуудад тухайн сэдвийн лекцийн хичээлийг орж, тодорхой ойлголт авсны дараа үнэлэлт, дүгнэлт хийлгэх, ойлголтоо бататгах зорилгоор хэрэглэх нь илүү зохимжтой.

Шүүх ажиллагааны тоглолт хийх /эвлүүлэгийн аргын хувилбар/

Хэрэгт авагдсан баримт, маргаантай асуудлуудыг тайлбарласны дараа

“нэхэмжлэгч, түүний өмгөөлөгч”, “хариуцагч, түүний өмгөөлөгч” “шүүгч” гэсэн 3 бүлэгт хуваана. Эхний 2 бүлэг нь өөр өөрсдийн нотолгооны үндэслэлийг боловсруулах ба “шүүгч” бүлэг нь асуултуудыг гаргаж дээрх 2 бүлэгт өгнө.

Бүлэг бүр өөрсдийн гаргаж буй үндэслэлийг шүүгчид ярих хүмүүсийг томилж ажиллуулах ба шүүгчээс шийдвэр гаргахын өмнө бүлэг бүхэнд асуулга тавих аргаар ажиллана.

Энэ аргыг аль болох олон хүнийг хамруулах хэлбэрээр нэг бүлэгт 3, 3-аар хуваарилах ба нэг нь нэхэмжлэгч, нөгөө нь хариуцагч, гуравдахь нь шүүгч гэх мэтээр олон бүлэгт хувааж ажиллуулж болно. Хоёр тал өөрсдийн нотолгоо үндэслэлийг шүүгчид танилцуулах ба шүүгч тэдэнд асуулт тавьж хариулт авсны дараа үндэслэл бүхий шийдвэр гаргана. Шүүгч багийнханы гаргасан шийдвэрийг дараах хүснэгтээр нэгтгэж ярилцана.

Санал нэгтгэх хүснэгт

Багууд	Нэхэмжлэгчийн зөв	Хариуцагчийн зөв	Үндэслэл
1-р баг			
2-р баг			
3-р баг			

Сургалтын шүүх ажиллагаа / Мини шүүх /

Энэ арга нь дээрх шүүх ажиллагааны тоглолттой төстэй боловч суралцагчид бүрэн бүрэлдэхүүнээрээ шүүх хуралдааныг хийдгээрээ ялгаатай. Шүүх хуралдаанд нэхэмжлэгч, хариуцагч, тэдгээрийн өмгөөлөгч нар, гэрч, шинжээч, шүүгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга гэх мэт тухайн тохиолдлыг хянан шийдвэрлэхэд шаардагдах бүх дүрүүдийг хуваарилж бэлтгэх хэрэгтэй болдог. Мөн анги танхимаа шүүхийн танхимын байдлаар засах хэрэгтэй. Иймээс дээрх аргаас илүү бэлтгэл, цаг хугацааг шаардана.

Шүүх хуралдааныг хуульд заасан дараалалаар удирдан явуулах учраас шүүгчийн багийг сайн бэлтгэж дараалалыг урьдчилан хэлж өгсөн байна. Мөн бусад оролцогчид эрх үүргээ сайн мэдсэн байх, хуралдааны дараалал, дэгийг сахиж оролцох ёстой.

Иргэний шүүх хуралдааныг:

- а. Анхан шатны шүүхийн
- б. Давж заалдах шатны шүүхийн
- в. Хяналтын шатны шүүхийн хэлбэрээр холбогдох сэдвийн хүрээнд зохион байгуулж болно.

Ингэхдээ ИХШХШТ Хуулийн холбогдох заалтын дагуу хуралдааныг явуулна. Тухайлбал, анхан шатны шүүх хуралдааны дэг, дараалал хуулийн 98-119-р зүйлд заасны дагуу явагдана. Энэ арга нь суралцагчдад шүүх хуралдаан хийх, дараалал, дэгийг зөв мэдэрч ойлгох, дүгнэлт хийх боломж олгодог төдийгүй тэдний идэвх санаачлагыг өрнүүлдэг давуу талтай, асуудлыг шийдвэрлэх, хууль хэрэглэх чадвар, итгэл үнэмшл, хандлагыг төлөвшүүлдэг.

Хичээлийн танхимыг урьдчилан бэлтгэсэн, хаягийг тавьсан байх шаардлагатай.

Оюуны довтолгоо

Зорилго: Энэ нь ихээхэн идэвхтэй сургалтын арга юм. Энэ нь тохиолдол буюу ямар
16



нэгэн асуудлын талаархи янз бүрийн санаа боддоо чөлөөтэй, нээлттэй илэрхийлэх боломжийг суралцагчдад олгодог. Мөн сэтгэлгээ, төсөөлөл болон бүтээлч хандлагаа ашиглахад ихээхэн хэрэгтэй.

Хэрэгжүүлэх дараалал:

- Албан бусаар чөлөөтэй суулгах
- Хэлж буй санаануудыг бичих самбар, буюу ердийн самбар бэлдсэн байх
- Гол асуултаа тавих, эсвэл шийдвэрлэх ёстой асуудлаа дэвшүүлэх
- Ерөнхий дүрмээ зохиож бичих /доор дурьдсаны дагуу/
- Хэлсэн санаа бодлуудыг дор бүрд нь бичиж тэмдэглэх. Ямар нэг засвар оруулж болохгүй.
- Том цаасан дээр бичиж байгаа тохиолдолд ханан дээр наах ба дуусахаар нь дахиад шинэ цаасан дээр бичих
- Өөрөө санаа өгч сурагчдаар шинэ санаа гаргуулах
- Хэн нэгнийхээ хэлсэн зүйлийг шоолохгүй, яаран шүүмжлэхгүй байхыг сануулах
- Шинэ санаа нэмж гартал асуусаар байх
- Эцэст нь гарсан саналуудыг авч хэлэлцэн, дүгнэлт гаргах

“Оюуны довтолгоо”-г хийхэд багшийн мөрдөх дүрэм:

Санаа бодлоо хэлж байх явцад үнэлж дүгнэсэн ямар нэгэн зүйлийг хэлэхгүй байх. Хэрэв та суралцагчдыг санаа бодлоо хэлж байх явцад ямар нэгэн үнэлэлт, дүгнэлт өгвөл тэд шинэ санаа гаргахаасаа илүү өөрийн хэлэх гэж буй зүйлдээ дүгнэлт хийж хянаад, чөлөөтэй байдлаа алдахад хүрнэ. Иймд ямар нэгэн үнэлэлт, дүгнэлт өгөхийг энэ үед хориглох хэрэгтэй.

Аль болох олон санаа гаргуулах хэрэгтэй. Сонирхолтой санаануудыг ямагт дэмжих нь зүйтэй. Хэрэв “тархины шуурганы” үед тийм олон санаа гарахгүй байгаа бол инээдэмтэй тэнэг байдалд орохгүйн тулд оролцогчид өөрсдийн санаа бодлоо чөлөөтэй, илэн далангүй хэлж чадахгүй байна л гэсэн үг.

Шинэ сонирхолтой санаа олон байх тусам хичээл төдий чинээ сонирхолтой байх болно. Эцсийн дүнд тооноос чанар байх болно. Мөн янз бүрийн санаанууд их гарах тусам үнэлж дүгнэх боломж, хугацаа хомс байх болно.

Оролцогч бүрийг биеэ барилгүй санаагаа илэрхийлэх боломж олгоход анхаарч, санаа бодлыг нь хөгжүүлж, сайжруулахад туслах хэрэгтэй. Гаргасан санаануудыг нэгтгэх эсвэл өөрчлөх нь цоо шинэ санаа гаргахад хүргэдэг талтай.

Оюуны довтолгоог явуулахад суралцагчдын мөрдөх дүрэм:

- Санаанд орж буй бүхий л зүйлийг сэтгэл зоволгүйгээр хэлэх
- Бусдын санаа бодлыг шүүмжлэхгүй байх
- Бусдын хэлсэн санааг давтахаас бүү зов
- Хэн нэгний санааг баяжуулж хөгжүүлэх
- Өөрийн чинь ургуулан бодох чадвар дуссан гэж бодож хэзээ ч болохгүй. Ямагт шинэ зүйлийг бодож олох хэрэгтэй.

Бод, Хамтар, Хуваалц

Энэ арга нь оролцогчдыг жижиг багаар ажиллуулж сургахад ач холбогдолтой. Мөн “бусадтай санаа бодлоо хуваалцахаас өмнө сайтар бод” гэдгийг ойлгуулахад тустай.

Зорилго: Аливаа асуудлыг эхлээд өөрсдөө сайтар бодож, дараа нь бусадтайгаа хуваалцахын чухлыг таниулах, санаа бодаоо батлах болон хэлэлцэх чадварыг нь сайжруулах, шүүмжлэлт сэтгэлгээний чадвараа хөгжүүлэх, амьдралд хэрэгжүүлэх чадвартай болгоход оршино.

Хэрэгжүүлэх дараалал:

Оролцогчдод ямар нэгэн маргаантай асуулт эсвэл зөв хариултгүй тохиолдлыг танилцуулна. Асуулт болон тухайн тохиолдлыг сайтар ойлгуулсны дараа боломжит хариултыг бодож олох болон тохирох шийдлийг гаргах хугацааг олгоно.

Дараа нь хос хосоор нь болгоод өөрсдийн санаагаа бусадтай хуваалцах боломж олгоно. Тэд тухайн хариултын болон шийдлийн талаар нэгдсэн зөвшилцөлд хүрэх ёстой.

Хос тус бүр өөрсдийн хариулт болон үндэслэлүүдээ бие биедээ танилцуулж улмаар нийтийн ярилцлага хийнэ.

Жижиг багаар ажиллах арга

Жижиг багаар ажиллуулах энэхүү арга нь бусдыг анхааралтай сонсох, нэгдсэн дүгнэлтэнд хүрэх зэрэг чадвартай болгодог. Түүнчлэн бүрэг ичимхий оюутанг бусадтай харилцах харилцааны чадвараа дээшлүүлэхэд нөлөөлдөг. Аливаа асуудлыг бие даан шийдвэрлэж чадахгүй тохиолдолд жижиг багаар ажиллах энэхүү аргыг ашигладаг.

Хэрвээ энэ арга нь хүссэн үр дүнг бий болгож чадахгүй тохиолдолд харилцан ажиллахыг хурдасгах үүднээс “бод, хамтар, хуваалц” аргыг хэрэглэсэн нь илүүтэй.

Хэрэгжүүлэх дараалал:

1. Багийн ажиллах зарчмыг танилцуулах

Багийн ажлыг яаран эхлүүлж болохгүй. Хоёр хүнээр баг бүрдүүлэх ба шаардлагатай тохиолдолд багт туслах үүрэгтэй гишүүнийг оролцуулж болно. Багийн гишүүн бүр тодорхой даалгавартай байна. Туслах нь багийн үйл ажиллагааг чиглүүлэх биш харин хөнгөвчлөхөд туслана. Багш жижиг багийн ажлыг хянана. Харин бусад оюутанууд дараах үүрэгтэй оролцоно.

Үүнд: Үйл ажиллагааг хөнгөвчлөх, Үйл явц болон шаардлагатай зүйлүүдийг бичиж тэмдэглэх, ажлаа танилцуулах, асуулт тавих, мэдэгдэл буюу асуудлыг өөр аргаар илэрхийлэх, ажиглах зэрэг болно.

Жижиг багаар ажиллаж сураагүй оюутанд онцгой анхаарал тавих ёстой.

Суралцагсад жижиг багаар ажиллаж сурмагц багийн гишүүдийн тоог гурав болгох хэрэгтэй. Энэ багийг бие даан ажиллах чадвартай боллоо хэмээн үзмэгц нэмж нэг хүн оруулах замаар гишүүдийн тоог аажмаар нэмэгдүүлнэ. Гэхдээ нэг багт таваас олон хүн оруулахгүй байхыг чухалчилна.

Оюутан жижиг багаар ажиллахад ямар чадварууд шаардлагатайг мэдэж авах ёстой ба багш түүнд туслах үүрэгтэй. Таны тусламжгүйгээр сайн ажиллаж чадна хэмээн ажлыг цалгардуулж болохгүй. Багийн гишүүдийн оролцож байгаа байдалд дүн шинжилгээ хийх нэг арга нь багийн ажлын гүйцэтгэлийг бичиж тэмдэглэх ажиглагчийг томилох явдал юм.

Ажиглагчийн дүгнэлт нь багийн гишүүд даалгавраа хэрхэн биелүүлсэнд дүн шинжилгээ хийх боломж олгодог.

Ажиглагчид нь багшийн урьдчилан хэлсэн тодорхой зан төлөвийн шинжүүдийг



болон ажлын явцад тулгарч буй асуудлуудыг багийн гишүүд хэрхэн шийдвэрлэж буйг ажиглан тэмдэглэх ёстой. Жишээ нь: харилцагчийнхаа нүд рүү харах, зөвшөөрч буйгаа илэрхийлэх, асуулт тавих, харилцагчийнхаа хэлсэн үгийг давтах, дахин томъёолох, харилцан хүндэтгэлтэй байх зэрэг чадварыг багийн гишүүд хэрхэн ашиглаж буйг “ажиглагч” шалгаж тэмдэглэнэ. Өөрийн ажигласан зүйлээ сайтар дүрсэлсэн байдаар багийнхандаа танилцуулна.

2. Багийн хэмжээ.

Багийн гишүүдийн тоо ихсэх тутам оролцогчдын дадал чадвар сайжирдаг ба багийн ажлыг биелүүлэхэд хэрэг болохуйц онцгой мэдлэг бүхий оролцогч бий болох магадлал өндөрсдөг. Гэхдээ багаар ажиллах чадварыг эзэмшээгүй бол бодлогогүй үйлдэл ихсэх магадлал ихсэнэ.

Гэвч баг олон гишүүнтэй байх тусам хүн тус бүрт үгээ хэлэх боломж олгохын тулд илүү их чадвар гаргах шаардлага тулгардаг.

Багаар ажиллах чадварыг сайн эзэмшсэн хүн тийм ч их байхгүй. Иймд тэднийг тэрхүү чадварт сургах шаардлагатай ба үүнд хугацаа хэрэгтэй.

Тухайн хичээлийн цаг хэдий богино байна багийн гишүүдийн тоо төдий хэмжээгээр бага байх ёстой. Жижиг багууд илүү үр бүтээлтэй ажиладаг бөгөөд тэднийг зохион байгуулахад ч амархан байдаг. Мөн тэд хурдан шаламгай ажиллахаас гадна гишүүн болгоныг тухайн ажилд идэвхтэй оролцох боломжоор хангадаг.

Жижиг багийн доторх харилцан үйлдлийн шинжүүд:

Хоёр гишүүнтэй баг

Энэхүү багт мэдээлэл солилцох боломж өндөр ба санал зөрөлдөх явдал бага байдаг. Гэвч ийм баг нь хэт их ачаалалтай ажиллаж сэтгэл хөдлөлөөр дүүрэн байх ба оюуны мухардалд хүрэх нь олонтоо тохиолддог. Санал зөрөлдөх явдал гарвал аль нэгнийх нь талд орох хүн байхгүй байдаг.

Гурван гишүүнтэй баг:

Багийн аль хоёр чадалтай нь сул нэгнийгээ захирах магадлалтай. Гэсэн хэдий ч энэ нь түр зуурын учир санал зөрөлдөх асуудлыг шийдвэрлэхэд хялбар байдаг.

Тэгш болон сондгой тоотой баг:

Санал зөрөлдөөнийг шийдвэрлэхэд тэгш тоотой багт хүндрэлтэй байдаг. Сондгой тоотой байх нь багийг мухардлаас гаргах болон олонхийн саналыг хүндлэхэд ихээхэн тустай.

Таван гишүүнтэй баг.

Ийм бүрэлдэхүүнтэй баг сургалтын үйл ажиллагаанд хамгийн тохиромжтой. Энэ бүрэлдэхүүн нь санал бодлоо үр бүтээлтэй солилцоход хангалттай боловч оюутан болгоныг тухайн үйл ажиллагаанд оролцуулах боломж олгоход бага зэрэг дутагдалтай

3. Багийг бүрдүүлэх.

Багш чадалтай, дунд зэрэг, сул хүүхдүүдийг хольж нэг багт оруулах хэрэгтэй. Иймэрхүү холимог баг бүтээлч сэтгэлгээ болон санал бодлоо идэвхтэй солилцох хэлбэрийг дэмждэг.

Оюутан өөрийн байр сууриа илэрхийлэхэд нилээд цаг хугацаа зарцуулдаг бөгөөд тухайн асуудлыг нарийвчлан олон талаас нь авч үзэх боломжтой байдаг. Түүнчлэн

ондоо хүйс, түвшин хүмүүжилтэй хүүхдүүдийг нэг багт оруулах нь тэдний хоорондын харилцааг сайжруулахад ач холбогдолтой.

Баг тус бүрт байгаа охид, хөвгүүдийн тоо болон чадварын түвшин ойролцоо байвал зүгээр. Багт хуваах олон янзын арга бий. Хамгийн энгийн арга нь тоо тоолуулах ижил тоотойнууд нэг багийг бүрдүүлэх эсвэл тэгш тоотой нь нэг баг, сондгой тоонууд нэг баг гэх мэт..

4. Нийтлэг бэрхшээл.

Жижиг баг бүрт нийтлэг тохиолддог багш, ажиглагч нар анхаарах ёстой зүйлд дараах асуудлууд хамаарна.

- Бусдын эрх болон үзэл бодлыг хүндэтгэх, өөрийн үзэл бодлоо илэрхийлэх боломжийг багийн гишүүн бүрт шударгаар олгож байгаа эсэх
- Хамтран ажиллах болон зөвшилцөхөд бэлэн байгаа эсэх
- Бусдад дэмжлэг үзүүлэх чадвар. Багийн гишүүд өөрийнх нь үзэл бодолтой ижил байгаа эсвэл ойролцоо байгаа бусад гишүүдэд дэмжлэг үзүүлж байна
- Бусдыг сонсох чадвар. Багийн гишүүд бусдын хэлж байгаа зүйлийг сонсохоосоо илүү өөрөө ярихыг хүсч байгаа эсэх? Ярианы үргэлжлэл болон хариултууд түрүүчийн хүний хэлснийг тодруулахад чиглэгдсэн эсэх
- Зөрчил. Багийн нэг эсвэл түүнээс олон хүн өөр байр суурь юмуу саналтай байгаад тэр нь зөрчилдөж байвал баг тэр зөрчилдөөнийг шийдвэрлэхийг хүсч байна уу? эсвэл энэ талаарх ярианаас зугтааж байна уу? Багийн гишүүд эсрэг байр суурьтай бусад гишүүдээ дэмжсэн байр суурь илэрхийлж байна уу? Багийн гишүүдтэй санал нийлэхгүй байгаа асуудлаа нээлттэй хэлэлцүүлэх сонирхол байна уу?

Жижиг багаар ажиллуулахад юу анхаарах хэрэгтэй вэ?

- Оюутан тухайн ажлыг гүйцэтгэх мэдлэг, дадал, чадвар эзэмшсэн байх ёстой
- Багт ажлын зааварчлагааг маш тодорхой өгөх ёстой. Нэг дор /хэдий маш тодорхой ч/ нэг юмуу хоёроос дээш зааварчлагаа өгөх ёсгүй.
- Жижиг багт тухайн ажлыг хийж гүйцэтгэх хангалттай хугацаа өгөх ёстой. Түрүүлж ажлаа дуусгасан багийг бусдад саад болгохгүй тулд юу хийлгэхээ сайтар төлөвлөсөн байна.
- Багийг 5 аас дээш хүнтэй бүрдүүлж болохгүй.
- Бие дааж бол он хамтран ажиллах чадварыг зэрэг хөгжүүл эх буюу тэнцвэртэй байлгахыг зорьсон асуудал даалгавар өгч болохгүй, Учир нь жижиг багаар ажиллах аргыг бие дааж ажиллах чадварыг биш зөвхөн хамтран ажиллах чадварыг хөгжүүлэхэд ашиглах нь илүү тохиромжтой байдаг.
- Энэ аргыг тодорхой зорилготойгоор, тохиромжтой үед дүрмийн дагуу хэрэглэх ёстой болохоос биш улиг домог болсон лекцийг орлуулах арга болгон ашиглаж болохгүй.
- Баг дотор удирдлагын асуудлыг мөн тооцож үзэх ёстой.
- Багаар ажиллахад гарах дуу чимээг хүлээн зөвшөөрөх ёстой.
- Баг болгон дээр очиж хэрхэн ажиллаж байгааг нь ажиглаж дүгнэх хэрэгтэй. Гэхдээ тэдний ажилд саад болохгүй байх
- Жижиг багаар ажиллахад суралцагч бие биенийхээ нүдийг харах боломжтой байдлаар суулгасан байна.



Хичээлд олон нийтийн төлөөлөгчийг болон мэргэжилтэнг урьж оролцуулах

Тодорхой сэдвээр сонирхолтой жишээ практик судлах харилцан ярилцах танин мэдүүлэх зорилгоор олон нийтийн төлөөлөгч, мэргэжлийн хүмүүсийг хичээлд урьж оролцуулах нь ашиг тустай. Жишээ нь залуу хүмүүс өөрийн амжилтанд хүрэх боломжоо амжилтанд хүрсэн танил хүмүүстэйгээ холбож үздэг. Нөгөө талаасаа багш нар өөрсдийн ерөнхий мэдлэгийг мэргэжилтнүүдийн мэдлэг, практик, туршлагаас нөхдөг. Үр дүн нь оюутан хичээлд сонирхолтой байхаас гадна итгэл үнэмшилтэй байна. Цаашид тухайн мэргэжлийг сонирхох хандлага төлөвших боломжтой.

Ялангуяа энэ хичээлийн хувьд шүүгчийн урьж оролцуулснаар шүүгчийн ажлын нарийн ур чадвар, процесс үйл явцыг ялгамжтайгаар ойлгоход ихээхэн ач холбогдолтой. Бодитой хэргийг талаар хэрхэн шийдвэрлэж байсан арга туршлагыг мэдэх зэргээр шүүхийн ажлын практик арга туршлагаас нийгмийн амьдралд гүйцэтгэх үүрэг ролийг улам бүр нарийн ойлгож сонирхох болно. Энэ аргын хүрээнд шүүгчээс гадна өмгөөлөгч, туршлагатай хуульч, иргэдийн төлөөлөгч гэх мэт хүмүүсийг ч урьж ирүүлэн тэдний хамтын ажиллагааны тухай гүйцэтгэх үүрэг, ролийн талаар ялгамжтай ойлголт авч дүгнэлт хийх боломжтой.

Хэрэв уригдан ирсэн гадны төлөөлөгч хичээлд идэвхтэй оролцвол түүнийг урьсаны утга учир гарна. Иймээс гадны зочинг урихдаа дараах зүйлийг анхаараарай.

- Багш тохирох хүнийг сонгож олох өөрөө эсвэл сургуулийн захиргаагаар дамжуулан урих
- Хичээлийн зорилгыг уригдан ирэх гадны зочны хичээлд үзүүлж болох нөлөөтэй уялдуулан төлөвлөнө. Ямар үр дүнд хүрэхээр төлөвлөж байгаага зочинтойгоо ярилцана.
- Зочинд хичээлд гүйцэтгэх үүргийг нь танилцуулж тайлбарлана. Мөн хичээлийн сэдвийн төлөвлөгөөг урьдчилан танилцуулах буюу хүргүүлсэн байна
- Тохирох асуултыг бэлтгэх хэрэгтэйг оюутнуудад сануулж гадны зочин оролцуулах тухайгаа урьдчилан мэдэгдсэн байна
- Гадны зочинг харилцан идэвхтэй үйл ажиллагаа бүхий хичээлд урьж оролцуулна.
- Тухайн хичээлд хэд хоногийн өмнө багш бэлтгэж, бэлтгэлийг хангасан байна.
- Зочноор лекц уншуулах буюу хэтэрхий олон зүйл яриулахаас аль болох зайлсхийх хэрэгтэй.
- Тэнцвэртэй байдлыг хангах үүднээс гадны зочны мэдлэг, туршлагыг бодит амьдралын нөхцөл байдалтай харьцуулах ёстой.
- Өдөр тутмын амьдралд тохиолддог хатуу үнэн болон зөрчил бэрхшээлийг нууж үл болно. Аливаа асуудлыг авч үзэхдээ бодитой хандах ёстой.
- Хичээлийн дараа багш оюутануудтай хичээлийн ач холбогдол, хөндөгдөөгүй үлдсэн асуудал болон шийдлүүдийн талаар ярилцаж уг хичээлийг дүгнэнэ.
- Хичээлийн дараа багш болон оюутанууд тухайн зочин болон түүний удирдлагад талархалын захидал бичиж явуулах хэрэгтэй.

Мэтгэлцээний арга

Энэ арга нь оюутанд онолын болон хууль хэрэглээний илүү их шаардлага тавих

төдийгүй мэтгэлцэх асуудлаараа нэлээдгүй зүйлийг судлах, боловсруулалт хийх зэргээр мэдлэг, чадварыг бүтээх хамгийн сонгодог арга юм.

Мэтгэлцээний зорилго

Оюутанд тухайн сэдвийн хүрээнээс хамааран бие даан өөрийн үзэл бодлыг хамгаалах нотолгооны зайлшгүй шинжийг ухамсарлуулах, алиа асуудалд хандахдаа эрх зүйн хувьд зөв үнэлж дүгнэх, өөрийнхөө санааг бусдад зөв илэрхийлэх, илтгэх болон сонсох урлаг эзэмшүүлэх, асуудалд зөв зохистой хандах, хувилбарын шалгуурыг тогтоож сургахад оршино.

Мэтгэлцээний аргын дүрэм:

- Мэтгэлцээний талуудыг тэнцүү тооны оюутантайгаар хуваарилна. Нэг талд орж байгаа оюутны тоо 3-аас илүүгүй байна.
- Мэтгэлцэх асуудлуудыг болон тохиолдол хэргийн жишээг багш танилцуулж энэ дагуу багууд шодож асуудалд тайлбар дүгнэлтээ гаргахад бэлтгэнэ.
- Мэтгэлцээнийг нээлттэй явуулна.
- Талуудын аль нэг нь тайлбар нотолгоо, үндэслэлээ тайлбарлаж байхад нөгөө тал сонсох үүрэгтэй.
- Мэтгэлцэж буй асуудал, тавьсан зорилго, агуулгаас хальсан тохиолдолд багш мэтгэлцээнийг шууд зогсоож, хэлэлцэх ёстой асуудал руу чиглүүлнэ.
- Талууд нэг нэгнийгээ доромжлох, гүтгэх, зүй бус авир гаргасан тохиолдолд ийм явдал гаргасан талыг мэтгэлцээнд хангалтгүй оролцсонд тооцож мэтгэлцээнийг зогсооно.

Байр сууриа илэрхийлэх арга.

Энэ арга нь маргаантай асуудлыг хэлэлцэхэд ихээхэн ач холбогдолтой. Маргаантай асуудал нь хууль зүйн үндэслэлтэй, зөв хариулт байхгүй, 2 ба түүнээс дээш эсрэг байр суурьтай байх ёстой.

Зорилго: Үзэж буй сэдэв хэлэлцэж буй тохиолдлын хүрээнд олон янзын эсрэг байр сууриуд байдаг гэдгийг харуулах, оюутнуудад өөрсдийн байр сууриа илэрхийлэх, үзэл бодолдоо үнэнч итгэлтэй байх, болон харилцааны чадвараа амьдрал хэрэглэх боломж олгоход тустай. Түүнчлэн тухайн сэдвийг оюутан хэрхэн ойлгосныг үнэлж дүгнэх үүднээс хичээлийн эцэст хэрэглэж бас болно.

Хэрэгжүүлэх дараалал:

1. Ангийн булангуудад хэлэлцэх асуудлын сэдвээс хамаарч “Санал бүрэн нийлж байна”, “санал нийлж байна”, “шийдэгдээгүй буюу эргэлзэж байна”, “санал нийлэхгүй байна” эсвэл “маш зөв”, “зөв”, “буруу”, “маш буруу” гэсэн бичиг бүхий цаасыг дээрх дарааллаар байрлуулсан байна.
2. Энэ дасгал ажлыг хэрхэн хийх талаар дүрэм зохиогоод түүнийгээ хэлэлцэж батална. Дүрмийн жишээг дороос үзнэ үү.
3. Хэлэлцэж буй асуудлаар оюутнууд өөрсдийн байр суурийг илтгэсэн бичиг бүхий буланд очиж зогсоно.
4. Оюутнуудаас өөрсдийн байр суурийг тодруулж тайлбарлахыг хүснэ. Ижил сонголттой оюутнууд нэг багийг үүсгэж ярилцаад байр сууриа танилцуулахад бэлтгэнэ.
5. Багууд өөрсдийн байр сууриа тайлбарласны дараа хэн нэг нь байр сууриа өөрчилж, өөр буланд очихыг хүсэх эсэхийг асууна. Хэрэв өөрчлөхийг хүссэн



оюутан гарвал яагаад ингэх болсон шалтгааныг асууна.

6. Эсрэг баримтлалуудын дэвшүүлсэн үндэслэлээс аль нь хамгийн үнэмшилтэй байсныг багуудаас асууна.

Байр сууриа илэрхийлэхэд баримтлах дүрэм:

- Өөрийнхөө ярих ээлжийг хүлээх
- Нэг нь ярьж байхад бусад нь чимээгүй сонсох
- Шинэ санал үндэслэл гаргах,
- Бие биетэйгээ маргалдахгүйгээр соёлтой харьцах
- Өөрийнхөө байр суурийг хэзээ ч өөрчилж өөр буланг сонгож болно. Гагцхүү яагаад үзэл бодлоо өөрчлөх болсон шалтгаанаа хэлнэ.
- Бусад хүмүүсийн үзэл бодлыг сонсож хүндэтгэх. Бусад үзэл баримтлал, үндэслэлүүдээс илүү их таалагдсанаа тайлбарлах

Байр сууриа илэрхийлж сурахын тулд дагаж мөрдөх үе шат:

- Өөрийн үзэл бодлоо тодорхойлох
- Өөрийн үзэл бодлоо хамгаалсан нэг шалтгаанаа хэлэх
- Өөрийн хэлсэн шалтгаанаа тодруулах жишээ татах
- Өөрийн үзэл бодлоо нэгтгэх

ИХШХШЭЗҮЙН ХИЧЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Үнэлгээний зорилго

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн хичээлийн явцад олж авсан мэдлэг, түүнийг практик амьдралд ашиглах чадвар хийгээд оюуны үнэт зүйлийн баримжаалалд гарсан өөрчлөлтийг бодитойгоор үнэлэхэд уг хичээлийн үнэлгээний гол зорилго оршино.

Үнэлгээ нь бүхэлдээ зорилгодоо хүрч чадсан эсэхийг тогтооход чиглэгдэнэ.

Багш үнэлгээний дүнг дараахь зорилгоор явуулна:

- давтан судлах шаардлагатай эсэхийг тогтоох
- сургалтын үр дүнд оюутны мэдлэг, чадвар ямар түвшинд байгааг тодорхойлох
- багш өөрийгөө болон хичээл зорилгодоо хүрсэн эсэхийг үнэлэх

Үнэлгээний шалгуур

Үнэлэх зүйл	Үнэлэх жишиг шалгуур
Мэдлэг	- тодорхой асуултанд онолын үндэстэй хариулж чадаж байгаа эсэх - мэдлэгээ бусдад танилцуулж, тайлбарлаж чадаж байгаа эсэх - тухайн судлагдахууны тодорхойлолт гаргах, үндсэн ба үндсэн бусыг ялгах, харьцуулалт хийх, хамаарлыг тогтоох арга зүйг эзэмшсэн эсэх - хариулт болон үзэл бодлынхоо үндэслэл нотолгоог гаргаж байгаа байдал

Чадвар	- тодорхой онолын мэдлэгийг ашиглан (үндэслэл, нотолгоо болгох, жишээ баримт татах, тайлбарлах) тухайн асуудлыг тайлбарлаж, шийдвэр гаргаж чадаж байгаа эсэх - бодлого бодох, тохиолдол шийдвэрлэхдээ ИХШХШ эрх зүйн онолын мэдлэгээ ашиглаж чадаж байгаа эсэх - баримт бичиг боловсруулах чадварт суралцсан байдал - амаар болон бичгээр өөрийгөө илэрхийлэх чадварын хөгжлийн түвшин
Хандлага	- өөрийн үзэл бодол, байр суурь, үнэлгээ дүгнэлтийг илэрхийлж чадаж байгаа эсэх, ийнхүү илэрхийлэхдээ бусдын үзэл бодол, байр сууринд хүндэтгэлтэй хандаж, түүнээс үнэ цэнэтэй зүйлийг олж харж, авч чадаж байгаа эсэх - багийн гишүүн байх, бусдыг төлөөлөх чадварын хөгжилт - ялгаатай үзэл бодол байр сууринд хандах хандлага, түүнийг хүлээн зөвшөөрч байгаа байдал

Үүнээс гадна оюутны мэдлэг, чадварын түвшинг дараахь байдлаар ангилан, үнэлгээг ялгавартай тогтоож байх нь зүйтэй. Энэ байдлыг хамгийн энгийн буюу доод түвшнээс хамгийн төвөгтэй буюу дээд түвшинд хүрэх дарааллаар тодорхойлж болно. Үүнд:

Мэдлэг: Хамгийн доод түвшин. Ихэвчлэн тодорхой баримт, мэдээллийг тогтоож авах, сэргээн санах чадварыг авч үзнэ.

Ойлгоц: Бусдын олж тогтоосон зүйлийг оюутан наад захын түвшинд ойлгосон болохыг харуулж буй тайлбарлах, өөрийн үгээр илэрхийлэх, ургуулан бодож дүгнэлт хийх чадвар юм.

Хэрэглээ: Оюутан олж авсан ойлголт, зүй тогтол зэргийг урьд тохиолдож байгаагүй, шинэ нөхцөл байдал, мөн практикийн тодорхой тохиолдолд хэрэглэх чадвар.

Анализ: Мэдээллийг бүрэлдэхүүн хэсгүүдэд задлан хувааж, ялгаж зааглахыг хэлнэ.

Синтез: Бүрэлдэхүүн хэсгүүдийг нэгтгэн бүхэл зүйл болгохыг хэлнэ. Оюутан урьд нь байгаагүй бүтцийн шинэ хувилбарыг бүтээх чадвартай байх ёстой.

Үнэлэлт: Хамгийн дээд түвшин. Бусдын бүтээсэн зүйл, түүний логик бүтэц, үндэслэл нотолгоо нь бүрэн гүйцэд хийгдсэн эсэхэд үнэлгээ өгөх зэргийг ойлгоно.

Дээрхи чадварын түвшинг дараахи байдлаар ангилж болно. Үүнд:

Сургалтын зорилго	Оюутны чадвар
Заавал эзэмшсэн байвал зохих (essential)	Мэдлэг, ойлгоц, хэрэглээ
Эзэмшсэн байвал сайшаалтай (desirable)	Анализ, синтез, үнэлгээ

Сэдвийн жишиг үнэлгээ

Сэдвийн нэр: Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

/семинар 2 цаг/

Сэдвийн зорилго: Иргэний хэрэг үүсгэснээс хойш шүүх хуралдаан хүртэлх хугацаанд хэргийн оролцогчдын хүсэл, зорилгыг үндэслэн шүүх хялбаршуулсан журмаар маргааныг эцэслэн хянан шийдвэрлэх ажиллагааны талаар тодорхой **мэдлэгтэй** болсноор энэхүү ажиллагаанд хууль зүйн үнэлэлт, дүгнэлт өгч тухайн асуудлаар эрх зүйн туслалцаа үзүүлэх, хэрэг маргааныг шийдвэрлэх **чадвартай** болно.



Мэдлэг үнэлэх шалгуур:

- Сэдвийн хүрээнд хэрэглэгдэж буй гол нэр томьёоны агуулгыг мэдэж байгаа
- Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог, ач холбогдол, үндэслэл, журмыг сайтар судалж мэдсэн эсэх
- Хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн тохиолдолд түүнээс үүсэх эрх зүйн үр дагаврыг мэдэж байгаа эсэх
- Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн, зохигч эвлэрсэн, нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагч биелүүлсэн зэрэг нь хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндэслэл мөн тул эдгээрийн хоорондын ялгааг сайтар ойлгосон эсэх
- Эвлэрлийн гэрээ гуравдагч этгээдийн хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхлыг хөндөөгүй байна гэдгийг мэдэж байгаа эсэх

Чадвар үнэлэх шалгуур:

- Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх мэдлэгээ ашиглан энэхүү ажиллагааны онцлог шинж, мөн чанарыг нь илрүүлж, чадаж байгаа эсэх
- Иргэний хэрэг үүсгэснээс хойш хэргийн оролцогчид хялбаршуулсан журмаар хэргээ шийдвэрлүүлэхээр тохиролцсон тохиолдолд энэхүү ажиллагааг хууль зүйн үүднээс задлан шинжилж, төсөөтэй тохиолдлуудыг харьцуулан авч үзэж, энэ талаарх хэрэг маргааныг хянан шийдвэрлэх чадвар эзэмшсэн эсэх
- Тодорхой өгөгдөл ашиглан тайлбар хийх чадвартай эсэх
- Амаар болон бичгэн хэлбэрээр санаа бодооо чөлөөтэй илэрхийлж чадаж байгаа эсэх
- Хялбаршуулсан журмаар хэрэг шийдвэрлэсэн шүүгчийн захирамжинд үнэлэлт, дүгнэлт өгөх боломжтой эсэх

Хандлага үнэлэх шалгуур:

- Өөрийн үзэл бодлыг илэрхийлэх, бусдын үзэл бодолд хүндэтгэлтэй хандаж байгаа эсэх
- Амьдрал практикт байж болох хязгааргүй олон янзын боломж, хувилбарыг хуульд нэг бүрчлэн, нарийвчлан зааж өгөх боломжгүй, гагцхүү ерөнхий хүрээ заагийг тогтоосон байдаг тул үүнийг зөв ойлгож, тухайн тохиолдолд бүрт хууль зүйн талаас нь хандах хандлага төлөвшсөн эсэх
- Аливаа асуудалд хууль зүйн талаас нь хандах хандлага төлөвшсөн эсэх

Мэдлэг, чадварын түвшинг ялгавартай үнэлэх жишиг

Мэдлэг	25%
Ойлгоц	40%
Хэрэглээ	55%
Анализ	70%
Синтез	85%
Үнэлэлт	100%

Оюутан өөрийн мэдлэгийн түвшинг харуулах боломжийг олон арга хэлбэрээр нээлттэй болгох хэрэгтэй. Асуултад хариулах, багшаас асуулт асуух, бусад оюутны өгсөн хариултад тайлбар, шүүмж хэлэх, эссэ бичих, бодлого бодох, тохиолдол

шинжлэх, шинэлэг мэдээлэл цуглуулж, дүгнэлт хийх, түүнийгээ бусад оюутнуудад танилцуулах гэх мэт арга хэлбэр байж болно. Эдгээрийн аль ч хэлбэрийг сонгосон оюутны мэдлэгийг дээрхи зургаан түвшинд ялгавартай үнэлэх нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, бичгээр хийсэн ажлыг илүү хөдөлмөр зарцуулсан гэж үзэн илүүтэй үнэлэх хандлагаас зайлсхийвэл зохино.

Жишиг даалгавар:

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 16-р хороо Согоотын 59- 783 тоотод амьдрах Цацрал нь 2004 оны 3 дугаар сарын 19-ний өдөр “Дэвжил” Хадгаламж зээлийн хоршооны тэргүүн Нарантай гэрээ байгуулж, тэр өдрөө 350000 төгрөг, түүнээс хойш 7 хоногийн дараа 500000 төгрөгийг сар бүрийн 3 хувийн хүүтэй, 2 сарын хугацаатай хадгалуулжээ. Цацрал гэрээний хугацаа дуусаад олон хоног, сар өнгөрсөн боловч хадгалуулсан мөнгөө эргүүлэн авч чадахгүй байгаагаа нотолж, шүүхэд ханджээ. Цацрал хадгалуулсан 850000 төгрөг түүний хүү 450000 төгрөг нийт 1300000 төгрөг Нарангаас гаргуулж авахыг хүсэж улмаар гэрээний үүргийг хангуулахын тулд Хадгаламж зээлийн хоршооны тэргүүн Нарангийн эд хөрөнгийг битүүмжлэхийг шаардсан байна. Шүүх хэргийг хэлэлцэж эхлэхэд Цацралд олгох 1,300,000 төгрөгийг Наран 3 сарын хугацаанд багтааж төлөх график гаргаж, эвлэрлийн гэрээгээр уг тохиролцоог баталгаажуулахаар харилцан тохиролцох нь зүйтэй гэсэн санал гаргасныг Цацрал хүлээн зөвшөөрөв.

Шийдвэрлэх асуудал:

- Шүүгч хурлаа үргэлжлүүлэх үү?
- Шүүх Цацрал, Наран нарын эвлэрлийг баталгаажуулах боломжтой эсэхэд дүгнэлт хийнэ үү?

Хяналтын асуулт:

- Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай ойлголт, онцлог, ач холбогдлыг жишээн дээр ярилцана уу?
- Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндэслэлийг жагсаан бичиж хооронд нь харьцуулан ялгааг гаргана уу?
- Хялбаршуулсан журмаар хэрэг шийдвэрлэсэн тодорхой даалгавар ажиллан хэлэлцэнэ үү?
- Эвлэрлийн гэрээний төсөл бичиж, баталгаажуулна уу?
- Хялбаршуулсан журмаар хэрэг шийдвэрлээд шүүгчээс гаргах захирамжийн төслийг бичнэ үү?



ХОЁРДУГААР ХЭСЭГ

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЭРХ ЗҮЙН ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

I БҮЛЭГ. ИХШХШЭЗ-Н ҮНДСЭН АСУУДАЛ

ИХШХШЭЗҮЙН ЗОХИЦУУЛАХ ЗҮЙЛ, ЗОХИЦУУЛАЛТЫН АРГА, ЭРХ ЗҮЙН СИСТЕМД ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

Сэдвийн агуулга:

- ИХШХШЭЗүйн ойлголт
- ИХШХШЭЗүйн зохицуулах зүйл
- Зохицуулалтын арга
- ИХШХШЭЗ ба бусад салбар эрх зүй

Сэдвийн зорилго: ИХШХШЭЗүйн ойлголт, зохицуулах зүйл, арга, эх сурвалжийн талаар шинжлэх ухааны онолын мэдлэгтэй болох, материаллаг эрх зүйн хэм хэмжээ, процессын эрх зүйн хэм хэмжээний мөн чанарыг, бусад салбар эрх зүйтэй харьцуулах, тодорхойлох чадвартай болно.



Нэр томъёоны тайлбар

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй - Шүүхээс иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн хэм хэмжээний нийлбэр цогц.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн зохицуулах зүйл-

Бусдын гаргасан нэхэмжлэл, хүсэлт, гомдлыг шүүх хүлээн авч иргэний хэрэг үүсгэн хянан шийдвэрлэхтэй холбогдсон иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдах нийгмийн харилцаа.

Зохицуулалтын арга - Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн харилцааг зохицуулахад хэрэглэгдэх хууль зүйн хэрэгсэл, арга барилуудын нийлбэр цогц.

Императив арга - ИХШХША-нд оролцогчдод заавал биелүүлэх үүргийг хүлээлгэх буюу хуульд заасан нөхцөл, журмын дагуу албадлагын аргыг хэрэгжүүлдэгээр илэрнэ.

Диспозетгав арга - ИХШХША-ны оролцогчид хэрэг маргааны тодорхой чиглэл буюу асуудлаар хоорондоо харилцан тохиролцож, зөвшилцөх гэсэн ойлголт. Өөрөөр хэлбэл зохигчид эвлэрэх, нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзах, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн, давж заалдах, хяналтын гомдол гаргасан этгээд шүүх хуралдаанаас өмнө гомдлоосоо татгалзах.

Шүүхэд мэдүүлэх эрх - Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзэж байгаа аливаа этгээд уг эрхээ хамгаалуулахаар шүүхэд нэхэмжлэл, хүсэлт, гомдол гаргах хэлбэрээр шүүхэд мэдүүлэх эрхтэй.

Иргэн, хуулийн этгээд зөрчигдсөн эрх, ашгаа хамгаалуулахаар шүүхэд мэдүүлэх эрхтэй бөгөөд энэхүү мэдүүлэх эрхийг хэрэгжүүлэх гол салбар бол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй юм. ИХШХШЭЗүй нь өөрийн зохицуулах зүйл, зохицуулалтын аргатай. ИХШХШЭЗүйн зохицуулах зүйл нь иргэний хэргийг шийдвэрлэх явцад үүсдэг нийгмийн харилцаа байна.

Зохицуулалтын арга: ИХШХШЭЗ нь императив /захирах/ ба диспозитив /зөвшмөл/ аргаар нийгмийн харилцааг зохицуулдаг.

Императив арга:

ИХШХШЭЗүйн харилцаанд оролцогчид хуульд заасан нөхцөл журмын дагуу албадлага хэрэглэж хэрэгждэг. Тухайлбал: Шүүхэд хүрэлцэн ирэх мэдэгдэх хуудас авсан хэргийн оролцогч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол шүүгч захирамжаар албадан ирүүлнэ. Тухайлбал: Иргэний хэргийг зөвхөн хуульд заасан хугацаа, журмыг баримтлан шийдвэрлэх, тэрхүү журмыг шүүх болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчид заавал биелүүлэх нь императив арга юм.

Диспозитив арга:

ИХШХШЭЗүйн харилцаанд оролцогчид хуульд зааснаар хэрэг маргааны тодорхой асуудлаар хоорондоо харилцан зөвшилцөж тохиролцож болно гэсэн ойлголт. Тухайлбал: зохигчид эвлэрэх, нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзах, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх, давж заалдах гомдол гаргах гаргасан



Бусад салбэр эрх зүйгээс ялгагдах нь

Маргаантай харилцаа байна

Шүүхэд маргаан шийдвэрлэх журам, үйл ажиллагааны дарааллыг ИХШХШТХ-иар зохицуулсан байдаг

Нэг талд нь зайлшгүй шүүх оролцдог

ИХШХШТХ-иар зохицуулсан журмыг шүүх болон оролцогчид заавал дагаж баримтладаг

Нэг нь нөгөөгөө нөхцөлдүүлсэн үе шатуудыг дамжиж хэрэгждэг үйл ажиллагаа байна.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа	Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
- Нотлох баримтыг зохигч, хэргийн оролцогчид өөрсдөө цуглуулж, гаргаж өгдөг - Иргэний хэрэг үүсэх захирамж гаргаснаас хойш 60 хоногийн дотор хэргийг хянан шийдвэрлэнэ. - Иргэн,хуулийн этгээд зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр шүүхэд шууд ханддаг. - Тэгш эрхтэй субъектүүдийн хооронд буюу хувийн эрх зүйн харилцаанаас үүссэн маргаан байдаг.	- Нотлох баримтыг захиргааны хэргийн шүүх өөрөө цуглуулж, нотлох үүрэгтэй. - Нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш нийслэлд 30 хоног, орон нутагт 40 хоногийн дотор хэргийг хянан шийдвэрлэнэ. - Иргэн, хуулийн этгээд захиргааны хууль бус актын талаар харъяа дээд шатны байгууллагад нь хандаж урьдчилсан журмаар шийдвэрлүүлсний дараа шүүхэд ханддаг. - Захиргааны байгууллага, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээдийн хооронд нийтийн эрх зүйн харилцаанаас үүссэн маргаан байдаг.



Хяналтын асуулт

- ИХШХШЭЗүйн зохицуулах зүйлийн онцлогийг тайлбарлана уу?
- ИХШХШЭЗ бусад салбар эрх зүйгээс ялгагдах гол шинжүүдийг нэрлэнэ үү?
- Зохицуулалтын арга ба зохицуулах зүйл / императив ба диспозитив аргын жишээ олж тайлбарлах / ийг тодорхойлно уу?
- ИХШХШЭЗүйг бусад процессын эрх зүйтэй харьцуулан хэлэлцэнэ үү?
- ИХШХШЭЗүйн хэрэгцээ, шаардлага, ач холбогдлыг дүгнэнэ үү?



Бодлого

1. Нямбуу, Халтар нар Нийслэлийн Налайх дүүргийн 1-р хорооны оршин суугчид ба 1978 онд эцгээс нь өв залгамжлалаар тэдний өмчлөлд нь шилжсэн 3 өрөө орон сууцны талаар маргалдсан. Нямбуу дүүргийн шүүхэд очиж, нэгэн шүүгчид маргааны талаар амаар танилцуулсан ба төлбөрийн чадваргүй учраас өмгөөлөгчийн туслалцаа авах боломжгүй байгаа, мөн түүнчлэн өөрөө хуульд заасан журмын дагуу нэхэмжлэлийг бичгээр бичих чадваргүй тухайгаа ч тайлбарлажээ.

Энэ тохиолдолд:

- Оюутан бүр өөрийгөө шүүгч хэмээн үзээд Нямбууд ямар тайлбар өгөх вэ?
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн харилцаа үүссэн эсэхэд дүгнэлт хийнэ үү?

2. Иргэн Дорж хүүхэд асрах төвийн 3 настай Сэргэлэнг үрчилж авах тухай хүсэлтээ өөрийнхөө оршин суугаа газрын харъяа шүүхэд гаргажээ. Шүүх хүсэлтийг хүлээн авахаас татгалзаж, шүүгчийн захирамж гаргасан байна. Хүүхэд үрчлэх асуудлыг шүүх шийдвэрлэх боломжгүй, шүүхээс өөр байгууллага Доржийн хүсэлтийг шийдвэрлэх ёстой гэж захирамжид заажээ.

Энэ тохиолдолд:

- Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдсан эсэхэд дүгнэлт хийнэ үү?
- ИХШХШЭЗ-н зохицуулах зүйлийг тодорхойлно уу?



Даалгавар:

- Шүүхийн практикт шийдвэрлэгддэг иргэний хэргийн жишээ 5-ыг олж, иргэний хэргийн талаарх ойлголтоо бататгах
- Шүүхээр иргэний хэрэг шийдвэрлэх ажиллагаа, эрүүгийн хэрэг шийдвэрлэх ажиллагаанаас ялгаатай болохыг тодруулж ойлгох.
- Шүүхэд гомдол, нэхэмжлэл, хүсэлт гаргах эрх ба иргэний хэрэг үүсгэх үндэслэлийг мэдэх



Эх сурвалж:

- Монгол Улсын Үндсэн хуулийн 16.14-р зүйл
- ИХШХШТ Хуулийн 1-р бүлэг



ИХШХША-НЫ ОЙЛГОЛТ, ТӨРӨЛ, ҮЕ ШАТ

Сэдвийн зорилго: ИХШХШ ажиллагааны ойлголт, төрөл, үе шатны талаар мэдлэгтэй болох, ИХШХША-ны үндсэн мөн чанарыг түүний төрөл, үе шат бүрт зөв тодорхойлох **чадвартай** болох, хууль хэрэглэхдээ энэ төрлийн ажиллагааны үндсэн зохицуулалтыг удирдлага болгодог **хандлага** төлөвшинө.

Сэдвийн агуулга:

- ИХШХША -ны ойлголт
- ИХШХША -ны төрөл
- ИХШХША -ны үе шат



Нэр томъёоны тайлбар

Шүүхэд мэдүүлэх эрх - Монгол Улсын Хууль, Монгол Улсын нэгдэн орсон Олон Улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөө хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзэж байвал аливаа этгээд уг эрхээ хамгаалуулахаар хуульд заасан журмын дагуу шүүхэд нэхэмжлэл, гомдол, хүсэлт гаргах хэлбэрээр мэдүүлэх эрхтэй

ИХШХША Ажиллагаа - Иргэн, хуулийн этгээдээс зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар шүүхэд нэхэмжлэл, гомдол хүсэлт гаргах, шүүх түүнийг хүлээн авч хянан шийдвэрлэх цаг хугацаа, үйл явцыг хамарсан ойлголт юм.

Нэхэмжлэл - Энэ нь хууль болон гэрээний үүргийг биелүүлээгүйгээс өөрт учирсан эдийн ба эдийн бус хохирлоо гэм буруутай этгээдээс гаргуулахаар шүүхэд хандаж гаргасан эрх баримт бичиг юм. Нэхэмжлэл нь иргэний хэрэг үүсгэх үндэслэл мөн ба түүнийг нэхэмжлэлээр үүсэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гэнэ.

Гомдол - Захиргааны байгууллага, шүүх, прокурор, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон бусад аж ахуйн нэгж, байгууллага тэдгээрийн албан тушаалтны үйл ажиллагаа болон шийдвэр нь бусдын хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзэж, уул эрх ашгаа сэргээлгэхээр шүүхэд хандаж гаргасан баримт бичиг. Гомдлоор авч хэлэлцэх хэргийн субъект нь нэг талд буруу шийдвэр гаргасан төрийн захиргаа, шүүх, прокурор, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон бусад байгууллага аж ахуйн нэгж, тэдгээрийн албан тушаалтан, нөгөө талд тэдгээрийн үйл ажиллагаа, буруу шийдвэрийн улмаас хохирсон иргэн, хуулийн этгээд байна. Гомдлоор үүсэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ИХШХШТХ хуулийн 14 дүгээр бүлэгт зааснаар зохицуулна.

Хүсэлт - Энэ нь ямар нэгэн эд хөрөнгө нэхэмжлээгүй, иргэн, хуулийн этгээдийн эрх, эрх чөлөө зөрчигдөөгүй, харин эрх Зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоолгохоор шүүхэд гаргасан баримт бичиг юм. Хүсэлтээр үүсэх хэргийг онцгой ажиллагааны улмаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гэнэ.

Шүүхэд иргэний хэрэг үүсгэх - Шүүх нэхэмжлэл, гомдол хүсэлтийг хүлээн авч, тэдгээр нь хуулийн шаардлага хангасан гэж үзвэл иргэний хэрэг үүсгэн захирамж гаргана. Иргэний хэрэг үүсгэх нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бие даасан үе шат юм.

Анхан шатны шүүх - Иргэний хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх сум буюу сум дундын, дүүргийн шүүх

Давж заалдах шатны шүүх - Иргэний хэргийг давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэх аймаг, нийслэлийн шүүх

Хяналтын шатны шүүх - Иргэний хэргийг хяналтын гомдлын үндсэн дээр шийдвэрлэдэг Улсын дээд шүүх.

Шүүхийн шийдвэр - Анхан шатны шүүх иргэний хэргийг хянан шийдвэрлээд шүүх хуралдаанаас гаргасан баримт бичгийг шийдвэр гэнэ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэл - Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр, магадлал, тогтоолыг төлбөр төлөгч сайн дураараа биелүүлэх, хэрэв биелүүлэхгүй бол эрх бүхий байгууллага албадан биелүүлдэг.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа нь нэг нөгөөгөөсөө урган гарсан, хоорондоо холбоотой, эрэмбэ дараалал бүхий үйл ажиллагааны нийлбэр байна.

ИХШХШ Ажиллагааны онцлог:

- Шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагаа зөвхөн ИХШХШТ Хуулиар зохицуулагдана
- Тодорхой зорилго, чиглэл бүхий үйл явц байна
- ИХШХШТ Хуулиар тодорхойлогдсон журмыг шүүх болон бусад оролцогчид сахин биелүүлж баримтлах үүрэгтэй.
- ИХШХШ Ажиллагаа нь тодорхой үе шатыг дамждаг ба үе шат бүхэн өөрийн онцлогтой.

ИХШХШ Ажиллагааны зорилт:

- Эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх
- Иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх
- Хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хамгаалах.

ИХШХШ Ажиллагааны төрөл:

ИХШХШ Ажиллагааг иргэн, хуулийн этгээдээс шүүхэд хандаж гаргасан нэхэмжлэл, өргөдөл, маргааны шинж байдлыг харгалзан дараах төрөлд ангилж үздэг.

Нэхэмжлэлээр үүсэх ажиллагаа - Эд хөрөнгөтэй холбоотой асуудлаар / эд хөрөнгө шаардах, өмчлөх, захиран зарцуулах эрхээ сэргээлгэх гэх мэт / иргэн, хуулийн этгээдийн гаргасан нэхэмжлэлээр үүсэх ажиллагаа бөгөөд дийлэнх нь ИЭЗ-н харилцаа /таваар мөнгөний шинжтэй/ зөрчсөнтэй холбоотой байна. Нэхэмжлэлийг ИХШХШТХ-ийн 61, 62-р зүйлд заасны дагуу гаргана.



Хүсэлтээр авч хэлэлцэх ажиллагаа - Иргэдийн хүсэлтээр үүсэх ИХШХШ ажиллагаа юм.


Онцгой ажиллагааны журмаар авч хэлэлцэх хэрэг

- **Ямар нэгэд хөрөнгө** нэхэмжлээгүй иргэн, хуулийн этгээдийн эрх зөрчигдөөгүй, харин ИХШХШТХ-ийн 133-р зүйлд заасан эрх зүйн ач холбогдол бүхий нөхцөл байдлыг хүлээн зөвшөөрүүлэх, сэргээж тогтоох агуулгатай байдаг онцлогтой.
- **Маргалдагч тал байхгүй.**
- **Сонирхогч этгээдийн хүсэлтээр** /сураггүй алга болсонд тооцох, улсад ажилласан жил тогтоолгох гэх мэт/ ИХШХША үүсдэг байна.

Гомдлоор авч хэлэлцэх ажиллагаа - Төрийн захиргаа, шүүх, прокурор, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаах болон бусад байгууллага, аж ахуйн нэгж, тэдгээрийн албан тушаалтны шийдвэр үйл ажиллагааны талаар иргэн, хуулийн этгээдээс гаргасан гомдлоор үүсэх ИХШХША мөн. Энэ нь эд хөрөнгө, цалин хөлс шаардсан шинжтэй байж болно. Энэ ажиллагааны үед гомдол гаргагч иргэн, төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны хооронд маргаан үүсч байдаг ажээ. Харьяаллын хувьд ихэнх тохиолдолд гомдлыг юуны өмнө дээд шатны байгууллагын шийдвэр гарсны дараа шүүх шийдвэрлэнэ.

ИХШХША-ны үе шат:

ИХШХША ажиллагааны тодорхой зорилгыг хангахад чиглэгдсэн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог хэсгүүдийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат гэнэ.





Хяналтын асуулт

- Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн шинжийг тодорхойлно уу?
- Нэхэмжлэлээр үүсэх ажиллагааны онцлогийг жишээ гарган тайлбарлана уу?
- Гомдлоор үүсэх ажиллагааны онцлогийг нэрлэнэ үү?
- Хүсэлтээр үүсэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар дүгнэлт гаргана уу?
- ИХШХШ Ажиллагааны үе шат бүрийн онцлогийг тодорхойлно уу?



Сорил

1. Иргэн Д нь ХААН банкнаас 6 сарын хугацаатай 3 сая төгрөгийг сарын 3% -ийн хүүтэй авчээ. Зээлийн хугацаа дуусч 3 сар өнгөрөхөд Д уг зээлээ, хүүгийн хамт төлөөгүй учраас банк шүүхэд нэхэмжлэл гаргаж зээл, зээлийн хүү 3540000 төгрөгийг Д-ээс гаргуулж өгөхийг хүссэн. ИХШХША-ны төрлийг тодорхойлно уу?
 - а. Нэхэмжлэлээр үүсэх ажиллагаа
 - б. Гомдлоор үүсэх ажиллагаа
 - в. Хүсэлтээр үүсэх ажиллагаа
2. Иргэн Ч БЗД-н ЗДТ газар жолооч ажилтай байсан ба тэрээр ээлжийн амралттай яваад ирэхэд нь ажлаас халсан байв. Ч. Ажилдаа эргүүлэн тогтоолгохоор шүүхэд хандсан. ИХШХША-ны төрлийг тодорхойлно уу?
 - а. Нэхэмжлэлээр үүсэх ажиллагаа
 - б. Гомдлоор үүсэх ажиллагаа
 - в. Хүсэлтээр үүсэх ажиллагаа
3. Иргэн Х СБД-н шүүхэд хандаж 1976-1979 онд улсын төв номын санд ажиллаж байсан юм. Тухайн үед хөдөлмөрийн дэвтэрт бичилт хийлгээгүй ба одоо тэтгэвэрт гарах гэхэд ажилласан жил хүрэхгүй байна. Иймд миний 1976-1979 онд улсад ажиллаж байсан байсныг тогтоож өгнө үү? гэжээ. Иргэн Х шүүхэд гомдол, нэхэмжлэл, хүсэлтийн алийг гаргасан бэ?
 - а. Гомдол
 - б. Нэхэмжлэл
 - в. Хүсэлт



Бодлого

Хан - Уул дүүргийн татварын улсын байцаагч Хандаа иргэн Батдоржид холбогдох нэгэн нэхэмжлэлийг тус шүүхэд гаргасан байна. Хандаа нэхэмжлэлдээ иргэн Батдорж нь Үндэсний татварын Ерөнхий газрын харьяа улсын бүртгэлийн албанд бүртгүүлэлгүйгээр хувийн хөдөлмөр эрхэлж, аж ахуйн үйл ажиллагаа явуулж, татвараас зайлсхийж байгаа талаар дурьджээ.

Энэ тохиолдолд:

- Шүүх иргэний хэрэг үүсгэн хэргийг шийдвэрлэх боломжтой эсэхэд дүгнэлт хийнэ үү?
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогийг нэрлэнэ үү?



Даалгавар:

- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх ойлголт, төрлийн талаар хэлэлцэж, тус бүр дээр жишээ олж тайлбарлах
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат тус бүрийн ялгаатай байдлыг гаргаж тайлбарлах.
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог, ач холбогдол, хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох



Эх сурвалж:

- Үндсэн хууль
- ИХШХШТ Хуулийн 1,133,156-р зүйл.

ИХШХШЭЗҮЙН СУРВАЛЖИЙГ ТАНИН МЭДЭХИЙН АЧ ХОЛБОГДОЛ

Сэдвийн зорилго: ИХШХШЭЗүйн эх сурвалжийн талаар ойлголт мэдлэг эзэмшин, ИХШХШЭЗүйн эх сурвалжийг процессын бусад эрх зүйн эх сурвалжаас ялгах, тодорхойлох, **чадвартай** болж эрх зүйн эх сурвалжийг ашиглаж сурна.

Сэдвийн агуулга:

- ИХШХШЭЗүйн эх сурвалжийн ойлголт, үндсэн шинж
- ИХШХШЭЗүйн эх сурвалжийн төрөл, ангилалт,
- ИХШХШЭЗ эх сурвалж болох хууль, хууль тогтоомжууд
- Хуулийг хэрэглэх ба тайлбарлах нь.
- Олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх
- Хэргийг хянан шийдвэрлэхээс татгалзахгүй байх шүүхийн үүрэг



Нэр томъёоны тайлбар

ИХШХШЭЗүйн эх сурвалж: ИХШХШЭЗүйг бүрдүүлэгч хэм хэжээнүүдийн илрэн гарах гадаад хэлбэр юм.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн хэм хэмжээ -

Энэ нь төрийн эрх бүхий байгууллагаас шүүх иргэний хэргийг хянан шийдвэрлэхтэй холбоотой нийгмийн харилцааг зохицуулах зорилгоор батлан гаргасан заавал дагаж мөрдөгдөх шинжтэй хэм хэмжээний горим журам юм

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хууль тогтоомж - Монгол Улсын Үндсэн хууль, ИХШХШТХууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актын нийлбэр юм.

Олон улсын гэрээ - Монгол Улс, МУ-ын Их хурал болон Монгол Улсын Засгийн газраас гадаадын нэг буюу хэд хэдэн улс, тэдгээрийн Засгийн газар, олон улсын байгууллагатай тодорхой асуудлаар харилцан эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлон тогтоосон олон улсын эрх зүйгээр зохицуулагдах хоёр буюу олон талын бичгээр үйлдсэн тохиролцоо. ИХШХШТХуулийн 2 дугаар зүйлийн 2.2-д зааснаар Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

Хуулийг төсөөтэй хэрэглэх - Тухайн маргаантай харилцааг зохицуулсан хууль байхгүй бол шүүх төсөөтэй харилцааг зохицуулж байгаа хуулийн хэм хэмжээг хэрэглэнэ. Хэрэв тийм хууль байхгүй бол шүүх Үндсэн хуулийн агуулга, ерөнхий үндэслэл, үзэл санаанд нийцүүлэн шийдвэрлэнэ.

ИХШХШЭЗүй нь өөрийн эх сурвалжтай. ИХШХШЭЗүйн гол эх сурвалжид Монгол Улсын Үндсэн хууль зүй ёсоор хамаарна. Үндсэн хуульд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тусгай, тулгуур зарчмууд, шүүхийн бүтэц, үндсэн тогтолцоо, Монгол Улсын Дээд шүүхийн бүтэц, бүрэн эрх, шүүгчид тавигдах шаардлага зэргийг зааж өгсөн. Үндсэн хуулийн Хүний эрх, эрх чөлөө гэсэн хоёрдугаар бүлэгт хүний эрх, эрх чөлөөг шүүхээр хамгаалах хамгаалалтыг баталгаажуулсан бол Монгол Улсын



төрийн байгуулал гэсэн гуравдугаар бүлгийн дөрөвдүгээр хэсэг шүүх эрх мэдэлд зориулагдан "шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ" гэж зааж өгсөн. Мөн түүнчлэн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдах, шүүх хэргийг ил таслан шийдвэрлэх, иргэний хэрэг маргааны хамтын зарчмаар хянан шийдвэрлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг монгол хэлээр явуулах зэрэг гол зарчмууд Үндсэн хуульд тусгалаа олсон.

ИХШХШЭЗ-н эх сурвалжид Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль хамаарна. Энэхүү хуулиар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нэг бүрчлэн зохицуулдаг ба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах зарчим, анхан шат, давж заалдах, хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх журмыг зохицуулсан байна.

ИХШХШТХууль 2002 оны 1-р сарын 10-ний өдөр батлагдаж, мөн оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн. Доорх бүдүүвчээс хуулийн бүтцийг үзнэ үү?

ИХШХШТХуулийн бүтэц / бүлэг /	1. Бүлэг	Нийтлэг үндэслэл / 1-11 дүгээр зүйл /
	2. Бүлэг	Иргэний хэрэг үүсгэх үндэслэл, хэргийн харьяалал /12-21-р/
	3. Бүлэг	Бүлэг Хэргийн оролцогч / 22-36- р зүйл /
	4. Бүлэг	Нотлох баримт / 37-51- р зүйл /
	5. Бүлэг	Шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамж / 52-60-р зүйл/
	6. Бүлэг	Нэхэмжлэл гаргах, түүнийг хүлээн авах / 61-73-р зүйл /
	7. Бүлэг	Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа / 74-75-р зүйл
	8. Бүлэг	Шүүх хуралдааны бэлтгэл хангах /76-80- р зүйл /
	9. Бүлэг	Шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдааны оролцогч, хуралдааны нийтлэг журам / 81-97- р зүйл /
	10. Бүлэг	Анхан шатны шүүх хуралдааны дэг / 98-114- р зүйл /
	11. Бүлэг	Шийдвэр, түүнийг гаргах / 115-124-р зүйл /
	12. Бүлэг	Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа /125-132- р зүйл /
	13. Бүлэг	Хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагаа / 133-155-р зүйл/
	14. Бүлэг	Гомдлоор авч хэлэлцэх хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа /156-160-р зүйл /
	15. Бүлэг	Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа / 161-171 -р зүйл /
	16. Бүлэг	Хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа/72-178-р зүйл /
	17. Бүлэг	Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах /179-182- р Зүйл /
	18. Бүлэг	Шүүхийн шийдвэр гүйцэтгэл / 183-188- р зүйл
	19. Бүлэг	Олон улсын иргэний эрх Зүйн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа /189-194-р зүйл
	20. Бүлэг	Бусад зүйл /195- р зүйл /

Мөн түүнчлэн Монгол Улсын Шүүхийн тухай хууль, Прокурорын байгууллагын тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль нь ИХШХШЭЗ-н эх сурвалжид хамаарна. Эдгээр хуулиуд тус эрх Зүйн эх сурвалж болохын учрыг сайтар судлах шаардлагатай.

ИХШХШЭЗүйн хэм хэмжээ хуулиар тодорхойлогдсон цаг хугацааны хүрээнд үйлчлэх ба орон зай, нутаг дэвсгэрийн хувьд Монгол улсын нутаг дэвсгэрт, хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хамгаалуулахаар шүүхэд хандсан Монгол Улсын иргэн, гадаадын иргэн харьяалалгүй хүн, хуулийн этгээдэд хүчин төгөлдөр үйлчилнэ.

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенци ИХШХШЭЗүйн эх сурвалж болно. Энэхүү эх сурвалжид 1999 оны 07 дугаар сарын 21-ний өдөр Монгол улс нэгдэн орсон, 1954 оны 03 дугаар сарын 01-ний өдөр баталж, 1957 оны 04 дүгээр сарын 12-ний өдөр хүчин төгөлдөр болсон Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай Гаагийн конвенци хамаарна. Энэхүү конвенцид иргэний болон худалдааны хэргийн талаарх баримт бичгийг дамжуулан гардуулах, үнэ төлбөргүй эрх зүйн тусалцаа үзүүлэх зэрэг ажиллагааг шүүх хэрхэн хэрэгжүүлэх, шүүхийн зардлыг хариуцах журам, иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийг хэрхэн гүйцэтгэх журам зэргийг тусгаж өгсөн. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хуулийн нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилнэ.



Хяналтын асуулт

1. ИХШХШЭЗүйн эх сурвалжийг процессын бусад эрх зүйн эх сурвалжаас ялгахын хамт шилжүүлэн хэрэглэгддэг зүйл, заалтыг тодорхойлно уу?
2. Хууль, хуульчилсан акт, олон улсын гэрээ нь ямар нөхцөлд ИХШХШЭЗүйн эх сурвалж болохыг жишээн дээр тайлбарлана уу?
3. ИХШХШТХ-ийн зүйл, заалтыг процессын бусад эрх зүйд хэрэглэж болох уу? Тухайлбал: Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг үндэслэж, иш татаж хэрэглэж болох уу? Жишээн дээр тайлбарлана уу?
4. Үндсэн хууль ИХШХШЭЗ нь эх сурвалж болохыг тодорхойлно уу?
5. ИХШХШТХуулийн гол зорилго ба зохицуулалтын талаар дүгнэлт гаргана уу?
6. Өмгөөллийн тухай хуулийн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулсан холбогдох заалтуудыг олж тайлбарлана уу?
7. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль эх сурвалж болохыг тодорхойлно уу?
8. Олон Улсын гэрээ эх сурвалж болох талаар хэлэлцэнэ үү?
9. Прокурорын байгууллагын тухай хууль эх сурвалж болохын учрыг тайлбарлана уу?
10. Шүүхийн тухай хууль эх сурвалж болох талаар хэлэлцэж, саналаа хэлнэ үү?



Сорил

1. Шүүх тухайн маргаантай харилцааг зохицуулсан хууль байхгүй бол хэргийг хэрхэн шийдвэрлэх вэ?
 - а. Шүүгч нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах тухай захирамж гаргана
 - б. Шүүгч төсөөтэй харилцааг зохицуулж байгаа хуулийг хэрэглэж, хэргийг шийдвэрлэнэ
 - в. Шүүгч тухайн маргаантай харилцааг зохицуулсан хууль байхгүй байгаа тухай УИХ-д санал оруулна.
 - г. Шүүгч хэргийг шийдвэрлэхээс татгалзаж, УДШүүхэд хэргийг хүргүүлнэ.
2. Шүүгчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай нь холбогдуулан айлган сүрдүүлж, амь биед нь халдана гэж заналхийлсэн этгээдэд ямар хуулиар хариуцлага хүлээлгэх вэ?
 - а. Шүүхийн тухай хууль
 - б. Эрүүгийн хууль
 - в. Захиргааны хариуцлагын тухай хууль
 - г. ИХШХШТХууль
3. Тодорхой хэргийг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль нь Үндсэн хуульд нийцэхгүй байна гэж үзвэл шүүгч:
 - а. УИХ-д санал оруулна
 - б. Үндсэн хуулийн цэцэд санал оруулна
 - в. Монгол Улсын Дээд шүүхэд санал оруулна
 - г. Хэргийг хүлээн авахаас татгалзаж, захирамж гаргана.
4. Үндсэн хуулиас бусад хуулийг нэг мөр хэрэглэх талаар УДШ-ээс гаргадаг тайлбар ИХШХШЭЗ-н эх сурвалжид хамаарах уу?
 - а. Тийм. Учир нь _____
 - б. Үгүй. Учир нь _____
5. Шүүхийн Ерөнхий зөвлөл, түүний бүгэц, үйл ажиллагаа, бүх шатны шүүх, шүүгчдийн бүрэн эрх, үйл ажиллагааны баталгааг аль хуулиар зохицуулах вэ?
 - а. ИХШХШТХууль
 - б. Үндсэн хууль
 - в. Шүүхийн тухай хууль
 - г. Бусад хууль



Бодлого

Төмөрсүх өөрийн өмчлөлийн орон сууцаа садангийн ах Батсүхэд хөлсөлжээ.

Батсүх сар бүр байр хөлсөлсний төлбөрт 200000 төгрөг төлөх үүрэг хүлээсэн боловч, гэрээний үүргээ үл биелүүлсэн тул Төмөрсүх түүнээс 1сая төгрөгийг орон сууц хөлсөлсний төлбөрт гаргуулах мөн түүнчлэн орон сууцнаас албадан нүүлгэн гаргуулах тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргажээ. Шүүгч Бадам нэхэмжлэлийг хүлээн авч иргэний хэрэг үүсгэсэн ба хариуцагч Батсүх дуудсан цагт ирээгүй гэсэн үндэслэлээр хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэж, нэхэмжлэлийн шаардлагыг хангасан шийдвэр гаргасан байна.

Энэ тохиолдолд:

- Хэргийг шийдвэрлэсэн шүүгч ИХШХШТХуулийн ямар нэгэн заалтыг зөрчсөн эсэхэд дүгнэлт гаргана уу?



Даалгавар:

- ИХШХШЭЗ эх сурвалжийг бусад салбар эрх зүйн эх сурвалжаас ялгах нь.
- Үндсэн Хуулийн 2, 3-р бүлгийг судлах ИХШХША-тай холбоотой заалтуудыг
- ИХШХШТХуулийн бүлэг, хэсэг бүртэй нэг бүрчлэн танилцаж ойлголт авах.
- Шүүхийн тухай хууль Өмгөөллийн хууль, Прокурорын байгууллагын тухай хуулийн холбогдох заалтуудыг судлах



Эх сурвалж:

- Үндсэн Хууль 2-р бүлэг, 3-р бүлэг
- ИХШХШТХууль 2002 он
- Шүүхийн тухай хууль 2002 он
- Өмгөөллийн хууль 2002
- Прокурорын байгууллагын тухай хууль 2002
- Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль. 1993 он
- Олон Улсын гэрээ конвенцүүд / иргэний хэрэгтэй холбоотой./



ИХШХШ АЖИЛЛАГААНЫ ХУГАЦАА

Сэдвийн зорилго: Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааны эрх зүйн зохицуулалтын талаар мэдлэгтэй болох, хугацааг уг ажиллагааны үе шат бүрт зөв тодорхойлох чадвартай болох, хэрэг маргааныг хуульд заасан хугацаанд шийдвэрлэдэг болох хандлага төлөвшинө.

Сэдвийн агуулга:

- Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааны ойлголт, ангилал, онцлог
- Хуулиар тогтоосон хугацаа
- Анхан шатны шүүхийн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа
- Давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа
- Анхан шатны шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт гомдол гаргах хугацаа
- Хяналтын шатны шүүхэд иргэний хэрэг хянан шийдвэрлэх хугацаа




Нэр томъёоны тайлбар

Иргэний хэргийг шийдвэрлэхэд зайлшгүй дагаж баримтлах, шүүх болон хэргийн оролцогчдоос тодорхой үйл ажиллагаа гүйцэтгэх ба гүйцэтгэж болох цаг хугацааны үеийг иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа гэнэ.


Хуулиар тогтоосон хугацаа - Иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад хуулиар тогтоож өгсөн хугацааг ойлгоно. Тухайлбал: Иргэний хэрэг үүсгэсэн захирамж гаргасан өдрөөс хойш хэргийг 60 хоногт багтаан шийдвэрлэх.

Шүүхээс тогтоосон хугацаа - Иргэний хэргийг хянан шийдвэрлэхийн тулд хуульд заасан хугацааны хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогтой уялдуулан шүүхээс тогтоосон хугацаа хамаарна.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа тодорхой цаг хугацаанд шийдвэрлэгдэж байдаг. ИХШХША-ны хугацааг шүүх болон хэргийн оролцогч дагаж мөрдөх үүрэг хүлээнэ. ИХШХША-ны хугацааг дор дурьдсанаар ангилан авч үздэг.




Хуулиар тогтоосон хугацаанууд:





Шүүхээс тогтоож болох хугацаа:





Хяналтын асуулт

- Хугацааны талаарх үндсэн ойлголтыг тодорхойлно уу?
- Хуулиар тогтоосон хугацаануудыг нэг бүрчлэн тайлбарлана уу?
- Шүүхээс тогтоож болох хугацаа онцлогийг нэрлэнэ үү?
- Хугацаа тоолох журам ямар байх вэ?
- Хугацаа түдгэлзүүлэх, үндэслэл журам ямар байх вэ?



Бодлого

1. Иргэн Д өөрийн эд хөрөнгөнд гэм хор учруулсан Р-ээс 34000 төгрөгийг гаргуулахыг шаардсан нэхэмжлэлийг шүүхэд гаргажээ. Шүүгч нэхэмжлэлийг хүлээн авч 30 хоногийн дараа “Иргэний хэрэг” үүсгэх захирамж гаргасан байна.

Энэ тохиолдолд:

- Шүүгч хуулийн хугацаанд асуудлыг шийдвэрлэсэн эсэхэд дүгнэлт хийнэ үү?
- Хуулиар тогтоосон хугацааны ач холбогдлыг нэрлэнэ үү?



2. Ажлаас үндэслэлгүй халсан гэж гомдол гаргасан Ц-ийн нэхэмжлэлтэй Нийслэлийн БЗД-ийн ЗДТ газарт холбогдох иргэний хэрэгт Дүүргийн ЗДТ газрыг төлөөлж Ч оролцох итгэмжлэлтэй ба хариуцагчид нэхэмжлэлийн хувийг гардуулахдаа шүүгч 20 хоногийн дотор хариу тайлбараа ирүүлэхийг шаардсан боловч 1 сарын хугацаа өнгөрөхөд ямар нэг тайлбар гаргаагүй тул хурал зарласан байна.

Энэ тохиолдолд:

- Асуудлыг шүүх хэрхэн шийдвэрлэх вэ?
- Хариуцагч нэхэмжлэлд холбогдох тайлбарыг ямар хугацаанд гаргах вэ?
- Шүүгч 20 хоногийн хугацаа өгсөн нь үндэслэлтэй юу?



Даалгавар:

- ИХШХШТХуулиар хугацаа тогтоож заасан бүх заалтыг түүвэрлэн бичээд дүгнэлт хийж ойлгох.
- Хугацааны ангиллын талаар ярилцах
 - ♦ Шүүгчээс баримтлах хугацаа
 - ♦ Хэргийн оролцогчдоос баримтлах хугацаа
 - ♦ Бусад оролцогчдоос баримтлах хугацаа
- Хугацааны суурь ач холбогдол, хугацааг алдагдуулах, хэтрүүлэх тохиолдолд хүлээх хариуцлагын талаар ойлголтыг авч, тайлбарлах.



Эх сурвалж:

- ИХШХШТХ-ийн 66-р зүйл, 72-р зүйл, 120-р зүйл
- ИХШХШЭЗ /Тайлбар схем/ 2003 он
- Шүүгчийн гарын авлага 2003 он

II БҮЛЭГ. ИХШХШЭЗҮЙН ЗАРЧИМ

ИХШХШЭЗҮЙН ЗАРЧМЫН ОЙЛГОЛТ, АНГИЛАЛ,ОНЦЛОГ ШИНЖ

Сэдвийн зорилго: ИХШХШЭЗҮЙН зарчмын ойлголт, үндсэн шинж, ач холбогдол, Үндсэн хуулийн тулгуур зарчмын талаар онолын мэдлэгтэй болох, тэдгээрийг ИХШХШ ажиллагаанд хэрэглэх **чадвартай** болох, зарчмыг мөн чанараар нь хэрэгжүүлэх **хандлага** төлөвшинө.

Сэдвийн агуулга:

- ИХШХШЭЗ -н зарчмын ойлголт, үндсэн шинж
- ИХШХШЭЗ -н зарчмын ач холбогдол
- ИХШХШЭЗ -н ангилал
- ИХШХШЭЗ -н тулгуур зарчим
- ИХШХШЭЗ -н тусгай зарчим



Нэр томъёоны тайлбар

Үндсэн хуулийн зарчим - Энэ зарчмыг тулгуур зарчим гэж авч үзэн судалдаг ба Монгол улсын Үндсэн хууль төдийгүй, ИХШХШТХуульд тодорхойлогдсон нийтлэг үндэслэлүүд юм.

Тусгай зарчим - Үндсэн хуулийн буюу тулгуур зарчмын хүрээнд иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон бусад хуульд тусгагдсан заалтыг хэлнэ.

Шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлэх - Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар тус улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлэх ба ямар ч тохиолдолд хуулиас гадуур шүүх байгуулах, шүүх эрх мэдлийг өөр байгууллага хэрэгжүүлэхийг хориглоно.

Шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдах - Шүүгч албан тушаал, ёс суртахуун, хөрөнгө, сүшиг бишрэл гэх мэтээр хэний ч нөлөөнд автахгүй, хууль бус юунаас ч хамаарахгүйгээр гагцхүү хуульд захирагдан хэрэг маргааныг шийдвэрлэхийг ойлгоно.

Шүүх хэргийг хамтын зарчмаар шийдвэрлэх - Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар бүх шатны шүүх хэрэг маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ. Хуульд тусгайлан заасан зарим хэргийг шүүгч дангаар хянан шийдвэрлэж болно.

Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх - Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдыг үндэс угсаа, хэл, арьс өнгө, нас хүйс, нийгмийн гарал, ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлахгүйгээр шүүх тэгш хандахыг ойлгоно.

Шүүх хуралдааныг нээлттэй явуулах - Хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд шүүх хэргийг ил таслан шийдвэрлэнэ. Бүх шатны шүүхийн шүүх хуралдааныг нээлттэй явуулах ба хэргийн нотлох баримт эсхүл үйл явдал, төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах бол хэргийн оролцогчдын хүсэлтээр шүүх хуралдааныг бүрэн буюу түүний зарим ажиллагааг хаалттай явуулж болно



Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг монгол хэлээр явуулах - Иргэний хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг монгол хэл дээр явуулна. Монгол хэл мэдэхгүй хэргийн оролцогчдод өөрийн эх хэл буюу мэдлэг хэл бичгээр оролцож, эрх үүргээ хэрэгжүүлэх боломж олгоно. Хэргийн оролцогч монгол хэл мэдэхгүй бол орчуулагчийг өөрөө сонгон авах эрхтэй, хэрэв өөрөө сонгоогүй бол шүүгч захирамж гарган орчуулагчийг томилох үүрэг хүлээнэ.

Хууль дээдлэх зарчим - Шүүх хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ Үндсэн хууль түүнд нийцүүлэн гаргасан, албан ёсоор нийтлэгдсэн, хүчин төгөлдөр хуулийг хэрэглэнэ.


Хэрэг хянан шийдвэрлэхэд иргэдийн төлөөлөгчдийг оролцуулах зарчим - Шүүх хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ хуульд заасан журмын дагуу иргэдийн төлөөлөгчийг оролцуулна. Иргэдийн төлөөлөгчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулж байгаа нь төрийн үйл хэрэгт ард нийтийн төлөөллийг бий болгож байгаа хэлбэр юм.


ИХШХШЭЗ-н зарчим. ИХШХША-ны мөн чанар, гол шинжийг илэрхийлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат бүрт хамаарах, шүүхээс иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны арга, хэлбэр, зохион байгуулалтыг тодорхойлдог, энэхүү ажиллагаанд мөрдлөг болговол зохих үзэл баримтлалыг ойлгоно. ИХШХШЭЗ-н зарчмын ойлголтын талаар судлаачдын дунд нэгдсэн нэг ойлголт үгүй юм.

ИХШХШЭЗ-н зарчим нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ямар хэлбэрээр явуулах, хуулийг сахих, бодит үнэнийг тогтоох, шударга ёсыг дээдлэх зарчимд нийцэж байгаа эсэхийг тодорхойлно.

ИХШХШЭЗ-н зарчим уг эрх зүйн бүтэц, гол шинжийг тодорхойлж, түүний хэм хэмжээг хамаарч, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны агуулга, уг зорилтод хүрэх аргыг зааж өгч, субъектүүдийн үйл ажиллагааны агуулгыг илэрхийлнэ.

ИХШХШЭЗ -н зарчмыг тулгуур буюу Үндсэн хуулийн, салбар дундын буюу хэд хэдэн бие даасан эрх зүйд хамаарах зарчим, тусгай буюу салбар эрх зүйн зарчим гэж дор хүснэгтэд заасан байдлаар ангилж болох боловч, ихэнх судлаачид тулгуур буюу тусгай зарчим гэж ангилах ангиллыг илүүтэй авч үздэг байна.





48



Хяналтын асуулт

1. ИХШХШЭЗүйн зарчмын үндсэн шинжийг Үндсэн хуулийн зарчим тус бүр дээр тайлбарлана уу?
2. Шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдах зарчим хэр зэрэг хангагдаж байгаад дүгнэлт өгнө үү?
3. Шүүгч дангаар хянан шийдвэрлэж болох хэрэг, маргааныг дурдана уу?
4. Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчмыг хангахад нөлөөлөх хүчин зүйлүүдийг тодорхойлно уу?
5. Шүүх хуралдааныг хаалттай явуулж болох үндэслэлүүдийг гаргана уу?
6. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг монгол хэлээр явуулах зарчмыг хангахад анхаарвал зохих асуудлыг тодорхойлно уу?
7. Иргэдийн төлөөлөгч ИХШХШ ажиллагаанд ямар эрх үүрэгтэй оролцох вэ?
8. ИХШХША-нд зарчим хэрэглэнэ гэдэг ойлголтыг тайлбарлана уу?
9. Зарчмыг хэрэгжүүлснээр ямар ач холбогдолтой вэ?



Сорил

1. Анхан шатны шүүхийн шүүх хуралдааныг иргэдийн төлөөлөгчийг оролцуулалгүй хийж болох уу
 - а. болно
 - б. Болохгүй
 - в. прокурор оролцож байгаа бол заавал оролцуулна
2. Хэргийн оролцогч монгол хэл мэдэхгүй атлаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд орчуулагч авахаас татгалзжээ.
 - а. Татгалзах эрхтэй. Учир нь орчуулагчийг өөрөө сонгоно.
 - б. Шүүгч захирамж гарган орчуулагч томилно
 - в. Энэ талаар хуульд зохицуулалт байхгүй тул орчуулагч авах эсэхийг хэргийн оролцогч өөрөө шийдвэрлэнэ.
3. Шүүх хэрэг маргааныг дараахь бүрэлдэхүүнтэй шийдвэрлэнэ.
 - а. Давж заалдах шатны шүүх 5 шүүгчийн
 - б. Анхан шатны шүүх 1 ба 3
 - в. Улсын дээд шүүхийн иргэний танхимын шүүх хуралдаан 3 шүүгчийн
 - г. Дээд шүүх нийт 17 шүүгчийн 2/3-н бүрэлдэхүүнтэй шийдвэрлэнэ
4. Давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдаан даргалагчийг татгалзан гаргах хүсэлтийг давж заалдах гомдол гаргасан этгээд шүүх хуралдаан дээр гаргажээ.
 - а. Энэ нь зөв. Учир нь аль ч шатны шүүхийн шүүх хуралдаан дээр шүүгчийг татгалзан гаргах эрхтэй
 - б. Энэ нь буруу. Учир нь шүүгчийг татгалзан гаргах эрх зөвхөн анхан шатны шүүх хуралдаанд хэрэгжинэ
 - в. Энэ нь буруу. Учир нь давж заалдах гомдол гаргасан этгээд энэхүү эрхийг эдэлдэггүй

5. Шүүхийг аль хуулийн дагуу байгуулах вэ?

- а. Үндсэн хууль*
- б. Шүүхийн тухай хууль*
- в. ИХШХШТХууль*
- г. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль*



Бодлого

1. Иргэн “О”, “Ц” нар 1982 онд гэрлэлтээ бүртгүүлжээ. Тэд хоёр хүүхэд төрүүлсэн бөгөөд 1995 онд хоорондоо үзэл бодлын хувьд таарахгүй болсон тул гэрлэлтээ цуцлуулсан байна. Гэрлэгчдийн эд хөрөнгийн маргааныг шүүх шийдвэрлэж, Нийслэлийн БГД-т байрлах 2 өрөө орон сууцыг 2 хүүхдээ асрамжиндаа авсан ээж “Ц”-д үлдээхээр шүүхийн шийдвэр гарсан байна. Гэвч шүүхийн шийдвэр гарах үед 0 нь байраа ганцаараа эзэмшиж үлдсэн бөгөөд түүнийг суллаж өгөлгүй 5 жил өнгөрсөн төдийгүй энэ хугацаанд “О” Ээрмэлийн үйлдвэрт сүлжигч ажилтай Х гэгчтэй гэрлэжээ. Тэд 3 жил гаруй хугацаанд хамт амьдраад мөн л таарч тохирохгүй болсон гэдэг үндэслэлээр шүүхээр гэрлэлтээ цуцлуулсан. 0, Х нарын хооронд өмнө Ц-д олгосон орон сууцны маргаан гарахад шүүх тухайн орон сууцыг Х-д олгохоор шийдвэрлэсэн. Шүүхийн шийдвэр гарах үед 0 нь БНСУ-д ажиллахаар явсан байв.

Энэ тохиолдолд:

1. ИХШХША-ны ямар нэгэн зарчим алдагдсан уу?
2. Ц-д эрх зүйн туслалцаа үзүүлнэ үү?



Даалгавар:

- ИХШХШЭЗ-н зарчмын асуудлыг тодорхой жишээ, шүүхийн практикт хэрэглэх дадал олж авах зорилгоор иргэний хэргийн материал дээр
- ИХШХШЭЗ-н тулгуур болон тусгай зарчмын асуудлыг ангилан зарчим зөрчигдсөн тохиолдолд үр дагавар ямар байх талаар ярилцах



Эх сурвалж:

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он.
2. Монгол Улсын Иргэний хууль. 2002 он.
3. ИХШХШТухай хууль. 2002 он.
4. Эрүүгийн байцаан шийтгэх хууль. 2002 он.
5. Захиргааны хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх журмын тухай хууль. 2003 он.
6. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн эмхтгэл. 2004 он.



ИХШХШЭЗ-Н ТУСГАЙ ЗАРЧИМ

Сэдвийн зорилго: ИХШХШЭЗ-н Үндсэн хуулийн болон тусгай зарчмын ойлголт, үндсэн шинж, ач холбогдол, тусгай зарчмын талаар онолын мэдлэгтэй болох, тэдгээрийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэх **чадвартай** болох, Үндсэн хуулийн зарчмыг тусгай зарчимтай зэрэгцүүлэн хэрэгжүүлэх хандлага төлөвшнө.

Сэдвийн агуулга:

- ИХШХШЭЗ-н тусгай зарчмын ойлголт, үндсэн шинж
- Хэргийн үнэнийг тогтоох зарчим, үндсэн шинж,
- Шүүх хуралдааныг амаар, шууд, биечлэн явуулах зарчим, үндсэн шинж
- Шүүх хуралдааны ажиллагааг тасралтгүй явуулах зарчим, үндсэн шинж
- Мэтгэлцэх зарчим, үндсэн шинж
- Диспозитив буюу зөвшилцөх зарчим, үндсэн шинж



Нэр томъёоны тайлбар

ИХШХШЭЗ-н тусгай зарчим - Үндсэн хууль буюу тулгуур зарчмын хүрээнд иргэний хэргийг шийдвэрлэх тодорхой ажиллагаа явуулах бөгөөд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон бусад хуульд тусгагдсан заалтыг хэлнэ. ИХШХШЭЗ-н тусгай зарчимд хэргийн үнэнийг тогтоох, шүүх хуралдааныг амаар, шууд, биечлэн явуулах, шүүх хуралдааны ажиллагааг тасралтгүй явуулах, мэтгэлцэх, диспозитив буюу зөвшилцөх зарчмууд хамаарна.

Хэргийг үнэнийг тогтоох зарчим - Шүүх нотлох баримтын тусламжтайгаар хэргийн нөхцөл байдлыг тогтоогоод хэрэглэвэл зохих материаллаг эрх зүйн хэм хэмжээг хэрэглэж, хэргийг шийдвэрлэхийг ойлгоно. Шүүх хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн, бодитойгоор судлан шинжлэх үүрэг нь иргэний хэргийг хянан шийдвэрлэх эрх зүйн энэхүү зарчмын агуулгыг бүрдүүлнэ.

Шүүх хуралдааныг амаар, шууд, биечлэн явуулах зарчим - ИХШХША-ны оролцогчид нь шүүхэд тайлбараа амаар гаргаж, биечлэн оролцож, маргааны үйл баримтыг нотлох, үндэслэлээ тайлбарлах зэргээр энэ зарчим хэрэгждэг. Шүүх бүрэлдэхүүн хэрэгт цугларсан нотлох баримтыг биечлэн шинжлэхээс гадна хэргийг зөвхөн шүүх хуралдааны үед судалсан нотлох баримтанд тулгуурлан шийдвэрлэхийг энд хамааруулан ойлгоно.

Шүүх хуралдааны ажиллагааг тасралтгүй явуулах зарчим - Шүүх хэргийг хуралдаанаар нэгэнт хэлэлцэж эхэлсэн бол завсар хооронд нь өөр хэрэг хэлэлцэхгүйгээр зөвхөн эхэлсэн хэргээ шийдвэрлэж дуусгахыг ойлгоно. Шүүх бүрэлдэхүүн нэгэнт хэлэлцэж эхэлсэн хэргээ дуусгах боломжгүй нөхцөл байдал бий болсон бол шүүх хуралдааныг хойшлуулж, шүүгч захирамж, шүүх тогтоол гаргана. Хэргийг шийдвэрлэж дуусгана гэдэгт тухайн хэргийн талаар шийдвэр гаргахыг ойлгоно.

Мэтгэлцэх зарчим - Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг мэтгэлцэх үндсэн дээр хэрэгжүүлнэ. ИХШХША- д нэхэмжлэгч, түүний төлөөлөгч,

өмгөөлөгч нэхэмжлэлийн шаардлага, маргааны үйл баримт, хариуцагчийн гэм бурууг нотолж, түүний татгалзлыг үгүйсгэх, хариуцагч түүний төлөөгч, өмгөөлөгч, нэхэмжлэлийн шаардлагаас татгалзах, түүнийхээ үндэслэлийг нотлох үүрэгтэй байна. Ингэж мэтгэлцэхдээ талууд тэгш эрхтэй байна.

Диспозитив зарчим - ИХШХША-гаа хэргийн оролцогчийн санаачилга, хүсэлтийн дагуу явагдана. Хэргийн оролцогчид хоорондоо маргаж байгаа зүйлийн талаар эвлэрэх, нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзах, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх зэрэг харилцан зөвшилцөж, сайн дурын үндсэн дээр асуудлаа өөрсдийн хүсэл зоригоор шийдвэрлэх боломжтой. Энэ боломжийг хуулиар тогтоож өгсөн нь энэхүү зарчим хэрэгжих үндсийг тогтоож байгаа юм.

ИХШХШЭЗүйн тусгай зарчим нь тулгуур зарчмын хүрээнд иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжид тусгалаа олсон байдаг. ИХШХШЭЗүйн тусгай зарчимд хэргийн үнэнийг тогтоох, шүүх хуралдааны ажиллагааг тасралтгүй явуулах, шүүх хуралдааны ажиллагааг амаар, шууд, биечлэн явуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэтгэлцэх, диспозитив зарчмууд хамаарна.

Тусгай зарчим тус бүрийн агуулга, хуульд тусгагдсан байдлыг сайтар ойлгож судлах шаардлагатай.



Хяналтын асуулт

Оюутнууд 3 багт хуваарилагдана. 1 дүгээр баг Нарангийн, 2 дугаар баг Батаагийн эрх ашгийг хамгаалж орлох ба 3 дугаар баг шүүгч Дулмаагийн гаргасан шийдвэр үндэслэлтэй эсэхэд дүгнэлт өгч бодлогын өгөгдөлд заасан асуултад тус бүр хариулт өгч мэтгэлцэнэ.

- Бодлогын өгөгдөлд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим алдагдсан эсэх
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тулгуур болон тусгай зарчмын харилцан хамаарал нь ямар байх
- Хэргийн оролцогчийн тэгш эрхтэйгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломжийг хангахын тулд юуг анхаарах шаардлагатай байна вэ?
- Мэтгэлцэх зарчмыг хэрхэн хэрэгжүүлэх ёстой вэ?
- Диспозитив зарчмыг хэрэгжүүлэхэд юуг анхаарах вэ?



Сорил

1. **ИХШХШЭЗ-н тулгуур зарчмыг олно уу?**
 - а. Хэргийн үнэнийг тогтоох
 - б. Хууль дээдлэх
 - в. Шүүх хуралдааны ажиллагааг амаар, шууд явуулах
 - г. Шүүх хуралдааныг тасралтгүй явуулах
2. **17 настай Б шүүх хуралдааны танхимд байжээ. Энэ нь:**
 - а. Хууль зөрчсөн үйлдэл
 - б. Хуулиар зөвшөөрсөн тул байж болно
3. **Давж заалдах шатны шүүхэд иргэдийн төлөөгч давж заалдах гомдол гаргах эрхтэй эсэхэд дүгнэлт хийнэ үү?**
 - а. Эрхтэй.
 - б. Эрхгүй
4. **Шүүх хуралдааныг хаалттай явуулсан тохиолдолд шийдвэрийг нийтэд уншиж сонгож болох уу?**
 - а. Болно
 - б. Болохгүй
5. **Шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад хөндлөнгөөс нөлөөлж болохгүй албан тушаалтан:**
 - а. Ерөнхийлөгч
 - б. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч
 - в. Тухайн шүүхийн Ерөнхий шүүгч
 - г. Үндсэн хуулийн цэцийн дарга



Бодлого

Наран Батаагаас 2 сая төгрөг гаргуулах тухай нэхэмжлэл гаргасныг шүүгч Дулмаа хүлээн авч, иргэний хэрэг үүсгэн Батаад танилцуулахад “Нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй. Худал зүйлийг надаас нэхсэн байна. Надад үүнийг гэрчлэх олон баримт байгааг шүүхэд авчирч өгнө” гэжээ. Шүүгч Дулмаа шүүх хуралдаан хийх өдөр, цагийг Наран, Батаа нарт мэдэгдсэн боловч шүүх хуралдаанд Батаа ирээгүй байна. Шүүх хуралдааныг Батаагийн эзгүйд явуулж, нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хэмжээгээр хангаж шийдвэр гаргасан байна.

Энэ тохиолдолд:

1. Хариуцагч Батаа шүүхэд нотлох баримт гаргаж өгөх үүрэгтэй эсэхэд дүгнэлт хийнэ үү?
2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ямар нэгэн зарчим зөрчигдсөн эсэхэд дүгнэлт хийнэ үү?



Даалгавар:

- ИХШХШЭЗ-н зарчим тус бүрийн мөн чанарыг тодорхойлсон жишээ бодлого бодож, хуулийн зүйл, заалтыг хэрэглэж сурах
- ИХШХШЭЗ-н зарчим зөрчигдвөл гарах үр дагаврыг тодорхойлох чадвартай болохын тулд шүүхийн практикыг судлах



Эх сурвалж:

- Үндсэн хууль 1992 он
- ИХШХШТХууль 2002 он
- Иргэний хууль 2002 он



III БҮЛЭГ. ИХШХШЭЗҮЙН ХАРИЛЦАА

ИХШХШЭЗ ХАРИЛЦААНЫ ОЙЛГОЛТ, ОНЦЛОГ

Сэдвийн зорилго: ИХШХШЭЗүйн харилцааны ойлголт, түүний объект, субъект, материаллаг эрх зүйн харилцаанаас ялгагдах шинжийн талаар онолын мэдлэгтэй болох, ИХШХШЭЗүйн харилцааг эрх зүйн бусад харилцаанаас ялган тодорхойлох чадвартай болно.

Сэдвийн агуулга:

- ИХШХШЭЗ харилцаа, бүтэц
- Харилцааны онцлог, шинж
- ИХШХШЭЗ харилцааны ангилалт
- Материаллаг эрх зүйн харилцаанаас ялгагдах нь.



Нэр томъёоны тайлбар

ИХШХШЭЗ-н харилцаа гэдэг нь: Иргэний хэрэг шийдвэрлэх явцад зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар иргэн, хуулийн этгээд шүүхэд хандах, шүүх нэхэмжлэлийг хүлээн авах, зохигч талууд нотлох баримтыг гаргаж өгөх, шүүх нотлох баримт бүрдүүлэх, үнэлэлт дүгнэлт өгч шийдвэрлэх зэргээр нэг талд шүүх, нөгөө талд нэхэмжлэгч, хариуцагч, гэрч, шинжээч, хэлмэрчийн хооронд үүсэх ИХШХШТ Хуулиар зохицуулагдаж буй нийгмийн тодорхой төрлийн харилцаа.

ИХШХШЭЗүйн харилцааны объект - Иргэний хэрэг шийдвэрлэх ажиллагаанд оролцох субъектүүдийн хооронд үүссэн нийгмийн харилцаа

ИХШХШЭЗүйн харилцааны субъект - Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчид.

ИХШХШЭЗүйн харилцааны агуулга - ИХШХШЭЗүйн харилцаанд оролцогчдын эрх, үүргийн нэгдлийг ойлгоно.

Шүүх - Хуулиар тогтоосон журмын дагуу иргэний хэрэг маргааныг хянан шийдвэрлэхийн тулд шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх төрийн байгууллага.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчид - Иргэний хэргийн оролцогч, болон шүүх хуралдаанд оролцогчдыг ойлгоно. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөрийн болон бусдын нэрийн өмнөөс оролцож байгаа маргаж байгаа зүйлд эрх ашиг сонирхол нь хөндөгдсөн этгээдүүд энд хамаарна.

Хэргийн оролцогч - Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, бусдын эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа этгээдийг хэргийн оролцогчид гэнэ.

Шүүх хуралдааны оролцогч - Шүүх хуралдаанд оролцогчдын бүрэлдэхүүнд шүүгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, гэрч, шинжээч, орчуулагч, иргэдийн төлөөлөгч зэрэг нь багтана.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн харилцааны бүтцийг авч үзвэл:





ИХШХШЭЗ-н харилцааны ангилалт:



ИХШХШЭЗ-н харилцааг материаллаг эрх зүйн харилцаанаас ялгах нь:

ИЭЗ харилцаа	ИХШХШЭЗ-н харилцаа
1. Субъектээрээ: Материаллаг эрх зүйн субъектын эдлэх эрх нь адил тэгш тэдний зан үйлийн сонголтбайдаг.	ИХШХШ процесст оролцогч талуудын хооронд маргаан үүсч харилцан бие биенийхээ эсрэг ханддаг
2. Зохицуулах зүйлээрээ: Иээ, ГБЭЗ, ААЭЗ-н харилцаагаар талуудын зан үйлийг зохицуулдаг.	ИХШХШЭЗ иргэн, хуулийн этгээдийн хооронд үүссэн эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус маргаан, түүнийг зохицуулах үйл ажиллагаа байдаг.
3. Хууль зүйн фактаараа: Иээ-н харилцаа үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болох нь уг харилцаанд оролцогчдын хууль зүйн дагуух үйлдэл, үйл явдал байдаг..	ИХШХШЭЗ-н харилцаа үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болох нь шүүх бусад оролцогчдын үйлдэл байна.



Хяналтын асуулт

- ИХШХШЭЗүйн харилцаа, онцлог шинжүүдийг тодорхойлно уу?
- Анхдагч ба үүсмэл харилцааг жишээгээр тайлбарлана уу?
- ИХШХШЭЗ-н харилцаа материаллаг эрх зүйн /ИЭЗүйн/ харилцаанаас ялгагдах онцлогийг тодорхойлно уу?
- ИХШХШЭЗ-н харилцааны бүтэц, элемент тус бүрийг тайлбарлана уу? /Субъект, объект, агуулга, хууль зүйн факт/



Даалгавар:

- ИХШХШЭЗ-н харилцаа бусад салбар эрх зүйн харилцаанаас ялгагдах онцлог шинжүүдийг харьцуулан судлах



Эх сурвалж:

- ИХШХШТХууль. 2002 он

ИРГЭНИЙ ХЭРГИЙН ОРОЛЦОГЧИЙН ОЙЛГОЛТ, ТЭДГЭЭРИЙН ЭРХ, ҮҮРЭГ

Сэдвийн зорилго: Иргэний хэргийн оролцогч, тэдгээрийн эрх, үүргийн талаар онолын мэдлэгтэй болох, оролцогчдын эрх зүйн байдлыг ялган тодорхойлох, оролцогчдын эрх, үүргийг хуульд зааснаар хэрэгжүүлэх чадвар эзэмших.

Сэдвийн агуулга:

- Иргэний хэргийн оролцогчдын ойлголт, чадвар, чадамж
- Иргэний хэргийн оролцогчдын эрх
- Иргэний хэргийн оролцогчдын үүрэг
- Зохигчийн эрх зүйн байдал
- Гуравдагч этгээд, тэдгээрийн ангилал
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэд хэдэн зохигч оролцох нь
- Нэхэмжлэгч, хариуцагчийг солих
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх залгамжлан авах



Нэр томъёоны тайлбар

Иргэний хэрэг - Иргэн, хөдөлмөр, гэр бүл, татвар, даатгал тэтгэвэрийн харилцаанаас үүссэн маргааныг шүүх иргэний хэрэг хэмээн томъёолж, хянан шийдвэрлэнэ. ИХШХШТХуульд шүүхээр шийдвэрлүүлэхээр урьдчилан заасан нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авч, зохих шаардлага хангасан гэж үзвэл шүүгчийн захирамжаар иргэний хэрэг үүсгэнэ.



Иргэний хэргийн оролцогч - Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, бусдын эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа этгээдийг хэргийн оролцогчид гэнэ.

Зохигч - ИХШХШАжиллагаанд нэхэмжлэгч, хариуцагч, хуульд заасны дагуу тэдгээртэй эрх зүйн хувьд адил эрх, үүрэгтэйгээр оролцож байгаа этгээдийг зохигч гэнэ.

Нэхэмжлэгч - Хуульд заасан эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж эрхээ сэргээлгэхээр өөрийн болон бусдын нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргасан этгээдийг нэхэмжлэгч гэнэ.

Хариуцагч - Нэхэмжлэгчийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд хохирол учруулсан буюу үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй гэж нэхэмжлэлийн үндсэн дээр шүүхэд дуудагдсан этгээдийг хариуцагч гэнэ.

Гуравдагч этгээд - Хуулиар хамгаалагдсан зөрчигдсөн эрх ашгаа хамгаалуулахаар шүүхээс иргэний хэрэг үүсгэсэн хэрэгт эрх ашиг нь хөндөгдөн өөрийн санаачилгаар буюу шүүхийн шийдвэрээр оролцож байгаа этгээдийг ойлгоно.

Төлөөлөгч - Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийн оролцогчдын нэрийн өмнөөс тэдгээрийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалан оролцож байгаа эрх зүйн бүрэн чадамжтай иргэн хуулийн этгээдийг төлөөлөгч гэнэ. Өөрийнхөө ашиг сонирхлыг хамгаалуулахын тулд шүүхэд бусдыг оролцуулж байгаа талыг төлөөлүүлэгч, харин тухайн үйл ажиллагааг түүний нэрийн өмнөөс гүйцэтгэж байгаа этгээдийг төлөөлөгч гэж нэрлэдэг.

Өмгөөлөгч - Иргэний хэрэг маргаан шийдвэрлэхэд хэргийн оролцогчийн хууль ёсны ашиг, сонирхлыг хамгаалж, гэрээний үндсэн дээр эрх зүйн туслалцаа үзүүлж байгаа хуульч мэргэжилтэй, ял шийтгэлгүй, өмгөөлөгчийн мэргэжлийн шаардлага хангасан, тогтоосон журмын дагуу сонгон шалгаруулалтад орж өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэн зөвшөөрөл авсан этгээдийг өмгөөлөгч гэнэ.

Прокурор - Төрийг төлөөлөн тэдний хүсэлтийн үндсэн дээр хэргийн оролцогчийн эрх, үүргийг хэрэгжүүлэн оролцож байгаа прокурорын байгууллагын албан тушаалтан.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомжид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдыг нэг бүрчлэн зааж тусгах боломжгүй бөгөөд харин тухайн хэргийн оролцогчдын бүрэлдэхүүнийг тодорхойлсон байдаг.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдыг 3 хэсэгт буюу шүүх, хэргийн оролцогч, шүүх хуралдаанд оролцогчид хэмээн ангилан авч үзнэ.

Шүүх нь энэхүү хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч гол субъект ба түүний эрх мэдэл, хэрэгжүүлэх чиг үүргийг Монгол улсын Үндсэн хууль, Шүүхийн тухай хууль, ИХШХШТХуульд тодорхой зааж өгсөн.

Хэргийн оролцогч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талууд бөгөөд түүний бүрэлдэхүүн, ангиллыг доорх бүдүүвчээс үзэж болно.



Иргэний хэргийн оролцогч байхын тулд эрх зүйн чадвар, чадамжтай байх ёстой. Иргэний хэргийн оролцогчийн чадвар гэдэгт хэргийн оролцогчийн хуулиар тогтоосон эрх эдэлж, үүрэгтэй байх боломжийг ойлгодог ба бүх иргэн, хуулийн этгээд түүнийг тэгш эдэлнэ. Хэргийн оролцогчийн чадамж бол хуулиар тогтоосон эрх, үүргийг өөрсдийн үйл ажиллагаагаар олж авах боломж юм. Хэргийн оролцогчийн чадамж нь маргаантай байгаа материалаг эрх зүйн харилцааны субъектийн чадамжтай харилцан уялдаатай ба энэ талаар ИХШХШ-уулийн 24 дүгээр зүйлээс тодруулан үзэх шаардлагатай.

Хэргийн оролцогч эсрэг талын тайлбар, татгалзал, түүний нотлох баримттай танилцах, тэдгээрт тайлбар өгөх, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай шүүгчийн захирамж гарсны дараа хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх, шүүх хуралдаанд оролцох, гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах, хуурамч нотлох баримтыг хууль бусаар бүрдүүлсэн цуглуулсан гэж үзвэл шалгуулах, нотлох баримтаас хасуулах, шүүх хуралдааны хойшлуулах тухай хүсэлт гаргах, шүүх бүрэлдэхүүнийг татгалзан гаргах, шүүх хуралдаанд оролцогчдод асуулт тавих, шүүхийн шийдвэрт давж заалдах, хяналтын гомдол гаргах зэрэг эрхийг эдлэхээс гадна шүүхэд хэргийн талаар үнэн зөв тайлбар гаргах, шүүхийн дуудсанаар ирэх, шүүхийн тавьсан шаардлагыг биелүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам, шүүх хуралдааны дэгийг сахих, шүүхийн шийдвэрийг биелүүлэх, нотлох баримтыг өөрөө гаргаж өгөх, цуглуулах үүргийг тус тус хүлээнэ.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх залгамжлан авах гэдэг нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч болох нэг этгээдийг материаллаг



эрх шилжиж байгаатай уялдан нөгөө этгээдээр солих явдал юм. Өөрөөр хэлбэл маргаантай байгаа эрх зүйн харилцааны зохигчийн аль нэг нь уг эрхийн харилцаанаас гарсан, тухайлбал хүн нас барсан, хуулийн этгээд татан буугдсан, шаардлага ба үүргээ бусдад шилжүүлсэн бол процессын эрх, үүргээ хэрэгжүүлэхээр эрх залгамжлагчийг оролцуулах тухай ойлголт юм.



Хяналтын асуулт

1. Иргэний хэргийн оролцогчийг эрүүгийн болон захиргааны хэргийн оролцогчоос ялган тайлбарлана уу?
2. Зохигч гэж хэнийг хэлэх вэ? Иргэн, хуулийн этгээдийн зохигч болох чадвар, чадамжийг тодорхойлно уу?
3. Хэргийн оролцогчийн эрх, үүргээр жишээ гаргана уу?
4. Ямар тохиолдолд гуравдагч этгээд иргэний хэргийн оролцогч болох вэ?
5. Бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээдийг жишээгээр тайлбарлана уу?
6. Бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээд гэж хэнийг хэлэх вэ?
7. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэд хэдэн зохигч оролцох жишээ гаргана уу?
8. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх залгамжлан авах харилцааны хууль зүйн үр дагаврыг тодорхойлно уу?



Сорил

1. **Хэргийн оролцогч гэдэгт:**
 - а. Гэрч, орчуулагч
 - б. Шинжээч
 - в. Иргэдийн төлөөлөгч
 - г. Бусдыг төлөөлж нэхэмжлэл гаргасан этгээд
2. **Нэхэмжлэгч гэдэгт**
 - а. Шүүхэд нэхэмжлэл гаргасан этгээдийг
 - б. Эрх нь зөрчигдсөн этгээдийг
 - в. Хуульд заасан эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж эрхээ сэргээлгэхээр өөрийн болон бусдын нэрийн өмнөөс шүүхэд хандсан этгээдийг хэлнэ
3. **Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх залгамжлагч оролцох үндэслэлийг олно уу?**
 - а. Зохигч хүндээр өвчилсөн
 - б. Хариуцагчийг эрэн сурвалжилж байгаа
 - в. Шаардлага ба үүргээ бусдад шилжүүлсэн
 - г. Зохигчид асран хамгаалагчийг томилох шаардлагатай

4. **Нэхэмжлэгч нь тухайн нэхэмлэлийг гаргах эрхгүй болох нь нотлогдвол шүүх:**
 - а. *Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж буцаана*
 - б. *Нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгоно*
 - в. *Жинхэнэ нэхэмжлэгчээр сольж болно*
 - г. *Нэхэмжлэлээ өөрчлөх эрхтэй гэдгийг тайлбарлана*
5. **Хэргийн оролцогчийн хүлээх үүргийг тодорхойлно уу?**
 - а. *Гэрчээс мэдүүлэг авах*
 - б. *Шүүхийн шийдвэрт давж заалдах*
 - в. *Шүүхийн шийдвэрийг биелүүлэх*
 - г. *Үзлэг явуулах*
6. **Зохигч гэдэгт**
 - а. *Нэхэмжлэгч, хариуцагчийн аль нэгийг ойлгоно*
 - б. *Нэхэмжлэгчийн төлөөлөгчийг хэлнэ*
 - в. *Нэхэмжлэгч, хариуцагчийн гэр бүлийн гишүүн*
 - г. *Хариуцагчийн өмгөөлөгчийг хэлнэ*
7. **Хэргийн оролцогч дараах үүрэг хүлээнэ:**
 - а. *Гэрчээс мэдүүлэг авах*
 - б. *Шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргах*
 - в. *Нотлох баримт гаргаж өгөх*
 - г. *Шүүхийн шийдвэрийг биелүүлэх*
8. **Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх залгамжлан авах үндэслэлийг олно уу?**
 - а. *Хүнийг сураггүй алга болсонд тооцсон*
 - б. *Хуулийн этгээд нийлж, нэгдсэн*
 - в. *Нэхэмжлэгч хүндээр өвчилсөн*
 - г. *Хүн нас барсан*
9. **16 настай Бат өөрийн эцгийг тогтоолгохоор шүүхэд нэхэмжлэл гаргажээ.**
 - а. *Тэрээр нэхэмжлэл гаргах эрхтэй*
 - б. *Зөвхөн төлөөлөгчөөрөө дамжуулан нэхэмжлэл гаргах эрхтэй*
 - в. *Энэ талаар нэхэмжлэл гаргах эрхгүй*
10. **Иргэн О-гийн нэхэмжлэлтэй орон сууцны түрээсийн төлбөр гадаадын иргэн Х-ээс гаргуулах тухай маргааныг хэлэлцсэн шүүх хуралдаан дээр О нь Х-гийн орчуулагчийг татгалзан гаргах хүсэлт тавихад шүүх хуралдаан даргалагч хүсэлтийг хүлээн авахаас татгалзан энэ эрхийг зөвхөн Х эдлэх эрхтэй гэж тайлбарлав. Энэ нь:**
 - а. *Шүүх хуралдаан даргалагчийн үйлдэл хуульд нийцэж байна*
 - б. *Орчуулагчийг татгалзан гаргах эрхийг зохигч эдлэх тул даргалагчийн үйлдэл хууль зөрчиж байна*
 - в. *Орчуулагч нь хариуцагчийн талд шүүхийн санаачилгаар оролцож байгаа тул нэхэмжлэгчийн эдлэх эрхэд хамаарахгүй*
 - г. *Зохигчид орчуулагчийг татгалзан гаргах эрхийг эдлэхгүй*



Бодлого

1. 17 настай Сүрэн нэгэн барилгын цехед мужааны ажил эрхэлдэг. Тэрээр ээлжийн амралтаа эдлэн хөдөө амарч байтал ажил ологчийн зүгээс түүнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээг цуцалж, ажлаа хүлээлгэн өгөх мэдэгдэл ирүүлснийг түүний эх Норжмаа утсаар хэл хүргэсэн. Сүрэн ажлаас халагдсан үндэслэлийг эс зөвшөөрч, шүүхэд хандан гомдол гаргах хүсэлтэй байсан учраас ээж Норжмаа нь түүнийг төлөөлөн ажлаас үндэслэлгүй халагдсан тул эргүүлэн ажилд нь тогтоолгож, шийдвэр гаргуулахаар шүүхэд гомдол гаргажээ.

Энэ тохиолдолд:

1. Хэргийн оролцогчдыг тодорхойлно уу?
 2. Зохигчийн чадвар, чадамж ямар байх вэ?
2. Эхнэр, нөхрийн хооронд бий болсон эд хөрөнгийн маргаантай хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгчийн өмгөөлөгчөөр оролцож байсан өмгөөлөгч Б хариуцагчийн унаж явсан "Бенц - 190" маркийн автомашины баримт бичгийг хураан авчээ. Тэрээр нэхэмжлэгчийн ажлыг хөөцөлдөхөд унааны хэрэг болсон тухайгаа хариуцагчид хэлсэн байна.

Энэ тохиолдолд:

1. Өмгөөлөгчийн үйлдэлд дүгнэлт өгнө үү?
 2. Өмгөөлөгч хэргийн оролцогч мөн эсэхэд дүгнэлт хийнэ үү?
3. Иргэн А, С-ээс гэрлэлтээ цуцлуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргав. Шүүх хуралдаанаар хэргийг шийдвэрлэх явцад С нь нөхөр А-г шүүхээс сэтгэцийн өвчний улмаас иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцсон ба дүүргийн Засаг даргын захирамжаар асран хамгаалагчаар нь С-ийг тогтоосон тул түүний зөвшөөрөлгүй А нэхэмжлэл гаргах эрхгүй гэсэн тайлбар өгөв.

Энэ тохиолдолд:

А нэхэмжлэл гаргах эрхтэй эсэхийг тодорхойлно уу?



Даалгавар:

- Хэргийн оролцогчийн чадамжийн асуудлыг тодорхой төрлийн маргаан бүрт тодорхойлох чадвартай болох
- Зохигч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоход тэгш эрх эдэлнэ гэдгийг тайлбарлах
- Гуравдагч этгээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох онцлог, өөрийн болон шүүхийн санаачилгаар оролцох зохицуулалтыг тайлбарлах
- Гуравдагч этгээд оролцсон 3-аас доошгүй иргэний хэргийн материалтай танилцаж, дүгнэлтээ баталгаажуулах
- Эрх залгамжлагч иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох зохицуулалтын онцлогийг хэлэлцэх



Эх сурвалж:

- ИХШХШТХууль. 2002 он
- Иргэний хууль. 2002 он
- Хөдөлмөрийн тухай хууль. 1999 он
- Гэр бүлийн тухай хууль. 1999 он

**БУСДЫН ЭРХИЙГ ХАМГААЛЖ БАЙГАА ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭД
ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ НЬ.
ИХШХША ДАХЬ ТӨЛӨӨЛӨЛ**

Сэдвийн зорилго: Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бусдын эрхийг хамгаалж оролцох хууль зүйн боломж болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дахь төлөөллийн онцлогийн талаар онолын **мэдлэгтэй** болох, эдгээр харилцаанд оролцоходоо хууль зүйн боломжийг ашиглах **чадвартай** болох, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн хандах **хандлага** төлөвшинө.

Сэдвийн агуулга:

- Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бусдын эрхийг хамгаалж оролцох эрх зүйн үндэслэл
- Бусдын эрхийг хамгаалж оролцогчийн эрх зүйн байдал, онцлог



Нэр томъёоны тайлбар

Төлөөлөл - Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төлөөлөл гэдэг нь сонирхогч этгээдийн нэрийн өмнөөс тэдгээрийн хууль ёсны ашиг, сонирхлыг хамгаалж, эрх зүйн чадвар, чадамж бүхий бүхий субъектүүдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох үйл ажиллагаа юм.

Төлөөлөгч - Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийн оролцогчдын нэрийн өмнөөс тэдгээрийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалан оролцож байгаа эрх зүйн бүрэн чадамжтай иргэн хуулийн этгээдийг төлөөлөгч гэнэ. Төлөөлөгч тухайн үйл ажиллагааг төлөөлүүлэгчийн нэрийн өмнөөс гүйцэтгэнэ.

Төлөөлүүлэгч - Өөрийнхөө ашиг сонирхлыг хамгаалуулахын тулд шүүхэд бусдыг оролцуулж байгаа талыг төлөөлүүлэгч гэнэ.

Хууль ёсны төлөөлөл - Энэхүү төлөөлөл нь эрх зүйн чадамжгүй зарим буюу бүрэн бус чадамжтай этгээдийн ашиг, сонирхлыг хамгаалж, төлөөлүүлэгчийн хүсэл зоригоос үл хамааран хуульд зааснаар хэрэгждэг. Төлөөлөгч нь төлөөлүүлэгчийг бүрэн төлөөлнө.

Сайн дурын төлөөлөл - Эрх зүйн чадамжтай иргэн сайн дураараа бусдаар төлөөлүүлэхийг ойлгоно.

Гэрээний төлөөлөл - Өмгөөлөгчтэй гэрээ байгуулан, өмгөөлөгчөөр төлөөлүүлэхийг ойлгоно.

Төлөөлөгчийн бүрэн эрх - Төлөөлөгчийн бүрэн эрхийг төлөөлүүлэгчээс олгосон итгэмжлэл, бусад баримт бичгээр тодорхойлно. Төлөөлөгч өөрийн бүрэн эрхийг гэрчилсэн баримт бичгийг шүүхэд үзүүлнэ.



Шүүхэд мэдүүлэх эрх: /ИХШХШТХ-ийн 3-р зүйл/ Монгол Улсын хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн гэж үзэж байгаа аливаа этгээд уг эрхээ хамгаалуулахаар хуульд заасан журмын дагуу шүүхэд нэхэмжлэл, гомдол, хүсэлт гаргах хэлбэрээр мэдүүлэх эрхтэй.

ИХШХШТХуулийн 12.1.2 -т зааснаар бусдын эрх, эрх чөлөө ашиг сонирхлыг хамгаалж шүүхэд мэдүүлэх эрхтэй этгээдүүд нэхэмжлэл гаргаж болно.

Бусдын эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хамгаалж байгаа этгээд ИХШХША-нд оролцохдоо хэргийн оролцогчийн эрхийг эдэлж, үүргийг хүлээж оролцоно. /ИХШХШТХ-н 31.2,25-р зүйл/

Бусдын эрхийг хамгаалж хэрэг шийдвэрлэх ажиллагаанд оролцогч этгээд

Хэрэг шийдвэрлэх үйл ажиллагаанд өмгөөлөгч оролцох

Хэрэг шийдвэрлэх үйл ажиллагаанд прокурор оролцох

Хэрэг шийдвэрлэх үйл ажиллагаанд төрийн захиргааны байгууллага оролцох

Хэрэг шийдвэрлэх үйл ажиллагаанд төрийн бус байгууллага оролцох /Үйлдвэрчний эвлэл/

Хэрэг шийдвэрлэх үйл ажиллагаанд бизнесийн байгууллага оролцох


Хэрэг шийдвэрлэх үйл ажиллагаанд зохигчийн эрхийг хамгаалах байгууллага оролцох

Хэрэг шийдвэрлэх үйл ажиллагаанд эцэг, эх бусад этгээд оролцох

Бусдын эрх ашиг, сонирхлыг хамгаалж иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох нь дараах онцлогтой:


- Бусдыг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргасан этгээд нь ИХШХШТХ-ийн 25-р зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.
- Гаргасан нэхэмжлэлээсээ татгалзсан явдал нь ИХШХША-г дуусгавар болгох үндэслэл болохгүй.
- Тодорхой хүрээ бүхий этгээдүүдийн эрх ашгийг хамгаалах зорилготойгоор оролцдог. Жишээ нь: Худалдааны байгууллага чанаргүй бүтээгдэхүүн зарсан тохиолдолд хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалахаар шүүхэд хандах гэх мэт.
- Эдгээр нь нэхэмжлэлээс татгалзсанаар шүүх хэргийг дуусгавар болгож болохгүй.

Бусдын эрхийг шүүхэд хамгаалах зарим хэлбэрийг жишээ болгон авч үзвэл:



Иргэн, хуулийн этгээд нь төлөөлөгчөөрөө дамжуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломжтой. Энэ тохиолдолд төлөөллийн тухай ойлголт гардаг.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төлөөлөл нь тодорхой нэг этгээдийн нэрийн өмнөөс явагддаг ажиллагаа ба төлөөлөгч нь төлөөлүүлэгчийн эрх, эрх чөлөө хуулиар хамгаалагдсан ашиг, сонирхлыг хамгаалах үйл ажиллагааг зөвхөн хуулиар зөвшөөрөгдсөн бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлдэг онцлогтой. Төлөөллийн төрөл нь дараах байдлаар тодорхойлогдоно.



Хяналтын асуулт

1. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бусдын эрхийг хамгаалж оролцох шаардлага, хэрэгцээг жишээгээр тайлбарлана уу?
2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцох хууль зүйн үндэслэл, журмыг тодорхойлно уу?
3. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурорын оролцооны талаарх бусад улсын зохицуулалтыг харьцуулан гаргана уу?
4. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох өмгөөлөгчийн эрх зүйн байдлыг тодорхойлно уу?
5. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төлөөлөгчийн оролцоо, эрх зүйн байдлыг жишээн дээр тайлбарлана уу?
6. Төлөөллийн төрөл тус бүр дээр жишээ гаргана уу?
7. Төлөөлөгчөөр оролцохыг хориглох хууль зүйн үндэслэлийг тайлбарлана уу?



Сорил

- 1. Төлөөллийн төрлийг тодорхойлно уу?**
 - а. Хуульд зааснаар*
 - б. Иргэнийг төлөөлөх*
 - в. Сайн дураар*
 - г. Хуулийн этгээдийн төлөөлөл*
- 2. Сураггүй алга болсонд тооцогдсон хүн оролцвол зохих байсан хэрэгт түүнийг төлөөлөн оролцох эрхтэй этгээдийг олно уу?**
 - а. Гэр бүлийн гишүүн*
 - б. Эхнэр, нөхрийн аль нэг нь*
 - в. Эд хөрөнгийг нь эрхлэн хамгаалагчаар томилогдсон этгээд*
 - г. Төрөл, садангийн хүмүүс*
- 3. Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг:**
 - а. Хууль зүйн сайдын тушаалаар*
 - б. Монголын Өмгөөлөгчдийн холбооны Ерөнхийлөгчийн тушаалаар*
 - в. Хууль Зүйн үндэсний төвийн даргын тушаалаар*
 - г. Аймаг, нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөлийн даргын тушаалаар олгоно.*
- 4. Аль хэргийг хянан шийдвэрлэхэд прокурор оролцох вэ?**
 - а. Гэрлэлт цуцлуулах*
 - б. Асран хамгаалагч тогтоосныг хүчингүйд тооцох*
 - в. Төрийн эрх ашиг хөндөгдсөн иргэний хэрэг*
 - г. Хүүхдийн тэтгэлэг тогтоох*
- 5. Төлөөлөгчийн бүрэн эрхийг нотлох бичиг баримтад эдгээрийн аль хамаарахгүй вэ?**
 - а. Иргэний үнэмлэх*
 - б. Гэрлэлтийн гэрчилгээ*
 - в. Төрсний гэрчилгээ*
 - г. МАХН-ын гишүүний үнэмлэх*
- 6. Итгэмжлэлийг нотариатаар гэрчлүүлэх шаардлагатай эсэхэд дүгнэлт хийнэ үү?**
 - а. Шаардлагатай*
 - б. Шаардлагагүй*
 - в. Хуульд заасан тохиолдолд шаардлагатай*
- 7. Гэрээний үндсэн дээр төлөөлөх этгээд нь:**
 - а. Эцэг, эх*
 - б. Харгалзан дэмжигч*
 - в. Асран хамгаалагч*
 - г. Өмгөөлөгч*



8. Сэтгэцийн өвчний улмаас эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон хүмүүсийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй этгээдийг олно уу?
 - а. эцэг, эх
 - б. асран хамгаалагч
 - в. харгалзан дэмжигч
9. Хэргийн оролцогч хэргийн материалыг хуулбарлан олшруулж авах эрхтэй юу?
 - а. тийм
 - б. үгүй
10. Анхан шатны шүүхийн шийдвэрт прокурор давж заалдах гомдол гаргажээ.
 - а. гомдол гаргах эрхтэй
 - б. гомдол гаргах эрхгүй



Бодлого

1. Булган аймгийн Баян-Агт сумын сургуулийн багш Чимгээ түүний ангид сурдаг өнчин Цэцэгээ гэгч 10 настай охиныг харж хандах хүнгүй амьдрал нь хүнд хэцүү байгааг дурьдаж, түүний ээжийн дүү Цолмонг асран хамгаалагчаар тогтоож өгөхийг хүсэж шүүхэд ханджээ.
Энэ тохиолдолд:
 - Ангийн багш Чимгээ шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй юу?
 - Шүүх хэрхэн шийдвэрлэх вэ?
2. Зохиогч Ч. Түвшингийн "Золиос" номыг зөвшөөрөлгүйгээр хувилан хэвлэж зараад ашиг олсон хэвлэлийн "Эхлэл" компанийг зохиогчийн эрх зөрчсөн тул олсон орлого, ашгийг зохиогчид олгуулахаар шаардаж зохиогчдын эвлэлийн хороо шүүхэд ханджээ.
Энэ тохиолдолд:
 - Зохиогчдын эвлэлийн хороо шүүхэд нэхэмжлэх эрхтэй юу?
 - Хууль Зүйн үндэслэлийг тайлбарлана уу?
3. Нэгэн алт мөнгөн эдлэл зардаг дэлгүүрээс алтан эдлэл гэж худалдан авсан Л-ийн ээмэг зүүлт нь алт биш байсныг мэдсэн Л уг дэлгүүрт буцаан өгч мөнгөө авах гэхэд зөвшөөрөөгүй тул улмаар хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах байгууллагад хандсан. Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах байгууллага шүүхэд энэ талаар нэхэмжлэл гаргах эрхтэй юу?
Энэ тохиолдолд:
 - Хууль зүйн үүднээс тайлбарлана уу?



Даалгавар:

- Хэргийн оролцогч нэхэмжлэгчээс эрх зүйн байдлын хувьд ялгагдах ялгаа байгаа эсэхийг харьцуулан схемлэж ойлголт авах.
- Бусдын эрх ашгийг хамгаалан оролцсон хэргийн жишээ тус бүр 2-ыг олж тайлбарлах.
Төлөөлөгчийн бүрэн эрхийн талаар дэлгэрэнгүй тайлбарыг бичнэ үү?



Эх сурвалж:

- Үндсэн Хуулийн 16.14
- ИХШХШТХ-ийн 3-р зүйл
- ИХШХШТХ-н 12.1.2
- ИХШХШТХ-н 31.2.3.



IV БҮЛЭГ. ХЭРГИЙН БА ШҮҮХИЙН Харъяалал

ХЭРГИЙН ХАРЪЯАЛЛЫН ОЙЛГОЛТ, ТӨРӨЛ. ШҮҮХИЙН ХАРЪЯАЛАЛ, АНГИЛАЛ, ТӨРӨЛ

Сэдвийн зорилго: Хэргийн болон шүүхийн харъяаллын үндсэн ойлголт, төрөл, ялгааны талаар онолын мэдлэгтэй болох, иргэний хэргийн харъяаллыг тогтоох чадвартай болно.

Сэдвийн агуулга:

- Хэргийн харъяаллын ойлголт, онцлог
- Хэргийн харъяаллын төрөл
- Шүүхийн харъяаллын ойлголт, онцлог
- Шүүхийн харъяаллын төрөл
- Нутаг дэвсгэрийн харъяалал, төрөл
- Шүүхийн онцгой харъяаллын зохицуулалт
- Хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн харъяалал



Нэр томъёоны тайлбар

Хэргийн харъяалал - Энэ нь хэрэг маргаан ямар байгууллагад харъяалагдан шийдвэрлэгдэх вэ гэдгийг тодорхойлдог ойлголт юм.

Нөхцөлт харъяалал - Шүүх хэрэг маргааныг хянан шийдвэрлэхээс өмнө өөр байгууллага тухайн маргааныг урьдчилан хянан шийдвэрлэсэн байхыг нөхцөлт харъяалал гэнэ.

Тусгай харъяалал - Хэрэг маргааныг зөвхөн шүүх харъяалан шийдвэрлэхийг тусгай харъяалал гэнэ.

Сонгох харъяалал - Хэрэг маргааныг шийдвэрлэвэл зохих хэд хэдэн байгууллага байгаа тохиолдолд маргааныг шийдвэрлүүлэх байгууллагыг сонгох боломж байдаг. Үүнийг хэргийн сонгох харъяалал гэнэ.

Шүүхийн харъяалал - Хэрэг, маргааныг Улсын дээд шүүх, аймаг, нийслэл, сум буюу сум дунд, дүүргийн шүүхийн аль нь харъяалж шийдвэрлэх вэ гэдэг нь шүүхийн харъяалал болно.

Шүүх бусдын гаргасан нэхэмжлэл, хүсэлтийг хянан шийдвэрлэхэд хэргийн ба шүүхийн харъяаллын асуудал чухал ач холбогдолтой.

Иргэн, хуулийн этгээдээс шүүхэд мэдүүлэх эрхийн хүрээнд, зөрчигдсөн эрх, ашгаа хамгаалуулахаар гаргасан нэхэмжлэл, хүсэлт, гомдлыг шүүхээс шийдвэрлэх боломжтой эсэх, уг асуудлыг шийдвэрлэх өөр байгууллага, хуулийн этгээд байна уу? гэдгийг тогтоосноор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлдэг. Энэ нь материаллаг эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд үүссэн маргаан нь шүүхэд харъяалагдан шийдвэрлэх үндэслэлтэй байвал иргэний хэрэг үүсгэж, эцэслэн хянан шийдвэрлэх гол үндэслэл болно гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл шүүх хэрэг, маргааныг харъяалан шийдвэрлэх асуудал нь шүүхэд мэдүүлэх эрхийг хэрэгжүүлэх хууль зүйн урьдчилсан нөхцөл мөн гэдгийг сайтар ойлгон судалбал зохих юм.


Хэргийн харъяалал гэдэг нь тухайн маргаан ямар байгууллагад харъяалагдахыг илэрхийлэх бөгөөд шүүх шийдвэрлэх хэргийн (иргэний, гэр бүлийн, хөдөлмөрийн, тэтгэврийн, тэтгэмжийн) хэмжээ, хүрээг зааглан тогтоож өгдөг ойлголт юм.

Хэргийн харъяаллын тухай ойлголтыг тодорхой болгохын тулд ямар шалгуураар маргааныг ялган зааглах вэ гэдэгт анхаарлаа хандуулж, маргаантай байгаа материаллаг эрх зүйн харилцааны онцлог, түүнд оролцогч субъектын бүрэлдэхүүн, маргагч талуудын хооронд байгуулагдсан гэрээ, хэлцлийн байдал, мөрдөгдөж буй хууль тогтоомжийн онцлог зэргийг түүнд хамааруулан судалвал зохино.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн хичээлийн явцад энэхүү сэдвийг судлах нь зарим оюутнуудад ихээхэн хүндрэлийг учруулдаг. Учир нь

1. ИХШХШЭЗ- н хичээлийг эхлэн судалж, энэ салбар шинжлэн ухааны олон янзын категори, нэр томъёо түүний агуулгыг бүрэн гүйцэд ойлгож, мэдэж чадаагүй байхдаа энэ сэдвийг судлах зайлшгүй шаардлага гардаг.
2. Хэргийн харъяаллыг тодорхойлсон хэм хэмжээ нь материаллаг болон процессын эрх зүйн харилцааг зохицуулсан олон тооны хуульчилсан актуудад тусгагдсан байдаг. Хэрэв эрхийн хамгаалалтыг зөвхөн шүүхийн журмаар хэрэгжүүлэхээр тогтоосон, бүх төрлийн эрх зүйн маргааныг шүүх дангаараа шийдвэрлэхээр заасан бол хэргийн харъяаллын асуудал хялбархан байх боломжтой юм. Гэтэл хууль тогтоомжид эрхийн хамгаалалтыг зөвхөн шүүхийн журмаар хэрэгжүүлэхээр тусгаснаас гадна эрхийн хамгаалалтын өөр хэд хэдэн хэлбэрийг зааж өгсөн байдаг. Эрхийн хамгаалалтын өөр бусад ямар хэлбэр байдаг талаар ИХШХШТХ болон материаллаг эрх зүйн харилцааг зохицуулсан хууль тогтоомжоос зайлшгүй судалж мэдэх ёстой юм.
3. Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд шүүхэд харъяалагдах хэрэг маргааны тоо нэмэгдсээр байдаг. Шүүхэд харъяалагдах хэрэг, маргаан нь байнгын, тогтмол байх шинжийг агуулдаггүй.

Ихэнх судлаач, эрдэмтэд хэргийн харъяалал нь альтернатив, нөхцөлт, тусгай гэсэн төрөлтэй байна гэдэг талаар нэгдсэн үзэл баримтлалыг дэвшүүлдэг бөгөөд төрөл тус бүрийн агуулга, онцлогийг авч үзвэл зохино.





Хэргийн харъяаллын хүрээнд шүүхийн харъяалан шийдвэрлэдэг хэргийн талаар тодорхой ойлголт авснаар Арбитрын шийдвэрлэх маргааныг шүүхийнхээс зааглаж тогтоож чаддаг болно. Доорх бүдүүвчээс арбитр шийдвэрлэх хэргийг харна уу?

Арбитрын харъяалал

Хууль, Монгол улсын олон улсын гэрээнд заасан буюу зохигч хэлэлцэн тохиролцсон бол иргэн, хуулийн этгээдийн хооронд үүссэн маргааныг арбитр шийдвэрлэнэ.

Талууд байгуулсан гэрээндээ маргаан гарвал арбитраар шийдвэрлүүлэхээр заагаагүй буюу энэ талаар хэлэлцэн тохиролцоогүй, эсхүл Засгийн газар хоорондын хэлэлцээрээр маргааныг арбитраар шийдвэрлүүлэхээр заагаагүй бол нэхэмжлэлийг шүүх шийдвэрлэнэ.

Хэрэг маргаан нь шүүхэд харъяалагдаж байгаа тохиолдолд шүүх дотроо аль шүүх хэргийг шийдвэрлэх вэ? гэдэг асуулт гарч ирэх нь зайлшгүй юм.

Хэрэг, маргааныг Улсын дээд шүүх, аймаг, нийслэл, сум буюу сум дунд, дүүргийн шүүхийн аль нь харъяалж шийдвэрлэх вэ гэдэг нь шүүхийн харъяалал болно. Оюутан иргэний бүх хэрэг маргааныг зөвхөн анхан шатны шүүх буюу сум ба сум дундын, дүүргийн шүүх хянан шийдвэрлэх бөгөөд аймаг нийслэлийн шүүх давж заалдах шатны, Дээд шүүх зөвхөн хяналтын шатны шүүхийн чиг үүргийг гүйцэтгэх талаар бүдүүвчээс үзнэ үү?

Иргэний хэргийг шийдвэрлэх шүүхийн харъяалал

Сум, сум дундын, дүүргийн шүүх хэргийг анхан шатаар шийдвэрлэх

Аймаг, нийслэлийн шүүх хэргийг давж заалдах шатаар хянах

Дээд шүүх хэргийг давж заалдах шатаар хянах

Дээд шүүх хэргийг хяналтын шатаар хянах

Дээд шүүх хэргийг анхан шатаар хянах

Шүүхийн харъяалал нь:

1. Нутаг дэвсгэрийн нийтлэг харъяалал
2. Нутаг дэвсгэрийн сонгох харъяалал
3. Шүүхийн онцгой харъяалал гэсэн төрөлтэй байна.

Нутаг дэвсгэрийн нийтлэг харъяаллын дагуу нэхэмжлэлийг хариуцагчийн оршин сугаа газрын харьяа шүүхэд гаргана. Харин нутаг дэвсгэрийн сонгох харъяалал ямар байх талаар доорх схемээс үзнэ үү?

Нутаг дэвсгэрийн сонгох харъяалал

Бусдын амь бие, эрүүл мэндэд гэм хор учруулсны хохирлыг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг хариуцагч, эсхүл нэхэмжлэгийн оршин суугаа газрын шүүхэд гаргаж болно.

Гэрээнд үүрэг гүйцэтгэх газрыг тусгайлан заасан бол түүнтэй холбогдсон нэхэмжлэлийг уг гэрээг биелүүлбэл зохих газрын шүүхэд гаргаж болно.

Өөр өөр газар оршин суугаа /оршин байгаа/ хэд хэдэн хариуцагчдад холбогдох нэхэмжлэлийг нэхэмжлэгч өөрийн үзэмжээр хариуцагчийн аль нэгний оршин суугаа /оршин байгаа/ газрын шүүхэд гаргана.

Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоолгох тухай нэхэмжлэлийг иргэн, хуулийн этгээд өөрийн оршин суугаа /оршин байгаа/ газрын, эсхүл тухайн үйл явдал болсон газрын шүүхэд гаргана.



Хяналтын асуулт

1. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь харъяаллын зохицуулалтын мөн чанар, ач холбогдлыг гаргана уу?
2. Хэргийн харъяалал, шүүхийн харъяаллын ялгааг тодорхойлно уу?
3. Хэргийн харъяалалтай холбоотой жишээ гарган, шүүхийн харъяалалтай холбон тайлбарлана уу?
4. Нутаг дэвсгэрийн харъяаллын төрлөөр жишээ гарган тайлбарлана уу?
5. Шүүхийн онцгой харъяаллын агуулга, ач холбогдлыг гаргана уу?
6. Хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн харъяалал, шүүхийн харъяалал хоёрын ялгааг тодорхойлно уу?
7. Хэргийн болон шүүхийн харъяаллыг буруу тогтоовол ямар үр дагавар үүсэх вэ?



Сорил

1. **Хариуцагч нь хуулийн этгээд байвал нэхэмжлэлийг :**
 - а. Татварын байгууллагад бүртгүүлсэн газрын харъяа шүүхэд
 - б. Ажил хэргээ байнга явуулдаг газрын харъяа шүүхэд
 - в. Удирдах байгууллага байгаа газрын харъяа шүүхэд
 - г. Хуулийн этгээдийн эд хөрөнгө байгаа газрын харъяа шүүхэд тус тус гаргана.
2. **Гадаад улсад байгаа Монгол Улсын иргэнтэй холбоотой нэхэмжлэлийг аль шүүхэд гаргах вэ?**
 - а. Хариуцагчийн эд хөрөнгө байгаа газрын харъяа шүүхэд
 - б. Нэхэмжлэгч өөрийн оршин суугаа газрын харъяа шүүхэд



- в. Энэ тохиолдолд зөвхөн эрэн сурвалжлуулахаар хүсэлт гаргах тул аль шүүхэд вэ гэдгийг нэхэмжлэгч сонгох эрхтэй
 - г. Хариуцагчийн оршин суугаа газрын харъяа шүүхэд
- 3. Хүүхдээ тэжээн тэтгүүлэхээр гаргасан нэхэмжлэлийг аль шүүхэд гаргах вэ?**
- а. Нэхэмжлэгч өөрийн оршин суугаа газрын харъяа шүүхэд
 - б. Хариуцагчийн оршин суугаа газрын харъяа шүүхэд
 - в. Нэхэмжлэгч, хариуцагч тохиролцвол аль алиныхаа оршин суугаа газрын харъяа шүүхэд сонгон гаргаж болно
 - г. Зөвхөн хүүхдийн оршин суугаа газрын харъяа шүүхэд гаргана
- 4. Үйлдвэрийн осол болсныг тогтоолгохоор гаргасан хүсэлтийг ямар шүүхэд гаргах вэ?**
- а. Нэхэмжлэгч өөрийн оршин суугаа газрын шүүхэд
 - б. Хариуцагчийн оршин суугаа газрын шүүхэд
 - в. Осол гарсан газрын харъяа шүүхэд
- 5. Бусдын эрүүл мэндэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг нэхэмжлэгч өөрийн эмчлүүлж байгаа газрын харъяа шүүхэд гаргажээ.**
- а. Болно
 - б. Болохгүй

Σ

Бодлого

1. Далай тээврийн яамнаас ТШ/02/ДТЯ-01 дугаар бүхий “Техник нийлүүлэх” нээлттэй тендер шалгаруулалтыг зарласан. Тендэр шалгаруулалтад 5 аж ахуй нэгж тендэрийн материалаа ирүүлсэн байна. Уг тендер шалгаруулалтад оролцсон Солонгос улсын “D” ХХК-иас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 1-д заасны дагуу үнэлгээг нарийвчлан үзэх талаар захиалагч байгууллагад гомдол гаргасан байна. Захиалагч дээр дурьдсан хуулийн 54.2-т заасныг удирдлага болгон гомдлыг авч үзэн “D” ХХК-нийг тус хуулийн 5.1.21-д заасан “гадаадын этгээд” гэж тодорхойлсон шаардлагыг хангаагүй гэдэг үндэслэлээр үнэлгээнээс хассан нь хууль зүйн дагуу байна гэсэн шийдвэрийг гаргасан. “D” ХХКТөрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55.1-д заасныг үндэслэн Төрийн захиргааны төв байгууллагад гомдлоо гаргасан. Тухайн үед “Тендер нийлүүлэх” тендерт шалгарсан гүйцэтгэгч аж ахуй нэгжтэй гэрээ байгуулах зөвшөөрөл хүссэн албан бичгийг захиалагчаас Төрийн захиргааны төв байгууллагад ирүүлээд байсан байна. Энэ тохиолдолд:
- Гомдлыг Төрийн захиргааны тав байгууллага шийдвэрлэх боломжтой эсэхэд дүгнэлт хийнэ үү?

- Шүүх гомдлыг хянан шийдвэрлэх үү?
- 2. Дор дурьдсан тохиолдлуудад хэргийн ба шүүхийн харъяаллыг тодорхойлно уу?
 - Хөдөлмөрийн гэрээгээр нэгэн үйлдвэрт ажилладаг Сүрэнжав ажлын үр дүнгийн шагналаас хассан ажил олгогчийн тушаалыг эс зөвшөөрөв. Сүрэнжав хаана, хэнд хандахаа мэдэхгүй байв.
 - 1976-1979 онуудад Дорноговь аймгийн Сайншанд сумын 10 жилийн дунд сургуулийн математикийн багшаар ажиллаж байснаа тогтоолгохоор өөрийн оршин суугаа газрын харьяа Нийслэлийн Баянгол дүүргийн шүүхэд хүсэлт гаргасан байна.
- 3. Цэцгээ 3,1 нас хүрээгүй 2 хүүхэддээ болон өөртөө тэтгэлэг тогтоолгохоор шүүхэд нэхэмжлэл гаргажээ. Түүний нөхөр Самбуу Нийслэлийн Баянзүрх дүүрэгт, харин Цэцгээ хүүхдүүдийнхээ хамт Налайх дүүрэгт амьдардаг. Цэцгээ аль шүүхэд нэхэмжлэлээ гаргах вэ?
- 4. Чимгээ 15 настай, үрчлэгдсэн хүүхэд бөгөөд БЗД-ийн 2 дугаар хороонд амьдардаг. Тэрээр Баянгол дүүргийн шүүхэд нэхэмжлэл гаргаж, өөрийнхөө төрсөн эцгээр Балдоржийг тогтоолгохыг хүссэн байна.
- 5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч хураагдсан эд хөрөнгийн үнэлгээг зохих хууль тогтоомжийн дагуу хийгээгүй тухай төлбөр төлөгчийн гомдол
- 6. Сэргэлэн нь нас барсан, хамтран амьдрагч Нямдоржийн өмчлөлийн БГД-ийн 3-р хорооллын 14-35 тоот орон сууцны өв залгамжлагчаар тогтоолгохыг хүсэж, Чингэлтэй дүүргийн шүүхэд нэхэмжлэл гаргажээ.
- 7. Ховд аймгийн Ховд суманд амьдардаг Анхаа Говь- Алтай аймгийн Алтай суманд үйл ажиллагаа явуулдаг эсгийний үйлдвэрт ажиллаж байхдаа 2004 оны 5 дугаар сард үйлдвэрийн осолд орж хөдөлмөрийн чадвараа алджээ. Тэрээр өөрийн эрүүл мэндэд учирсан гэм хорын хохирол болох 500000 төгрөгийг гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргажээ.

**Даалгавар:**

- Хэргийн харъяаллыг зааглах шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, практик жишээ гарган тайлбарлана уу?
- Шүүхийн харъяаллыг хэрхэн тогтоох вэ?
- Шүүхийн харъяаллыг тодорхойлсон, бодлого бодож хэлэлцэнэ үү?
- Монгол Улсын Иргэний хуулийн 1, 12, 13, 14, 15, 16, 17, 20, дугаар зүйлүүдийг харьцуулан судална уу?

**Эх сурвалж:**

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он.
2. Монгол Улсын Иргэний хууль. 2002 он.
3. ИХШХШТухай хууль. 2002 он.
4. Эрүүгийн байцаан шийтгэх хууль. 2002 он.
5. Захиргааны хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх журмын тухай хууль 2003 он.
6. Арбитрын тухай хууль. 2003 он



ШҮҮХИЙН ХАРЪЯАЛЛЫН ОНЦЛОГ, ШҮҮХИЙН ХАРЪЯАЛАЛТАЙ ХОЛБОГДУУЛАН ХИЙГДЭХ АЖИЛЛАГААНУУД

Сэдвийн зорилго: Шүүхийн харъяалал, түүнтэй холбогдон хийх ажиллагаануудын талаар онолын мэдлэгтэй болох, харъяалалтай холбогдон гарах асуудлыг хууль зүйн дагуу шийдвэрлэх чадвартай болох, иргэний хэрэг үүсгэхдээ харъяаллын асуудалд анхаарал хандуулдаг болно.

Сэдвийн агуулга:

- Хэргийн нутаг дэвсгэрийн харъяаллыг зохигч хэлэлцэн өөрчлөх нь
- Хоорондоо холбоотой хэд хэдэн хэргийн шүүхийн харъяалал, онцлог
- Хэрэг шилжүүлэх үндэслэл
- Нэхэмжлэлийг нэхэмжлэгчид буцаах үндэслэл
- Шилжүүлсэн хэргийг хүлээн авсан шүүхийн үүрэг
- Хэрэг шилжүүлэх журам
- Хэрэг шилжүүлэх тухай шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гомдол гаргах нь



Нэр томъёоны тайлбар

Харъяаллыг өөрчлөх - Хэргийн нутаг дэвсгэрийн харъяаллыг зохигч хэлэлцэн өөрчилж болно. Харин шүүхийн онцгой харъяаллыг зохигч хэлэлцэн өөрчилж болохгүй.

Хэрэг шилжүүлэх - Харъяаллын дагуу нэхэмжлэлийг хүлээн авсан бол шүүх хэргийг хянан шийдвэрлэнэ. Шүүх нэхэмжлэлийг хүлээж авахдаа шүүхийн харъяаллыг зөрчсөн, хэргийг нотлох баримтын дийлэнх нь байгаа газрын шүүх шийдвэрлэх шаардлагатай гэж үзсэн, хэргийг шийдвэрлэх шүүхийн бүх шүүгчийг татгалзан гаргасан тохиолдолд хэргийг шилжүүлэх тухай ойлголт гарч ирнэ.

Арбитр - Арбитрын хууль тогтоомжийн дагуу нэхэмжлэгч, хариуцагч маргаанаа шийдвэрлүүлэхээр харилцан тохиролцож сонгосон маргаан шийдвэрлэх байгууллага.

Хэргийн болон шүүхийн харъяалал зөрчигдөөгүй тохиолдолд хэргийг тухайн шүүх эцэслэн шийдвэрлэнэ. Зарим үед нэхэмжлэлийг шүүх хүлээн авахдаа шүүхийн харъяаллыг зөрчсөн, иргэний хэргийг шийдвэрлэх бүх шүүгчдийн татгалзан гаргасан, хэргийг тал бүрээс нь бодитой шийдвэрлэхийн тулд нотлох баримтын дийлэнх байгаа газрын харъяа шүүхэд шийдвэрлэх шаардлага хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад илэрдэг. Энэ тохиолдолд хэрэг шилжүүлэх ажиллагааг шүүх өөрийн болон зохигчдын хүсэлтээр анхан шатны шүүх хуралдаанаас өмнө буюу хуралдааны явцад гүйцэтгэх боломжтой ба шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана.

Хэрэг маргаан нь арбитрт харъяалагдана гэдгийг нэхэмжлэл хүлээн авахад шууд мэдэх боломжгүй байснаас шүүх хүлээн авч иргэний хэрэг үүсгэсэн бол иргэний хэргийг арбитрт шууд шилжүүлэх үндэслэлгүй. Учир нь арбитр нь хэдийгээр маргаан шийдвэрлэдэг байгууллага боловч шүүхийн тогтолцоонд үл хамаарах учраас хэргийг шилжүүлэх боломжгүй. Ийм учраас нэхэмжлэлийг нэхэмжлэгчид буцаах зохицуулалттай.

Хэргийг нэг шүүхээс нөгөө шүүхэд шилжүүлэхэд шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж гаргана. Энэхүү тогтоол, захирамжид гомдол гаргах эрхтэй ба гомдол гарсан бол гомдлыг тухайн шатны шүүх бүрэлдэхүүн хэлэлцэж, хэвээр баталсан бол хэргийг шилжүүлнэ. Хэргийн оролцогчид мэдэгдэлгүйгээр хэрэг шилжүүлэх ажиллагаа явуулах нь хууль зөрчсөн ажиллагаа болно.



Хяналтын асуулт

1. Хэргийн нутаг дэвсгэрийн харьяаллыг зохигч хэлэлцэн өөрчлөх зохицуулалтыг ИХШХШЭЗүйн зарчмуудтай холбон тайлбарлана уу?
2. Хоорондоо холбоотой хэд хэдэн хэрэг гэж юуг ойлгох вэ? Жишээ гарган тайлбарлана уу?
3. Хэрэг шилжүүлэх үндэслэл тус бүрийг тайлбарлана уу?
4. Хэрэг шилжүүлэх тухай шүүхийн тогтоолын төсөл гаргана уу?
5. Хэрэг шилжүүлэх шүүгчийн захирамжид гомдол гаргах жишээ хэлнэ үү?
6. Арбитрт харьяалагдах хэргийг яагаад арбитрт шилжүүлэхгүйгээр нэхэмжлэлийг нэхэмжлэгчид буцаах шийдвэр гаргадаг вэ?
7. Тухайн шүүхийн бүх шүүгчийг татгалзан гаргаснаар хэргийг шилжүүлсэн шүүхийн тогтоолын төсөл боловсруулна уу?



Сорил

1. **Хэргийн харьяалал, шүүхийн харьяалал гэдэг ойлголтууд адил уу?**
 - а. ИХШХШТХ-ийн 13,14 дүгээр зүйлд зааснаар эдгээр нь адилхан ойлголт
 - б. Эдгээр нь ямар төрлийн маргааныг ямар шүүх шийдвэрлэх вэ гэдгийг зохицуулсан журам мөн
 - в. Шүүхийн харьяалал бол шүүхүүд ямар, ямар хэргийг хянан шийдвэрлэх вэ гэдгийг зохицуулсан асуудал болно
 - г. Хэргийн харьяалал бол эрх зүйн маргааны дотроос ямар маргааныг иргэний хэрэг гэж үзэж шүүх шийдвэрлэх вэ гэдэг ойлголт бөгөөд энэ хэргийг ямар шүүх хүлээн авч шийдвэрлэх вэ гэдэг эрх хэмжээг тогтоосон журмыг шүүхийн харьяалал гэнэ
2. **Хариуцагч этгээдийн хаяг мэдэгдэхгүй бол нэхэмжлэлийг хаана гаргах вэ?**
 - а. Эд хөрөнгө нь байгаа газрын шүүхэд
 - б. Гэр бүл, эцэг эхийнх нь байгаа газрын шүүхэд
 - в. Ажиллаж байсан газрынх нь харьяалах шүүхэд
 - г. Аймаг, нийслэлийн буюу дээд шатны шүүхэд
3. **Насанд хүрээгүй Хорлоогийн эрүүл мэндэд авто ослын улмаас хохирол учруулсан тухайн нэхэмжлэлийг нэхэмжлэгч өөрийн оршин суугаа газрынхаа шүүхэд гаргаж болох уу?**
 - а. Аль ч нэхэмжлэлийг хариуцагчийн байгаа газрын шүүхэд гаргах тул хориглоно
 - б. Нэхэмжлэгч өөрөө хүссэн тохиолдолд зөвшөөрнө



- в. *Нэхэмжлэгчийн харъяалах шүүх зөвшөөрсөн учир болно*
- г. *Бусдын амь бие, эрүүл мэндэд гэм хор учруулсны хохирлыг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг хариуцагчийн төдийгүй нэхэмжлэгчийн оршин суугаа газрын шүүхэд гаргаж болно*
4. **Гэрээнд үүрэг гүйцэтгэх газрыг тусгайлан заасан бол түүнтэй холбогдсон нэхэмжлэлийг аль шүүхэд гаргах вэ?**
 - а. *Үүрэг гүйцэтгэвэл зохих газрын шүүхэд*
 - б. *Нэхэмжлэгчийн байгаа газрын шүүхэд*
 - в. *Нэхэмжлэгчийн сонгосон шүүхэд*
 - г. *Хариуцагчийн байгаа газрын шүүхэд*
5. **Өөр өөр газар оршин суугаа хэд хэдэн хариуцагчтай нэхэмжлэлийг аль шүүхэд гаргах вэ?**
 - а. *Тус тусад нь харъяалах шүүхэд нэхэмжлэлийг гаргана*
 - б. *Хариуцагч гол этгээдэд хандаж нэхэмжлэлийг гаргана*
 - в. *Нэхэмжлэгч өөрөө байгаа газрын шүүхдээ гаргана*
 - г. *Нэхэмжлэгч үзэмжээрээ хэн нэгний оршин байгаа газрын шүүхэд нэхэмжлэл гаргана*
6. **ИХШХШТХ-иар тогтоосон шүүхийн харъяаллыг зохигч хоорондоо тохиролцон өөрчилж болох уу?**
 - а. *Хэргийн нутаг дэвсгэрийн харъяаллыг зохигч харилцан тохиролцон тогтоож болно*
 - б. *Шүүхийн харъяаллыг зохигч өөрчилж болохгүй*
 - в. *Нэхэмжлэлийг хүлээн авах шүүх зөвшөөрсөн бол хэргийн нутаг дэвсгэрийн харъяаллыг өөрчилж болно*
 - г. *Улсын дээд шүүх зөвшөөрсөн бол шүүхийн харъяаллыг өөрчлөн тогтоож болно*
7. **Сум, сум дундын болон дүүргийн шүүх, иргэний ямар ямар хэргүүдийг хянан шийдвэрлэх вэ?**
 - а. *Аймаг нийслэл, улсын дээд шүүхэд харъяалагдахаас бусад иргэний хэргүүдийг*
 - б. *Иргэний бүх төрлийн хэргүүдийг*
 - в. *Захиргааны эрх зүйн харилцаанаас үүссэнээс бусад иргэний хэрэг*
 - г. *Гэр бүл, захиргааны харилцаанаас үүссэнээс бусад бүх иргэний хэрэг*
8. **Аймаг нийслэлийн шүүх, иргэний ямар ямар хэргүүдийг хянан шийдвэрлэх вэ?**
 - а. *10 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй иргэний бүх төрлийн хэрэг*
 - б. *Хариуцагч нь сум, сум дунд болон дүүргийн шүүх оролцсон иргэний хэрэг*
 - в. *Давж заалдсан гомдолтой хэрэг*
 - г. *Улсын дээд шүүхээс харъяаллыг тогтоон өгсөн хэрэг*
9. **Хэргийг харъяаллын дагуу шилжүүлэх тохиоодолд ямар акт гаргах вэ?**
 - а. *Шүүгч захирамж гаргана*
 - б. *Шүүхийн тогтоол эсвэл албан бичгээр*
 - в. *Шүүгчийн албан бичгээр*
 - г. *Шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолоор*



Бодлого

1. Иргэн Алдар Нийслэлийн Баянзүрх дүүргийн гэр хорооллын захдуу нэгэн газрыг өмчилдөг бөгөөд газар дээрээ хашаа, байшин барьжээ. Түүний газрын зэргэлдээ “Оч” компани тоосгоны үйлдвэр шинээр байгуулсан ба энэ үйлдвэрээс нарийн тоос ялгардаг учраас Алдар өөрийн байшингийн цонхыг онгойлгож чаддаггүй болсон байна. “Оч” компаний захиргаа Сүхбаатар дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг.

Энэ тохиолдолд:

- Алдар “Оч” компанид холбогдуулан нарийн тоос ялгаруулахгүй байх, түүнтэй холбогдсон хохирол гаргуулах нэхэмжлэлээ аль шүүхэд гаргах вэ?
- Шүүх маргааныг хэрхэн шийдвэрлэх вэ?

2. 14 настай Нямдорж Нийслэлийн БЗД-ийн 3-р хороонд оршин суудаг. Тэрээр түүнийг 3 настай байхад нь хаяад явсан, Налайх дүүргийн 2 дугаар хороонд оршин сууж байгаа Сүрэнг өөрийн эцгээр тогтоолгохоор Налайх дүүргийн шүүхэд хүсэлт гаргажээ.

Энэ тохиолдолд:

- Хэргийн болон шүүхийн харьяаллыг тодорхойлно уу?



Даалгавар:

- Шүүхийн харьяаллын талаар маргаантай иргэний хэргийн материалтай танилцаж, дүгнэлт бичих
- Хэргийн оролцогчоос хэрэг шилжүүлэх талаар гаргах хүсэлтийн төсөл бэлтгэх
- Хэрэг шилжүүлэх ажиллагааны талаар баримталдаг журмыг тодорхойлон шүүгчийн захирамжийн төсөл бэлтгэх
- Арбитрт харьяалагдах нэхэмжлэлийг шүүх хүлээн авч иргэний хэрэг үүсгэсэн бол шүүх ямар ажиллагаа явуулах талаар хэлэлцэх
- Шилжүүлсэн хэргийг хүлээн авсан аль ч шүүх хэргийг шийдвэрлэхээс татгалзах эрхгүй гэдгийг хэрхэн ойлгож, тайлбарлах



Эх сурвалж:

- Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он.
- Монгол Улсын Иргэний хууль. 2002 он.
- ИХШХШТухай хууль. 2002 он



V БҮЛЭГ. НОТЛОХ БАРИМТ

НОТЛОХ БАРИМТЫН ОЙЛГОЛТ, АНГИЛАЛ

Сэдвийн зорилго: Нотлох баримт, түүний онцлог шинж, ангилалтын талаар онолын цогц мэдлэгтэй болж, түүнийг тодорхой хэрэг, маргааныг шийдвэрлэхэд хэрэглэх чадвар эзэмшинэ.

Сэдвийн агуулга:

- Нотлох баримтын тухай ойлголт
- ИХШХША-ны нотлох баримтын онцлог шинж
- Нотлох баримтыг нотолгооны шинж, эх үүсвэр олох аргаар ангилах нь.
- Нотлох баримтыг ангилахын ач холбогдол
- Нотлох баримт ба иргэний хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйн зарчмын харилцан хамаарал



Нэр томъёоны тайлбар

Нотлох баримт - Хэргийн оролцогчоос өөрийн шаардлага ба татгалзлаа үндэслэж байгаа, шүүх хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, хуульд заасан арга хэрэгслээр олж авсан бодит нөхцөл байдлыг тогтооход шаардлагатай аливаа баримтаг мэдээллийг нотлох баримт гэнэ.

Анхдагч ба дамжмал нотлох баримт - Нотлох баримтыг олох аргаар нь анхдагч ба дамжмал нотлох баримт гэж ангилна. Нэхэмжлэлийн үндэслэл, хариуцагчийн татгалзлыг баталж байгаа, эсхүл үгүйсгэж байгаа нөхцөл байдлуудыг байгаа байдлаар шууд сонсож мэдсэнээр нь тодорхойлохыг анхдагч нотлох баримт гэнэ. Ямар нэгэн эх сурвалжаас дамжуулан авсан баримт сэлтийг дамжмал нотлох баримт гэнэ.

Шууд ба шууд бус нотлох баримт - Нотлох баримтыг нотолгооны шинжээр нь шууд ба шууд бус нотлох баримт гэж ангилна. Хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлыг шууд нотолж, батлан эсхүл үгүйсгэж байгаа нотлох баримтыг шууд нотлох баримт гэнэ. Шууд бус нотлох баримт нь хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтыг шууд тодорхойлохгүй, харин түүнийг шууд бусаар нотолдог.

Нотлох баримтын хамааралтай байх шинж - Энэ нь шүүхэд хянагдаж буй хэрэгт хамааралтай бүх факт, нөхцөл байдлыг тодруулан судлах үйл ажиллагаа бөгөөд тухайн хэрэгт хамааралгүй нотлох баримтыг хүлээж авахгүй байхыг шүүгчид үүрэг болгодог.

Хууль зүйн онолын ном зохиолд нотлох баримтын ойлголтыг тодорхойлохын тулд олон үзэл баримтлалыг дэвшүүлсэн байдаг. Түүнээс тоймлон үзүүлбэл:

- Нотлох баримт бол хуульд заасан нотолгооны хэрэгсэл, мөн түүнээс гарган авч байгаа шүүх хэргийн нөхцөл байдлыг тогтооход үндэслэл болгодог мэдээ, мэдээлэл юм.
- Нотлох баримт гэдэг нь арга хэрэгсэл бөгөөд түүний тусламжтайгаар аливаа батлахыг хүсэж байгаа бодит байдлын агуулага, шалгагдвал зохих зүйлийн үнэн тогтоогддог.

- Нотлох баримтыг гагцхүү мэдээ, мэдээлэл гэж авч үзэх нь танин мэдэхүйн үүднээс уг ойлголтыг зөвөөр авч үзэх үндэслэл болно.

Нотлох баримтын үндсэн элемент нь түүнд агуулагдаж байгаа мэдээлэл, уг мэдээллийн илрэн гарч буй хэлбэр нь нотолгооны хэрэгсэл юм. (Энэ нь философид тодорхой юмс үзэгдлийн бүх тал, шинж тэмдэг, үйл явцын нэгдлийг агуулга гэдэг бол хэлбэр нь агуулгын оршин тогтнох, хөгжих арга, агуулгын илэрхийлэл болдог хэмээн үздэгтэй холбоотой юм.)

Эдгээр нь нэг юмны хоёр тал буюу агуулга, хэлбэрийн холбоонд оршино.

Иймд хэргийг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий мэдээ, мэдээлэл нь нотлох баримт хэмээх ойлголтын агуулга, харин нотолгооны хэрэгсэл нь түүний илрэн гарах процессын хэлбэр гэж үзэж болох юм. Нотлох баримтын хэлбэр ба агуулгын салшгүй холбоо нь нотолгооны хэрэгсэл болгон мэдээлэл агуулдаг ба шүүх уг мэдээллийг хуульд заасан арга хэрэгслээр дамжуулан танин мэдлэгээр илэрхийлэгддэг.

ИХШХШАжиллагаан дахь нотлох баримтын онцлог шинжүүд:

- Нэхэмжлэлийн факт болон бусад нөхцөл байдлын талаар хэргийг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий мэдээллийг агуулж байдаг. Өөрөөр хэлбэл аливаа нотлох баримт нь иргэний хэргийг шийдвэрлэхэд хамааралтай, маргааныг шийдвэрлэхэд ач холбогдолтой байна.
- Нотолгооны чадвар бүхий мэдээллүүд нь процесс үйл ажиллагаанд илрэх тодорхой хэлбэртэй байна.
- Иргэний хэргийн нотлох баримтыг хуульд заасан арга хэрэгслээр олж авсан байх. Хэргийн оролцогчдоос нотлох баримт гаргах, цуглуулахдаа зөвхөн хуульд заасан арга хэрэгслээр олж авах ёстой. Нэхэмжлэгч, хариуцагчаас бусдыг хуурч мэхлэх, төөрөгдүүлэх, айлган сүрдүүлэх зэрэг хууль бус аргаар олж авсан баримт мэдээлэл нь нотлох баримт болж чадахгүй. Тийм ч учраас нотлох баримтыг гаргах, цуглуулах, бүрдүүлэх зэрэг үйл ажиллагаа нь хуулиар нарийвчлан зохицуулагддаг.
- Иргэний хэргийн нотлох баримт нотолгооны хэрэгслээр тогтоогдоно. Нотолгооны хэрэгсэлд хэргийн оролцогчдын тайлбар, гэрчийн мэдүүлэг, бичмэл нотлох баримт, шинжээчийн дүгнэлт, эд мөрийн баримт, кино ба гэрэл зураг, дүрс дууны бичлэг, ул мөрнөөс буулгаж авсан хэв. үзлэг, туршилт, таньж олуулах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл зэрэг хамаарна.
- Хэргийн оролцогчид өөрсдийн шаардлага ба татгалзлын үндэслэл болгон гаргасан нотлох баримт нь хэргийн бодит нөхцөл байдлыг тогтооход ач холбогдолтой байна.

Дээр дурьдсанаас үндэслэн “Иргэний хэргийг шүүх хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий хуульд заасан арга хэрэгслээр илэрхийлэгдэж байгаа мэдээллийг иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь нотлох баримт гэнэ” хэмээн тодорхойлох боломжтой.

Нотлох баримттай холбоотойгоор “нотолгооны зүйл” хэмээх ойлголт гарч ирдэг.

Нотолгооны зүйл гэдэг иргэний хэргийг бодитой, үнэн зөв, шийдвэрлэхэд ач холбогдол бүхий шүүхээс тогтоох ёстой нөхцөл байдлыг ойлгоно.

Шүүхээс тогтоовол зохих нөхцөл байдлуудыг

1. Материаллаг эрх зүйн шинжтэй хууль зүйн факт. Энэ нь маргаантай байгаа эрх зүйн харилцааг зөв тодорхойлж, тухайн харилцааг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээг зөв хэрэглэх, хэргийг үнэн зөв шийдвэрлэхэд ач холбогдолтой.



2. Процессын шинжтэй нөхцөл байдлууд. Хэргийн харъяалал тогтоох, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх зэрэг тохиолдолд процесс ажилагаатай холбогдсон нөхцөл байдлыг тогтооно.
3. Шүүх хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий талуудын гаргасан бусад нөхцөл байдлууд

Нотлох баримтыг хэрхэн ангилахыг авч үзвэл:



Хяналтын асуулт

1. ИХШХШЭЗ-н нотлох баримт, түүний онцлог шинжийг тайлбарлана уу?
2. Нотлох баримтын ангиллын талаар хэлэлцэнэ үү?
3. “Нотлох баримт нь хэрэгт ач холбогдолтой байх” гэдэг нь нотлох баримтын ямар чанарыг илэрхийлж байна вэ? /
4. Нотлох баримт нь хамааралтай байх, эргэлзээгүй байх асуудлыг хэн шийдвэрлэх вэ?
5. Нэхэмжлэгч шүүхэд бэлэглэлийн гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцуулахаар нэхэмжлэл гаргахдаа гэрээг эхээр хавсаргав. Нотлох баримтыг ангилна уу?
6. Хэрэгт хамааралгүй, ач холбогдолгүй нотлох баримтыг хэргийн нотлох баримтаас хасах тухай шүүгч захирамж гаргажээ. Түүнийг эс зөвшөөрсөн нэхэмжлэгч гомдол гаргах эрхтэй юу?



Сорил

1. **Нотлох баримт гэж :**
 - а. *Хэргийн оролцогчдоос өөрийн шаардлага ба татгалзлаа үндэслэж байгаа шүүх хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий хуульд заасан хэрэгслээр тодорхойлогдож буй нөхцөл байдлыг хэлнэ.*
 - б. *Хэргийн оролцогчдоос өөрийн шаардлага ба татгалзлаа үндэслэх байгаа, шүүх хэргийг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий хуульд заасан арга хэрэгслээр олж авсан бодит нөхцөл байдлыг тогтооход шаардлагатай аливаа баримтат мэдээллийг хэлнэ.*

2. **Нотлох баримтыг нотолгооны шинжээр нь хэрхэн ангилах вэ?**
 - а. Анхдагч
 - б. Шууд
 - в. Бичгийн
 - г. Дамжмал
3. **Хэргийн нотлох баримт нь дараахь нотолгооны хэрэгслээр тогтоогдоно. Үүнд:**
 - а. Эд мөрийн баримт
 - б. Иргэдийн төлөөлөгчийн дүгнэлт
 - в. Шүүгчийн хэргийн талаар гаргасан мэдээлэл
 - г. Шүүх хуралдааны тэмдэглэл
4. **Гэрч, шинжээч нь нотолгооны хэрэгсэлд хамаарна гэдгийн үнэн зөв эсэхийг тодорхойлно уу?**
 - а. Тийм
 - б. Үгүй
5. **Гадаад улсад байгаа нотлох баримт хэрэгт ач холбогдолтой бол түүнийг бүрдүүлж болох уу?**
 - а. Тусгайлсан журам байвал бүрдүүлж болно
 - б. Бүрдүүлэхийг хуулиар хориглосон байна.
 - в. Болно
 - г. Энэ талаар ямар нэгэн зохицуулалт хуульд байхгүй
6. **Шүүх хуралдааны явцад хэрэгт хамааралгүй, нотолгооны ач холбогдолгүй баримтыг нотлох баримтаас хасах уу?**
 - а. Шүүгч захирамж гаргаж хасаж болно
 - б. Шүүгч энэ асуудлыг хэлэлцэхгүй
 - в. Хэргийн оролцогч энэ талаар хүсэлт гаргасан тохиолдолд хасаж шийдвэрлэнэ
 - г. Энэ талаар хуульд зохицуулалт байхгүй
7. **Иргэний хэргийн нотлох баримтыг шалгах эрхтэй субъектыг нэрлэнэ үү?**
 - а. Шүүх
 - б. Хэргийн оролцогч
 - в. Зохигч
 - г. Хуульд энэ талаар зохицуулалт байхгүй
8. **Иргэний хэргийг хянан шийдвэрлэхэд нотлох баримтыг бүрдүүлэх эрхтэй этгээдийг нэрлэнэ үү?**
 - а. Нэхэмжлэгчийн хүсэлтээр хариуцагч
 - б. Шүүхийн санаачилгаар зохигч
 - в. Шүүхийн санаачилгаар өмгөөлөгч, төлөөлөгч
 - г. Хэргийн оролцогчийн хүсэлтээр шүүх
9. **Иргэн Э нь өөрийн нэр төрийг гутаасан, бодит үнэнд нийцээгүй мэдээ тараасан гэж Х-д холбогдуулан шүүхэд нэхэмжлэл гаргажээ. Э нь хэрэгт ач холбогдолтой нөхцөл байдлыг тогооолгохын тулд Ө-г оролцуулна гээд түүний бичсэн тодорхойлолтыг шүүхэд гаргаж өгөв. Тодорхойлолт нь :**



- а. Нотолгооны ач холбогдолтой баримт мөн
- б. Шүүхэд нотлох баримтыг гаргаж байгаа хэлбэр
- в. Э нотлох баримт гаргах, цуглуулах журат зөрчсөн тул нотлох чадвараа алдана
- г. Аль нь ч биш

10. Иргэн Б бэлэглэлийн гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцуулахаар нэхэмжлэл гаргахдаа гэрээг эхээр нь хавсаргав. Нотлох баримтыг ангилна уу?

- а. Шууд, бичгийн, үүсмэл
- б. Шууд бус, бичгийн, албан ёсны
- в. Шууд, бичгийн, анхдагч
- г. Шууд, албан ёсны бус, бичгийн



Бодлого

1. Хан-Уул дүүргийн иргэн Нямсүрэн Бадарчид холбогдуулан нэр хүндэд учирсан гэм хорын төлбөр нэг сая төгрөгийг гаргуулахыг хүсэж нэхэмжлэл гаргажээ. Бадарч нь Нямсүрэнг ажлаасаа тарахдаа үйлдвэрийн өмч хөрөнгөнөөс байнга хулгай хийдэг гэж захирлын зөвлөлийн хурал дээр мэдээлжээ. Энэхүү мэдээлэл нь бодит үнэнд үл нийцэх тул учирсан хохирлоо нэхэмжилж байна гэжээ.

Энэ тохиолдолд:

- Хэргийн зохигчид нотлох баримтыг шүүхэд гаргаж өгөх талаар тус бүр ямар үүрэг хүлээх вэ?



Даалгавар:

- Нотлох баримт, нотолгооны харилцан хамаарал ямар байх вэ гэдгийг тодорхой жишээ авч тайлбарлах
- Нотлох баримтын онцлог шинжийг нотолгооны хэрэгсэл тус бүрээр гаргах
- Иргэний хэрэг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэртэй танилцаж нотлох баримтын асуудлыг хэрхэн авч үзсэнийг тодорхойлж сурах
- Нотлох баримтыг ангилахын ач холбогдлыг жишээ гарган тайлбарлах



Эх сурвалж:

- ИХШХШТХууль 2002

ШҮҮХИЙН НОТОЛГООНЫ ОЙЛГОЛТ, ҮЕ ШАТ

Сэдвийн зорилго: Шүүхийн нотолгооны ойлголт, онцлог шинж, нотолгооны зүйл, элементын талаар цэгцтэй **мэдлэг** эзэмшихын зэрэгцээ нотолгооны процесст шүүх болон хэргийн оролцогчдын эрх, үүргийг харьцуулан судалснаар нотлох баримт гаргах, цуглуулах, бүрдүүлэх, хамгаалах, шинжлэн судлах, үнэлэх ажиллагааны онцлогийг танин **мэдэж**, тодорхой төрлийн хэрэг бүрт нотолгооны зүйлийг зөв тогтоох **чадвартай** болж, цаашид хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх бэлтгэлтэй болоход оршино.

Сэдвийн агуулга:

- Шүүхийн нотолгооны ойлголт, онцлог шинж
- Шүүхийн нотолгооны элемент
- Нотлох баримтыг илрүүлэх ба гаргах
- Нотлох баримтыг бүрдүүлэх, цуглуулах
- Нотлох баримтыг шинжлэх
- Нотлох баримтыг үнэлэх



Нэр томъёоны тайлбар

Шүүхийн нотолгоо - Энэ нь мэтгэлцэх зарчмын мөн чанараас урган гарсан, хэргийн бодит нөхцөл байдлыг тогтооход чиглэсэн, шүүх ба хэргийн оролцогчдоос хуульд заасан журмын дагуу нотлох баримтыг илрүүлэх, гаргаж өгөх, цуглуулах, шинжлэх болон үнэлэх талаар явуулж байгаа танин мэдэхүй процесс үйл ажиллагааны цогц мөн.

Нотолгооны зүйл - Нотолгооны зүйл гэдэг иргэний хэргийг бодитой, үнэн зөв, шийдвэрлэхэд ач холбогдол бүхий шүүхээс тогтоох ёстой нөхцөл байдлыг ойлгоно.

Нотолгооны элемент ба үе шат - Шүүхийн нотолгоо нь тодорхой үе шатуудыг агуулж байдаг ба түүнийг нотолгооны элемент гэж нэрлэдэг

Нотлох баримтыг гаргах - Энэ нь шүүхэд нэхэмжлэл, хүсэлт, гомдол гаргасан этгээд өөрт байгаа, эсхүл хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан баримтуудыг нэхэмжлэлийн шаардлага ба татгалзлаа баталгаажуулах зорилгоор шүүхэд гарган өгч байгаа ажиллагааг ойлгоно.

Нотлох баримтыг бүрдүүлэх ба цуглуулах ажиллагаа - Хэргийн оролцогч өөрсдөө гаргаж өгөх боломжгүй нотлох баримтыг шүүхэд хүсэлт тавьснаар шүүх нотлох баримтыг бүрдүүлэхэд оршино.

Нотлох баримт шинжлэх - Энэ нь хэрэгт ач холбогдол бүхий аливаа мэдээллийг хүлээн авах, нотолгооны субъектээс нотлох баримтыг судлах болон шалгах, түүний агуулгыг танин мэдэх үйл ажиллагаа юм

Нотлох баримтыг хамгаалах - Хэрэг хянан шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай нотлох баримтыг өөрчлөх, устгах, бусдад шилжүүлэх, нуун дарагдуулах зэргээр хэргийг шийдвэрлэхэд саад учруулж болох үндэслэлтэй гэж үзвэл хэргийн оролцогч уг нотлох баримтыг хамгаалуулахаар шүүхэд хүсэлт гаргадаг. Шүүгч уг хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл нотлох баримтыг хамгаалах тухай захирамж гаргана.

Нотлох баримтыг үнэлэх - Шүүх хэргийн оролцогчдын гаргасан нотлох баримтыг тал бүрээс нь бодитойгоор харьцуулан үзсэний үндсэн дээр нотлох баримтыг өөрийн дотоод итгэлээр үнэлнэ.



Шүүхийн нотолгооны онцлог шинжүүд:

- Шүүхийн нотолгооны объект, нотолгоонд оролцох субъектүүдийн хүрээг хуулиар тодорхойлсон.,
- Хэргийн оролцогчид болон бусад оролцогчид шүүхийн нотолгооны процесст хуулиар олгогдсон эрх эдэлж, үүрэг хүлээдэг.
- Нотлох баримтыг үнэлэхдээ хуулинд захирагдана.,
- Шүүхийн нотолгооны үйл явц хуульд заасан хугацааны дотор явагдана.,
- Нотолгооны хэрэгслийн төрөл, түүнд тавигдах шаардлага, хэрэглэх журмыг хуулиар зохицуулсан байна,
- Нотолгооны үйл ажиллагаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчимд тулгуурладаг.

Шүүхийн нотолгоо нь тодорхой үе шатуудыг агуулж байдаг ба түүнийг нотолгооны элемент гэж нэрлэдэг. Энэхүү үе шатын талаар эрдэмтэн судлаачид янз бүрийн үзэл баримтлалыг дэвшүүлсэн байдаг.

Шүүхийн нотолгооны элементэд нотлох баримтыг илрүүлэх ба гаргах, бүрдүүлэх ба цуглуулах, шинжлэх, үнэлэх ажиллагаа хамаарна.

ИХШХШТХуульд зааснаар хэргийн оролцогч нотлох баримтыг анхан шатны шүүхийн шүүх хуралдаан эхлэхийн өмнө гаргаж өгөх үүрэгтэй. Хэргийн оролцогч хуурамч нотлох баримт гаргаж өгөх буюу түүнийг хууль бус аргаар цуглуулахыг хориглоно

Хэргийн шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримт төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой, өөр улс орон нутагт байгаа учраас олж авах боломжгүй, түүнчлэн туршилт, үзлэг, таньж олуулах, шинжилгээ хийлгэх гэрчийн мэдүүлэг авах тохиолдолд нотлох баримтыг хэргийн оролцогчийн хүсэлтээр шүүх бүрдүүлнэ.

Нотлох баримт шинжлэх нь хэрэгт ач холбогдол бүхий аливаа мэдээллийг нотолгооны субъектүүд хүлээн авах, нотлох баримтыг судлах болон шалгах, түүний агуулгыг танин мэдэх үйл ажиллагаа юм. Эрдэмтэн судлаачид нотлох баримт шинжлэх ажиллагааны талаар янз бүрийн үзэл баримтлалыг дэвшүүлдэг.

Доктор, профессор Л.Баасан “Нотлох баримт шинжлэхийг судлах хэмээн нэрлээд энэ нь шүүхэд цугларсан нотлох баримтууд хууль ёсны дагуу цугларсан эсэх, уг нотлох баримтууд бүрэн эсэх зэрэг нотолгооны ач холбогдол бүхий байдлуудыг тогтоох талаар шүүхээс гүйцэтгэж байгаа шинжилгээ танин мэдэхүйн ажиллагаа юм” гэжээ. Нотлох баримтыг хэрхэн шинжлэх журмыг хуулиар тогтоож өгчээ. Тухайлбал: Бичмэл нотлох баримтыг уншиж сонсгох, эд мөрийн баримтыг танилцуулах, гэрчийн мэдүүлэг болон шинжээчийн дүгнэлтийг сонсох гэх мэт. Нотлох баримт шинжлэх ажиллагаа шүүх хуралдаан дээр явагдана.

Шүүхийн нотолгооны элементийн чухал хэсэг нь нотлох баримтыг үнэлэх ажиллагаа юм. Шүүх нотлох баримтыг үнэлэхдээ хараат бус байх, урьдаас хөдөлбөргүй үнэн гэж тогтоогдсон ямарч нотлох баримт байхгүй гэсэн зарчмыг баримтлах ба тухайн нотлох баримт хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, үнэн, зөв, эргэлзээгүй талаас нь үнэлнэ.



Хяналтын асуулт

1. Шүүхийн нотолгооны ойлголт, онцлог шинжийг тайлбарлана уу?
2. Шүүхийн нотолгооны талаархи онолын үзэл баримтлалын талаар хэлэлцэнэ үү?
3. Шүүхийн нотолгооны ач холбогдлыг жишээн дээр тайлбарлана уу?
4. Шүүхийн нотолгооны элемент, үе шатыг тодорхой жишээн дээр тайлбарлана уу?
5. Нотлох баримт гаргах, цуглуулах үүргийг хэн хэрэгжүүлэх боломжтойг жишээн дээр тайлбарлана уу?
6. Нотолгооны хэрэгсэл тус бүрийг шинжлэх онцлогийг хэлэлцэнэ үү?
7. Нотлох баримтыг үнэлэх ажиллагааг хэн, хэрхэн явуулах вэ?
8. Шүүхийн нотолгооны эцсийн зорилгыг тодорхойлно уу?
9. Мэтгэлцэх болон хэргийн бодит үнэнийг тогтоох зарчмын асуудлыг шүүхийн нотолгооны асуудалд хамааруулан авч хэлэлцэнэ үү?



Бодлого

1. Надмид хөрш айлд нь мэргэжлийн түвшинд хэрэглэх өндөр хүчин чадал бүхий дүрс бичлэгийн аппарат байгааг мэдэж, түүнийг худалдан авах хүсэлтэй байгаа тухайгаа эхнэр Содхүүд хэлжээ. Энэ үед нөхөр Гансүх нь гэртээ байгаагүй ба харин Содхүүгийн найз Цэмаа байсан байна.

Надмид сэтгүүлч мэргэжлийнхээ дагуу нэгэн телевизийн суваг шинээр нээх ажлынхаа талаар ярьж, түүний ажилд дүрс бичлэгийн хэрэгсэл хэрэгтэй болоод байна гэдгээ ч хэлсэн. Содхүү Надмидын хүсэлтийг хүлээн авах боломжгүй гэж хариулсан ба учир нь түүний нөхөр Гансүх Япон улсад айлчлалаар явахдаа гэр бүлдээ хөрөнгө оруулалт хийх зорилгоор уг төхөөрөмжийг худалдаж авсан юм гэжээ. Энэ явдлаас хойш хэдэн хоног өнгөрсөн боловч Надмидын ажилд дүрс бичлэгийн хэрэгсэл зайлшгүй хэрэгтэй болсон учраас нэг удаа боловч гуйж хэрэглэхээр хөршийнхөө хаалгыг тогшжээ. Энэ үед нөхөр Гансүх хаалгыг тайлж өгсөн ба тэрээр гэртээ ганцаараа байсан. Надмид Гансүхэд өмнө нь түүний эхнэрт хэлсэн, ярьснаа давтаж, дүрс бичлэгийн хэрэгслийг худалдан авах хүсэлтэй байна гэдгээ хэлсэн. Энэ үед Гансүхийн амнаас архи ханхалж байсан бөгөөд их согтсон гэдэг нь мэдэгдээгүй. Гансүх Надмидын хүсэлтийг хүлээн авах боломжтой гэдгээ хэлж харин үнийг тохиролцох хэрэгтэй гээд нэг сая төгрөгөөр худалдах санал гаргасан. Ингээд Надмид Гансүхийн саналаар буюу нэг сая төгрөгийг бэлнээр төлж, дүрс бичлэгийн хэрэгслийг худалдаж авсан. Содхүү ажлаасаа тарж ирээд болсон бүх зүйлийг мэдсэн ба нөхрөөсөө дүрс бичлэгийн үнийг шаардахад тэрээр мөнгөний зарим хэсгээр архи уусан гэдгээ хэлсэн. Содхүү Надмидаас дүрс бичлэгийн хэрэгслээ эргүүлж өгөхийг шаардсан боловч тэрээр татгалзсан учраас шүүхэд нэхэмжлэл гаргасан.

Содхүү нэхэмжлэлдээ нөхөр Гансүхийг согтуу байхад нь миний зөвшөөрөлгүйгээр, зөвшөөрөхгүй гэдгийг мэдсээр байж, худалдах худалдан



авах гэрээ байгуулсан тул уг гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцож өгнө үү? гэжээ.

Энэ тохиолдолд:

- Содхүү нь Гансүх, Надмид нарын хооронд байгуулсан дүрс бичлэгийн хэрэгсэл худалдах худалдан авах гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцуулахаар нэхэмжлэл гаргах эрхтэй эсэхийг тодруулна уу?
- Шүүх нэхэмжлэлийг хэрхэн шийдвэрлэх вэ?
- Хэрвээ шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, дээр дурьдсан гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцвол Надмидад эргүүлж төлөх мөнгийг хэн хариуцах вэ?
- Шүүхэд хэргийг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг гаргаж өгөх, цуглуулах ажиллагаа хэрхэн явагдах вэ?



Сорил

1. Шүүх нь хэрэгт ач холбогдолтой гэж үзвэл өөрийн санаачилгаар нотлох баримтыг албадан гаргуулах эрхтэй юу?
 - а. Тийм
 - б. Үгүй
 - в. Тодорхой төрлийн хэргийг шийдвэрлэхэд зөвшөөрнө
 - г. Аль нь ч биш
2. Нотлох баримтыг хамгаалах ажиллагааг шүүх өөрийн санаачилгаар хэрэгжүүлж болох уу?
 - а. Тийм
 - б. Үгүй
 - в. Зарим төрлийн хэргийн хувьд эрхтэй
 - г. Зарим төрлийн нотлох баримтын хувьд тийм эрхтэй
3. Нотлох баримтыг үнэлэх эрхтэй этгээдийг нэрлэнэ үү?
 - а. Хэргийн оролцогч нэхэмжлэл гаргахаас эхлэн нотлох баримтыг үнэлнэ
 - б. Зөвхөн шүүх үнэлнэ
 - в. Гэрч үнэлнэ
 - г. Шинжээч үнэлж дүгнэлт гаргаж болно
4. Өөр орон нутагт байгаа, шүүхэд ирэх боломжгүй гэрчийн мэдүүлэг хэрэгт заавал ач холбогдолтой бол шүүх ямар үйл ажиллагаа явуулах?
 - а. Байгаа газар нь очиж гэрчээс мэдүүлэг авна
 - б. Шүүхийн даалгавар бичнэ
 - в. Байгаа газар нь очиж шүүх хуралдааныг хийнэ
 - г. Гэрчийг албадан ирүүлнэ
5. Нотлох баримтыг үнэлэх шалгуурыг тодорхойлно уу?
 - а. Нотлох баримт хөдөлбөргүй үнэн байх

б. Хэрэгт шууд холбоотой байх

в. Бодитой байх

г. Эргэлзээгүй байх

6. Шүүх хэрэгт ач холбогдолтой нөхцөл байдлыг тодруулахын тулд өөрийн санаачилгаар шинжээч томилох эрхтэй юу?

а. Тийм

б. Үгүй

в. Шүүх хэргийн онцлог байдлаас шалтгаалан томилох боломжтой

г. Зөвхөн хүүхдийн эцэг, эхийг тогтооход шинжээч томилох эрхтэй

7. Нотолгооны үе шатанд нотлох баримтыг хэргийн оролцогчдод танилцуулах буюу бэхжүүлэх нь хамаарах уу?

а. Тийм

б. Үгүй

в. Зарим тодорхой төрлийн хэргийн хувьд хамаардаг

г. Дээрх хариулт бүгд буруу

8. Шүүгч хэрэгт ач холбогдолтой нөхцөл байдлыг тодруулахын тулд шүүх хуралдааны товыг зарлахаас өмнө туршилт явуулж энэ тухай тэмдэглэл үйлдэв. Туршилт явуулсан тухай тэмдэглэлийг шүүгчийн даалгаснаар шүүх хуралдааны нарийн бичгийн дарга үйлдэв. Энэ нь зөв үү? Дүгнэлт хий.

а. Зөв. Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга тэмдэглэл үйлдэх эрхтэй.

б. Буруу. Шүүгчийн даалгаснаар шүүгчийн туслах тэмдэглэл үйлдэнэ.

в. Зөв. Энэ тухай нарийвчилсан зохицуулалт хуульчлагдаагүй.

г. Зөв. Нэхэмжлэгч, хариуцагч нар тэмдэглэл үйлдэх этгээдийн талаар хүсэлт гаргаагүй учраас.



Даалгавар:

- Шүүхийн нотолгооны талаарх онолын үзэл баримтлалыг хэлэлцэн өөрсдөө дүгнэлт хийх
- Нотлох баримтыг гаргахад ямар журам баримтлах талаар бүдүүвч зохиож мэдлэгээ бататгах
- Шүүхийн нотолгоонд шүүхийн эрх мэдэл, хэргийн оролцогчийн эрх, үүрэг ямар байх талаарх мэдлэгийг сайжруулах



Эх сурвалж:

1. ИХШХШТХууль. 2002 он
2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар. УДШ. УБ, 2007 он



НОТОЛГООНЫ ХЭРЭГСЭЛ ТҮҮНИЙ ТӨРӨЛ

Сэдвийн зорилго: ИХШХША-ны нотлох баримт, нотолгооны хэрэгслийн талаарх янз бүрийн үзэл баримтлалтай танилцаж, тэдгээрийг харьцуулан дүгнэж, онцлог шинжээр ялган тодорхойлж, нотолгооны хэрэгсэл, түүний төрлийн талаар **мэдлэгтэй** болж, тодорхой төрлийн маргааны хувьд заавал байх, нотолгооны хэрэгслийг тодруулж, практикт зөв хэрэглэх **чадвар** эзэмшинэ.

Сэдвийн агуулга:

- Нотолгооны хэрэгслийн тухай ойлголт, онцлог
- Нотолгооны хэрэгслийн төрлүүд
- Зохигч, гуравдагч этгээд тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн тайлбар нотолгооны хэрэгсэл болох тухай
- Гэрчийн мэдүүлэг нотолгооны ач холбогдолтой болох нь
- Бичмэл баримт ба түүнд тавигдах шаардлага
- Эд мөрийн баримтын бусад нотолгооны хэрэгслээс ялгагдах онцлог
- Шинжээчийн дүгнэлт нотолгооны хэрэгсэл мөн болох тухай.
- Үзлэг, туршилт, таньж олуулах ажиллагаа явуулсан тухай тэмдэглэл
- Шүүх хуралдааны тэмдэглэл нотолгооны хэрэгсэл болох тухай



Нэр томъёоны тайлбар

Шүүхийн нотолгоо - Энэ нь мэтгэлцэх зарчмын мөн чанараас урган гарсан, хэргийн бодит нөхцөл байдлыг тогтооход чиглэсэн, шүүх ба хэргийн оролцогчдоос хуульд заасан журмын дагуу нотлох баримтыг заах, илрүүлэх, гаргаж өгөх, цуглуулах, шинжлэх болон үнэлэх талаар явуулж байгаа танин мэдэхүй, процесс үйл ажиллагааны цогц юм.

Нотолгооны хэрэгсэл - Нотлох баримтыг тодорхойлох Монгол улсын ИХШХШТХууль тогтоомжид тусгагдсан аргуудыг хэлнэ. Зохигч түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээдийн тайлбар, гэрчийн мэдүүлэг, бичмэл баримт, эд мөрийн баримт, шинжээчийн дүгнэлт, шүүх хуралдааны тэмдэглэл, үзлэг, туршилт, таньж олуулах ажиллагаа явуулсан тухай тэмдэглэл зэрэг нь нотолгооны хэрэгсэлд хамаарна.

Нотолгооны хэрэгсэл бүр өөрийн гэсэн онцлог, хуулийн тусгайлсан шаардлагыг хангасан байх ёстой.

Зохигч, гуравдагч этгээд тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн тайлбар - Зохигч, гуравдагч этгээдийн тайлбар нь хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаарх мэдээлэл агуулдаг учраас нотолгооны хэрэгсэл болно. Тэдний гаргасан тайлбар бодит үнэнд нийцсэн байна.

Гэрчийн мэдүүлэг - Хэрэгт ач холбогдол бүхий байдлыг мэдэж байгаа хэн ч гэрч байж болно. Гэрчийн мэдүүлэг нь иргэний хэргийн талаар тодорхой зүйл үзсэн, сонссон этгээдээс авч байгаа байцаалт юм. Гэрчээс мэдүүлэг авахын өмнө хуульд заасан хариуцлагыг сануулдаг. Гэрчээс мэдүүлэг авахад гэрч тус бүрийг тусад нь асуух ба үнэн зөв мэдүүлэг өгөхөөс татгалзах, буюу зайлсхийх, зориуд худал худал мэдүүлэг өгвөл Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй гэдгийг сануулан, хуулиар

эрх олгогдсон эрх бүхий этгээд мэдүүлэг авна. Гэрч хэргийн үйл баримт, нөхцөл байдлын талаар мэдэж байгаа бүх зүйлийг мэдүүлнэ. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүхийн дуудсанаар ирж чадахгүй гэрчээс байгаа газарт нь очиж, өөр нутаг дэвсгэрт амьдарч байгаа гэрчээс шүүхийн даалгавар биелүүлэх журмаар мэдүүлэг авна.

Бичмэл нотлох баримт - Хэргийн талаар ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар мэдээлэл агуулсан бичгийн хэлбэртэй баримтыг бичмэл нотлох баримт гэнэ. Бичмэл нотлох баримтанд үйл баримтын мэдээлэл агуулсан, үсгэн тэмдэгт ашиглан цаасан дээр буулгасан баримтаас гадна бичгийн тэмдэгтүүдийг ашиглан бэхжүүлсэн аливаа эд зүйлс хамаардаг. Уг баримт нь ямар материалд бэхжиж үлдсэн гэдгээс үл хамааран үйл баримтын мэдээллийг агуулсан бол нотолгооны хэрэгсэл болдог онцлогтой.

Бичмэл нотлох баримтыг:

а/ Хэлбэрийн хувьд:

- энгийн буюу гэрчлүүлэх, бүртгүүлэх шаардлагагүй нотлох баримт / баримт бичгийн эх, албан бичиг г.м /
- гэрчлүүлэх, эсхүл бүртгүүлэх шаардлагатай нотлох баримт /зарим гэрээ хэлцэл, баримт бичгийн хуулбар г.м/

б/ Хууль зүйн ач холбогдлоор нь:

- албаны бичмэл нотлох баримт /Шүүхийн шийдвэр, гэрлэлтийн гэрчилгээ, үнэмлэх г.м/
- албан бус бичмэл нотлох баримт /тэмдэглэлийн дэвтэр, гарын үсэг, захидал г.м/

в/ Агуулгын шинжээр нь:

- Хүсэл зориг илэрхийлсэн шинжтэй бичмэл нотлох баримт
- Мэдээллийн шинжтэй бичмэл нотлох баримт гэж тус тус ангилна.

Эд мөрийн баримт - Хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тогтоож чадах биет зүйлийг эд мөрийн баримт гэнэ./ ИХШХШТХ-ийн 45-р зүйлийн 45.1/

Жишээ нь: Гэмтсэн эд зүйл, үнэт эдлэл, түүх соёлын зүйлс, хувцас, чанарын доголдолтой бүтээгдэхүүн г.м/

Шинжээчийн дүгнэлт - Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжлэх ухаан, тооцоо, тоо бүртгэл, урлаг, утга зохиол, техникийн зэрэг тусгай мэдлэг шаардагдах асуудлыг тодруулахын тулд хэргийн оролцогчийн хүсэлтээр шүүгч захирамж, шүүх тогтоол гарган шинжээчийг томилно. Шүүх өөрийн санаачилгаар шинжээч томилохыг хориглоно.



Иргэний хэргийн нотлох баримт нотолгооны хэрэгслээр тогтоогдоно. Нотолгооны хэрэгсэлд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд, тэдгээрийн өмгөөлөгч төлөөлөгчийн тайлбар, гэрчийн мэдүүлэг, бичмэл баримт, шинжээчийн дүгнэлт, эд мөрийн баримт, кино, гэрэл зураг, зураглал, дүрс, дууны бичлэг, ул мөрнөөс буулгаж авсан хэв, үзлэг туршилт, таньж олуулах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл зэрэг хамаарна. Иргэний хэргийн хувьд түгээмэл хэрэглэдэг нотолгооны хэрэгсэлд бичмэл нотлох баримт, шинжээчийн дүгнэлт, гэрчийн мэдүүлэг, хэргийн оролцогчид, тэдгээрийн өмгөөлөгч төлөөлөгчийн тайлбар зэрэг хамаарна. Ийм учраас нотолгооны хэрэгсэл тус бүрийн ойлголт, онцлог, баримтлаж журмыг мэдэх шаардлагатай. Тухайлбал: Бичмэл нотлох баримтын талаар тодруулан авч үзэхэд бичмэл нотлох баримтад үйл баримтын мэдээлэл агуулсан, үгсэн тэмдэгт ашиглан цаасан дээр буулгасан баримтаас гадна бичгийн тэмдэгтүүдийг ашиглан бэхжүүлсэн аливаа зүйл хамаарна.

Бичмэл нотлох баримтыг хэлбэрийн хувьд жинхэнэ эх бичмэл баримт буюу хуулбарласан баримт, хууль зүйн ач холбогдлоор нь албаны бичмэл баримт, албан бус бичмэл баримт, агуулгын шинжээр нь хүсэл зоригын илэрхийлэл болсон баримт бичиг, мэдээллийн шинжтэй нотлох баримт гэж ангилан авч үздэг. Хэргийн оролцогчид нотлох баримтаа өөрсдөө гаргаж өгөх үүрэгтэй. ИХШХШТХуульд зааснаар бичмэл нотлох баримтыг эхээр нь хэрэв эхийг нь өгөх боломжгүй бол нотариатаар гэрчлүүлнэ.



Хяналтын асуулт

1. Нэхэмжлэлийн үндэслэл, материаллаг эрх зүйн хэм хэмжээ нь тухайн хэргийн нотолгооны зүйлийг тодорхойлдог эх сурвалж юм. Зөв хариултыг тодорхойлно уу?
2. Нотолгооны субъектэд зөвхөн хэргийн оролцогчид хамаарна. Дүгнэлт хийнэ үү?
3. Нотолгооны хэрэгсэлд - нэхэмжлэгч, хариуцагчийн тайлбар, гэрчийн мэдүүлэг, бичгийн ба эд мөрийн баримт, шинжээчийн дүгнэлт зэрэг багтана. Зөв хариулт эсэхийг дүгнэнэ үү?
4. ИХШХША-ны нотолгооны үүрэг хуваарилах ерөнхий журмыг нэрлэнэ үү?
5. Нэхэмжлэгч шинжээчийг давтан томилуулахаар хүсэлт гаргав. Түүнийг ямар тохиолдолд томилох вэ?
6. Нотолгооноос чөлөөлөгдөх нөхцөл байдал гэж байдаг уу?
7. Гэрлэлтийг цуцлах, хамтран өмчлөх дундын эд хөрөнгийн талаарх хэргийг хянан шийдвэрлэхэд хуримын тухай дүрс бичлэг нь гэрлэгчдэд өгсөн бэлгийн эд зүйлийг тодорхойлсон бол энэ нь нотолгооны ямар хэрэгсэлд багтах вэ?
8. Өөр орон нутагт байгаа, шүүхэд ирэх боломжгүй гэрчийн мэдүүлэг хэрэгт заавал ач холбогдолтой гэж үзвэл шүүх ямар ажиллагаа явуулах вэ?
9. Нотлох баримтыг үнэлэх шалгуурыг тодорхойлно уу?
10. Ямар тохиолдолд бичгийн нотлох баримтыг хадгалагдаж буй газар нь очиж үзлэг, шинжилгээ хийх вэ?



Сорил

1. Шүүхэд гаргаж өгсөн нотлох баримтаас нэг тал нь татгалзвал эсрэг тал нь түүнийг иш татах эрхтэй юу?
 - а. Шүүхийн зөвшөөрснөөр иш татаж болно
 - б. Хориглоно
 - в. Иш татаж болно
 - г. Зөвхөн гуравдагч этгээд иш татах эрхтэй
2. Нотлох баримтыг шүүхэд гаргаж өгөх үүрэгтэй этгээдийг олно уу?
 - а. Иргэдийн төлөөлөгч
 - б. Хэлмэрч
 - в. Гуравдагч этгээд
 - г. Гэрч
3. Шүүх үзлэг, туршилт явуулах тохиолдолд:
 - а. Шүүх өөрийн санаачилгаар аль үе шатанд ч болно
 - б. Шүүхийн үүрэг
 - в. Шүүх хэргийн оролцогчийн хүсэлтээр бүрдүүлнэ
4. Бичгийн нотлох баримтын нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг шүүхэд өгсөн тохиолдолд шүүх жинхэнэ эхийг нь шаардан авах эрхтэй юу?
 - а. Тийм
 - б. Үгүй
 - в. Хэргийн оролцогчийн зөвшөөрснөөр
 - г. Гэрч хүсэлт гаргасан бол
5. Анхан шатны шүүхийн шүүх хуралдааны тэмдэглэлд :
 - а. Шүүх бүрэлдэхүүн нарийн бичгийн дарга гарын үсэг зурна
 - б. Шүүх хуралдаан даргалагч, нарийн бичгийн дарга гарын үсэг зурна
 - в. Зөвхөн шүүх хуралдааны нарийн бичгийн дарга гарын үсэг зурна
 - г. Хэргийн оролцогчдын өмгөөлөгч гарын үсэг зурна
6. Шүүхэд дуудагдсан дараахь субъектээс мэдүүлэг, тайлбар өгөхөөс татгалзсан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар сануулга өгдөг субъектэд аль нь хамаарах вэ?
 - а. Зохигч
 - б. Гуравдагч эогээд
 - в. Шинжээч
 - г. Гэрч
7. Гэрлэлтийг шүүхийн журмаар цуцлах хэргийг шүүхээс хянан шийдвэрлэхэд дор дурьдсан нотолгооны хэрэгслээс аль нь “зайлшгүй” байх шаардлагатай вэ?
 - а. Гэрлэлтийн гэрчилгээ



- б. Нэхэмжлэгчийн ажил, байдлын тодорхойлолт
- в. Гэрлэлтийн болон тэжээн тэтгэх гэрээ

8. Нотолгооны хэрэгслийг олно уу?

- а. Шинжээчээс явуулсан шинжилгээ
- б. Хариуцагчийн тайлбар
- в. Гэрчийн тодорхойлолт
- г. Орчуулагчийн бичгээр хийсэн орчуулгын материал

9. Шүүх хэрэгт ач холбогдолтой гэж үзвэл өөрийн санаачилгаар нотлох баримтыг албадан гаргуулах эрхтэй юу?

- а. Тийм
- б. Үгүй
- в. Тодорхой төрлийн хэргийг шийдвэрлэхэд зөөшөөрнө
- г. Аль аль нь биш

Σ

Бодлого

Иргэн Шарав, Орсоог орон байрнаас нүүлгэн гаргуулах, түүнтэй байгуулсан орон сууц худалдах, худалдан авах гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцуулахаар нэхэмжлэл гаргажээ. Тэрээр нэхэмжлэлдээ уг гэрээг 2000 оны 10 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан, мөн түүнчлэн Шарав нь Чингэлтэй дүүргийн Бага тойруу, 9- 45 тоот орон сууцны өмчлөгч мөн гэж тогтоолгохыг хүссэн байна.

Хариуцагч Орсоо сөрөг нэхэмжлэл гаргаж, 1999 оны 7 дугаар сарын 30-ны өдөр байгуулсан орон сууц худалдах, худалдан авах гэрээ хүчин төгөлдөр тул Шаравын маргаж байгаа орон сууцны өмчлөгчөөр тогтоолгох тухай шаардлага тавьжээ.

Дүүргийн шүүх: Шаравын нэхэмжлэлийн шаардлагыг хэсэгчлэн хангаж, 2000 оны 10 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан орон сууц худалдах худалдан авах гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцсон ба харин Орсоог орон сууцнаас нүүлгэн гаргахаас татгалзсан.

Орсоогийн нэхэмжлэлийг хангаж, 1999 оны 7 дугаар сарын 30-ны өдөр байгуулсан орон сууц худалдах, худалдан авах гэрээ хүчин төгөлдөр гэдгийг тогтоосон.

Энэ тохиолдолд:

1. Дүүргийн шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон нотолгооны хэрэгслийг нэрлэнэ үү?



Даалгавар:

- Нотолгооны хэрэгсэл тус бүрийн онцлог шинжийг хэлэлцэх
- Нотолгооны хэрэгсэл тус бүрийг өөр хооронд нь харьцуулан жишиж ярилцах
- Нотолгооны хэрэгсэл тус бүр дээр нэг нэг бүрдүүлбэр хийх



Эх сурвалж:

- ИХШХШТХууль 2002 он
- Эрүүгийн хууль 2002 он
- ЭБШТХууль 2002 он



VI БҮЛЭГ. ИРГЭНИЙ ХЭРЭГ ҮҮСГЭХ

ИРГЭНИЙ ХЭРЭГ ҮҮСГЭХ АЖИЛЛАГАА, ҮР ДАГАВАР

Сэдвийн зорилго: Шүүхэд мэдүүлэх эрхийг хэрэгжүүлэх үндсэн хэлбэр болсон нэхэмжлэл гаргах, түүнийг хүлээн авах, иргэний хэрэг үүсгэх ажиллагааны талаар цэгцтэй мэдлэг эзэмшсэнээр хуулийн хүрээнд нэхэмжлэл гаргах, иргэний хэрэг үүсгэсний дараа шүүгчийн болон хэргийн оролцогчийн эрх зүйн байдлыг ялган тодорхойлох дадал, чадвартай болж, цаашид өөрийн болон бусдын хуулиар хамгаалагдсан зөрчигдсөн эрхийг нэхэмжлэл гаргах журмаар сэргээлгэх боломжтой болно.

Сэдвийн агуулга:

- Шүүхэд мэдүүлэх эрх
- Шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах
- Иргэний хэрэг үүсгэх тухай захирамж
- Иргэний хэрэг үүсгэсэн шүүгчийн ажиллагаа
- Иргэний хэрэг үүсгэх үе шатанд хэргийн оролцогчийн эрх зүйн байдал



Нэр томъёоны тайлбар

Нэхэмжлэлийг хүлээн авах - Нэхэмжлэлийг ИХШХШТХ-ийн 64 дүгээр зүйлийн 1-д заасан журмын дагуу хүлээн авна. Хуулийн шаардлага хангасан нэхэмжлэлийг шүүгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга хүлээн авч бүртгэлд бүртгэж, нэхэмжлэлийн хуудасны тоо, хавсаргасан баримтын хуудасны тоо, хүлээн авсан огноо, цаг минутыг тэмдэглэж тусгай дардас дарж баримтжуулна.

Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах - Шүүгч ИХШХШТХ-ийн 65-р зүйлд заасан үндэслэл байгаа өөрөөр хэлбэл шаардлага хангаагүй нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан захирамж гаргаж буцаана. Уг захирамжиндаа нэхэмжлэлийг хэрхэн мэдүүлэх, шүүх түүнийг хүлээн авахад саад болж байгаа зөрчлийг хэрхэн засахыг зааж өгнө.

Хэрэг үүсгэх тухай захирамж - Шүүх хэргийн харъяалал зөрчөөгүй, хуульд заасан шаардлага хангасан нэхэмжлэлийг хүлээн авч, хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногийн дотор хэрэг үүсгэх тухай захирамж гаргана./ ИХШХШТХ-ийн 66-р зүйл/

Хэрэг үүсгэсэн шүүгчийн ажиллагаа - Нэхэмжлэлийг хүлээн авч хэрэг үүсгэсэн шүүгч дараах ажиллагааг явуулна. /ИХШХШТХ-ийн 67-р зүйл/

- Зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээдэд шаардлага ба татгалзлаа үндэслэж буй нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх үүрэгтэйг танилцуулж, эдлэх эрхийг нь тайлбарлан өгөх
- Нэхэмжлэлийн хувийг хариуцагчид гардуулах
- Шаардлагатай буюу зохигч хүсэлт гаргасан бол туршилт, үзлэг, таньж олуулах ажиллагаа, шинжилгээ хийлгэх, гэрчийн мэдүүлэг авах зэргээр нотлох баримт бүрдүүлэх ажиллагаа хийх.

Нэхэмжлэлийг хариуцагчид гардуулах - Шүүх нэхэмжлэлийг хүлээн авч, зохих ажиллагаа явуулахын хамт хариуцагч этгээдэд нэхэмжлэлийн хувийг гардуулан хариуцагчийг мэтгэлцэх, эвлэрэн хэлэлцэх эрхээр хангана.

Шүүх иргэний хэрэг үүсгэснээс хойш Нийслэлд-7 хоног, Орон нутагт -14 хоногийн дотор нэхэмжлэлийг хариуцагчид гардуулан,эрхийг нь танилцуулж гарын үсэг зуруулна.Хариуцагч нэхэмжлэлийн хувийг гардаж авснаас хойш 14 хоногийн дотор эсхүл шүүгчээс тогтоосон хугацаанд хариу тайлбараа шүүхэд ирүүлнэ.

Нэхэмжлэлийн шаардлагыг нэгтгэх - Нэхэмжлэгч хоорондоо холбоотой хэд хэдэн шаардлагыг нэг нэхэмжлэлд нэгтгэн гаргаж болно. Нэг нэхэмжлэгчээс өөр өөр хариуцагчид гаргасан нэхэмжлэлтэй буюу өөр өөр нэхэмжлэгчээс нэг хариуцагчид гаргасан нэхэмжлэлтэй хэд хэдэн хэргийг нэг ажиллагаагаар хамтатган шийдвэрлэх нь уг хэргийг шуурхай үнэн зөв шийдвэрлэхэд ач холбогдолтой гэж үзвэл тэдгээрийг шүүгч захирамжаар нэгтгэн хянан шийдвэрлэж болно.

Нэхэмжлэлийн шаардлагыг тусгаарлах - Нэгтгэн гаргасан нэхэмжлэлийн шаардлагаас нэг буюу хэд хэдэн нэхэмжлэлийн шаардлагыг тусгаарлан шийдвэрлэх нь зохистой гэж үзвэл тэдгээрийг шүүгчийн захирамжаар тусгаарлаж болно. Хэд хэдэн нэхэмжлэгч гаргасан буюу хэд хэдэн хариуцагчид холбогдуулан гаргасан нэхэмжлэлийн шаардлагаас нэг буюу хэд хэдэн шаардлагыг тусгаарлан шийдвэрлэх нь зохистой гэж үзвэл тэдгээрийг шүүгч захирамжаар тусгаарлан шийдвэрлэж болно.

Сөрөг нэхэмжлэл - Үндсэн нэхэмжлэлтэй хамт шийдвэрлүүлэхийн тулд хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэхээс өмнө хариуцагчаас гаргасан нэхэмжлэлийг сөрөг нэхэмжлэл гэнэ. Сөрөг нэхэмжлэл нь хариуцагчийн татгалзалыг илэрхийлсэн байдаг. Сөрөг нэхэмжлэл үндсэн нэхэмжлэлийн нэгэн адил шаардлага хангасан байна.

Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах-Нэхэмжлэгчийн эрх, ашгийг хамгаалан хангах ажиллагааны нэг хэлбэр бол шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах ажиллагаа юм. Энэ нь нэхэмжлэгчийн хүсэлтээр шүүгч захирамж гаргаж шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг найдвартай, баталгаатай болгох урьдчилсан ажиллагаа юм. Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг урьдчилан баталгаажуулах нь хариуцагч этгээдэд хөрөнгөө үгүй хийх, бусад хэлбэрээр төлбөр төлөхөөс зайлсхийхээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой нэхэмжлэгчийн хүсэлтээр хэрэгжих хамгаалалтын шинжтэй ажиллагаа юм.

Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзах - Нэхэмжлэгч өөрийн хүсэл зоригоор өөрийнхөө шүүхэд хандаж гаргасан нэхэмжлэлээс татгалзах хүсэлтийг амаар болон бичгээр гаргаснаар хэрэг хэлэлцэх ажиллагааг шүүх зогсоохыг хэлнэ. Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзах нь хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх үндэслэл болдог.

Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн - Нэхэмжлэгчийн нэхэмжлэлээрээ шаардсан зүйлийг хариуцагч биелүүлэхээ



хүлээн зөвшөөрч буй хэлбэр. Энэ тохиолдолд хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хангах талаар баталгаа гаргана.

Зохигчид эвлэрэх - Нэхэмжлэгч, хариуцагч нар өөрсдийн хоорондох маргаантай асуудлын талаар харилцан зөвшилцөж тохиролцсны үндсэн дээр шүүхэд хэрэг үүсгэснийг дуусгавар болгох тухай тохиролцоо.

Нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагч биелүүлсэн - Иргэний хэрэг үүсгэсэн үеэс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх хүртэлх хугацаанд нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагч биелүүлж нэхэмжлэлээр шаардсан зүйлийг бүрэн биелүүлж цаашид маргаангүй болсноор хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх шаардлагагүй болох явдал.

Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа - Нэхэмжлэлийг шүүх хүлээн авч иргэний хэрэг үүсгэсний дараа нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн, зохигч эвлэрсэн, хариуцагч шаардлагыг биелүүлсэн бол шүүгч хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж захирамж гаргаснаар хэрэг хэлэлцэх ажиллагаа дуусгавар болохыг ойлгоно.

Иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд үүссэн иргэний эрх зүйн маргааныг шүүх иргэний хэрэг үүсгэн хянан шийдвэрлэнэ. Шүүхэд мэдүүлэх эрхийг хэрэгжүүлэх явцад иргэн, хуулийн этгээдээс гаргасан нэхэмжлэл, хүсэлт, гомдлыг шүүх хүлээн авч хуулийн шаардлага хангасан байна гэж үзвэл иргэний хэрэг үүсгэсэн захирамж гаргана. Харин шаардлага хангаагүй бол иргэний хэрэг үүсгэхээс татгалзаж, үндэслэлийг заасан захирамж гаргана. Нэхэмжлэлийг хүлээн авсан шүүгчийн ажиллагааг бүдүүвчээс үзэж болно.

Шүүхэд мэдүүлэх эрх: /ИХШХШТХ-ийн 3-р зүйл/ Монгол Улсын хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн гэж үзэж байгаа аливаа этгээд уг эрхээ хамгаалуулахаар хуульд заасан журмын дагуу шүүхэд нэхэмжлэл, гомдол, хүсэлт гаргах хэлбэрээр мэдүүлэх эрхтэй.

Монгол улсын хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзэж байгаа аливаа этгээд уг эрхээ хамгаалуулахаар шүүхэд мэдүүлэх эрхтэй. Нэхэмжлэх эрхийг хэн ч хасах буюу хязгаарлах ёсгүй.

Гадаад, дотоодын хуулийн этгээд байгууллага өөрсдийн төлөөлөгчөөрөө дамжуулан нэхэмжлэх эрхээ эдэлнэ.

- Харьяалалгүй иргэн
- Гадаадын харъяат
- Монгол Улсын иргэн аль аль нь нэхэмжлэх эрхтэй.

Нэхэмжлэл гаргах ба хүлээн авах журам.

- Нэхэмжлэгч нэхэмжлэлийг шүүхэд бичгээр гаргана.
- Нэхэмжлэл нь ИХШХШТХ-ийн 61, 62-р зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

- Нэхэмжлэлийн өргөдлөө хариуцагчийн тоогоор хуулбарлаж хавсаргана.
- Нэхэмжлэгч нь эрх зүйн чадамжгүй, заримдаг болон хэсэгчилсэн чадамжтай этгээдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж түүний хууль ёсны төлөөлөгч, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нэхэмжлэл гаргана.

Бүрэн эрхийг нь нотлох бичиг баримт итгэмжлэлээ хавсаргана.

- Нэхэмжлэлийг тэмдэглэн бичсэн дарааллаар нэхэмжлэл бүртгэх дэвтэрт бичнэ.
- Нэхэмжлэлийг тухайн шүүхийн шүүгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга хүлээн авна.
- Нэхэмжлэлд хавсаргасан материалын хуудасны тоо, огноо, цаг минутыг нэхэмжлэлд тэмдэглэж баталгаажуулна./дардас дарна/.

Шүүх дараахь үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж үндэслэл бүхий захирамж гаргана.

Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл:

- Шүүхэд харъяалагдахгүй;
- Тухайн шүүхэд харъяалагдахгүй;
- Шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлүүлэх талаар хуульд заасан журмыг нэхэмжлэгч зөрчсөн ба энэ журмыг хэрэглэх боломжтой бол;
- Нэхэмжлэгч нь эрх зүйн чадамжгүй этгээд байвал;
- Нэхэмжлэгчийг төлөөлөх бүрэн эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан;
- Нэхэмжлэлд дурдсан үйл баримт зохигчийн гэм буруугийн талаар хуулийн хүчин төгөлдөр шүүхийн болон арбитрын шийдвэр, эсвэл нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан, түүнчлэн хэргийг хэрэгсэхгүй болгосон хуулийн хүчин төгөлдөр шүүхийн болон арбитрын шийдвэр буюу шүүгчийн захирамж;
- Зохигчдын маргаж байгаа зүйл ба түүний үндэслэлийн талаар өөр хэргийг шүүх шийдвэрлэж байгаа;
- Уг нэхэмжлэлтэй холбоотой хэргийг эрүүгийн журмаар шалгаж байгаа;
- Хариуцагчийн хаяг тодорхойгүй;
- Зохигч нас барсан, хуулийн этгээд татан буугдсан тохиолдолд маргаж байгаа шаардлага буюу маргаантай үүрэг нь эрх залгамжлагчид шилжээгүй;
- ИХШХШТХ-ийн 62-р зүйлд заасан шаардлага хангаагүй бол зэрэг болно.
- Шүүгч нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан захирамжиндаа нэхэмжлэлийг хэрхэн мэдүүлэх, шүүх түүнийг хүлээн авахад саад болж байгаа зөрчлийг хэрхэн арилгахыг дурдана.

Иргэний хэрэг үүсгэх үндэслэл, журам.

Гомдол, хүсэлт, шүүхэд мэдүүлэх эрх хуулиар олгогдсоны дагуу гаргаж буй нэхэмжлэл тэдгээрийг хүлээн авч иргэний хэрэг үүсгэх журамтай.

Иргэний хэргийг:

- Эдийн ба эдийн бус баялагтай холбоотой эрх нь зөрчигдсөн, тухай эрх зүйн харилцаанд оролцогч этгээдээс гаргасан нэхэмжлэл.



- Бусдын эрх, эрх чөлөө ашиг сонирхолыг хамгаалж, шүүхэд, мэдүүлэх эрх нь хуулиар олгогдсон этгээдээс гаргасан нэхэмжлэл.
- Онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлүүлэхээр хуульд заасан асуудлаар сонирхогч этгээдээс гаргасан хүсэлт.
- Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1, 4.2-т зааснаас бусад байгууллага албан тушаалтны үйл ажиллагаа болон тэдгээрийн гаргасан захиргааны актын талаарх гомдолд үндэслэн үүсгэнэ.

II. Шүүхэд ирүүлсэн нэхэмжлэл нь нэхэмжлэлийн шаардлага хангасан, хэргийн харъяалал зөрчөөгүй бол 7 хоногийн дотор Шүүгч “иргэний хэрэг” үүсгэх тухай захирамж гаргана. /ИХШХШТХуулийн 66-р зүйл/



Шүүгч нэхэмжлэгч хүсэлт гаргавал иргэний хэрэг үүсгэхдээ буюу үүсгэсний дараа шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулахаар хариуцагчийн эд хөрөнгө буюу мөнгийг тухайн нэхэмжлэлийн үнийн дүнгийн хэмжээгээр битүүмжлэх, хариуцагчаас эд хөрөнгөтэй холбоотой ямар нэгэн тодорхой ажиллагаа явуулахыг нэхэмжлэлийн үнийн дүнгийн хэмжээгээр хориглох, хариуцагчийн дансны зарлагын хөдөлгөөнийг нэхэмжлэлийн үнийн дүнгийн хэмжээнд зогсоох нэхэмжлэлээр шаардсан хэмжээний мөнгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн дансанд урьдчилан оруулах, тодорхой ажиллагаа гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхыг даалгаж захирамж гаргах эрхтэй. Нэрлэсэн эдгээр арга хэмжээг нэгэн зэрэг авч болно. Хариуцагч энэ талаар гарсан захирамжид гомдол гаргах эрхтэй.



Хяналтын асуулт

1. Нэхэмжлэл гэдгийг хэрхэн ойлгохыг жишээ гарган тайлбарлана уу?
2. Иргэний хэрэг үүсгэх үндэслэлүүдийг дурьдаж тус бүрд нь тайлбарлана уу?
3. Нэхэмжлэлийн үндсэн шинжийг тодорхойлон гомдол, хүсэлтээс ялгана уу?
4. Ямар нэхэмжлэлийг шаардлага хангасан нэхэмжлэл хэмээн ойлгох талаар ярилцанауу?
5. Нэхэмжлэл гаргах, түүнийг хэрхэн хүлээн авч баталгаажуулахыг хэлэлцэн ярилцана уу?
6. Ямар тохиолдолд нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах вэ? гэдгийг тодорхой тохиолдолд дүгнэн хэлэлцэнэ үү?
7. Шүүгч иргэний хэрэг үүсгэх тухай захирамж гаргасны ач холбогдол, эрх зүйн үр дагаврыг илэрхийлнэ үү?
8. Хэрэг үүсгэсэн шүүгчийн ажиллагааг тодорхойлно уу?



Сорил

1. Иргэний хэргийг ямар үндэслэлээр үүсгэх вэ?
 - а. Прокурорын нэхэмжлэлээр
 - б. Гомдол, хүсэлтээр
 - в. Төрийн захиргааны болон бусад этгээдийн шардлагаар
 - г. Эрх зүйн харилцаанд оролцогчдоос гаргасан нэхэмжлэл, гомдол, хүсэлтээр
2. Шүүгч нэхэмжлэлийн өргөдлийг хүлээн авснаас хойш хугацаанд иргэний хэрэг үүсгэх асуудлыг шийдвэрлэх вэ?
 - а. 14 хоногийн дотор
 - б. Нийслэлд-7 хоног, Орон нутагт -14 хоног
 - в. 7 хоногийн дотор
3. Хариуцагч нэхэмжлэлд холбогдуулан гаргах тайлбараа хугацаанд шүүхэд ирүүлэх вэ?
 - а. 14 хоногийн дотор
 - б. 7 хоногийн дотор
 - в. 14 хоногийн дотор эсхүл шүүгчээс тогтоосон хугацаанд
4. Нэхэмжлэлийг хэдэн хувь гаргах вэ?
 - а. Хоёр хувь
 - б. Хэдэн ч хувь байж болно
 - в. Хариуцагчийн тоогоор хувилж өгнө
 - г. Нэхэмжлэлийг хэдэн хувь өгөх талаар хуулийн зохицуулалт байхгүй.
5. Нэхэмжлэлийг хэн хүлээн авах вэ?
 - а. Нэхэмжлэлийг тухайн шүүхийн ерөнхий шүүгч хүлээн авч он, сар, өдөр минутыг баталгаажуулна.
 - б. Тухайн шүүхийн нарийн бичгийн дарга хүлээн авна.
 - в. Тухайн шүүхийн шүүгч, нарийн бичгийн дарга хүлээн авч, хүлээн авсан он, сар өдөр, цае, минутыг бичиж баталгаажуулна.



- г. Ерөнхий шүүгчээс гаргасан хуваарийн дагуу туслах шүүгч хүлээн авч, хүлээн авсан он, сар, өдөр, цаг, минутыг баталгаажуулна.
- 6. Шүүгч нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах тохиолдолд ямар акт гаргах вэ?**
- Шүүгч энэ талаар албан бичиг өгнө
 - Шүүгч захирамж гаргана.
 - Шүүх тогтоол гаргана
 - ИХШХШТХ-д зааснаар магадлал гаргана
- 7. Ямар үндэслэлээр шүүгч нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах вэ?**
- Нэхэмжлэлийн шаардлага тодорхойгүй
 - Нэхэмжлэл гаргах журам тодорхойгүй
 - ИХШХШТХ-ийн 65-р зүйлд заасан 11 үндэслэл тогтоогдсон
 - Нэхэмжлэгч эрх зүйн чадамжгүй этгээд болох нь тогтоогдсон
- 8. Иргэний хэргийг ямар журмаар үүсгэх вэ?**
- Нэхэмжлэлийн шаардлага хангасан өргөдлийг шүүх хүлээн авснаар
 - Шүүгч захирамж гаргаснаар
 - Нэхэмжлэлийг шүүгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга хүлээн авч дэвтэрт бүртгэснээр
 - Нэхэмжлэлийг хариуцагчид гардуулснаар

Σ

Бодлого

- Очир өөрийн танил Сүрэнд гадаадаас машин авчирч өгөхөөр тохирч 3 сая төгрөг авч явсан боловч уг машиныг авчирч өгөлгүй удаасан төдийгүй, мөнгийг нь өгөөгүй байна. Очир өөрийн эрх ашгийг хамгаалуулахаар шүүхэд хандсан.
Энэ тохиолдолд:
 - Шүүх нэхэмжлэлийг хүлээн авч иргэний хэрэг үүсгэх үү?
 - Иргэний хэрэг үүсгэх үндэслэл, журмыг тодорхойлно уу?
- Иргэн Б шүүхэд хандаж С-д автомашинаа худалдсан үнийн үлдэгдэл 1.300 000 төгрөгийг гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан. Шүүх нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш 30 хоног өнгөрсөн байхад иргэний хэрэг үүсгэсэн захирамж гаргаагүй, хариуцагчид нэхэмжлэлийн хувийг гардуулаагүй байсан.
Энэ тохиолдолд:
 - Шүүхийн үйл ажиллагаанд дүгнэлт хийнэ үү?
 - Иргэний хэрэг үүсгэх захирамжийг шүүгч ямар хугацаанд гаргах, болон иргэний хэрэг үүсгэсэн шүүгчийн захирамжийн үр дагаврыг тодорхойлно уу?
- Иргэн Д шүүхэд хандаж, 20 настай өөрийн төрсөн дүү охин О-г сэтгэл мэдрэлийн өвчтэй учир эрх зүйн чадамжгүйд тооцуулах тухай хүсэлт

гаргасан боловч шүүх энэхүү хүсэлтийг шүүхэд харъяалагдах хэрэг биш гэсэн үндэслэлээр хүлээн авахаас татгалзсан байна.

Энэ тохиолдолд:

- Шүүхийн шийдвэр зөв үү?
- Иргэн Д-гийн гаргасан хүсэлт иргэний хэрэг үүсгэх үндэслэл болох уу?
- ИХШХШТХуулийн 12,13 дугаар зүйлийг тайлбарлана уу?



Даалгавар:

- Иргэний хэрэг үүсгэх тухай захирамжийн төсөл боловсруулах
- Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан захирамжийн төсөл бэлтгэх
- Иргэний хэрэг үүсгэсэн шүүгчийн ажиллагааны талаар тодорхой системтэй мэдлэг эзэмшиж, зарим ажиллагааг хэрхэн хэрэгжүүлэхийг жишээ гарган тайлбарлах
- Иргэний хэрэг үүсгэсэн тохиолдолд хэргийн оролцогчийн эрх, үүрэг ямар байх талаар тодруулах
- Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах талаар гаргасан шүүгчийн захирамжийн төсөл бэлтгэх



Эх сурвалж:

- ИХШХШТХууль 2002 он
- Шүүгчийн гарын авлага 2004 он



НЭХЭМЖЛЭЛИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ТҮҮНИЙ БҮРДҮҮЛБЭР, ТӨРӨЛ, НЭХЭМЖЛЭЛ ГАРГАХ ЖУРАМ

Сэдвийн зорилго: Нэхэмжлэл гэж юуг ойлгох, түүний бүрдүүлбэр, төрөл, нэхэмжлэл гаргах журмын талаар тодорхой **мэдлэгтэй** болсноор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэлбэрүүдэд дүгнэлт хийх, харьцуулах **чадварыг** эзэмшин, цаашид нэхэмжлэл гаргаж эрхээ хамгаалуулах, боломжтой болж, энэ асуудалд эрх зүйн талаас хандах **хандлага** төлөвшинө.

Сэдвийн агуулга:

- Нэхэмжлэлийн тухай ойлголт
- Нэхэмжлэлийн бүрдүүлбэр
- Нэхэмжлэлийн төрөл



Нэр томъёоны тайлбар

Нэхэмжлэл - Хууль болон гэрээний үүргийг биелүүлээгүйгээс өөрт учирсан эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус хохирлоо гэм буруутай этгээдээс гаргуулахаар шүүхэд хандаж гаргасан эрх зүйн ач холбогдол бүхий баримт бичгийг хэлнэ.

Нэхэмжлэлийн бүрдүүлбэр - Нэхэмжлэл нь хууль зүйн агуулга, хэлбэр, загвараар бичигдэж, холбогдох баримт бичиг хавсаргасан нөхцөлд шаардлага хангасан гэж үзнэ. ИХШХШТХуулийн 62 дугаар зүйлд нэхэмжлэлийн бүрдүүлбэр ямар байхыг заасан байна. Үүнд: нэхэмжлэлийг ямар шүүхэд гаргаж байгаа, нэхэмжлэгч, хариуцагчийн овог, эцгийн нэр, хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, хаяг, оршин байгаа газар, нэхэмжлэлийн шаардлага, түүнийг нотлох баримтын жагсаалтыг хавсаргасан байхаас гадна улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримтыг хавсаргасан байна. Эдгээр шаардлага хангаагүй нэхэмжлэлийг шүүх хүлээн авахаас татгалзана.

Нэхэмжлэлийн зүйл ба үндэслэл - Нэхэмжлэлийн зүйл нь нэхэмжлэгчийн шаардлага байдаг бол уг шаардлага гаргах болсон нөхцөл нь нэхэмжлэлийн үндэслэл болно. Эдгээрийг нэхэмжлэлийн элемент гэнэ.

Эд хөрөнгийн нэхэмжлэл - Хариуцагчаас хүл ээсэн үүргээ биелүүлэхийг шаардаж, эд хөрөнгө гаргуулахаар шүүхэд хандсан баримт бичгийг хэлнэ.

Эрх хүлээн зөвшөөрүүлэх нэхэмжлэл - Нэхэмжлэгчээс хариуцагчтай маргаж байгаа болон зөрчигдсөн гэж үзэж байгаа эрхээ хууль ёсны болох эсэхийг шүүхэд хандан зөвшөөрч баталгаажуулахаар гаргасан баримт бичиг юм.

Эрх зүйн харилцааг өөрчлүүлэх нэхэмжлэл - Шүүхэд гаргаж байгаа шаардлага нь эрх зүйн харилцааг өөрчлөх, дуусгавар болгоход чиглэсэн байхыг ойлгоно.

Нэхэмжлэлийн шаардлагыг нэгтгэх - Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэд хэдэн нэхэмжлэл буюу хэргийг нэгтгэн шийдвэрлэх нь хэргийн оролцогчдын эрх ашгийг зөрчихгүй, нэг мөр үнэн, зөв шийдвэрлэхэд ач холбогдолтой гэж үзвэл нэхэмжлэлийн шаардлагыг нэгтгэж болно. Нэг шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд адил төрлийн хэд хэдэн хэрэгт урд оролцож байсан зохигч оролцож байгаа,

эсхүл нэг нэхэмжлэгчээс өөр, өөр хариуцагчид гаргасан нэхэмжлэлтэй, буюу өөр өөр нэхэмжлэгчээс нэг хариуцагчид гаргасан нэхэмжлэлтэй хэд хэдэн хэргийг нэг ажиллагаагаар хамтатган шийдвэрлэх нь уг хэргийг шуурхай, үнэн зөв хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой гэж үзвэл тэдгээрийг шүүгчийн захирамжаар нэгтгэн хянан шийдвэрлэж болно.

Нэхэмжлэлийн шаардлагыг тусгаарлах - Хэд хэдэн нэхэмжлэгч гаргасан буюу хэд хэдэн хариуцагчид холбогдуулан гаргасан нэхэмжлэлийн шаардлагаас нэг буюу хэд хэдэн шаардлагыг тусгаарлан шийдвэрлэх нь зохистой байвал тэдгээрийг шүүгчийн захирамжаар тусгаарлаж болно.

Нэхэмжлэл нь маргаж байгаа болон зөрчигдсөн эрх, ашиг сонирхлоо хамгаалуулахын тулд хуулиар тогтоосон журмын дагуу шүүхэд хандаж нэхэмжлэгчээс хариуцагчид тавьсан шаардлага байхад түүнийг илэрхийлж буй хэлбэр нь нэхэмжлэлийн өргөдөл мөн. Нэхэмжлэл нь хууль зүйн шаардлага хангасан, тодорхой, үндэслэлтэй байх ёстой. Нэхэмжлэл агуулгын хувьд дараахь бүтэцтэй байна.

- Нэхэмжлэлийн зүйл
- Нэхэмжлэлийн үндэслэл

Нэхэмжлэлийн зүйл нь нэхэмжлэгчээс хариуцагчид тавьж буй материаллаг эрх зүйн шаардлага юм.

Нэхэмжлэлийн үндэслэл гэдэг нь нэхэмжлэлийн шаардлага гаргах болсон нөхцөл байдал юм. Өөрөөр хэлбэл эрх зүйн ямар харилцаанаас үүссэн маргаан болох, уг маргаан үүссэн шалтгаан, хууль зүйн факт, үйл баримт, үр дагавар зэрэг хамаарна.

Нэхэмжлэлийн үндэслэл нь нэг биш хэд хэдэн факт байж болно.

Нэхэмжлэл бүр өөрийн зорилготой байна. Тэрхүү зорилго нь нэхэмжлэлийн зүйл, үндэслэлээс хамаарч иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц, арга, агуулга, хэлбэрт шууд нөлөөлдөг.

Энэ байдлаас нь нэхэмжлэлийн төрлийг:

- Эрх хүлээн зөвшөөрүүлэх
- Эд хөрөнгө гаргуулах
- Эрх зүйн харилцааг өөрчлүүлэх нэхэмжлэл гэж ангилна.

Эрх хүлээн зөвшөөрүүлэх нэхэмжлэл:

Эрх хүлээн зөвшөөрүүлэх нэхэмжлэл нь нэхэмжлэгчээс хариуцагчтай маргаж байгаа болон зөрчигдсөн гэж үзэж буй эрхээ хууль ёсны болохыг шүүхэд хандан хүлээн зөвшөөрч, баталгаажуулж өгөхийг хүсдэг.

Эд хөрөнгө гаргуулах нэхэмжлэлд нэхэмжлэгч хариуцагчаас хүлээсэн үүргээ биелүүлэх, эд хөрөнгө авахаар шаардсан байна.

Эрх зүйн харилцааг өөрчлөх, дуусгавар болгох нэхэмжлэлийн зүйлийн гэрээний талуудын хэн нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөнөөс зохицох боломжгүй болсон маргаан, гэр бүлийн гишүүдийн дундын өмчтэй холбоотой шаардах эрх, тэтгэвэр тэтгэмжтэй холбоотой шаардлага нь эрх зүйн харилцааг өөрчлөхөд чиглэгддэг.



Нэхэмжлэлийн бүрдүүлбэр:

- Нэхэмжлэлийг ямар шүүхэд гаргаж байгаа;
- Нэхэмжлэгчийн овог, эцгийн нэр, нэр, хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр хаяг, оршин байгаа газар
- Хариуцагчийн овог, эцгийн нэр, нэр, хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, хаяг, оршин байгаа газар;
- Нэхэмжлэлийн үндэслэл, шаардлага, түүнийг нотлох баримт, Нэхэмжлэлийн үнэ.
- Нэхэмжлэлд нэхэмжлэгч буюу төлөөлөгч гарын үсэг зурж нэхэмжлэл болон баримтыг хариуцагчийн тоогоор хувилж өгнө;
- Хэрэв нэхэмжлэлийг төлөөлж гаргасан бол итгэмжлэлийг хавсаргана;
- Улсын тэмдэгтийн хураамж төлөхөөс чөлөөлүүлэх тухай хүсэлт;
- Нэхэмжлэлд улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримтыг хавсаргана;

Хавсаргасан баримт бичгийн жагсаалт; нэхэмжлэлийг шүүхэд гаргахдаа хариуцагчийн тоогоор хувилж ирүүлнэ.



Хяналтын асуулт

1. Нэхэмжлэлийн тухай ойлголтыг явцуу болон өргөн агуулгаар нь харьцуулж тайлбарлана уу?
2. Нэхэмжлэлийн бүрдүүлбэрт юуг хамааруулан ойлгодог вэ? Тодорхой жишээ гарган тайлбарлана уу?
3. Нэхэмжлэлийн зүйлийг тодорхойлно уу?
4. Нэхэмжлэлийн үндэслэлийг хэрхэн тодорхойлох вэ?
5. Нэхэмжлэлийн төрлийг жишээн дээр ялгаж тайлбарлана уу?



Сорил

1. Аль нь нэхэмжлэлийн үндэслэлийг тодорхойлж байна вэ?
 - а. Нэхэмжлэлд дурьдсан бүх зүйл юм.
 - б. Нэхэмжлэлд хавсаргасан баримт бичиг
 - в. Нэхэмжлэлийн шаардлага гаргах болсон нөхцөл юм
2. Эдгээрээс аль нь нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэлд хамаарахгүй вэ?
 - а. Маргаан шүүхэд харъяалагдахгүй бол
 - б. Хариуцагчийн хаяг тодорхойгүй
 - в. Нэхэмжлэлийг хоёр буюу гурван хувь үйлдсэн байх
 - г. Нэхэмжлэлд улсын тэмдэгтийн хураамж төлөөгүй байх
3. Нэхэмжлэл гаргасан этгээд эрхийн бүрэн чадамжгүй бол:
 - а. Нэхэмжлэгчийг солино
 - б. Төлөөлөгчийг томилно
 - в. Хүлээн авахаас татгалзана
 - г. Эрх залгамжлагчийг шүүх томилно.

- 4. Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамжид гомдол гаргах эрхтэй байх үндэслэлийг олно уу?**
- а. Нэхэмжлэлийн бүрдүүлбэр дутуу*
 - б. Нэхэмжлэлийг төлөөлөх бүрэн эрхгүй этгээд гаргасан*
 - в. Нэхэмжлэл уг шүүхэд харъяалагдах бол*
 - г. Нэхэмжлэл нь шүүхэд харъяалагдахгүй бол*
- 5. Сөрөг нэхэмжлэл гэдгийг тодорхойлно уу?**
- а. Үндсэн нэхэмжлэлтэй хамт шийдвэрлүүлэх шаардлагыг хариуцагч гаргасныг хэлнэ.*
 - б. Маргаж байгаа зүйлийн хувьд нэхэмжлэгчид тавьсан шаардлага юм.*
 - в. Үндсэн нэхэмжлэлд үл хамаарах шаардлага юм.*
- 6. Хариуцагч сөрөг нэхэмжлэл гаргасан тохиолдолд тухайн хэргийг шийдвэрлэх гэж байгаа шүүгч сөрөг нэхэмжлэл гаргасантай холбогдуулж дахин иргэний хэрэг үүсгэх тухай захирамж гаргах уу?**
- а. Шүүгч дахин иргэний хэрэг үүсгэх тухай захирамж гаргана*
 - б. Дахин иргэний хэрэг үүсгэх тухай шүүгчийн захирамж гаргах асуудлыг шүүгч үзэмжээрээ шийдвэрлэнэ.*
 - в. Үгүй*
 - г. Тухайн шүүхийн ерөнхий шүүгч зөвшөөрвөл шүүгч дахин иргэний хэрэг үүсгэх тухай захирамж гаргана*
- 7. Хариуцагчийн гаргасан сөрөг нэхэмжлэлийг шүүх үндсэн нэхэмжлэл гаргасан этгээдэд гардуулан өгөх үүрэгтэй юу?**
- а. Тийм*
 - б. Үгүй*
 - в. Энэ асуудлыг шүүгч өөрийн үзэмжээр шийднэ*
 - г. Энэ асуудлыг тухайн шүүхийн ерөнхий шүүгчид танилцуулан шийдвэрлэнэ*



Бодлого

1. Иргэн Намсрай 2007 оны 7 дугаар сарын 1-ний өдөр БЗД-ийн шүүхэд нэхэмжлэл гаргажээ. Нэхэмжлэлдээ төрсөн охин Мөнхөө 2004 онд нас барснаас хойш Мөнхөөгийн ганц хүү Дорж түүний өмчлөлийн “Сансар” зочид буудлыг ганцаараа өмчилж байгаа тул өв залгамжлагчаар тогтоолгож өгөхийг хүсчээ. Намсрай нэхэмжлэлийг өөрийн оршин суугаа газрын харьяа шүүхэд гаргасан ба хариуцагч нь Баянгол дүүргийн 3 дугаар хороонд амьдардаг байв. Өвийн хөрөнгө гэж маргаж байгаа үл хөдлөх хөрөнгө нь Сүхбаатар дүүрэгт байрладаг. Шүүх Намсрайн нэхэмжлэлд иргэний хэрэг үүсгэхээс татгалзаж захирамж гаргасан байна.
Энэ тохиолдолд:



- Шүүхийн иргэний хэрэг үүсгэхээс татгалзсан захирамжийн үндэслэлийг олно уу?
 - Намсрай энэхүү захирамжинд гомдол гаргах эрхтэй эсэхийг тодорхойлж, түүнд эрх зүйн туслалцаа үзүүлнэ үү?
2. Дор дурьдсан тохиолдолд нэхэмжлэлийн элемент ба төрлийг тодорхойлно уу?
- а. Оргил 800 000 төгрөгийг 3 сарын хугацаатай зээлж авсан боловч, уг хугацаа дуусахад мөнгийг эргүүлж өгөөгүй Эрдэнээс зээлдүүлсэн 800 000 төгрөгийг нэхэмжлэв.
 - б. Орхон аймгийн Баян - Өндөр суманд оршин суух Шүрээ тус сумын Зэст багийн 1-3-29 тоотод оршин суух Энхээг уг орон байрнаас албадан нүүлгэж гаргуулах тухай нэхэмжлэл гаргажээ. Энхээ нь Шүрээгийн ах Санжаатай 2006 оны 1 дүгээр сараас эхлэн байрны үнэ төлөлгүй хажуу өрөөнд нь амьдарч байсан бөгөөд ах Санжаа 2006 оны 3 дугаар сарын 28 ний өдөр 85 насандаа нас барсан байтал одоо хүртэл байрыг нь чөлөөлж өгөхгүй элдэв янзаар доромжлоод байдаг тухай дурьджээ.
- Шүрээ нэхэмжлэлийг эсэргүүцэж, сөрөг нэхэмжлэл гаргахдаа:*
2000 оноос эхлэн Санжааг төрсөн эцэг мэт халамжлан асарч тэтгэж байсан. Хувцсыг нь угааж, хоол цайг нь хийж асран халамжилж, амьдарсан үеэсээ эхлэн байр, гэрлийн мөнгийг төлдөг байсан ба асран халамжилсанд талархаж, орон сууцны байраа үлдээнэ гэж олон удаа хэлж, энэ тухайгаа бичгээр бичиж үлдээсэн. Санжааг асарсны хөлс 2 200 000 төгрөг, байрны хөлс төлсөн 2 220 000 төгрөг бүгд 4 420 000 төгрөгийг надад гаргуулж өгнө үү? гэжээ.
3. Оюунцэцэг 3 настай хүүгийн эцгээр Нямболдыг тогтоолгож, хүүдээ тэтгэлэг гаргуулахаар нэхэмжлэл гаргав.



Даалгавар:

- Иргэн Ядмаад эрх Зүйн туслалцаа үзүүлж, хуулийн шаардлага хангасан нэхэмжлэл бичиж өгнө үү?
Болсон үйл явдал: Ядмаа “Аз” ХЗХоршооноос 5 сая төгрөгийг 1 жилийн хугацаатай, сар бүр 2 хувийн хүүтэйгээр зээлж авсан ба зээлийн барьцаанд өөрийн өмчлөлийн хашаа байшинг тавьсан байна. Зээлж авсан мөнгөө өөрийн сайн найз Дандарт зээлдүүлсэн ба тэрээр мөнгийг эргүүлж өгөлгүй хохироож байгаа. Тийм учраас тэрээр хуульд заасан бүрдүүлбэр хангасан нэхэмжлэл шүүхэд гаргах шаардлагатай.



Эх сурвалж:

- ИХШХШТХууль 2002 он
- Иргэний хууль 2002 он

ШҮҮХИЙН ЗАРДАЛ БА УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖ

Сэдвийн зорилго: Шүүхээс иргэний хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдон зайлшгүй гарах зардал, улсын тэмдэгтийн хураамж, шүүхийн зардлын ямар хэсгийг хэрхэн төлөх, талаар **мэдлэгтэй** болж, нөхөн төлөх шүүхийн зардлын хэмжээ болон улсын тэмдэгтийн хураамжийн хувь хэмжээг зөв тодорхойлох **чадвар** эзэмшинэ.

Сэдвийн агуулга:

- Шүүхийн зардлын тухай ойлголт
- Нөхөн төлөх шүүхийн зардал
- Нөхөн төлөх шүүхийн зардлаас чөлөөлөх
- Улсын тэмдэгтийн хураамж
- Улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх
- Нэхэмжлэгч төлбөрийн чадваргүй болох
- Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал



Нэр томъёоны тайлбар

Шүүхийн зардал - Шүүхээс хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдон зайлшгүй гарах зардлыг шүүхийн зардал гэнэ. Шүүхийн зардлыг улсын төвлөрсөн төсвөөс санхүүжүүлнэ.

Нөхөн төлөх шүүхийн зардал - Иргэний хэрэгхянан шийдвэрлэх явцад гарсан зарим зардлыг хэргийн оролцогчдоор нөхөн төлүүлдэг. Нөхөн төлөх шүүхийн зардалд шинжээч, орчуулагч, хэлмэрчийн болон гэрчийн тээвэр, байр, хоолны зардал, үзлэг, туршилт, таньж олуулах ажиллагаа явуулахад гарсан зардал, эд мөрийн баримт хадгалах зардал зэрэг хамаарна.

Улсын тэмдэгтийн хураамж - Шүүхээс тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлсний төлөө хуульд заасан хэмжээ, журмаар төлөх мөнгөн хураамж юм. Өөрөөр хэлбэл улсын тэмдэгтийн хураамж нь шүүхээс эрх зүйн маргааныг шийдвэрлэхтэй холбогдсон үйлчилгээ үзүүлсний төлөө зохигчоос төлж байгаа мөнгөн хөрөнгө. Улсын тэмдэгтийн хураамжийг урьдчилан нэхэмжлэгчээр төлүүлж, нэхэмжлэл хангагдсан тохиолдолд хариуцагчаар төлүүлэн нэхэмжлэгчид буцаан олгоно. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар шүүх улсын тэмдэгтийн хураамжийг нөхөн төлүүлэх, чөлөөлөх, буцаах, хувиарлах зэрэг харилцааг зорицуулдаг бол Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулиар улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоох, төлөх, хураахтай холбогдсон харилцааг зохицуулна.

Нэхэмжлэлийн үнэ - Энэ нь нэхэмжлэлийн шаардлагын мөнгөн илэрхийлэл. Нэхэмжлэлийн үнээс шалтгаалан шүүхэд төлөх улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээ нь өөр өөр байна. Нэхэмжлэлийн үнийг зөв тодорхойлох нь төлөх улсын тэмдэгтийн хураамжийг төлөх үндэслэл болно. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 63 дугаар зүйлд нэхэмжлэлийн үнийг мөнгө төлүүлэхээр шаардсан нэхэмжлэлд нэхэмжилж байгаа мөнгөний үнийн дүнгээр, эд хөрөнгө гаргуулах тухай нэхэмжлэлд эд хөрөнгийн тухайн үеийн зах зээлийн үнийн дүнгээр, бие даасан хэд хэдэн шаардлагыг нэг нэхэмжлэлд бичсэн бол бүх шаардлагын үнийн нийлбэрээр,



гэрээ, хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулах нэхэмжлэлд уг гэрээ, хэлцлийн үнийн дүнгээр, тогтмол хугацаанд төлөгдөх тэтгэвэр, тэтгэмж, тэтгэлэг, хохирол, нөхөн төлбөр шаардсан нэхэмжлэлд тэдгээрийн нэг жилийн хугацаанд төлбөл зохих дүнгээр, үл хөдлөх хөрөнгө гаргуулах нэхэмжлэлд Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газарт бүртгүүлсэн үнийн дүнгээр, нэр төр, алдар хүнд,ажил хэргийн нэр хүндэд учирсан гэм хорын хохирлыг нэхэмжлэлд заасан үнийн дүнгээр, үнэт цаастай холбогдох нэхэмжлэлд хөрөнгийн биржийн тухайн үеийн ханшаар, тусгай зөвшөөрөл, тендертэй холбогдох нэхэмжлэлд тусгай зөвшөөрлийн, эсхүл тендерийн хураамжийн дүнгээр тус тус нэхэмжлэлийн үнийг тодорхойлно.

Шүүхээс иргэний хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдон зайлшгүй гарах зардлыг шүүхийн зардал гэнэ.

Шүүхийн зардал нь улсын тэмдэгтийн хураамж, хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдон гарсан бусад зардлаас бүрдэнэ.

Улсын тэмдэгтийн хураамж нь шүүхийн зардлыг бүрдүүлэгч гол хэсэг бөгөөд төрийн байгууллага, тухайлбал шүүхээс тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлсэний төлөө хуульд заасан хэмжээ, журмаар төлөх мөнгөн хураамж юм. Энэ нь улсын төсвийн орлогод орсноор шүүхээс хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдон гарсан зарим зардлыг багасгахад чиглэгддэг.

Улсын тэмдэгтийн хураамжийг Монгол улсын улсын тэмдэгтийн тухай хуульд зааснаар гаргуулна. /1993 оны хууль 6-р зүйл/. /Уг хуульд 1999 оны 4-р сарын 22-нд нэмэлт өөрчлөлт орсон/

Шүүхэд нэхэмжлэл гаргагч улсын тэмдэгтийн хураамжийг нэхэмжлэлийн үнийн дүнгээс хамаарч хуульд заасан хувь, хэмжээгээр төлж баримтыг нэхэмжлэлд хавсаргах журамтай. Харин анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалд гомдол гаргаж байгаа этгээд шийдвэр, магадлалыг хүлээн зөвшөөрөхгүй байгаа хэмжээгээр улсын тэмдэгтийн хураамжийг тооцон төлнө.

Анхан шатны шүүхэд буюу нэхэмжлэл гаргахдаа ямар хэмжээний хураамж төлөх вэ? гэдэг нь нэхэмжлэлийн үнээс хамаарна.

Нэхэмжлэлийн үнэ нь нэхэмжлэлийн шаардлагын мөнгөн илэрхийлэл.

Нэхэмжлэлийн үнийг нэхэмжлэгч тогтоох бөгөөд онцгой тохиолдолд шүүх тогтоох журам бий. Улсын тэмдэгтийн хураамжийг хуульд зааснаар дараах хувь хэмжээгээр төлдөг. /УГХ-ийн тухай хууль 6-р зүйл/

Улсын тэмдэгтийн хураамж

Нэхэмжлэлийн үнэ /төгрөгөөр/		Хураамжийн хувь хэмжээ
1	0-3.000	50 төгрөг
2	301-10.000	Нэхэмжлэлийн үнийн дүнгийн 2%
3	10.001 - 50.000	200 төгрөг дээр 10.000-с дээш төгрөгний нэхэмжлэлийн үнийн дүнгийн 3.5% - ийг нэмнэ.

4	50.001 - 500.000	1.500 төгрөг дээр 50.000-с дээш төгрөгний нэхэмжлэлийн үнийн дүнгийн 4% - ийг нэмнэ.
5	500.001 -1.000.000	19.500 төгрөг дээр 500.000 - с дээш төгрөгний нэхэмжлэлийн үнийн дүнгийн 2.1% - ийг нэмнэ.
6	1.000.001 - 10.000.000	30.000 төгрөг дээр 1.000.000 - с дээш Төгрөгний нэхэмжлэлийн үнийн дүнгийн 1.4% - ийг нэмнэ.
7	10.000.001 - ээс дээш	156.000 төгрөг дээр 10.000.000 - с дээш төгрөгний нэхэмжлэлийн үнийн дүнгийн 0.5% - ийг нэмнэ

Шүүхийн зардлын нэг гол хэсэгт *хэрэг хэлэлцэх үйл ажиллагаатай холбоотой бусад зардлууд хамаарна. Үүнд:*

- Шинжээч, орчуулагчийн (хэлмэрч) тээвэр байр хоолны зардал, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар гүйцэтгэсэн ажил үүрэгт ажилд нь хамаарахгүй бол ажлын хөлс,
- Гэрчийн тээвэр, байр, хоолны зардал, цалин, хөдөлмөрийн хөлс,
- Үзлэг хийх, туршилт явуулах, таньж олуулах ажиллагаа явуулахад гарсан зардал,
- Эд мөрийн баримт хадгалах зардал,
- Гэрчийн мэдүүлгийг газар дээр нь очиж авсан зардал гэх мэт болно.

Шүүхийн нөхөн төлүүлэх зардлыг ИХШХШТХ-ийн 54, 56-р зүйлд зааснаар тодорхойлж зохигчдод хувиарлан төлүүлнэ.

Улсын тэмдэгтийн тухай Монгол улсын хуулийн 18-р зүйлд заасан үндэслэлээр улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөнө.

ИХШХША-д улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх үндэслэлүүд:

- Тэтгэвэр, тэтгэмжийн талаар гаргасан нэхэмжлэл.,
- Патент, зохиогчийн эрхтэй холбогдсон нэхэмжлэл.,
- Төсвийн байгууллагын нэхэмжлэл.,
- Төсөвт төлөх албан татвар хураамж, төлбөр торгууль гаргуулах талаарх нэхэмжлэл.,
- Гомдлоор авч хэлэлцэх хэргийн нэхэмжлэл.,
- Шүүхийн зардал төлөх хөрөнгөгүй учир шүүгчийн захирамжаар шүүхийн зардал төлөхөөс чөлөөлөгдсөн бол.,
- Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгуулахаар гаргасан нэхэмжлэл.,
- Цэргийн албан хаагчаас цэргийн үүрэг гүйцэтгэхтэй холбогдон гаргасан өргөдөл, нэхэмжлэл.,
- Хууль бусаар ял шийтгэсэн, эрүүгийн хариуцлагад татсан, таслан шийтгэх арга хэмжээ болох цагдан хорьсон, захиргааны шийтгэлийн журмаар баривчлах арга хэмжээ авснаас учирсан хохирлыг төлүүлэхээр гаргасан нэхэмжлэл.,
- Хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авсан тохиолдолд нөхөх олговор, үнийг төлүүлэхтэй холбогдон гаргасан нэхэмжлэл.

Улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгох журам:

Хэрэв шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан бол улсын тэмдэгтийн



хураамжийг шүүгчийн захирамжаар буцаан олгохоос гадна давж заалдах буюу хяналтын журмаар гомдол гаргасан этгээд шүүх хуралдаанаас өмнө түүнээсээ татгалзвал тухайн шатны шүүхэд гомдол гаргахдаа төлсөн улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгох захирамж гаргана. Мөн түүнчлэн давж заалдах болон хяналтын шатны шүүх хэргийн оролцогчид тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн гаргасан гомдлыг үндэслэл бүхий байна гэж үзэн шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгосон буюу өөрчилсөн тохиолдолд гомдол гаргагчаас тухайн шатны шүүхэд төлсөн улсын тэмдэгтийн хураамжийг тухайн шатны шүүгчийн захирамжаар буцаан олгоно.

Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг сайн дураараа хүлээн зөвшөөрч биелүүлсэн шалтгаанаар нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан бол хариуцагчийн төлөх шүүхийн зардлыг тавин хувиар хөнгөлнө.

Нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаа багасгах, нэхэмжлэлээсээ татгалзах, зохигч эвлэрэх замаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болсон бол /энд хялбаршуулсан журмаар хэргийг шийдвэрлэсэн байдал хамаарахгүй/, ИХШХШТХуулийн 100.2-т заасны дагуу нэхэмжлэлийг шүүх буцаасан бол улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгохгүй.

Энэхүү журмыг бүдүүвчээр үзүүлбэл:



Нөхөн төлүүлэх шүүхийн зардлыг хувиарлах журам.

- Нэхэмжлэлийг бүрэн хангасан тохиолдолд хариуцагчаар шүүхийн зардлыг төлүүлнэ.

- Нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон бол нэхэмжлэгчээр шүүхийн зардлыг хариуцна.
- Нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангасан бол тэр хэмжээгээр нэхэмжлэгч, хариуцагчид хувиарлан нөхөн төлүүлнэ.
- Хяналтын болон давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг өөрчилбөл шүүхийн зардлын хувиарлалтыг нэгэн адил өөрчлөн шийдвэрлэнэ.

Нөхөн төлүүлэх шүүхийн зардлын хэмжээг тодорхойлох

Шүүхийн зардлыг дараах журмаар нөхөн төлүүлнэ.

- Шинжээч, орчуулагч, хэлмэрч, гэрчид олгох тээвэр, хоолны зардал. Үүнийг улсын төсвөөс санхүүждэг байгууллагад мөрдөгдөж буй албан томилолтыг зардлын хэмжээгээр.
- Шинжээч, орчуулагч, хэлмэрчийн ажлын хөлсийг шүүхээс төлсөн хэмжээгээр
- Мэдүүлэг өгөхөөр дуудсан хугацаанд гэрч цалин хөлсөөрөө хохирсон бол энэ хугацаанд цалин хөдөлмөрийн хөлсний дунджаар.
- Бусад зардлыг гүйцэтгэлийн баримтад заасан хэмжээгээр.
- Зардлыг шүүхээс заасан улсын төвлөрсөн төсвийн дансанд тушаана. Эдгээр зардлыг бодит зардлаар тодорхойлно.



Хяналтын асуулт

1. ИХШХША-нд шүүхийн зардал гэдгийг хэрхэн тодорхойлдог вэ?
2. Шүүхийн зардалд юу хамаарахыг жишээн дээр тайлбарлана уу?
3. Улсын тэмдэгтийн хувь хэмжээг хуулиар хэрхэн тодорхойлох вэ?
4. Улсын тэмдэгтийн хувь хэмжээг жишээн дээр бодож гаргана уу?
5. Нөхөн төлөх шүүхийн зардлын хэмжээг хэрхэн тодорхойлох вэ?
6. Улсынтэмдэгтийн хураамжийг хэрхэн хуваарилах вэ?
7. Улсын тэмдэгтийн хураамж буцаах үндэслэл нь юу вэ?
8. Улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх үндэслэл журмыг хэлэлцэнэ үү?



Сорил

1. **Шүүхийн зардалд аль нь хамаарах вэ?**
 - а. Шүүхээс хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотойгоор гарсан бүх зардал
 - б. Гэрч шинжээчийн зардал
 - в. Шүүгч, шүүхийн ажлын зардал
 - г. Улсын тэмдэгтийн хураамж
2. **Шүүхийн зардлыг хаанаас гаргах вэ?**
 - а. Зохигч
 - б. Буруутай этгээд
 - в. Улсын төвлөрсөн төсвөөс
 - г. Орон нутгийн орлогоос



3. **Нөхөн төлүүлэх зардлыг хаанаас гаргадаг вэ?**
 - а. Улсын төвлөрсөн төсвөөс
 - б. Зохигчийн хураамж зардлаас
 - в. Орон нутгийн орлогоос
 - е. Буруутай этгээдийн хөрөнгөнөөс
4. **Улсын тэмдэгтийн хураамжийг хэн төлөх вэ?**
 - а. Зохигч
 - б. Нэхэмжлэгч
 - в. Улсын төсвөөс
 - г. Шүүхээс тогтоосон этгээд
5. **Эдгээрийн аль нь нөхөн төлүүлэх шүүхийн зардалд хамаарах вэ?**
 - а. Зохигчийн шүүхэд тайлбар өгөх, шүүх хуралдаанд оролцоход гарсан тээврийн зардал
 - б. Нэхэмжлэгч нэхэмжлэлдээ хавсарган өгсөн бичмэл нотлох баримтыг хувилахад төлсөн мөнгө
 - в. Зохигчийн шүүхэд тайлбар өгөх, шүүх хуралдаанд оролцсон үедээ авч чадаагүй цалин, хөдөлмөрийн хөлс
 - г. Эд мөрийн хадгалсны зардал
6. **Улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх асуудлыг хэн шийдвэрлэх вэ?**
 - а. Шүүхийн тогтоолоор
 - б. Шүүгчийн захирамжаар
 - в. Зохигчийн хүсэлтээр
 - г. Дээд шатны шүүхийн шийдвэрээр
7. **Дараахаас улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгох үндэслэлийг ол.**
 - а. Зохигчийн хүсэлтээр
 - б. Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан бол
 - в. Зохигчид эвлэрсэн
 - г. Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан бол
8. **Давж заалдах болон хяналтын гомдолд улсын тэмдэгтийн хураамж төлөх үү?**
 - а. Анхан шатны шүүхэд төлсөн бол дахин төлөхгүй
 - б. Давж заалдах болон хяналтын шатанд гомдол гаргахад улсын тэмдэгтийн хураамж төлнө.
 - в. Шийдвэр, магадлалд гомдол гаргаж байгаа этгээд шийдвэр магадлалыг хүлээн зөвшөөрөхгүй байгаа хэмжээгээр төлнө
 - г. Хяналтын журмаар гомдол гаргасан бол төлөхгүй



Бодлого

1. Нэхэмжлэгч Ариунаа иргэн Занаатай орон сууц худалдах-худалдан авах гэрээ хийж, 16 сая төгрөгөөр орон сууцаа худалдахаар тохирчээ. Худалдан авагч Ариунаа нь Иргэний хуулийн 109 дүгээр зүйлийн 109.2-л заасны дагуу үл хөдлөх эл хөрөнгө болох орон сууцны өмчлөх эрхийг шилжүүлэхээр хэлцэл хийж, нотариатаар гэрчлүүлж, төлбөрөө худалдагч Занаад төлсний дараа орон сууцыг худалдахаар гэрээ хийсэн Занаа нь сэтгэцийн өвчтэй болохыг хамтран өмчлөгч Нансаагийн орон сууцаа зарахгүй гэсэн шаардлагаас үүдэн мэдсэн байна. Иймд иргэн Ариунаагийн Занаатай байгуулсан орон сууц худалдах-худалдан авах гэрээг Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.6-д заасны дагуу хүчин төгөлдөр бус болохыг тогтоолгохоор Нансаа нэхэмжлэлийн шаардлага шүүхэд гаргажээ.

Энэ тохиолдолд:

- Нэхэмжлэгчийн шүүхэд төлөх улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн тодорхойлно уу?
2. Цэцгээ 6 настай хүүгийнхээ эцгээр Болдсайханыг тогтоолгож, хүүхдийн тэтгэлэг гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргав.

Энэ тохиолдолд:

- Цэцгээ улсын тэмдэгтийн хураамж төлөх эсэхэд дүгнэлт хийнэ үү?
- Хэрэв Цэцгээ улсын тэмдэгтийн хураамж төлөх бол түүний хэмжээг тодорхойлно уу?



Даалгавар:

- Улсын тэмдэгтийн хураамжийн хувь хэмжээг зөв тодорхойлж сурах
- Улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх үндэслэлийг нарийвчлан судлах
- Ямар тохиолдолд улсын тэмдэгтийн хураамжийг буцаах вэ гэдгийг тодорхой жишээ авч, энэ талаар олсон мэдлэгээ бататгах



Эх сурвалж:

1. ИХШХШТХууль. 1994, 2002 он
2. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль. 1993
3. Шүүхийн тухай хууль
4. УДШүүхийн 2002.07.24-ны 263 дугаар тогтоол (Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай, Төрийн мэдээлэл 2003.09.28. №36)



VII БҮЛЭГ. АНХАН ШАТНЫ ШҮҮХ ХУРАЛДААН

АНХАН ШАТНЫ ШҮҮХ ХУРАЛДААНД БЭЛТГЭХ ҮЕ ШАТ

Сэдвийн зорилго: Иргэний хэргийг анхан шатны журмаар хянан хэлэлцэх шүүх хуралдааны бэлтгэл ажиллагааг хангахад чиглэгдсэн эрх зүйн үндсэн зохицуулалтыг танин мэдэхэд оршино.

Сэдвийн агуулга:

- Анхан шатны шүүх хуралдаанд бэлтгэх ажиллагааны ойлголт, агуулга
- Анхан шатны шүүх хуралдааны бэлтгэл хангах шүүгчийн ажиллагаа
- Анхан шатны шүүх хуралдаанд бэлтгэх ажиллагаанд хэргийн оролцогчдын эрх, үүргийг тодорхойлох тухай
- Шүүхийн мэдэгдэх хуудас, түүний ач холбогдол
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх үндэслэл, журам
- Шүүгч дангаар шийдвэрлэх хэрэг маргаан
- Шүүх хуралдаан даргалагч түүний эрх, үүрэг
- Шүүх хуралдааны нийтлэг дэг
- Шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг томилох
- Иргэдийн төлөөлөгчийг томилох
- Шүүгчийг татгалзан гаргах тухай ойлголт, үндэслэл, журам



Нэр томъёоны тайлбар

Анхан шатны шүүх хуралдаанд бэлтгэх ажиллагаа - Иргэний хэргийг шүүх хуралдаанд бэлтгэх үйл ажиллагаа нь анхан шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх чухал үе шат байдаг. Иргэний хэргийг шүүх хуралдаанд бэлтгэх ажиллагааг явцуу буюу өргөн утгаар авч үзэж болох юм. Хэргийг шүүх хуралдаанд бэлтгэх эрх үүрэг зөвхөн **шүүхэд** хамаарна гэсэн талаасаа явцуу утгыг, харин **хэргийн зохигч болон оролцогчид** нь зөрчигдсөн эдийн ба эдийн бус баялагтай холбоотой эрхээ хамгаалж, өөртөө ашигтай шийдвэр гаргуулахын тулд шаардаагатай нотлох баримт гаргах, бусад үйлдэл хийх эрх, үүрэгтэй болох талаас нь авч үзвэл өргөн ойлголт байна.

Шүүхийн мэдэгдэх хуудас - Монгол Улсын ИХШХШ тухай хуулийн 77 дугаар зүйлд зааснаар шүүгч нь хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид хэргийг ямар шүүхэд, хэзээ, хаана хэлэлцэж шийдвэрлэх тухай шүүхийн мэдэгдэх хуудсаар мэдэгдэнэ.

Шүүхийн мэдэгдэх хуудсыг хэргийн оролцогчийн оршин суугаа газар буюу ажлын газрын хаягаар хүргүүлнэ. Мэдэгдэх хуудас нь шүүх хуралдаанд хэргийн оролцогчид мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэхэд ач холбогдолтой.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх - Иргэний хэргийг шүүхээс хянан шийдвэрлэхэд саад болж байгаа, хуульд заасан тодорхой нөхцөл байдлыг арилгах хүртэл уг хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааг зогсоохыг хэлнэ. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шүүх хуралдааны үед шүүхийн тогтоолоор шүүх хуралдаанаас өмнө шүүгчийн захирамжаар түдгэлзүүлнэ.

Шүүх хуралдааны оролцогч - ИХШХШТ хуулийн 85-р зүйлд “Шүүх хуралдааны оролцогч гэдэгт хэргийн оролцогч, шинжээч, гэрч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, иргэдийн төлөөлөгч хамаарна” гэж тодорхойлсон. Харин хэргийн оролцогчийн бүрэлдэхүүнд зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч ба ИХШХШТ хуулийн 12.1.2, 12.1.4,-д заасны дагуу бусдын эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалж хэрэг шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа субъектүүд хамаарна.

Шүүгч дангаар шийдвэрлэх хэрэг: ИХШХШТ тухай хуулийн 82 дугаар зүйлд шүүгч дараах хэргийг дангаар хянан шийдвэрлэнэ гэж заажээ.

Үүнд: Иргэний хуулийн 8.1.1, 8.1.3, 8.1.4, 8.1.6, 8.1.8 дахь заалт, Хөдөлмөрийн хуулийн 128.1.1-ээс 128.1.4, 128.1.6-аас 128.1.11 дэхь хэсэгт заасан хэрэг, Гэр бүлийн эрх зүйн харилцаанаас үүссэн маргаан, Тэтгэврийн харилцаанаас үүссэн маргаан, Тэтгэмжийн тухай хуулийн 27 дугаар зүйл, ИХШХШ тухай хуулийн 74, 133 дугаар зүйл, шүүх мөнгөн торгууль оногдуулахаар хуульд заасан асуудал болон бусад хуулиар шүүхэд харъяалуулсан хэрэг, эрх зүйн маргаан. ИХШХШ тухай хуулийн дээрх зүйлд (82-р зүйлд) заасан хэргээс бусад хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэнэ.

Энэ үе шатанд нэхэмжлэгч, хариуцагч болон хэргийн бусад оролцогчид хуульд заасан эрх үүргийн дагуу идэвхитэй оролцох ёстой.

Тухайлбал: ИХШХША-ны зохигчдын аль нэг нь хэргийг шүүх хуралдаанд бэлтгэх шатанд идэвхитэй оролцохгүй буюу эсвэл өөрийг нь гарцаагүй буруугүй гэж тогтоох ач холбогдол бүхий нотлох баримтыг гаргаж чадахгүй, цуглуулсан нотлох баримтыг нь шүүгч ач холбогдолгүй гэж дүгнэсэн гэх мэт тохиолдолд түүний шүүхээр шийдвэрлэх гэж байгаа хэргийн хувьд ашигтай шийдвэрлэх боломж тухайн идэвхигүй оролцогчийн хувьд хязгаарлагдана.

Шүүгч нэхэмжлэлийн өргөдлийг хүлээн аваад иргэний хэрэг үүсгэмэгц зохигчдод эрх үүргийг сайтар тайлбарлаж өгөх бөгөөд хуулиар тодорхойлогдсон (ИХШХШ тухай хуулийн 25-р зүйл) эрхээ эдэлж, үүргээ биелүүлж иргэний хэрэг шийдвэрлэх ажиллагаанд идэвхитэй оролцвол шүүх хэргийг шийдвэрлэж үндэслэлтэй шийдвэр гаргах боломж бүрдэнэ. Иргэний хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлтгэх энэ шатанд шүүгчийн гүйцэтгэх үүрэг, эдэх эрх хэмжээ ч өргөн бөгөөд олон тал, чиглэлтэй байна. Үүнд:

Нотлох баримтуудыг гардуулж бүрдүүлэх, зохигчийн тайлбарыг авах, нэхэмжлэлийн агуулыг тодорхойлж эрх зүйн харилцааны аль төрөл болохыг зүйлчлэх, холбогдох хууль тогтоомжийг судлах, цугларсан нотлох баримтуудад үнэлэлт дүгнэлт өгөх зэргээр тухайн хэргийн хувьд ямар үйл ажиллагаа хийхийг урьдаас төлөвлөсөн байна. Шүүгч нэхэмжлэгч нь нэхэмжлэл гаргах эрхтэй этгээд мөн эсэхэд (эрх зүйн чадамжтай, итгэмжлэгдсэн болон хууль ёсны төлөөлөгч нь мөн эсэх), хуулийн дагуу үнэлэлт хийж болно.

Тухайлбал: ИХШХШ тухай хуулийн 80-р зүйлд заасан үндэслэлээр “Хэрэг хэлэлцэх ажиллагааг түдгэлзүүлэх”, “Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах” (ИХШХШ тухай хуулийн 69-р зүйл), хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх (74-р зүйл) “Нотлох баримтыг хамгаалах” гэх мэт




ажиллагаануудыг хуульд заасан журмын дагуу хэрэгжүүлдэг байна. Мөн энэ үе шатанд шүүгчийн туслах, нарийн бичгийн дарга, шүүхийн тамгын хэлтсийн дарга, зарлага гэх мэт хүмүүс хамтран ажиллана. Шүүх хуралдааны бэлтгэлийг сайтар хангасан нөхцөлд анхан шатны шүүхээр иргэний хэрэг хэлэлцэх ажиллагаа ч мөн тийм хэмжээнд явагдах нь тодорхой.



ИХШХШТХийн 76-р зүйл/

Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлтгэх ажиллагаанд оролцогч субъектууд



Өөрөөр хэлбэл иргэн хуулийн этгээд болон тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч болон төрийг төлөөлөн оролцож буй прокуророос шүүхэд гаргасан нэхэмжлэл, хүсэлт гомдлыг хүлээн авсан шүүгч ИХШХШ тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу иргэний хэрэг үүсгэх үндэслэлтэй бол захирамж гаргаснаар тухайн хэргийг шүүх хуралд бэлтгэж эхэлнэ

Иймд иргэний хэргийг шүүхэд бэлтгэх нь шүүх, нэхэмжлэгч, хариуцагч, бусад оролцогчдын хамтын ажиллагаа байна хэмээн товчоор хэлж болно. Хэргийг шүүх хуралд бэлтгэх ажиллагаа нь хууль зүйн дагуу үндэслэлтэй бөгөөд шударга зарчимтай хийгдэх эсэхээс хамаарч дараагийн үе шат, тухайлбал шүүх хуралдаан, шийдвэр гаргах, давж заалдах болон хяналтын шатны шүүхийн үйл ажиллагаанд эерэг буюу сөрөг аль нэг хэлбэрээр нөлөөлнө.

Хэрэг хянан шийдвэрлэх бэлтгэл ажиллагааны үед хэргийн оролцогч нь оршин суугаа хаяг болон ажлаа өөрчилбөл энэ тухай шүүхэд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй. Хаягаа өөрчилснөө мэдэгдээгүй хариуцагчид мэдэгдэх хуудсыг өгөхдөө түүний хамгийн сүүлд оршин сууж байсан эсвэл ажиллаж байсан газрын хаягаар хүргүүлнэ.

Хариуцагчийг олох боломжгүй тохиолдолд түүний урьд нь оршин сууж байсан орон нутгийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэх хуудсыг гардуулан өгч гарын үсэг зуруулан, хүлээлгэн өгсөн, сар, өдөр цагийг нэгэн адил тэмдэглэнэ. Мэдэгдэх хуудсаар шүүх хурлын товыг хариуцагч болон хэргийн оролцогч, төлөөлөгчид урьдчилан мэдэгдэж байгаа нь тэдэнд тухайн хэрэгт оролцох бэлтгэлийг хангах нөхцөл бололцоог олгодог байна.

ИХШХШТХуулийн 80 дүгээр зүйлд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх үндэслэлийг тодорхой зааж өгсөн ба зохигч болох хүн нас барсан, хуулийн этгээд татан буугдсан тохиолдолд маргаантай байгаа шаардлага буюу маргаантай үүрэг нь эрх залгамжлагчид шилжих байвал, зохигчид асран хамгаалалт тогтоох шаардлагатай бол, зохигч нь онц ба дайны байдал зарласан нөхцөлд цэргийн алба хааж байгаа, эрүүгийн, иргэний, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх, арбитрын журмаар шийдвэрлэгдвэл зохих өөр хэрэг маргааныг шийдвэрлэхээс өмнө уг хэргийг шийдвэрлэх боломжгүй, зохигч хүнд өвчний учир эмнэлэгт байгаа, хариуцагчийг эрэн сурвалжилж байгаа, хэргийг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль Үндсэн хуульд нийцээгүй тухайн асуудлаар Улсын дээд шүүхэд санал оруулсан зэрэг үндэслэл байгаа бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ.

Хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсэн шалтгаан арилмагц хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээх тухай шүүгч захирамж гаргах ба энэ өдрөөс эхлэн хэрэг хянан шийдвэрлэх хугацааг үргэлжлүүлэн тоолно.



Хяналтын асуулт

1. Анхан шатны шүүх хуралдаанд бэлтгэх ажиллагааны зорилго, ач холбогдлын талаар хэлэлцэнэ үү?
2. Шүүх хуралдаанд бэлтгэх ажиллагааны агуулгыг тодорхойдно уу?
3. Шүүх хуралдаанд бэлтгэх шүүгчийн ажиллагааг нэрлэнэ үү?
4. Энэ үе шатанд түүгчээс гаргах эрх үйн баримт бичгийг дүгнэнэ үү?
5. Шүүх хуралдаанд бэлтгэх үе шатанд хэргийн оролцогчийн эрх, үүрэг ямар байх вэ?
6. Мэдэгдэх хуудас гэдгийг хэрхэн ойлгох вэ? Түүний үр дагавар.
7. Ямар тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх вэ?
8. Шүүх хуралдаанд оролцогчдыг нэрлэнэ үү?
9. Шүүх хурадааны нийтлэг дэг ямар байх вэ?
10. Иргэдийн төлөөлөгчийн эрх, үүргийг тодорхойлно уу?
11. Шүүгчийг татгалзан гаргах, түүний үндэслэлийг тайлбарлана уу?
12. Хэрийг шүүх хурадаанаар хэлэлцүүлэх тухай шүүгчийн захирамжийн төсөл бэлтгэж ярилцана уу?



Сорил

1. Шүүх хуралдааны товыг гаргахдаа шүүгч ямар эрхийн акт гаргах вэ?
 - а. Албан бичиг
 - б. Мэдэгдэх хуудас
 - в. Шүүгчийн захирамж
 - г. Шүүгчийн тогооол
2. Мэдэгдэх хуудсыг ямар журмаар мэдэгдэх вэ?
 - а. Амаар мэдэгдэж энэ тухай тэмдэглэл үйлдэнэ
 - б. Утсаар мэдэгдэж энэ тухай тэмдэглэл үйлдэнэ.
 - в. Мэдэгдэх хуудсыг хүргүүлж, үлдэх тасалбарт гарын үсэг зуруулна.
3. Иргэний хэрэг шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнийг яаж шийдвэрлэх вэ?
 - а. Ерөнхий шүүгчийн захирамжаар томилно.
 - б. Шүүхийн нарийн бичгийн даргын гаргасан хуваарийн дагуу
 - в. Урьдчилан тогтоосон харъяалалаар
 - г. Шүүгчдийн зөвлөгөөнөөр баталсан хуваарийн дагуу
4. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдааныг шүүгч дангаараа хийж байгаа тохиолдолд иргэдийн төлөөлөгч оролцох уу?
 - а. Шүүхийн тухай хуульд зааснаар оролцоно
 - б. Шүүгч дангаараа хэрэг хянан шийдвэрлэхэд иргэдийн төлөөлөгч оролцохгүй
 - в. Шүүх хуралдаан даргалагчийн шийдвэрээр оролцоно.
 - г. Шүүгчдийн зөвлөгөөнөөс хуваарилсан бол оролцоно.

5. Шүүгч дангаар шийдвэрлэх хэргийн тухай ИХШХШТХуулийн аль зүйлд заасан бэ? Хэдэн төрлийн хэрэг байдаг вэ?
 - а. 82-р зүйлд 19 хэрэг
 - б. 81-р зүйлд, 19 хэрэг
 - в. 83-р зүйл, 20 хэрэг
 - г. 80-р зүйл, 19 хэрэг
6. Гэр бүл, тэтгэвэр тэтгэмжийн харилцаанаас үүссэн хэргийг ямар шүүх бүрэлдэхүүнээр шийдвэрлэх вэ?
 - а. Шүүгч дангаараа
 - б. 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй
 - в. Шүүгч, иргэдийн төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй
 - г. 3 шүүгч, иргэдийн төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй
7. Шүүх хуралдааны оролцогч гэж хэнийг хэлэх вэ?
 - а. Хэргийн оролцогч, шинжээч, гэрч, иргэдийн төлөөлөгч
 - б. Шүүгч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичиг хэргийн оролцогчийг
 - в. Хэргийн оролцогч, шинжээч, гэрч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, иргэдийн төлөөлөгч
 - г. Хэргийн оролцогч, гуравдагч этгээд, гэрч, хэлмэрч
8. Иргэн “А” иргэн “Б”-ээс 5 сая төгрөг гаргуулахаар нэхэмжилсэн иргэний хэргийг хянан хэлэлцэх шүүх хуралдаанд бэлтгэх ажиллагааны явцад шүүгч Бат нэхэмжлэгч “А”-гийн хүсэлтийн дагуу хэрэг шийдвэрлэх ажиллагаанд маргааны зүйлийн талаар бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдээр “Д”- татан оролцуулахаар болсон бол үүнийг зөвшөөрөөгүй хариуцагч “Б” шүүх хурлын өмнө энэ талаар шүүхэд гомдол гаргах эрхтэй юу?
 - а. Эрхгүй
 - б. Тухайн шүүхийн ерөнхий шүүгч зөвшөөрвөл гомдол гаргах эрхтэй
 - в. Эрхтэй
 - г. Гомдол гаргахыг тухайн шүүхийн 3 шүүгчдээс бүрдсэн хуралдаанаас хэлэлцээд зөвшөөрвөл гомдол гаргах эрхтэй



Бодлого

1. Иргэн Б өөрийн нөхөр С-ээс гэрлэлтээ цуцлуулж, хүүхдийн тэтгэлэг тогтоолгох тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргасан. Шүүгч энэ хэргийн ээдрээ төвөгтэй гэсэн үндэслэлээр 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх саналыг Ерөнхий шүүгчид тавьсан байна.
Энэ тохиолдолд:
 - Энэ хэргийг шүүх ямар бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэх ёстой вэ?
 - Шүүгчийн гаргасан саналд дүгнэлт хийнэ үү?



- Иргэн О-гийн нэхэмжлэлтэй, эрүүл мэндэд нь гэм хор учруулсны хохирол гаргуулахыг хүссэн иргэний хэргийн хариуцагч Ч шүүх хуралдааны товыг мэдсэн атлаа хуралдаанд хүрэлцэн ирээгүй байна.

Энэ тохиолдолд:

- Шүүх хуралдааныг хойшлуулах боломжтой эсэхийг шалгана уу?
 - Шүүх хэргийг шүүх хуралдаанаар Ч-г оролцуулалгүйгээр шийдвэрлэсэн бол Ч-гийн эрх, ашиг зөрчигдөх эсэхэд дүгнэлт хийнэ үү?
- Шүүхээр шийдвэрлэгдэх гэж байсан иргэний хэргийн хариуцагч Ц хүнд өвчтэйн улмаас эмнэлэгт хэвтэж байсан тул шүүх хуралдаанд хүрэлцэн ирж чадаагүй. Тэрээр шүүх хуралдааныг өөрийн биеэ тэнхрэх хүртэл хугацаагаар хойшлуулж өгөөч гэсэн хүсэлтийг шүүхэд ирүүлжээ.

Энэ тохиолдолд:

- Шүүхээс асуудлыг хэрхэн шийдвэрлэх вэ?
- ИХШХШТХуулийн зохих зүйл, заалтыг тайлбарлана уу?



Даалгавар:

- Анхан шатны шүүх хуралдаанд бэлтгэх ажиллагааны үе шат нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бие даасан үе шат болох талаар ойлголттой болж, түүний онцлог шинжийг сайтар мэдэх
- Шүүх хуралдаанд бэлтгэх бэлтгэлийн ажиллагаанд шүүгчийн эрх мэдэл ямар байх талаар сайтар ойлгож, 4-оос доошгүй жишээн дээр ажиллах
- Шүүх хуралдааны бэлтгэлийн үе шатанд хэргийн оролцогчийн эрх, үүргийг тодорхойлсон бодлого бодож, эцсийн шийдлийг гаргах
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх үндэслэлийг зөв тогтоож, үүсэх үр дагаврын талаар мэдлэгтэй болох
- Шүүхийн мэдэгдэх хуудас, түүнийг хэргийн оролцогчдод хүргүүлсний үр дагаврыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчимтай уялдуулан судлах



Эх сурвалж:

- ИХШХШТХууль. 1994, 2002 он
- УДШүүхийн 2002.07.24-ны 263 дугаар тогтоол (Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай, Төрийн мэдээлэл 2003.09.28 №36)

ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

Сэдвийн зорилго: Иргэний хэрэг үүэснээс хойш түүх хуралдаан хүртэлх хугацаанд хэргийн оролцогчдыг хүсэл, зорилгыг үндэслэн шүүх хялбаршуулсан журмаар маргааныг эцэслэн хянан шийдвэрлэх ажиллагааны талаар тодорхой **мэдлэгтэй** болсноор энэхүү ажиллагаанд хууль зүйн үнэлэлт, дүгнэлт өгч тухайн асуудлаар эрх зүйн туслалцаа үзүүлэх, хэрэг маргааныг шийдвэрлэх **чадвартай** болно.

Сэдвийн агуулга:

- Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай ойлголт, онцлог, ач холбогдол
- Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах үндэслэл, журам
- Эвлэрлийн гэрээ түүнийг баталгаажуулах
- Хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамжийн ахуулга
- Хялбаршуулсан журмаар хэрэг шийдвэрлэсэн шүүгчийн захирамжийг биелүүлэх ажиллагаа



Нэр томъёоны тайлбар

Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа - Зохигчид субъектив эрх, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлоо хамгаалах арга хэрэгсэл, хэмжээг өөрсдийн хүсэл зоригийн дшуу тодорхойлж, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тодорхой хүрээнд зөвшилцөх зарчмаар нэхэмжлэлийн шаардлагыг өөрчлөх, эсвэл тэдгээрээс бүрэн татгалзах боломжтой ажиллагаа бол хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа юм

Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзах - Нэхэмжлэгчийн хүсэл зоригийн үйлдэл бөгөөд нэхэмжлэгч шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлагаас бүрэн хэмжээгээр татгалзсан байхыг ойлгоно.

Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн - Энэ нь хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хэмжээгээр хүлээн зөвшөөрсөн байх явдал бөгөөд ийнхүү нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн нь амлалт хэлбэртэй байна.

Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг биелүүлсэн - Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг тодорхой бодит үйлдлээр биелүүлсэн байхыг ойлгоно. Хариуцагчийн зөвшөөрлийг ийнхүү бодит үйлдэл болон амлалтаар хэмээн ялгаж хуульчилсан нь хариуцагч амлалт хэлбэрээр хүлээн зөвшөөрөхөд үүний дараа шүүхийн шийдвэр биелэлтийн ажиллагаа явагддаг бол нэхэмжлэлийн шаардлагыг нэгэнт биелүүлсэн тохиолдолд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдах шаардлагагүй юм.


Зохигч эвлэрсэн байх - Нэхэмжлэгч болон хариуцагч нэхэмжлэлийн шаардлагын талаар харилцан тохиролцож, нэхэмжлэгч нэхэмжлэлийн



шаардлагын зарим хэсгээс татгалзан, үлдэх хэсгийг нь төлөхийг хариуцагч зөвшөөрөн хүлээснийг ойлгодог. Зохигч эвлэрсэн тохиолдолд нэг онцлог зохицуулалт байдаг нь талууд эвлэрлийн гэрээ байгуулж болох тухай заалт юм. ИХШХШ тухай хуулийн 74-р зүйлийн 74.6-д “Зохигч эвлэрсэн тохиолдолд зохигч талууд нэхэмжлэлийн нийт шаардлага буюу тодорхой хэсгийн талаар тохиролцож шүүхийн өмнө эвлэрлийн гэрээ байгуулж болно. Гэрээний агуулгыг зохигч талууд бичгээр гарган түүнийг хоёр тал хүлээн зөвшөөрч, гарын үсэг зурснаар эвлэрлийн гэрээ хүчин төгөлдөр болно. Эвлэрлийн гэрээ нь Иргэний хуульд нийцсэн, гуравдагч этгээдийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хөндөөгүй байна” гэж заасан.

Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамж - Хэргийг хялбартуулсан журмаар хянан шийдвэрлэн, шүүхээс гаргаж байгаа эрх Зүйн баримт бичгийг ойлгоно. Энэхүү шүүгчийн захирамж нь удиртгал, тодорхойлох, үндэслэх, захирамжлах хэсгээс бүрдэнэ. Удиртгал хэсэгт захирамжийг хэзээ, хаана, ямар шүүхэд гаргасан, шүүгч, хэргийн оролцогчийг заана. Тодорхойлох хэсэгт нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн, эсхүл зохигч талууд эвлэрсэн, нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагч биелүүлсэн тухай хэргийн оролцогчийн тайлбарын агуулгыг заана. Үндэслэх хэсэгт хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд үндэс болгосон нотлох баримт, зохигч эвлэрсэн, нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрч биелүүлсэн тухай бичгээр баталгаажуулсан баримт, эвлэрлийн гэрээ зэргийг тусгана. Захирамжлах хэсэгт хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэхэд баримталсан хуулийн нэр, зүйл, заалтыг тодорхой зааж, нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан, эсхүл зохигч талууд эвлэрсэн, нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагч биелүүлснийг баталсны аль нь болох, улсын тэмдэгтийн хураамж, шүүхийн зардал төлүүлэх асуудал хэрхэн шийдвэрлэснийг заана. Энэ захирамжийг хариуцагч сайн дураар биелүүлээгүй бол шүүхийн шийдвэрийн нэгэн адил албадан гүйцэтгэнэ.

Хялбаршуулсан журмаар хэрэг шийдвэрлэх Зохигчид өөрсдийн субъектив эрх, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлоо хамгаалах арга хэрэгсэл хэмжээг өөрсдийн хүсэл зоригийн дагуу тодорхойлж: ИХШХША-ны явцад тодорхой хүрээнд зөвшилцөх зарчмаар нэхэмжлэлийн шаардлагыг өөрчлөх эсвэл тэдгээрээс бүрэн татгалзах боломжтой ажиллагаа бол ажиллагаа мөн.



Шүүгч захирамж гарган баталгаажуулна. Энэхүү захирамжийг сайн дураараа биелүүлэхгүй бол шүүхийн шийдвэрийн нэг адил албадан биелүүлнэ.



Хяналтын асуулт

1. Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай ойлголт, онцлог, ач холбогдлыг жишээ гарган тайлбарлана уу?
2. Хялбаршуулсан журмаар хэрэг шийдвэрлэх үндэслэлүүдийг харьцуулан судална уу?
3. Эвлэрлийн гэрээний төсөл бичиж шүүгчийн захирамжаар баталгаажуулна уу?



Сорил

1. Хэргийг шүүх хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн тохиолдолд зохигч тухайн асуудлаар анхан шатны шүүхэд дахин нэхэмжлэл гаргах эрхтэй юу?
 - а. Эрхтэй
 - б. Шүүгч зөвшөөрвөл нэхэмжлэл гаргах эрхтэй
 - в. Эрхгүй
2. Хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн тохиолдолд зохигч давж заалдах болон хяналтын гомдол гаргах эрхтэй юу?
 - а. Эрхтэй
 - б. Эрхгүй
 - в. Тухайн шүүхийн ерөнхий шүүгч зөвшөөрвөл гомдол гаргах эрхтэй
3. Хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж байгаа тохиолдолд хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх үү?
 - а. Хэлэлцэнэ
 - б. Хэлэлцэхгүй



- в. Шүүгч үзэмжээрээ шийдвэрлэнэ
 - г. Аль ч биш
- 1. Хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн тохиолдолд улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг:**
- а. Хуульд заасан ердийн журмаар төлнө
 - б. ИХШХШТХ-д зааснаар 50% хөнгөлнө
 - в. УТХ-ийн тухай хуульд зааснаар 50% бууруулна
 - г. ИХШХШТХ-д зааснаар 30% бууруулна
- 2. Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн шүүгчийн захирамжийг хариуцагч сайн дураараа биелүүлээгүй бол**
- а. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар албадан биелүүлнэ
 - б. Шүүхийн шийдвэрийн нэг адил албадан гүйцэтгэнэ.
 - в. Албадан биелүүлэх журмыг хуульд заагаагүй
- 3. Зохигч талуудын эвлэрлийн гэрээг шүүх:**
- а. ямар ч тохиолдолд батална.
 - б. Иргэний хуульд нийцсэн бол батална.
 - в. зохигч талуудын хэн аль нэг нь хүссэн бол батална
- 4. Шүүх хуралдаан хийхгүйгээр талуудын хүсэл зоригийн үндсэн дээр иргэний хэрэг шийдвэрлэх ажиллагаа нь анх:**
- а. 1952 оны ИБШХуульд тусгагдсан
 - б. 1967 оны ИБШХуульд тусгагдсан
 - в. 1994 оны ИХШХШТХуульд тусгагдсан
 - г. 2002 оны ИХШХШТХуульд тусгагдсан
- 5. Шүүх хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх үндэслэлд дараахаас аль нь хамаарахгүй вэ?**
- а. Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзах
 - б. Шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах
 - в. Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх
 - г. Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг биелүүлсэн

Σ

Бодлого

1. Иргэн Д нэгэн байгууллагын хувцасны өлгүүрт булган малгайгаа хадгалуулахаар өгсөн боловч малгай алдагдсан. Д малгайны үнийг гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан. Шүүх иргэний хэрэг үүсгэн шийдвэрлэх шатанд уг байгууллагын өлгүүрийн ажилтан өөрийн буруугаас алга болгосон малгайны үнийг бүрэн хэмжээгээр төлнө гэж нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн байна.

Энэ тохиолдолд:

- Шүүх хэргийг ямар үндэслэлээр, хэрхэн шийдвэрлэх вэ? Дүгнэлт хийнэ үү?

2. Иргэн Ц нэгэн барилгын компанитай гэрээ байгуулж амины орон сууцны барилга бариулжээ. Гэтэл уг компани гэрээнд заасан хугацаанд барилгын ажлыг гүйцэтгэж чадаагүй тул гэрээгээ цуцлах шаардлагыг гүйцэтгэгчид удаа дараа тавьжээ. Гэтэл барилгын ажилд ямар ч ахиц гараагүй ба хугацаа алдсаар байсан. Ц шүүхэд нэхэмжлэл гаргасан ба гэрээг цуцлах шаардлага тавьсан. Хариуцагч барилгын компани нэхэмжлэлийн шаардлагыг эс зөвшөөрсөн ба гэрээний хугацааг тодорхой хугацаагаар сунгах, энэ хугацаанд чанарын шаардлага хангасан барилга хүлээлгэж өгөхөөр нэхэмжлэгчтэй тохиролцож эвлэрлийн гэрээ байгуулснаар хэрэг хэлэлцэх ажиллагааг дуусгавар болсон байна. Гэтэл эвлэрлийн гэрээнд тохиролцсон хугацаанд барилгын ажлыг гүйцэтгэж чадаагүй.

Энэ тохиолдолд:

- Иргэн Ц дахин шүүхэд хандах боломжтой юу?
- Асуудлаа хэрхэн шийдвэрлүүлэх вэ?

3. 0 - гийн нэхэмжлэлтэй гэрлэлт цуцлуулах нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагч Э хүлээн зөвшөөрч, гэр бүлийн эд хөрөнгө, хүүхдийн талаар ч ямар нэгэн маргаангүй гэсэн тайлбар өгчээ.

Энэ тохиолдолд:

- Хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэх боломжтой эсэхэд дүгнэлт хийнэ үү?



Даалгавар:

- Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх үндэслэл тус бүр дээр нэг нэг жишээ олж бодлого зохио
- Хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн шүүгчийн захирамж бичиж дүгнэлт хийх
- Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог, ач холбогдлын талаар ярилц



Эх сурвалж:

- ИХШХШТХууль 2002 он
- Шүүгчийн гарын авлага
- УДШ-ийн иргэний хэргийн танхимын зөвлөмж. 2006.05.05-ний өдөр. “Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74-75 дугаар зүйл болон 106 дугаар зүйлийн зарим заалтыг шүүхийн практикт зөв хэрэглэх тухай”



АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ОНЦЛОГ, ТҮҮНИЙ ДЭГ

Сэдвийн зорилго: Анхан шатны шүүхийн шүүх хуралдааны онцлог, түүний дэгийн талаар мэдлэгтэй болж, тухайн хуралдаанд оролцох чадвар эзэмшиж, шүүх хуралдааны ач холбогдлыг ойлгон хэрэгжүүлэх боломжтой болно

Сэдвийн агуулга:

- Анхан шатны шүүх хуралдааны онцлог, түүний дэг
- Анхан шатны шүүх хуралдаанаар хэргийг хэлэлцэх
- Анхан шатны шүүх хуралдаанд нотлох баримтыг шинжлэх
- Иргэдийн төлөөлөгч дүгнэлт гаргах, түүний ач холбогдол



Нэр томъёоны тайлбар

Анхан шатны шүүхийн шүүх хуралдааны дэг - Анхан шатны шүүхийн шүүх хуралдаан ИХШХШТухай хуульд заасан тодорхой дэг журмын дагуу явагддаг. Анхан шатны шүүх хуралдааныг бэлтгэлийн, хэргийг хэлэлцэх, шүүмжлэлийн, шийдвэр гаргах гэсэн үндсэн үе шатуудад хуваан ангилж болно. Эдгээр үе шат бүр нь тодорхой асуудлыг хянан хэлэлцэх ба нэг нь нөгөөдөө шилжин тасралтгүй явагддаг ажиллагаа юм

Анхан шатны шүүх хуралдааны бэлтгэлийн үе шат – Шүүх хуралдааны бэлтгэлийн үе шат нь хэргийг хэлэлцэх боломжийг бий болгоход чиглэгдсэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эхний үе шат байдаг. Энэхүү үе шат нь шүүх хуралдааныг зарлан хуралдуулахаар тогтоосон хугацаанд шүүх хуралдаан даргалагч хуралдааныг нээж, ямар хэргийг хянан шийдвэрлэх гэж байгааг зарлан мэдээлснээр эхэлнэ. Дараа нь шүүх хуралдааны нарийн бичгийн дарга хуралдаанд оролцогчдын ирцийг бүртгэж илтгэнэ.

Шүүхээс ирцийг шалгахад нэхэмжлэгч, түүний төлөөлөгч, өмгөөлөгч мэдэгдэх хуудсыг хүлээн авсан атлаа хүндэтгэн үзэх шалтгаанаар ирээгүй бол шүүх хуралдааныг хойшлуулна. Харин тэдгээр нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол нэхэмжлэлийг буцаах буюу эсхүл хариуцагчийн хүсэлтээр шүүх хэргийг шийдвэрлэнэ. Хэрэв шүүх хуралдаанд орчуулагч оролцож байгаа бол түүнд орчуулагчийн эрх үүргийг тайлбарлана. Шүүх хуралдаанд дуудагдсан гэрчийг хуралдааны танхимаас түр гаргана. Үүний дараа шүүх бүрэлдэхүүнийг зарлах ба хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгч, прокурор, шинжээч, орчуулагч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг танилцуулж тэдгээрийг татгалзан гаргах эрхтэйг зохигчид, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчид тайлбарлаж өгнө. Шүүх хуралдааныг даргалагч хэргийн оролцогчдод эрх үүргийг нь тайлбарлан өгч хэргийг үнэн зөв шийдвэрлэхтэй холбогдуулан шинэ нотлох баримтыг бүрдүүлэх, хэрэгт ач холбогдолтой бусад асуудлын талаар болон шүүх хуралдааныг хойшлуулахаар санал хүсэлт гаргах нэхэмжлэгч, хариуцагчийг өөр этгээдээр солихыг зөвшөөрөх буюу татгалзах эрхтэйг сайтар мэдүүлсэн байх ёстой. Хэргийн оролцогчдын гаргасан санал хүсэлтийг шүүх анхааралтай хянан үзэх бөгөөд түүнийг нэн даруй шийдвэрлэнэ. Ингэж

шүүх хуралдааны бэлтгэлийн үе шат дуусч хэрэг хэлэлцэх үе шат эхэлнэ.

Анхан шатны шүүх хуралдаанд хэргийг хэлэлцэх үе шат - Хэрэг хэлэлцэх ажиллагаа нь шүүх хуралдаан даргалагч буюу шүүгч хэргийн талаар танилцуулснаар эхэлнэ. Дараа нь нэхэмжлэгч нэхэмжлэлээ дэмжиж байгаа эсэх, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрч байгаа эсэх, зохигчид эвлэрэн хэлэлцэх хүсэлтэй байгаа эсэхийг хуралдаан даргалагч тодруулан хэрэв нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн, зохигчид эвлэрэн хэлэлцсэн нь бусдын хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолыг хөндөөгүй, хуульд харшлаагүй бол зөвлөлдөх тасалгаанд шүүх тогтоол, шүүгч захирамж гарган шүүх хариуцагчийн зөвшөөрөл, нэхэмжлэгчийн татгалзал, зохигчдийн эвлэрлийг батлана. Шүүх хуралдаан даргалагч хэргийг танилцуулсны дараа дээрх байдлаар нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзаагүй, зохигчид эвлэрээгүй бол нэхэмжлэгч түүний талд оролцож байгаа гуравдагч этгээд тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч нь нэхэмжлэлийн шаардлагын талаар тайлбар өгч түүнийхээ үндэслэлийг нотолно. Дараа нь хариуцагч түүний талд оролцож буй гуравдагч этгээд тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нь нэхэмжлэлийн шаардлагаас татгалзаж байгаа үндэслэлээ тайлбарлаж түүнийгээ нотолно. Зохигчид харилцан асуулт тавьж болох ба мөн хэргийн оролцогчдод асуулт тавина. Хэрэв шүүх хуралдаанд нэхэмжлэгч, хариуцагч хүрэлцэн ирээгүй бол тэдний гаргасан тайлбар мэдүүлгийг уншиж сонсоно. Шүүх хэргийн оролцогчдын тайлбар, мэдүүлгийг сонссоны дараа хэргийн нөхцөл байдал, онцлогоос шалтгаалж нотлох баримтыг шинжлэн судлах дарааллыг тогтооно.

Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ИХШХШТХуульд зааснаар нотлох баримтын шинжлэх ажиллагаа шүүх хуралдаан дээр явагдаж байгаа бөгөөд түүний журмыг тус хуулийн 108-112 дугаар зүйлд тодорхой тусгажээ.

Бичмэл нотлох баримтыг шинжлэх - Бичмэл нотлох баримтыг шинжлэх гэдэг нь шүүх болон хэргийн оролцогчдоос хэрэгт цугларсан бичмэл баримтыг судлаж мэдэх процесс ажиллагаа юм. Энэхүү үйл ажиллагааг шүүх хуралдааны хэргийг бодит байдлаар хэлэлцэх үе шатанд хэрэгжүүлнэ. Шүүх хэрэгт цугларсан баримт бичгийг судлаж, шаардлагатай бол хэргийн оролцогч, гэрч, шинжээчийн хүсэлтээр уншиж сонсоно. Хуульд заасан төр байгууллага, хувь хүний нууцтай холбогдсон баримтыг шүүх хуралдаанд танилцуулахгүй. Захидал харилцааны нууцыг хамгаалахын тулд хувийн захидал бичгийг тухайн этгээдийн зөвшөөрөлтэйгөөр нээлттэй шүүх хуралдаанд уншиж сонсоно. Хэрэв зөвшөөрөл аваагүй бол хувийн захидал, бичгийг уншсан сонсгох ба шинжлэх явцыг хаалттай шүүх хуралдаанаар гүйцэтгэнэ. Хэрэв бичмэл нотлох баримт хуурамч болох нь мэдэгдвэл түүнийг мэдсэн этгээд уг баримтыг нотлох баримтаас хасахыг хүсч болно. Хуульд зааснаар бичмэл нотлох баримтыг хуурамч гэж үзсэн этгээд тэр тухайгаа нотлон үүрэгтэй. Бичмэл нотлох баримтыг шинжилсний үр дүнд түүний агуулга нь тухайн шүүхээс тогтоох гэж буй нөхцөл байдалтай хамааралтай эсэх, үнэн зөв эсэх тухай болон, түүнд байгаа мэдээлэл хангалттай эсэх талаар шүүгчийн дотоод итгэл бий болно.




Эд мөрийн баримтыг шинжлэх - Шүүх хэрэгт цугларсан эд мөрийн баримтыг судлаж, шаардлагатай гэж үзсэн бол хэргийн оролцогч, иргэдийн төлөөлөгч шинжээчийн хүсэлтээр эд мөрийн баримтыг танилцуулна. Эд мөрийн баримтыг үзлэг хийх журмаар шинжлэх ба энэ ажиллагааны үед олж авсан мэдээллийг шүүх хуралдааны тэмдэглэлд тэмдэглэнэ. Эд мөрийн баримтыг түүний байгаа газарт үзлэг хийж энэ тухай тэмдэглэл үйлдсэн бол түүнийг уншиж танилцуулна.

Гэрчийн мэдүүлгийг шинжлэх - Шүүх хуралдаан даргалагч гэрчийн биеийн байцаалтыг шалгаж гэрчид эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг нь урьдчилан сануулж энэ тухай хуралдааны тэмдэглэлд гарын үсэг зуруулна. Гэрч бүрийг тус тусд нь асууна. Мэдүүлгээ өгөөгүй буюу мэдүүлгээ өгч дуусаагүй байгаа гэрч хэргийг хэлэлцэх үед шүүх хуралдааны танхимд байж болохгүй. Гэрч мэдүүлгээ өгсөний дараа түүнд асуулт тавих ба асуулт тавих дарааллыг ИХШХШТ хуулийн 108 дугаар зүйлийн гуравт зааснаар тогтооно. Гэрчийг дуудаж асуухыг хүссэн этгээд тэргүүн ээлжинд, дараа нь хэргийн бусад оролцогчид асуулт тавина. Насанд хүрээгүй гэрчийг байцаахдаа тэдний эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг, шаардлагатай гэж үзвэл хүүхдийн сэтгэхүйн онцлогийг сайн мэдэх сурган хүмүүжүүлэгчийг байлцуулна. Мөн насанд хүрээгүй гэрч үнэн, зөв мэдүүлэг өгөхөд саад болж болохуйц хэргийн оролцогчдыг шүүх хуралдааны танхимаас гаргана. Хуралдааны танхимаас гарсан хэргийн оролцогчдыг хуралдааны танхимд ороход насанд хүрээгүй гэрчийн мэдүүлгийг ушпиж сонсгох ба асуулт тавих, тайлбар өгөх боломжоор хангах ёстой. Насанд хүрээгүй гэрч нь мэдүүлгээ өгч дууссаны дараа шүүх хуралдааны танхимаас гарна.

Шүүх хуралдааны шүүмжлэлийн үе шат - Шүүх хуралдааны шүүмжлэлийн үе шат нь хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хэлсэн үг, санал дүгнэлт, шүүх хуралдаанд оролцогчдын санал дүгнэлтээс бүрдэнэ.

Шүүх хурлын нийтлэг журам



Анхан шатны шүүх хуралдааны дэг, дараалал





Хяналтын асуулт

1. Анхан шатны шүүх хуралдааны онцлогийг давж заалдах болон хяналтын шатны хуралдаантай харьцуулан хэлэлцэнэ үү?
2. Анхан шатны шүүх хуралдааны үе шатыг ангилан тодорхойлно уу?
3. Шүүх хуралдааны бэлтгэлийн үе шатны ажиллагааг нэрлэнэ үү?
4. Анхан шатны шүүхийн шүүх хуралдаанд нотлох баримт шинжлэх ажиллагааг ямар журмын дагуу явуулах вэ? Жишээ гарган тайлбарлана уу?
5. Иргэдийн төлөөлөгчийн дүгнэлт гаргах явцын талаар ярилцана уу?
6. Шүүх хуралдааны явцад хэргийн оролцогчийн мэтгэлцээн хэрхэн явагдах вэ?
7. Шүүх хуралдааныг хойшлуулах тухай шүүгчийн захирамжид гомдол гаргах эрхтэй эсэх талаар хэлэлцэнэ үү?
8. Шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх гэдгийг хэрхэн тайлбарлаж байна вэ?
9. Анхан шатны шүүх хуралдаанаар хэргийг шийдвэрлэх нь ямар ач холбогдолтой гэж үзэж байна вэ?
10. Гэрчийн мэдүүлэг шинжлэх онцлогийг жишээн дээр тайлбарлана уу?
11. Иргэдийн төлөөлөгч дүгнэлт гаргана гэдгийг тайлбарлана уу?
12. Шүүх хуралдааныг хойшлуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэхийн ялгааг тайлбарлана уу?



Сорил

1. **Нэхэмжлэгч этгээд шүүх хуралдаанд оролцож чадахгүй тухайгаа урьдчилан мэдэгдсэн бол асуудлыг яаж шийдвэрлэх вэ?**
 - а. Шүүх хуралдааныг хойшлуулна
 - б. Нэхэмжлэгч өөрийгээ байлцуулахгүйгээр асуудлыг шийдвэрлэхийг зөвшөөрсөн бол шүүх хурлыг ердийн журмаар хийнэ
 - в. Шүүх хуралдааныг хойшлуулах, эсхүл хуралдах эсэхийг тухайн шүүгч, шүүх бүрэлдэхүүн өөрсдөө шийдвэрлэнэ
 - г. Шүүх хуралдааныг хойшлуулах, эсхүл нэхэмжлэгч зөвшөөрсөн бол түүний оролцоогүйгээр хуралдааныг хийнэ
2. **Нэхэмжлэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдааны товыг мэдсэн атлаа хүрэлцэн ирээгүй бол асуудлыг хэрхэн шийдвэрлэх вэ?**
 - а. Шүүх өөрийн үзэмжээрээ зохицуулна
 - б. Хэргийн хэрэгсэхгүй болгоно
 - в. Нэхэмжлэлийн өргөдлийг буцаана, хариуцагч зөвшөөрсөн бол нэхэмжлэгчийн оролцоогүйгээр асуудлыг шүүх шийдвэрлэнэ.
 - г. Шүүх тогтоол, шүүгч захирамж гарган хэрэг шийдвэрлэх ажиллагааг хойшлуулна
3. **Хариуцагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй бол асуудлыг яаж зохицуулах вэ?**
 - а. Шүүх хуралдааныг хойшлуулна
 - б. Нэхэмжлэгч хүсэлт гаргасан бол хариуцагчийн оролцоогүйгээр хэргийг хянан шийдвэрлэнэ

- в. *Шүүгч, шүүх өөрийн үзэмжээрээ асуудлыг зохицуулна*
- г. *Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ*
- 4. Нэхэмжлэгч ирээгүйн улмаас нэхэмжлэлийг буцаах тохиолдолд шүүхээс ямар акт гаргах вэ?**
 - а. *Албан бичиг явуулна*
 - б. *Мэдэгдэх хуудас хүргүүлнэ*
 - в. *Шүүгчийн захирамж*
 - г. *Асуудлыг шүүх хуралдаанаар шийдвэрлэж байгаа бол шүүхийн тогтоол, бусад тохиолдолд шүүгч захирамж гаргана*
- 5. Шүүх хуралдааны үед хэрэг хэлэлцэх ажиллагааг яаж эхлэх вэ?**
 - а. *Нэхэмжлэгчийн тайлбар сонссоноор*
 - б. *Нотлох баримтуудыг хянан хэлэлцэх замаар*
 - в. *Хуралдаан даргалагч хэргийн талаар танилцуулга хийснээр*
 - г. *Зохигчид хоорондоо мэтгэлцсэнээр*
- 6. Шүүх хуралд хэргийг хэлэлцэхээс өмнө нотлох баримт хүсэлтийг хүлээн авч болох уу?**
 - а. *Болно*
 - б. *Зохигч бусад этгээд хүсвэл болно*
 - в. *Шүүх бүрэлдэхүүн шаардвал болно*
 - г. *Хуульд зааснаар хэргийг хэлэлцэхийн өмнө хүсэлтийг заавал сонсоно*
- 7. Хэргийг анхан шатны шүүх хуралдаанаар хэлэлцэж байх явцад зохигч талууд эвлэрсэн бол хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн гэж үзэж болох уу?**
 - а. *Тийм*
 - б. *Тухайн шүүхийн Ерөнхий шүүгч зөвшөөрсөн бол зөвшөөрнө*
 - в. *Үгүй*
 - г. *Хуралдаан даргалагчийн үзэмжээр шийдвэрлэнэ*
- 8. Шүүгч дангаараа хуралдааныг даргалж буй тохиолдолд шийдвэр гаргахаар зөвлөлдөх гэсэн ойлголт байх уу?**
 - а. *Үгүй*
 - б. *Зөвлөлдөх асуудал бий*
 - в. *Өөрөө өөртөөгөө зөвлөлдөнө*
 - г. *Хуулийн холбогдох заалтыг удирдлага болгоно*
- 9. “Азын шоо” ХХК нь шүүх хуралдааны үед нэхэмжлэлийн шаардлагаа ихэсгэсэн байна. Үндэслэлтэй эсэхэд дүгнэлт хийнэ үү?**
 - а. *Шүүх хуралдааны явцад ийм эрх эдлэх нь хууль зөрчсөн ажиллагаа*
 - б. *Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд ийм эрхийг эдлэх тул үндэслэл бүхий байна.*
 - в. *Энэ талаар хуульд зохицуулалт байхгүй тул үндэслэлтэй*
 - г. *Хариуцагч хүлээн зөвшөөрвөл нэхэмжлэлийн шаардлагыг ихэсгээж болно*



10. Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх үед шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлүүлэх талаар хуульд заасан журмыг нэхэмжлэгч зөрчсөн нь тогтоогдсон ба энэ журмыг хэрэглэх боломжтой байвал шүүгч хэргийг хэрэгсэхгүй болгох тухай:

- а. Шийдвэр гаргана.
- б. Тогтоол гаргана.
- в. Захирамж гаргана.
- г. Шийтгэвэр гаргана.



Бодлого

Иргэн Думаагийн Нямаагаас панасоник маркийн гар утасны үнэ 300000 төгрөг гаргуулах иргэний хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх явцад хэд хэдэн гэрчээс мэдүүлэг авсны дараа хариуцагч Нямаа шүүх хуралдаан даргалагч Саруул хэргийг үнэн зөв шийдвэрлэх боломжгүй, энэ талаар эргэлзэж байгаа тул шүүгчээс татгалзаж байна гэсэн саналаа хэлжээ. Шүүгч Саруул саналыг хүлээн авах ямар ч хууль зүйн үндэслэл байхгүй гээд хуралдааныг үргэлжлүүлэн, шийдвэр гаргаж уншиж сонсгов.

Энэ тохиолдолд:

- Шүүх Думаагийн шүүх хуралдааны явцад гаргасан саналыг хүлээн авч шийдвэрлэх хууль зүйн үндэслэлтэй эсэхийг дүгнэн үү?



Даалгавар:

- Анхан шатны шүүхийн шүүх хуралдааны үе шат нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бие даасан үе шат болох талаарх ойлголтыг бататгаж, түүний онцлог шинжийг мэдэх
- Шүүх хуралдааны нийтлэг дэгийг анхан шатны шүүхийн шүүх хуралдаанд үзүүлж, дүрээр харуулах
- Анхан шатны шүүхийн шүүх хуралдааны бэлтгэлийн үе шатанд хэргийн оролцогчдод эрх, үүргийг танилцуулсны үр дагавар
- Анхан шатны шүүхийн шүүх хуралдаанаас шийдвэр гаргах явцыг дүрээр харуулах



Эх сурвалж:

- ИХШХШТХууль. 1994, 2002 он
- Шүүхийн тухай хууль 2002 он
- УДШүүхийн 2002.07.24-ны 263 дугаар тогтоол (Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай, Төрийн мэдээлэл 2003.09.28 №36)

АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШИЙДВЭР

Сэдвийн зорилго: Иргэний хэргийг анхан шатны шүүхийн шүүх хуралдаанаар хянан хэлэлцэж шийдвэр гаргах эрх зүйн үндэслэлийн талаар суурь мэдлэгтэй болох, шүүхийн шийдвэрийн агуулга, бүтцийг тодорхойлох, шийдвэрт эрх Зүйн үүднээс үнэлэлт, дүгнэлт өгч тайлбарлах, шийдвэр бичиж үйлдэх чадвар эзэмшинэ.

Сэдвийн агуулга:

- Анхан шатны шүүхээс гарах шийдвэрийн агуулга
- Шийдвэрийн хэлбэр, бүтэц, агуулга
- Шийдвэрийн үндэслэх хэсгийн ач холбогдол
- Шийдвэрт тавигдах шаардлага
- Шийдвэр хүчин төгөлдөр болох нь
- Шүүхийн шийдвэрийг биелүүлэх үндэслэл, үр дагавар

**Нэр томъёоны тайлбар**

Анхан шатны шүүхийн шийдвэр - Анхан шатны шүүхээс хэргийг хянан шийдвэрлээд гаргасан баримт бичгийг шийдвэр гэнэ.

Анхан шатны шүүхийн шийдвэрийн хэлбэр - Шүүхийн шийдвэр тодорхой хэлбэрээр гарах бөгөөд энэ тухай ИХШХШ тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасан байна. Шийдвэрийг бичгийн хэлбэрээр гаргах, шүүх хуралдаанд гурван шүүгч оролцсон, эсхүл нэг шүүгч дангаараа шийдвэрлэсэн бол шийдвэрт гарын үсэг зурна.

Анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох - Шийдвэр уншиж сонсгосноор хүчин төгөлдөр болно. Зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд шийдвэр магадлалыг гардан авсан өдрөөс хойш давж заалдах журмаар бол 14 хоногийн дотор, хяналтын журмаар хэргийг хянуулахаар бол 30 хоногийн дотор тус тус гомдол гаргаж болно. Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч давж заалдах, хяналтын гомдол гаргасан бол тэдгээрийг хянан шийдвэрлэх хүртэл шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдахгүй.

Шийдвэр хууль ёсны байх шаардлага - ИХШХШ Тухай хуулийн 116.2 дугаар зүйлд шүүх буюу шүүгч хууль ёсны шаардлага хангасан шийдвэр гаргахыг үүрэг болгон хуульчлан заасан юм. Шийдвэрийн хууль ёсны шаардлага нь нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг шүүх хүлээн авахаас эхлээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх үе шатанд хийгдвэл зохих ажлыг хууль Зүйн дагуу, үнэн зөв, гүйцэтгэсэнтэй холбоотой байна.

Шүүхийн шийдвэр үндэслэл бүхий байх - Шүүхийн шийдвэр зөвхөн бодит нөхцөл байдалд үндэслэсэн байх ёстой. Өөрөөр хэлбэл ИХШХШ тухай хуулийн гуравдугаар бүлэгт заасан нотлох баримтад тулгуурлана гэсэн ойлголт юм. Нотлох баримтыг хуульд заасан журмын дагуу цуглуулж бүрдүүлэх, түүнд хууль зүйн үүднээс үнэн зөв үнэлэлт, дүгнэлт өгснөөр шийдвэр бодитой байх болно.

Нотлох баримтыг цуглуулах, түүнд үнэлэлт өгөх хоёр хоорондоо холбоотойн зэрэгцээ ялгаатай ойлголт юм. Нотлох баримтыг нэхэмжлэгч,



хариуцагч хоёр тал шүүхэд гаргаж өгөх үүрэгтэйгээс гадна шүүх шаардлагатай гэж үзсэн нотолгоог хэргийн оролцогчдын хүсэлтээр бүрдүүлэх эрхтэй байдаг. Нотолгоог ямар байдлаар цуглуулснаас үл хамааран эцсийн бүлэгт маргааныг нотлох буюу үгүйсгэхэд гол ач холбогдол оршино.

Нэгэнт цугларсан нотлох баримтад зөв дүгнэлт хийх шаардлагатай. Шийдвэрийг анхан шатны шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн нотлох баримтын үндсэн дээр гаргана. /ИХШХШ тухай хуулийн 116.3 дугаар зүйл/ гэжээ. Хавтаст хэрэгт авагдаагүй баримтанд хийсвэр дүгнэлт өгч болохгүй.

Шийдвэр нь тодорхой, ойлгомжгой, эргэлзээгүй байх - Энэ нь ямар нэг сул үггүй, хоёрдмол утгагүй, хууль зүйн нэр томъёо, үгийг зөв хэрэглэсэн, хэн ч уншсан ойлгомжтой, утга төгөлдөр байхыг шаардана гэсэн ойлголт болно.

Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж - Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шийдвэр гаргаснаас бусад тохиолдолд шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана. Хэргийг хэрэгсэхгүй болгох, шүүх хуралдааныг хойшлуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх, сэргээн явуулах, татгалзан гаргах, хүсэлтийг шийдвэрлэх болон шүүх хуралдааны бусад үед хянан шийдвэрлэж байгаа асуудлаар шүүхийн тогтоол, захирамжийг бичгээр бусад асуудлыг хуралдааны тэмдэглэлд тусган амаар гаргана.

Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл - Хуульд тусгайлан заасан эрх бүхий байгууллагын шийдвэр, тогтоол, захирамж, шийтгэвэр тэдгээрийн үндсэнд бичигдсэн гүйцэтгэх хуудас нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэл болно. Иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр, магадлал, тогтоол, шүүхээр баталгаажуулсан нотариатын мэдэгдэх хуудас, арбитрын шийдвэр зэрэг нь эрх бүхий байгууллагын шийдвэрт хамаарна.

Энэ тохиолдолд шийдвэрийг албадан биелүүлэх тухай шүүгчийн захирамж, гарч, гүйцэтгэх хуудас бичигдсэн байна. Шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагааг ШШГЕГазар эрхлэн хэрэгжүүлнэ.

Анхан шүүхээс иргэний хэргийг хянан шийдвэрлээд гаргасан баримт бичгийг шүүхийн шийдвэр гэнэ. /ИХШХШТХ-ийн 115-р зүйл/

Шүүхийн шийдвэрийг төрийн баталсан хуулийн дагуу, түүний хүрээнд гаргах ба ийм учраас шийдвэрийг Монгол улсын нэрийн өмнөөс гаргадаг билээ. Нөгөө талаар шийдвэр нь төрийн бодлого, зориг санааг илэрхийлэхийн зэрэгцээ төрийн албадлагын механизмыг хэрэгжүүлэх эрх зүйн хэлбэр болдог. Шүүхийн шийдвэр нь хууль ёсны, үндэслэлтэй, тодорхой, ойлгомжтой, эргэлзээгүй, заавал биелэгдэх шинжтэй байна.

Шүүх буюу шүүгч зөвхөн хуулийг удирдлага болгох ёстой. Өөрөөр хэлбэл материаллаг - эрх зүйн, процесс- эрх зүйн хэм хэмжээг удирдлага болгон шийдвэрийг гаргана гэсэн үг юм.

Шүүх тухайн маргаантай харилцааг зохицуулсан хууль байхгүй бол түүнтэй төсөөтэй харилцааг зохицуулж байгаа хуулийн хэм хэмжээг хэрэглэнэ. Хэрэв тийм

хууль байхгүй бол шүүх Үндсэн хуулийн агуулга, ерөнхий үндэслэл, үзэл санаанд нийцүүлэн маргааныг шийдвэрлэж болно. /ИХШХШ тухай хуулийн 10.4 дүгээр зүйл/. Энэ заалт бол шүүх хууль ёсыг хангах арга замыг нээж, шүүхэд эрх олгосон хэрэг юм.

Шүүх тухайн маргаантай харилцааг зохицуулсан хууль байхгүй бол түүнтэй төсөөтэй харилцааг зохицуулж байгаа хуулийн хэм хэмжээг хэрэглэнэ. Хэрэв тийм хууль байхгүй бол шүүх Үндсэн хуулийн агуулга, ерөнхий үндэслэл, үзэл санаанд нийцүүлэн маргааныг шийдвэрлэж болно. /ИХШХШ тухай хуулийн 10.4 дүгээр зүйл/. Энэ заалт бол шүүх хууль ёсыг хангах арга замыг нээж, шүүхэд эрх олгосон хэрэг юм.

Шүүх иргэний хэргийг хянан шийдвэрлэж материаллаг эрх зүйн хэм хэмжээг хэрэглэж зөрчигдсөн эрхийг сэргээх бөгөөд ийнхүү хэм хэмжээ хэрэглэж гаргасан эрхийн акт бол шүүхийн шийдвэр юм.

МУ-н иргэн, гадаадын иргэн харъяат, харъяалалгүй хүн, бүх төрлийн хуулийн этгээд шүүхийн шийдвэрийг заавал биелүүлэх үүрэгтэй.

Шүүхийн шийдвэр ёсоор үүрэг хүлээсэн буюу төлбөр тэтгэлэг төлөгч сайн дураараа биелүүлэхгүй бол ШШГ-ийн журмаар албадан биелүүлнэ.

- МУ-н нэрийн өмнөөс төрийн сүлд бүхий тусгай хэвлэмэл хуудсан дээр гаргадаг.
- Бичгээр гаргаж шүүгч, шүүх бүрэлдэхүүн гарыг үсэг зурна.
- Хуульд заасан хэлбэр, агуулгаар гаргана.

- МУ-н нэрийн өмнөөс гаргаагүй, шийдвэрийн эрэмбэ, дараалал, утга агуулгыг алдагдуулсан
- Шүүгч, шүүх бүрэлдэхүүн гарыг үсэг зураагүй
- Огноо, дугааргүй, шийдвэрийн хэлбэрийг алдагдуулсан бол шийдвэр хүчингүй болох үндэслэл болно.



Шийдвэрийн бүрэлдэхүүн, агуулга:

Удиртгал хэсэг	Шийдвэрийг хэзээ, хаана ямар шүүх гаргаж байгаа, шүүх бүрэлдэхүүн болон шүүгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, хэргийн оролцогч болон шүүх хуралдааны оролцогчдыг нэрлэн заана.
Тодорхойлох хэсэг	Нэхэмжлэлийн шаардлага, нэхэмжлэгчийн тайлбар, хариуцагчийн татгалзал, тайлбар, зохигчийн төлөөлөгч буюу гуравдагч этгээдийн тайлбарын агуулгыг заана.
Үндэслэх хэсэг	Хэрэгт байгаа болон шүүх хуралдаанаар хэлэлцэгдэж, хэргийг хянан шийдвэрлэхэд үндэс болсон нотлох баримтын хууль зүйн болон бодит үндэслэл, түүнийг шүүхээс хэрхэн үнэлж байгаа тухай заана.
Тогтоох хэсэг	хэргийг хянан шийдвэрлэхэд баримталсан хуулийн нэр, зүйл, хэсэг, заалтыг тодорхой зааж, шүүхэд гаргасан нэхэмжлэл болон сөрөг нэхэмжлэлийг хангасан, эсхүл зарим хэсгийг хангаж, заримыг хэрэгсэхгүй бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон, улсын тэмдэгтийн хураамж, шүүхийн зардал төлүүлэх, эд мөрийн баримтыг хэрхэх, хэрэгт хэд хэдэн нэхэмжлэгч хариуцагч оролцсон бол нэхэмжлэгч, хариуцагч бүр ямар эрх эдэлж, үүрэг хүлээхийг тусгана.

Шүүхийн шийдвэрийг уншиж сонсгох ба хүчин төгөлдөр болох түүний үр дагавар:

Шийдвэрийг шүүх хуралдааны төгсгөлд хуралдаан даргалагч шүүгч тогтоох хэсгийн агуулгыг сонсгож, шаардлагатай бусад асуудлыг тайлбарлаж өгнө.



Шийдвэрийг гаргаснаас хойш бичгээр үйлдэж бүрэн эхээр нь 7 хоногийн дотор зохигчид хүргүүлнэ.



Зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд шийдвэр, магадлалыг гардан авсан өдрөөс хойш давж заалдах журмаар бол 14 хоногийн дотор, хяналтын журмаар хэргийг хянуулахаар бол 30 хоногийн дотор тус тус гомдол гаргаж болно.



Шийдвэр уншиж сонсгосноор хуулийн хүчин төгөлдөр болно.



Хяналтын асуулт

1. Шүүхийн шийдвэрийн тухай ойлголт, онцлогийг тодорхойлно уу?
2. Шүүхийн шийдвэр бусад эрхийн актаас ялгагдах ялгааг тайлбарлана уу?
3. Өгөгдсөн шүүхийн шийдвэртэй танилцан бүтцээр нь задлан, ярилцлага хийнэ үү?
4. Шүүхийн шийдвэрийн заавал биелэгдэх учир шалтгааныг тайлбаршна уу?
5. Шүүхийн шийдвэрт тавигдах шаардлагыг тодорхойлж, шийдвэр нь хууль ёсны, үндэслэлтэй байх шаардлагыг тайлбарлана уу?
6. Шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох, түүний үр дагаврыг тодорхойлно уу?
7. Шүүхийн шийдвэрийн тухай ойлголт, онцлогийг тодорхойлно уу?
8. Шүүхийн шийдвэр дээр ажиллаж, бүтцээр нь задлан тайлбарлана уу?
9. Шийдвэр хууль ёсны ба үндэслэлтэй байх шаардлагыг тайлбарлана уу?
10. Шүүхийн шийдвэрийн заавал биелэгдэх шинжийг тодорхойлж нэрлэнэ үү?



Сорил

1. Шүүхийн шийдвэр ямар бүтэцэй вэ?
 - а. Оришил, хяналтын, тогтоох
 - б. Оришил, тодорхойлох, үндэслэл, тогтоох
 - в. Удиртгал, тодорхойлох, үндэслэх, тогтоох
 - г. Оришил, тодорхойлох, үндэслэл, тогтоох
2. Шүүхийн шийдвэрээр нэхэмжлэлийн шаардлагыг хэрхэн шийдвэрлэх вэ?
 - а. Нэхэмжлэлийн шаардлагыг хангах
 - б. Нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгох
 - в. Нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хэрэгсэхгүй болгох нэхэмжлэлийн шаардлагыг хангах, шаардлагын зарим хэсгийг хангахгүй
 - г. Үлдсэнийг хэрэгсэхгүй, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох
3. Шүүхийн шийдвэрийг уншиж сонсгох уу?
 - а. Шүүхийн шийдвэрийг уншиж сонсгох гэдэг ойлголт байхгүй
 - б. Шийдвэрийг бэлтгэн, эхийг нь бэлтгэсэн бол уншиж сонсгоно
 - в. Шүүх хуралдаан даргалагч шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийн агуулгыг сонсгоно
 - г. Шүүх хуралдаан даргалагч шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийн агуулгыг сонсгож, шаардлагатай бусад асуудлыг тайлбарлана
4. Шүүхийн шийдвэрийн бүрэн эхийг ямар хугацаанд бэлэн болгох вэ?
 - а. Шийдвэрийг гаргаснаас хойш 10 хоногийн дотор
 - б. Шийдвэрийг гаргаснаас хойш 14 хоногийн дотор
 - в. Шийдвэрийг гаргаснаас хойш 7 хоногийн дотор
 - г. Шийдвэрийг гаргаснаас хойш 5 хоногийн дотор



5. Шүүхийн шийдвэр хүчинтэй болох үндэслэлийг дурьдана уу?
 - а. Шийдвэр танилцуулан сонсгомогц
 - б. Шийдвэрийг хяналтын болон давж заалдах шатны хуралдаанаар хянагдан тогтоол магадлал гарснаар
 - в. Давж заалдах гомдол гаргах хугацаа дуусгавар болсноор
 - г. Хяналтын шатны гомдол, гаргах хугацаа дуусгавар болсноор
6. Шүүхийн шийдвэрийг ямар үндэслэлээр тайлбарлах вэ?
 - а. Шүүх хуралдаан даргалагчийн шаардлагаар
 - б. Шүүх шаардлагатай асуудлыг тайлбарлана
 - в. Хэргийн оролцогчийн хүсэлтээр
 - е. Ерөнхий шүүгчийн даалгавраар
7. Шийдвэрийг хэн тайлбарлах вэ?
 - а. Шүүгч
 - б. Шүүх хуралдаан даргалагч
 - в. Хуралдаанд оролцсон аль нэг шүүгч
 - г. Шүүх бүрэлдэхүүн, шүүгч
8. Шийдвэрийн тайлбарын хэлбэр ямар байх вэ?
 - а. Зөвхөн амаар
 - б. Зөвхөн бичгээр
 - в. Хуулиар тогтоосон тусгай хэлбэрээр
 - г. Амаар, бичгээр, аль ч хэлбэрээр



Бодлого

1. “Нарлаг хотхон” ХХК-ний нэхэмжлэлтэй үл хөдлөх хөрөнгийн өмчлөгчөөр тогтоолгох тухай иргэний хэргийг шийдвэрлэх шүүх хуралдаанд нэхэмжлэгч оролцоогүй ба шүүх хуралдаанаас гарсан шийдвэрийг ч гардан аваагүй байна. Нэхэмжлэгч нүүхийн шийдвэрээр нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэснийг шүүх хуралдаан болсноос хойш нэг сарын дараа мэдсэн. Нэхэмжлэгч шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч давж заалдах гомдол гаргах шаардлагатай болов.
Энэ тохиолдолд:
 - Хэргийн оролцогчийн оролцоогүйгээр шийдвэрлэсэн шүүх хуралдаанаас гарсан шийдвэрийг хэрхэн гардуулах журамтайг тодорхойлно уу?
 - Нэхэмжлэгчид эрх зүйн туслалцаа үзүүлнэ үү?

**Даалгавар:**

- Анхан шатны шүүхийн шүүх хуралдаанаас гарах шийдвэрийн төсөл бэлтгэх /5-аас доошгүй бодлого бэлтгэж түүнийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн төсөл бэлтгэх/
- Шүүх хуралдаанаас гарсан шийдвэрийг гардуулах ажиллагаатай танилцаж, түүний үр дагавартай холбогдсон бодлого бодох
- Шүүхийн шийдвэрт тавигдах шаардлагыг хангаагүйгээс гарах үр дагавар ямар байх талаар жишээ бодлого дээр ажиллах
- Анхан шатны шүүхийн шүүх хуралдаанаас шийдвэр гаргах явцыг дүрээр харуулах
- Шүүхийн шийдвэр бичих дадал дүйд суралцах /3-аас доошгүй шүүхийн шийдвэрийн төсөл бичих/
- Шийдвэр хууль ёсны ба үндэслэлтэй байх шаардлага хангасан эсэх талаар дүгнэн ярилцах

**Эх сурвалж:**

- ИХШХШТХууль /11-р бүлэг 115-124-р зүйл/
- Иргэний хууль. 2002 он
- Гэр бүлийн хууль 1999 он
- Хөдөлмөрийн хууль 1999он
- МУДШ-ийн тогтоол. 2006.04.24-ний өдөр.” Шүүхийн шийдвэрийн тухай
- МУДШ-ийн зөвлөмж. 2006.04.25-ний өдөр. “Шүүхийн шийдвэрийг боловсруулах аргачлалын тухай”.



АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮХ ХУРАЛДААН /ДҮРД ТОГЛОХ/

Семинарын хичээлийн зорилго: Анхан шатны шүүхийн шүүх хуралдааны дэгийг тодорхой тохиолдолд дүрээр үзүүлж, шүүх хуралдааны ажиллагааг дэгийг харуулснаар цаашид шүүх хуралдааны дэгийн талаар **мэдлэгтэй** болж, шүүх хуралдаанд оролцох **чадвар** эзэмшиж, шүүх хуралдааны үр нөлөөг ойлгож хэрэгжүүлэх боломжтой болно.

Сэдвийн агуулга:

- Анхан шатны шүүхийн шүүх хуралдааныг дүрээр дуурайлган явуулах тоглолт хийх
- Шүүх хуралдааныг тасралтгүй, амаар, нээлттэй явуулах зарчмыг хангах байдлаар зохион байгуулах
- Шүүх хуралдааны танхимыг засаж бэлтгэх
- Шүүх хуралдааны дэгийг харуулах / Үе шат бүрээр/
- Нотолгооны элемент шүүх хуралдааны явцад хэрхэн илэрлээ олохыг үзүүлэх
- Гэрчийн мэдүүлэг, болон бусад нотлох баримтыг шинжлэх ажиллагааг дүрээр үзүүлэх
- Иргэдийн төлөөлөгчийн дүгнэлт гаргах үйл явц
- Өмгөөллийн хэсэг ямар байх
- Шийдвэр гарах үйл явцыг харуулах

Дүрээр үзүүлэх тохиолдол: Заяа нөхөр Алдараас гэрлэлтээ цуцлуулсаны дараа гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын хөрөнгийн талаар маргаж шүүхэд ханджээ. Заяа шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ охин Сарнайг 16, 17 насанд хүрэхэд төрсөн өдрийн баярыг тохиолдуулан бэлэглэсэн компьютер, дүрс бичлэгийн камер, мөн түүнчлэн охины нэр дээр банкны хадгаламжинд байгаа 20 сая төгрөгийг оролцуулалгүйгээр гэрлэснээс хойш бий болсон гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын хөрөнгийн өөрт болон охин Сарнайд оногдох хэсгийг Алдараас гаргуулж өгөөч гэжээ.

Шүүх хуралдаанаар хэргийг хэлэлцэх явцад Алдар шүүхэд өгсөн тайлбартаа: Компьютер, дүрс бичлэгийн камерыг зөвхөн охин Сарнайд зориулан худалдаж аваагүй, гэр бүлийн хэрэгцээнд зориулагдсан байсан бөгөөд Заяа, Сарнай бид бүгдээрээ эзэмшдэг байсан. Сарнайгийн нэр дээр банкин дахь хадгаламжинд байгаа 20 сая төгрөгийг Заяа бид хоёр худалдаа эрхэлж, түүнээс олсон ашгийн мөнгийг төвлөрүүлсэн учраас компьютер, дүрс бичлэгийн камер, банкин дахь хадгаламжинд байгаа 20 сая төгрөгөөс өөрт оногдох хэсгээ гаргуулна гэжээ.

Шүүх хуралдаанд гэрчээр Нараа, Сараа нар оролцох болов. Заяа, Алдар нарын гэр бүлийн эд хөрөнгийн талаарх маргааныг шүүх хуралдаанаар шийдвэрлэх ажиллагааг дүрээр үзүүлнэ үү?

Шүүх хуралдааны явцад оролцох дүрүүд:

Шүүх хуралдаан даргалагч: Энэхүү иргэний хэргийг шүүгч дангаар шийдвэрлэх эсэх асуудлыг тодруулна. Оюутнууд хэргийг дангаар шийдвэрлэнэ гэж үзвэл шүүх хуралдаан даргалагчийн дүрд тоглоно. Харин энэ хэргийг бүрэлдэхүүнтэй шийдвэрлэнэ гэж үзвэл шүүх хуралдаан даргалагч бусад шүүгчид, мөн түүнчлэн иргэдийн төлөөлөгчийн дүрд тоглоно.

Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга: Шүүх хуралдааныг явуулах байр танхимыг бэлтгэх, шүүх хуралдаанд оролцогчдын ирцийг бүртгэж шүүгч, шүүх бүрэлдэхүүнд танилцуулах, шүүх хуралдаанын ажиллагааг тэмдэглэл үйлдэж баталгаажуулах дүрд тоглоно.

Заяагийн дүр: Нэхэмжлэгч. Заяа гэр бүлийн эд хөрөнгөөс өөрт болон охин Сарнай нарт оногдох хэсгээ гаргуулахаар нэхэмжлэл гаргасан.

Алдарын дүр: Хариуцагч. Алдар гэр бүлийн эд хөрөнгө гэж маргаж байгаа хөрөнгийн хувьд эрх ашиг нь хөндөгдсөн, зарим эд хөрөнгө нь түүний эзэмшилд байгаа.

Мөн түүнчлэн нэхэмжлэгч Заяа, хариуцагч Алдар нарын өмгөөлөгч нарын дүрд тоглоно.

Гэрч Нараа, Сараа нар нэхэмжлэгчийн хүсэлтээр шүүх хуралдаанд оролцож байгаа бөгөөд гэрч гэж хэнийг хэлэх, түүний эрх, үүргийг тодруулах дүрд тоглоно.

Хэргийн материалд дараах нотлох баримтууд байна. Тухайлбал: Заяа, Алдар нарын гэрлэлтийн гэрчилгээний хуулбар, гэрлэлт цуцалсан шүүхийн шийдвэр, хадгаламжийн дэвтэр, дүрс бичлэгийн камер, компьютерийн фото зураг, тэдгээрийг худалдаж авсан тухай баримтууд байна.

Шүүх хуралдааныг явуулах

Заяагийн нэхэмжлэлтэй иргэний хэргийн шүүх хурлын ажиллагааг 2 цагт багтаан явуулна. Шүүх хуралдаан даргалагчийн дүрд тоглох оюутан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуулийн дагуу явуулах, хэргийн оролцогч эрх, үүргээ хэрэгжүүлэх, мэтгэлцэх зарчмыг хангах, шүүх хуралдааны дэгийг сахиулах талаар шаардлагатай арга хэмжээ авна.

Шүүх хуралдааны танхимд байгаа бүх хүн шүүхийг хүндэтгэх, хуралдааны танхимд тогтоосон журмыг сахих шаардлагатай.



Даалгавар:

- Анхан шатны шүүх хуралдааны дэгийг бүдүүвч зохиж үзүүлэх



Эх сурвалж:

- ИХШХШТХууль 2002 он



VIII БҮЛЭГ. ДАВЖ ЗААЛДАХ ЖУРМААР ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН ОЙЛГОЛТ, ОНЦЛОГ, ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХЭЭР ХЭРЭГ ХЭЛЭЛЦЭХ АЖИЛЛАГАА

Сэдвийн зорилго: Давж заалдах шатны шүүх, түүний эрх хэмжээ, онцлог, давж заалдах журмаар гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх журам, шүүхээс гарах магадлал, түүний агуулгын талаарх ойлголт **мэдлэгийг** олж авч, бусад шатны шүүхээс ялгагдах онцлогийг зөв тодорхойлох, эрх зүйн үүднээс үнэлэлт, дүгнэлт өгөх, бусдад давж заалдах гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэхэд эрх зүйн туслалцаа үзүүлэх **чадвар** эзэмшинэ.

Сэдвийн агуулга:

- Давж заалдах шатны шүүхийн үйл ажиллагааны ойлголт, онцлог
- Давж заалдах гомдол, түүнд тавигдах шаардлага
- Давж заалдах гомдол гаргах эрхтэй этгээдүүд
- Давж заалдах гомдол гаргах хугацаа, гомдлыг шүүх хүлээн авах журам
- Давж заалдах шатны шүүхээр хэрэг хэлэлцэх журам, хугацаа
- Магадлал, түүний агуулга, үр дагавар
- Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл
- Шүүгчийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт гомдол гаргах журам, онцлог
- Гомдлыг шүүх хүлээн авч хянан шийдвэрлэх ажиллагаа



Нэр томъёоны тайлбар

Давж заалдах шатны шүүх - Аймаг, нийслэлийн шүүх иргэний хэргийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ. Иргэний хэргийг давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэх аймаг, нийслэлийн шүүхийг хэлнэ.

Давж заалдах шатны шүүхээр иргэний хэргийг хянах - Энэ нь давж заалдах шатны шүүхээс хэргийн оролцогчдын гаргасан давж заалдах гомдлын үндсэн дээр хуулийн хүчин төгөлдөр болсон анхан шатны шүүхийн шийдвэрийн хууль ёсны ба үндэслэлтэй эсэхийг хянах ажиллагааг зохицуулж байдаг эрх зүйн хэм хэмжээний бүрдэл цогц юм.

Давж заалдах шатны шүүх хуралдаан - Давж заалдах гомдлыг давж заалдах шатны шүүх хуралдаанаар 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан хэлэлцэж магадлал гаргах үйл явцыг ойлгоно.

Давж заалдах гомдол - Анхан шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрсөн хэргийн оролцогчоос түүнийг хянуулахаар гаргаж байгаа гомдол юм. Давж заалдах гомдлыг шийдвэр гаргасан шүүхээр дамжуулан бичгээр гаргана.

Давж заалдах гомдол гаргах эрх - Анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлээд гаргасан шүүхийн шийдвэрт зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч давж заалдах гомдол гаргах эрхтэй.

Магадлал - Давж заалдах шатны шүүхээс давж заалдах гомдлын үндсэн дээр хэргийг хянан хэлэлцээд гаргасан эрх зүйн баримт бичгийг хэлнэ.


Давж заалдах шатны шүүх гэдэгт аймаг, нийслэлийн шүүх хамаарахаас гадна, Дээд шүүх хуулиар харъяалуулсан хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэсэн тохиолдолд Дээд шүүх давж заалдах шатны шүүхэд хамаарч болно. /Монгол Улсын Үндсэн хуулийн 50-р зүйлийн 1 дэхь хэсгийн 1-р заалтыг / үзнэ үү/. Давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийн хууль ёсны ба үндэслэлтэй эсэхийг хэргийн оролцогчдын гаргасан гомдлыг үндэслэн хэргийг бүхэлд нь хянана.

Анхан шатны шүүхийн шийдвэр үндэслэлгүй болсон гэдэгт хэргийн нөхцөл байдлыг буруу тогтоосныг ойлгох ба анхан шатны шүүхээс хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлыг буруу тогтоосон, хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлыг шүүх тогтоогдсон гэж үзэж байгаа боловч хавтаст хэрэгт цугларсан нотлох баримтаар уг нөхцөл байдал тогтоогдоогүй, шүүхийн шийдвэрт хэргийн талаар хийсэн дүгнэлт нь хэргийн нөхцөл байдалтай тохирохгүй байгаа зэрэг нөхцөлүүд хамаарна.

Анхан шатны шүүхийн шийдвэр хууль ёсны болоогүй гэдэгт материаллаг болон процессн хуулийн заалтууд зөрчигдсөн буюу дээрх хуулийн заалтуудыг буруу хэрэглэсэн явдлыг ойлгоно. Материаллаг хуулийн /иргэн, гэр бүл, хөдөлмөрийн г.м/ заалт зөрчигдсөн гэдэгт шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, эсхүл хэрэглэх ёсгүй буюу өөр хуулийг хэрэглэсэн, шүүх хуулийг буруу тайлбарлан хэрэглэсэн, төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийг буруу хэрэглэсэн зэргийг хамааруулан ойлгоно.

Давж заалдах журмаар хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа анхан шатны хүүх хэргийг хянан шийдвэрлэхээс онцлогтой. Үүнийг тодруулан авч үзвэл анхан шатны шүүх хуралдаанаар шүүгч дангаараа эсхүл бүрэлдэхүүнтэй хэргийг хянан шийдвэрлэдэг бол давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдааныг тухайн шатны шүүхийн 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэнэ. Мөн түүнчлэн анхан шатны шүүх хуралдаанаар хуулиар хамгаалагдсан зөрчигдсөн эрх, эрх чөлөө, ашиг сонирголоо хамгаалуулахаар шүүхэд харъяалуулан шийдвэрлүүлэхээр хуульд заасан үндэслэлийн дагуу гаргасан нэхэмжлэл, хүсэлт, гомдлын үндсэн дээр үүссэн хэргийг хянан шийдвэрлэдэг бол давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаан нь анхан шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрсөн гомдлын үндсэнд хэргийг хэлэлцэнэ.

Анхан шатны шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгч оролцох эрх зүйн үндсийг Монгол Улсын Үндсэн хуулийн тавин хоёрдугаар зүйл, ИХШХШТХ-ийн 86 дугаар зүйлд заасан байдаг. Үндсэн хуулийн тавин хоёрдугаар зүйлд “ Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчдийг хуульд заасан журмын дагуу оролцуулна” гэжээ. Хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчдийг оролцуулахаар ИХШХШТ хуульд заасан. Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчдийг оролцуулахаар хууль тогтоомжинд заагаагүй. Анхан шатны шүүх хуралдаанаар хэргийг хэлэлцэх үе шатанд ИХШХШЭЗ-н үндсэн болон тусгай зарчмууд хэрэгждэг. Тухайлбал: Шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдах, хууль шүүхийн өмнө эрх тэгш байх, шүүх эрх мэдлийг зөвхөн шүүх хэрэгжүүлэх, хууль дээдлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэдийн төлөөлөгчийг оролцуулах хэргийн бодит үнэнийг тогтоох, шүүх хуралдааны ажиллагааг амаар шууд биечлэн явуулах, мэтгэлцэх гэх мэт. Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд ИХШХШЭЗ-н зарим зарчим хязгаарлагдмал байдлаар хэрэгждэг байна. Тухайлбал: Талуудын мэтгэлцэх, шүүх хуралдааныг амаар шууд биечлэн явуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэдийн төлөөлөгчийг оролцуулах гэх мэт.



Давж заалдах гомдлын хэлбэр, агуулга:

Давж заалдах гомдлыг бичгээр гаргана

Хэргийг хянан шийдвэрлэсэн анхан шатны шүүгч буюу нарийн бичгийн дарга хүлээн авна.

Зохигч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч, гуравдагч этгээдэд танилцуулж, тайлбарыг хэргийн хамт авна.

3 хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд хүргүүлнэ.

Давж заалдах гомдол гаргасан этгээд давж заалдах шатны шүүх хуралдаанаас өмнө гомдлоосоо татгалзвал шүүх түүнийг гомдол гаргаагүйд тооцно.

Гомдлыг ямар шүүхэд гаргаж байгаа

Гомдолд гаргаж буй этгээдийн овог, эцгийн нэр, нэр, хаяг, эсхүл албан тушаал, хуулийн этгээд бол оноосон нэр, хаяг, оршин байгаа газар

Аль шүүхийн ямар шийдвэрт гомдол гаргаж байгаа

Шийдвэрийн чухам аль нотлох баримтыг зөвшөөрөхгүй байгаа, түүний үндэслэл

Гомдол гаргаж буй этгээдийн хүсэлт

Гомдол гаргасан этгээдийн гарын үсэг

Давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа:

Зохигч тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцохыг бичгээр хүсвэл шүүх давж заалдах шатны шүүх хуралдаан хэзээ, хаана болохыг мэдэгдэнэ.

Давж заалдах гомдол гарсан хэргийг шүүх хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан, 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэнэ.

(Гомдолд үндэслэхгүйгээр хэргийг хянана)

(Шүүх хуралдааныг шүүгчдийн бүхэлд нь, зөвлөлгөөнөөс томилсон даргалагч)

(Шүүх хуралдаанд хэргийг нэг шүүгч илтгэнэ)

(Шүүх хурал завсарлаж шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөнө.)

(Зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд тайлбар гаргах, харилцан асуулт тавих зэргээр хэргийн материалыг судална)

(Шүүх хуралдаанд нотлох баримтын талаархи мэдүүлгийг унших, эсхүл бичлэгээс танилцуулж болно)

Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл:

Давж заалдах журмаар хэрэг хянан хэлэлцсэн шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг дараахь үндэслэлээр хүчингүй болгоно. /ИХШХШТХ-ийн 168-р зүйл/

Шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй

Зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн шүүх хуралдаанд биечлэн оролцох эрхийг хангалгүй хэргийг хянан шийдвэрлэсэн

Хэргийн болон шүүх хуралдаанд оролцогчийн хуулиар олгогдсон эрх ноцтой зөрчигдсөн

Хууль бус бүрэлдэхүүнээр хэргийг хянан шийдвэрлэсэн

Шүүхийн шийдвэрт шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч гарын үсэг зураагүй, эсхүл шүүх бүрэлдэхүүнд ороогүй шүүгч гарын үсэг зурсан;

Хуурамч нотлох баримтын үндсэн дээр хэргийг хянан шийдвэрлэсэн нь давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд илэрсэн

Хуульд зааснаар /ИХШХШТХ-ийн 38.6-д/ шүүх нотлох баримтыг дутуу бүрдүүлж хэргийг хянан шийдвэрлэсэн.v

Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон бол давж заалдах журмаар хянан хэлэлцсэн шүүх тухайн хэргийг дахин шийдвэрлүүлэхээр анхан шатны шүүхэд буцаана.



Давж заалдах шүүхийн шийдвэрээс гарах магадлал түүний агуулга

Давж заалдах шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн хэргийг дахин хянан хэлэлцээд магадлал гаргана.

Шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх

Шүүхийн шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулах

Шийдвэрийг хүчингүй болгож дахин шийдвэрлүүлэхээр анхан шатны шүүхэд буцаах

Шүүхийн шийдвэрийн зарим хэсгийг хүчингүй болгож бусад хэсгийг хэвээр үлдээх буюу өөрчлөх;

Бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох

Магадлалд анхан шатны шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийн агуулга, давж заалдах гомдлын товч үндэслэлийг тусгана.

Магадлал уншиж сонсгомогц хуулийн хүчин төгөлдөр болно.

Магадлалыг гарснаас хойш 7 хоногийн дотор зохигчид хүргүүлнэ.

Давж заалдах шатны шүүхийн магадлал нь хуульд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн, хууль буруу хэрэглэсэн гэж зохигч, гуравдагч этгээд үзвэл 30 хоногт багтаан хяналтын журмаар гомдол гаргаж болно.



Хяналтын асуулт

1. Давж заалдах гомдол гаргах эрхийн хэрэгжилт, үр нөлөөг тодорхойлно уу?
2. Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг анхан шатны болон хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай харьцуулж, онцлог ялгааг тодорхойлно уу?
3. Магадлалын үндэслэлийг тайлбарлана уу?
4. Шийдвэр, магадлалыг харьцуулж бүтцийн ангилалт хийнэ үү?
5. Давж заалдах гомдол гаргах, хүлээн авах журмыг дүрд тоглох хэлбэрээр харуулна уу?
6. Давж заалдах шатны шүүхийн ажиллагааны онцлогийг бүдүүвчээр үзүүлнэ үү?
7. Шийдвэр, магадлалыг харьцуулж бүтцийн ангилалт хийнэ үү?

**Сорил**

1. Давж заалдах гомдол гаргасан этгээд давж заалдах шатны шүүх хуралдаанаас өмнө гомдлоосоо татгалзвал:
 - а. Хэргийг хэрэгсэхгүй болгоно
 - б. Гомдлыг анхан шатны шүүхээр шийдвэрлүүлэхээр буцаана
 - в. Гомдлыг хүлээн авахаас татгалзсан захирамж гаргана
 - г. Гомдол гаргаагүйд тооцно.
2. Дараах этгээдүүдээс давж заалдах гомдол гаргах эрхгүй этгээдийг олно уу?
 - а. Зохигч
 - б. Өмгөөлөгч
 - в. Гуравдагч этгээд
 - г. Иргэдийн төлөөлөгч
3. Давж заалдах шатны шүүхээр хэргийг хянан хэлэлцэх үед гомдолд дурьдаагүй зөрчил тогтоогджээ. Эл үндэслэлээр шийдвэрт өөрчлөлт оруулж болох уу?
 - а. Давж заалдах өргөдөлд дурьдаагүй тул болохгүй
 - б. Шүүх хэргийг бүхэлд нь хянах эрхтэй учир болно
 - в. Давж заалдах гомдол гаргагч этгээдэд ашигтай бол болно
 - г. Хуралдаан даргалагч тухайн шүүхийн бүрэлдэхүүн өөрсдөө шийдвэрлэх асуудал
4. Зохигч, гуравдагч этгээд давж заалдах шатны шүүх хуралдаанд биечлэн оролцох бол
 - а. Энэ тухайгаа бичгээр хүсэлт гаргана
 - б. Энэ тухай амаар мэдэгдэхэд хангалттай
 - в. Мэдэгдэх шаардлагагүй, учир нь шүүх оролцуулах үүрэгтэй
 - г. Оролцуулах эсэхийг шүүх шийдвэрлэнэ
5. Давж заалдах гомдлыг гаргах журам
 - а. Аймаг, Нийслэлийн шүүхэд шууд гаргана
 - б. Анхан шатны шүүхээр дамжуулан гаргана
 - в. зохигч өөрөө сонгоно
6. Давж заалдах шатны шүүх хэргийг хүлээн авснаас хойш ямар хугацаанд шийдвэрлэх вэ?
 - а. 14 хоногийн дотор
 - б. 60 хоногийн дотор
 - в. 30 хоногт багтаан шийдвэрлэнэ
7. Давж заалдах шатны шүүх хэргийг шийдвэрлэхдээ
 - а. 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй шийднэ
 - б. Шүүгч дангаараа болон 3 шүүгч хамтарч
 - в. Зөвхөн илтгэгч шүүгч шийдвэрлэнэ
8. Давж заалдах шатны шүүхээс гарах эрхийн акт
 - а. Магадлал
 - б. Шийдвэр
 - в. Тогтоол



Бодлого

1. Иргэн О анхан шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч давж заалдах гомдол гаргахдаа шүүхийн шийдвэрийг гардан авснаас хойш 15 хоногийн дараа шууд нийслэлийн шүүхэд гомдлоо гаргажээ. Шүүх гомдлыг хүлээн авахаас татгалзжээ.

Энэ тохиолдолд:

- Шүүхийн татгалзал үндэслэлтэй юу?
- Ямар хугацаанд, хаана хандаж давж заалдах гомдол гаргах вэ?

2. СХД-ийн шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч давж заалдах гомдол гаргасан С шүүх хуралдаанд биеэр оролцох тухайгаа бичгээр илэрхийлсэн боловч давж заалдах шатны шүүх түүнд мэдэгдэлгүйгээр шүүх хуралдааныг явуулж, хэргийг шийдвэрлэсэн байна.

Энэ тохиолдолд:

- Давж заалдах шатны шүүх С-ийг шүүх хуралдаанд биечлэн оролцуулах үүрэгтэй эсэхийг дүгнэнэ үү?

3. Иргэн Д-гийн нэхэмжлэлтэй Г-д холбогдох орон сууцнаас нүүлгэн гаргах тухай иргэний хэргийг шүүх шийдвэрлэж Г-г албадан нүүлгэхээр шийдвэрлэсэн. Шүүхийн шийдвэрийг Г эс зөвшөөрч давж заалдах гомдол гаргасан ба гомдолдоо анхан шатны шүүхэд өгч амжаагүй байсан орон сууц эзэмшихтэй холбогдолтой баримтуудыг шүүхэд гаргаж өгсөн.

Энэ тохиолдолд:

- Давж заалдах шатны шүүх асуудлыг хэрхэн шийдвэрлэх вэ?



Даалгавар:

- Оюутан бүр магадлал дээр ажиллаж, түүнд хууль зүйн үүднээс дүгнэлт хийх
- Давж заалдах шатны шүүхэд гомдол бичиж, уг гомдлыг давж заалдах журмаар шийдвэрлэх ажиллагаа явуулах



Эх сурвалж:

- ИХШХШТХууль 2002 он 15-рбүлэг

**IX БҮЛЭГ . ХЯНАЛТЫН ЖУРМААР ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ
АЖИЛЛАГАА****ХЯНАЛТЫН ЖУРМААР ГОМДОЛ ГАРГАХ ҮНДЭСЛЭЛ, ЖУРАМ,
ТҮҮНИЙГ ХЭЛЭЛЦЭХ АЖИЛЛАГАА**

Сэдвийн зорилго: Хяналтын журмаар гомдол гаргах үндэслэлийг зөв ойлгож мэдэх, Хяналтын шатны шүүхийн онцлог, эрх хэмжээ, хэрэг хянан шийдвэрлэх үе шат, журам, шүүх бүрэлдэхүүний ялгаа хяналтын шатны шүүхээс гарах шийдвэрийн талаарх **мэдлэгийг** олж авч, бусад шатны шүүхээс ялгагдах талыг танин мэдснээр хяналтын журмаар гомдол гаргахад эрх зүйн туслалцаа үзүүлэх, шүүхээс гарсан тогтоолд хууль зүйн дүгнэлт хийх **чадвар** эзэмшинэ.

Сэдвийн агуулга:

- Хяналтын шатны шүүхээр хэрэг хэлэлцэх ажиллагааны ойлголт
- Хяналтын журмаар гомдол гаргах эрх, үндэслэл
- Хяналтын журмаар хэрэг хэлэлцэх ажиллагааны журам, үе шат, онцлог
- Тогтоол, түүний агуулга, бүтэц
- Анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгох, өөрчлөх үндэслэлүүд
- Тогтоолын эрх зүйн ач холбогдол, үр дагавар

**Нэр томъёоны тайлбар**

Хяналтын шатны шүүх - Улсын дээд шүүх хяналтын журмаар иргэний хэргийг хянан шийдвэрлэнэ.

Хяналтын гомдол - ИХШХШТХ-ийн 172-р зүйлд заасан үндэслэлээр давж заалдах шатны шүүхийн магадлалыг эс зөвшөөрч зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчөөс гаргасан гомдлыг ойлгоно.

Хяналтын гомдол гаргах үндэслэл - Шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хуулийг болон хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийг буруу хэрэглэсэн, хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн үндэслэлээр хяналтын гомдол гаргана.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчих гэдэгт - Шүүх хуралдаанд зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч зайлшгүй биечлэн оролцох хэрэгт тэднийг оролцуулаагүй, хууль бус бүрэлдэхүүнээр хэргийг хянан шийдвэрлэсэн, хэргийн оролцогчийн эрхийг ноцтой зөрчсөн гэх мэт ИХШХШТХуулиар тогтоосон журмыг зөрчсөн байхыг ойлгоно.

Хяналтын гомдол гаргах журам - Хяналтын журмаар гаргах гомдлыг уг хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн шүүх хүлээн авна. Гомдлыг хүлээн авсан шүүх хэрэгт улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, зохигчийн гомдлыг хавсарган гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш нийслэлд 3 хоногийн дотор, хөдөө орон нутагт 14 хоногийн дотор Улсын дээд шүүхэд хүргүүлнэ.

Хяналтын шатны шүүх хуралдаан - УДШ-ийн иргэний танхим 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хяналтын гомдлын үндсэн дээр хэргийг хянан хэлэлцэх хуралдааныг хэлнэ.



Хяналтын шатны шүүхийн тогтоол - Танхимын шүүх хуралдаанаас тогтоол гаргана оогтоолд шүүх хуралдаан даргалагч, илтгэгч шүүгч гарын үсэг зурсан байна. Тогтоолд анхан шатны болон давж заалдах журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, магадлалын агуулга, түүний үндэслэл, гаргаж байгаа тогтоолын үндэслэлийг тусгана.

Давж заалдах шатны шүүхийн магадлалд зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй.

Дараахь үндэслэлээр гомдол гаргана:

- Шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийг буруу хэрэглэсэн
- Хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн:
 - шүүх хуралдаанд зохигч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч зайлшгүй биечлэн оролцох хэрэгт тэднийг оролцуулаагүй;
 - хууль бус бүрэлдэхүүнээр хэргийг хянан шийдвэрлэсэн;
 - хэргийн оролцогчийн эрхийг ноцтой зөрчсөн зэрэг журмуудыг зөрчсөн

Хяналтын журмаар гомдол гаргахдаа гомдол гаргагч хэргийг шийдвэрлэсэн анхан шатны шүүхээрээ дамжуулна.

Анхан шатны шүүх гомдлыг нийслэлд 3 хоногт, хөдөө орон нутагт 14 хоногийн дотор хяналтын шатны шүүхэд хүргүүлнэ.

Гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагаа:

УДШ-ийн иргэний танхимын 5 шүүгч хэргийг 30 хоногийн дотор шийдвэрлэнэ

Шүүх хуралдаанд хэргийн оролцогчид ирээгүй нь хэргийг хянан шийдвэрлэхэд саад болохгүй

Зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч хуралдаанд оролцохыг хүсвэл шүүх хуралдаан хэзээ, хаана болохыг мэдэгдэнэ.

Зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд гомдлын талаар тайлбар гаргах эрхтэй.

Тогтоол

Гомдол гаргагч хүлээн авсанаас 30 хоногийн дотор хууль зөрчсөн үндэслэлээр ерөнхий шүүгчид гомдол гаргаж болно.

Гомдлыг үнлэслэлтэй гэж үзвэл дүгнэлт гаргаж уг хэргийг Улсын дээд шүүхийн хуралдаанд хэлэлцүүлнэ.

Хяналтын шатны шүүхийн тогтоол, түүний агуулга:

Хяналтын шатны шүүх /УДШ-ийн иргэний хэргийн танхим, УДШ-ийн нийт шүүгчидийн хуралдаан/ хэргийг хэлэлцээд тогтоол гаргана.

Шийдвэр, магадлал, тогтоолыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхих

Шийдвэр, магадлал, тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах

Шийдвэр, магадлал, тогтоолыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчлөх

Шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох

Шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны болон давж заалдах шатны шүүхэд буцаах

Танхимын шүүх хуралдаанаас тогтоол гаргана. Тогтоолд шүүх хуралдаан даргалагч, илтгэсэн шүүгч гарын үсэг зурна. Тогтоолд анхан шатны болон давж заалдах журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, магадлалын агуулга, түүний үндэслэл, гаргаж байгаа тогтоолын үндэслэлийг тусгана.

**Хяналтын асуулт**

- Хяналтын журмаар гомдол гаргах үндэслэлийг тайлбарлана уу?
- Хяналтын журмаар гомдол гаргах хугацааг тодорхойлно уу?
- Хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй субъектүүдийг нэрлэнэ үү?
- Хяналтын гомдлыг гаргах журам, хүлээн авах шилжүүлэх хугацааг тайлбарлана уу?
- Хяналтын шатны шүүхийн хуралдааны халбэр, онцлог, даргалагч шүүгч ба шггэгч шүүгчийн үүргийг тайлбарлана уу ?
- Анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн ажиллагаанаас хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ялгагдах талыг тодорхойлж, тайлбарлана уу?
- Хяналтын шатны шүүхийн тогтоол, давж заалдах шатны магадлал, анхан шатны шүүхийн шийдвэрийг харьцуулж, ялгаа ,онцлогийг гаргаж тайлбарлана уу?



Сорил

1. Дараахаас аль нь хяналтын журмаар гаргах гомдлын үндэслэлд хамаарахгүй вэ.
 - а. Хуулийг буруу хэрэглэсэн
 - б. Нотлох баримтыг дутуу үнэлсэн
 - в. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн
2. Хянанын журмаар гаргах гомдлыг ямар хугацаанд гаргах вэ?
 - а. Шийдвэр, магадлалыг гардаж авснаас хойш 30 хоногт
 - б. Гардаж авснаас эсхүл хүргүүлснээс хойш 14 хоногийн дотор
 - в. Унишж сонсгосноос хойш 30 хоногт
3. Төв аймгийн сум дундын шүүх хяналтын журмаар гаргасан гомдолтой хэргийг гомдлыг хүлээн авснаас хойш хэд хоногийн дотор Улсын дээд шүүхэд хүргүүлэх вэ?
 - а. 3 хоногийн дотор
 - б. 7 хоногийн дотор
 - в. 14 хоногийн дотор
 - г. 10 хоногийн дотор
4. Хяналтын шатны шүүх хэргийг
 - а. 30 хоногийн дотор
 - б. 60 хоногийн дотор
 - в. 14 хоногийн дотор
5. Хяналтын шатны шүүх хуралдааны шүүгчдийн бүрэлдэхүүн
 - а. 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэй
 - б. 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй
 - в. 16 шүүгчийн бүрэлдэхүүнтэй
6. Хяналтын шатны шүүхээс ямар эрхийн акт гарах вэ?
 - а. Тогтоол
 - б. Магадлал
 - в. Шийдвэр
7. Хяналтын журмаар гомдол гаргах эрхгүй этгээдэд аль нь хамаарах вэ?
 - а. Өмгөөлөгч
 - б. Гуравдагч этгээд
 - в. Прокурор
8. Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдааны тогтоолд зохигч, гуравдагч этгээд ИХШХШ тухай хуулийн 1761-р зүйлд заасан хугацаанд хүндэтгэх шалтгаангүйгээр гомдол гаргаагүй бол уг тогтоолыг “эцсийнх” гэж үзэж болох уу?
 - а. Уг тогтоолыг “эцсийнх” гэж үзэж болохгүй
 - б. Уг тогтоолыг “эцсийнх” гэж үзэх эсэхийг Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн шийднэ

в. Уг тогтоолыг “эцсийнх” гэж үзэх эсэхийг Дээд шүүхийн Ерөнхий шүүгч шийднэ

г. Уг тогтоолыг “эцсийнх” гэж үзнэ

1. Давж заалдах ба хяналтын журмаар гомдол гаргасан этгээд шүүх хуралдаанаас өмнө гомдлоосоо татгалзвал урьд нь түүний гомдол гаргахдаа төлсөн улсын тэмдэгтийн хураамжийг :

а. Буцаан олгохгүй

б. Буцааж олгоно

в. Буцааж олгох эсэх нь тухайн шатны шүүх бүрэлдэхүүний үзэмжээр шийдэгдэнэ

г. Гомдол гаргасан этгээд улсын тэмдэгтийн хураамжаа буцаан авах тухай хүсэлт гаргасан бол буцаан олгоно

2. Анхан шатны шүүхийн шийдвэрт зохигч талын нэг нь давж заалдах гомдол гаргасан, харин эсрэг тал нь түүнээс 2 хоногийн өмнө хяналтын журмаар гомдол гаргасан бол:

а. Зөвхөн давж заалдах журмаар хэргийг хянан шийдвэрлэнэ.

б. Хяналтын журмаар хянан шийдвэрлэж болно

в. Зохигч талуудын тохиролцсоноор шийдвэрлэнэ.

г. Анхан шатны шүүх аль журмаар шийдвэрлэхийг нь тогтооно.



Бодлого

1. Завхан аймгийн сум дундын шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч хууль буруу хэрэглэсэн гэсэн үндэслэлээр хяналтын гомдол гаргасан С-ийн гомдолтой иргэний хэргийг Завхан аймгийн сум дундын шүүх хүлээн авснаас хойш 30 хоногийн дараа УДШ-д явуулсан байна. Энэ тохиолдолд:

- С анхан шатны шүүхийн шийдвэрт хяналтыг гомдол гаргах эрхтэй эсэх?

2. УДШ-ийн хяналтын хуралдаанд гомдол гаргагч Т, түүний өмгөөлөгч хүрэлцэн ирээгүй тул тэднийг оролцуулахгүйгээр хэргийг шийдвэрлэсэн байна. Энэ тохиолдолд:

- Хяналтын шатны шүүх хууль зөрчсөн үү?



Даалгавар:

- Анхан болон давах шатны шүүхээс хяналтын шатны шүүхийн ялгагдах гол ялгааг мэдэх
- Хяналтын шатны шүүхэд гомдол гаргах үндэслэл тус бүр дээр жишээ зохиох
- Хяналтын шатны шүүхэд гомдол бичих



Эх сурвалж:

- ИХШХШТХУУЛЬ. 2002 ОН. 16



Х БҮЛЭГ. ГЭР БҮЛИЙН ХОЛБОГДОЛТОЙ ХЭРЭГ МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

ШҮҮХИЙН ЖУРМААР ГЭРЛЭЛТ ЦУЦЛАХ АЖИЛЛАГАА

Сэдвийн зорилго: Гэрлэлтийг шүүхийн журмаар цуцлах үндэслэл, шүүхэд гаргах нэхэмжлэл, түүнд тавигдах шаардлага, нэхэмжлэл гаргах харьяалалын талаарх ойлголт **мэдлэгийг** олж авч, шүүх уг асуудлыг хэрхэн шийдвэрлэдэг журам, онцлогийг бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай харьцуулан дүгнэлт хийх, шүүхийн журмаар гэрлэлт цуцлуулахад хууль зүйн туслалцаа, зөвлөгөө өгөх, шүүхийн шийдвэрт дүгнэлт хийх **чадвар** эзэмшинэ.

Сэдвийн агуулга:

- Гэр бүлийн холбогдолтой маргаан, түүний төрөл
- Нэхэмжлэл гаргах харьяалал
- Гэрлэлтийг цуцлахгүй орхих, түдгэлзүүлэх үндэслэл, журам.
- Тэтгэвэр, эд хөрөнгийн асуудлыг шүүхээр шийдвэрлэх нь
- Гэрлэгсэдийн эд хөрөнгийн буюу тэжээн тэтгэх гэрээ
- Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх урьдчилсан арга хэмжээг хэрэглэх, өөрчлөх, хүчингүй болгох, дуусгавар болгох үндэслэл, журам. Гэр бүлийн хүчирхийлэл, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн холбогдох зохицуулалт.
- Гэрлэлт цуцлах хэргийг шүүх хянан шийдвэрлэх журам
- Шүүхээс гаргах шийдвэр, түүний хэрэгжилт.



Нэр томъёоны тайлбар

Гэрлэгчид - Гэрлэлтээр холбогдсон харилцан тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээх нөхөр, эхнэр.

Гэр бүлийн гишүүн - Гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл садангийн хүн гэр бүлийн гишүүн юм

Гэрлэлт цуцлах - Энэ нь гэрлэлт дуусгавар болох нэгэн үндэслэл бөгөөд гэрлэлт цуцлах гэдэг нь гэрлэлтийн үр дүнд бий болсон эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон гэрлэгчдийн хамтын амьдрал тэдний хүсэл зоригийн үндсэн дээр эрх бүхий байгууллагын шийдвэрээр дуусгавар болохыг ойлгоно.

Гэрлэлтийг шүүхийн журмаар цуцлах - Гэрлэлтийг шүүхийн журмаар цуцлах асуудлыг Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, ИХШХШТХуулийн 12 дугаар бүлэгт заасан журмын дагуу шийдвэрлэнэ. Гэрлэгчдийн гаргасан гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлийг шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэхийг шүүхийн журмаар гэрлэлт цуцлах гэж ойлгоно.

Гэр бүлийн эд хөрөнгө - Гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар үрчлэн авсан хүүхэд болон төрөл садангийн хүн гэр бүлийн гишүүн юм.

Хамтран өмчлөх дундын хөрөнгө - Гэрлэснээс хойш хамтран амьдарсан хугацаанд бий болсон гэр бүлийн гишүүдийн хуваарьт хөрөнгөөс бусад хөрөнгө нь гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын өмч юм.

Хуваарьт хөрөнгө - Гэр бүлийн гишүүн өөрийн үзэмжээр эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах эрхтэй, гэрлэхийн өмнө байсан буюу гэрлэлтийн явцад бий болсон хөрөнгө юм. Гэр бүлийн гишүүний хуваарьт хөрөнгөнд гэрлэхийн өмнө олж авсан эд хөрөнгө, мөнгөн хуримтлал, эд хөрөнгийн эрх, өв, бэлэглэлийн журмаар шилжүүлэн авсан мөнгөн хуримтлал, эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, тэдгээрийг худалдсан, арилжааны үр дүнд олж авсан эд хөрөнгө, мөнгө; амин хувийн хэрэгцээг хангахад зориулсан эд хөрөнгө, хуваарьт эд хөрөнгөөрөө олж авсан мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах хөрөнгө, зохиогчийн шагнал буюу оюуны өмчлөлийн зүйлийн үнэ, хувийн авъяас чадвар, ололт амжилтыг сайшаан шагнасны орлого зэрэг хамаарна. Гэр бүлийн гишүүн хуваарьт хөрөнгөө өөрийн үзэмжээр эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах эрхтэй ба гэр бүлийн хамтран өмчлөх дундын хөрөнгөнд хэдийд ч шилжүүлэх боломжтой юм.

Эд хөрөнгийн гэрээ - Гэрлэгчид нь эд хөрөнгийнхөө харилцааг эд хөрөнгөтэй холбогдсон гэрээний үндсэн дээр зохицуулж болно. Гэрлэгчид гэрлэгч тус бүрээс өрхийн төсөв, зарддыг хариуцах журам, гэрлэлтийг цуцалсан нөхцөлд ногдох хөрөнгийг тодорхойлох, хөрөнгийн эрхтэй холбогдсон бусад нөхцлийг энэ хуульд нийцүүлэн байгуулсан гэрээний үндсэн дээр зохицуулж болно гэж Иргэний хуульд заажээ.

Тэжээн тэтгэх гэрээ - Тэжээн тэтгэх гэрээгээр тэтгэгч, тэтгүүлэгчтэй тохиролцсоны үндсэн дээр тэжээн тэтгүүлэх эрх үүссэнээс хойш тохиролцсон нөхцлөөр бие биеэ тэтгэхтэй хол богдсон харилцааг зохицуулна. Тэжээн тэтгэх гэрээний оролцогч талд нэг талаас бусдыг тэжээн тэтгэх үүрэг хүлээсэн тэтгэгч, нөгөө талд тэтгэгчээс материаллаг тусламж зайлшгүй шаардлагатай болсон тэтгүүлэгч байна. Гэрээний тэтгэгч тал нь үүрэг хүлээсэн учраас нэг талын, хариу төлбөргүй гэрээ юм. Тэтгэгч нь тэтгүүлэгчийг тэтгэсний төлөө хариу төлбөр нэхэх, эд хөрөнгө, мөнгө шаардах эрхгүй ба тэтгүүлэгч тэтгэгчид буцааж, төлбөр төлөх үүрэг хүлээхгүй. Тэжээн тэтгэх гэрээг бичгээр үйлдэж нотариатаар гэрчлүүлсэн байна.

Гэрлэгчдийг эвлэрүүлэх - Шүүх гэрлэлт цуцлах хэргийг шийдвэрлэхдээ гэрлэлт цуцлах болсон шалтгааныг сайтар судлан тогтоох, гэрлэгчдийн болон хүүхдийн эрх, ашгийг хамгаалах зорилгод нийцүүлэн, аль болох гэрлэгчдийг эвлэрүүлэхэд анхаардаг. Шүүгч эвлэрүүлэх хугацааг 3 сар хүртэл хугацаагаар тогтоох ба гэрлэгчид шүүхээс тогтоосон хугацаанд эвлэрээгүй бол хэргийг шийдвэрлэнэ. Харин гэрлэгчид бие биенээ байнга хүчирхийлж дарамталдаг нь тэдний болон гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд хүүхдийн хүмүүжилд ноцтой хохирол учруулж болзошгүй; эсхүл учруулсан нь тогтоогдвол шүүх эвлэрүүлэх арга хэмжээ авалгүйгээр гэрлэлтийг цуцална.

Хүүхдийн асрамж тогтоох - Нэгэнт эцэг, эх нь хамт амьдрах боломжгүй болсон бол шүүхээс насанд хүрээгүй хүүхдийг хэний асрамжинд үлдээх вэ гэдэг асуудлыг шийдвэрлэхдээ эцэг, эхийн тохиролцоог харгалзан үзэх ба тэд энэ талаар тохиролцож чадаагүй бол хүүхдийн нас, эцэг, эхийн хайр халамж, амьдрал ахуйн нөхцөл бололцоо, эцэг, эхийн ёс суртахууны байдал, 7 (долоо) ба түүнээс дээш насны хүүхдийн саналыг харгалзан үзнэ.



Хүүхдийн тэтгэлэг тогтоох - Шүүх хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлээд түүнд олгох тэтгэлэгийг тогтоож өгнө. Хүүхдийн тэтгэлэгийн асуудлаар гэрлэгчид харилцан тохиролцож тэжээн тэтгэх гэрээ байгуулах боломжтой бөгөөд энэ талаар тохиролцож чадаагүй бол Гэр бүлийн тухай хуульд зааснаар хүүхдийн насны байдлыг харгалзан сар тутам, хүүхэд тус бүрт тэтгэлгийг тогтооно. Тэтгэлэгийн хэмжээ нь 11 хүртэлх насны хүүхдэд, түүний амьдарч байгаа бүс нутагт Засгийн газраас тогтоосон амьжиргааны баталгаажих доод түвшингийн 50 хувьтайтэнцэх бол 11 -ээс дээш насны хүүхдэд амьжиргааны баталгаажих доод түвшингийн хэмжээгээр тус тус бодож олгоно.

Гэр бүлийн холбогдолтой дараах хэрэг маргааныг шүүх хянан шийдвэрлэнэ:

Нэхэмжлэлийг хариуцагчийн оршин суугаа газрын шүүхэд гаргана.

Нэхэмжлэгч бага насны хүүхэдтэй буюу тахир дутуу, хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас хариуцагчийн байгаа газар очиход бэрхшээлтэй бол нэхэмжлэлийг өөрийн оршин суугаа газрын шүүхэд гаргаж болно.

Гэрлэлт цуцлуулах тухай

Тэтгэвэр гаргуулах ба гэрлэгчдийн дундын эд хөрөнгө хуваах

Гэрлэгчдийн эд хөрөнгийн буюу тэжээн тэтгэх гэрээг биелүүлэх тухай

Гэрлэлт цуцлах ажиллагаа, түүний онцлог:

Гэрлэлт цуцлуулах тухай

- Гэрлэлт цуцлах ажиллагаанд шүүх хууль зүйн үндэслэлтэй зөв дүгнэлт хийх
- Шүүх хуралдаанд оролцох
- Хуралдааны нээлттэй, хаалттай хийж болно


Тэтгэвэр гаргуулах ба гэрлэгчдийн дундын эд хөрөнгө хуваах

Шүүхэд нэхэмжлэл гаргаж байгаа эхнэр нөхөр, хөдөлмөрийн чадваргүй, хүнд өвчтэй, эдийн засгийн хувьд зайлшгүй туслалцаа авах шаардлагатай нөхцөл, шалтгаанаа нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд шүүх гэрлэлт цуцлах нэхэмжлэлтэй хамтатган шийдвэрлэхгүй


Гэрлэгчдийн эд хөрөнгийн буюу тэжээн тэтгэх гэрээ гэрээг биелүүлэх тухай

Эд хөрөнгийн гэрээг аль нэг тал нь биелүүлээгүй, тэжээн тэтгэх гэрээг нотариатаар батлуулсан, гэрээг хэн нэг нь биелүүлэхгүй байгаа бол шүүгч тэдгээрийн хүсэлтээр захирамж гарган ШШГБ-д шилжүүлнэ.

Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх урьдчилсан ажиллагаа:



Гэрлэлт цуцлах тухай хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа:





Хяналтын асуулт

- Шүүхээр шийдвэрлэгддэг гэр бүлийн холбогдолтой маргааны төрлүүдийг нэрлэж тайлбарлана уу?
- Гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлийг бичиж, үндэслэл, шаардлагыг тайлбарлана уу?
- Гэрлэгсэдийн эд хөрөнгийн буюу тэжээн тэтгэх гэрээ түүнд тусгагдах зүйлүүд түүнийг хэрхэн биелүүлэхийг тайлбарлана уу?
- Урьдчилсан арга хэмжээ авах үндэслэл, журам, төрөл
- Гэрлэгчид шүүх хуралдаанд ирээгүйн үр дагаварыг хүснэгтийн дагуу зөв бөглөж тодорхойдно уу? /Буцаана Хойшлуулна. Байхгүйд нь шийдвэрлэнэ. Оролцуулахгүйгээр шийдвэрлэнэ/.



Сорил

1. Нөхөж бичнэ үү?

Нэхэмжлэгч, хариуцагч нь хүндэтгэн үзэх шалтгаанаар ирээгүй бол	Хариуцагч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 2 дахь удаагаа ирээгүй бол	Нэхэмжлэгч ирээгүй бол	Нэхэмжлэгч хүндэтгэн үзэх шалтгаанаар оролцуулахгүйгээр шийдвэрлүүлэх хүсэлт гаргасан бол

2. Гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлийг анхан шатны ямар шүүхэд гаргах вэ?

- Хариуцагчийн оршин суугаа газрын харъяа шүүхэд
- Хариуцагчийн хамгийн сүүлд амьдарч байсан газрын харъяа шүүхэд
- Гэр бүлийн гишүүдийн хамгийн сүүлд хамт амьдарч байсан газрын харъяа шүүхэд
- Гэрлэгчдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгө байгаа газрын харъяа шүүхэд

3. Гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэл гаргах эрхтэй этгээдийг нэрлэнэ үү?

- Сонирхогч этгээд
- Хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хатгаалсан байгууллага
- Прокурор
- Эхнэр, нөхрийн аль нэг нь

4. Шүүх гэрлэлт цуцлах нэхэмжлэлтэй хамт шийдвэрлэдэг маргааныг нэрлэнэ үү?

- Хүүхдэд нэр өгөхтэй холбогдсон маргаан.
- Тэтгэвэр гаргуулах.
- Тэжээн тэтгэх гэрээний биелэлтийг хангах тухай.
- Хүүхдээ үрчлүүлснийг хүчингүйд тооцох тухай.

5. Гэрлэлт цуцлах тухай нэхэмжлэлийг шүүхэд хянан шийдвэрлэхэд дор дурдсан нотлох баримтаас аль нь хэрэгт зайлшгүй ач холбогдолтой вэ?
- Гэрлэлтийн гэрчилгээ
 - Нөхрийн ажлын газрын цалин, хөлсний талаарх тодорхойлолт
 - Эхнэрийн эрүүл мэндийн тодорхойлолт
 - Тэжээн тэтгэх гэрээ
6. Шүүх гэр бүлийн холбогдолтой хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ урьдчилан авах арга хэмжээг нэрлэнэ үү?
- Хүүхдэд асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг томилуулах
 - Шүүхийн зардлын тодорхой хувийг урьдчилгаа болгон төлүүлэх
 - Эхнэр, нөхрийн эрүүл мэндийн үзлэгт хамруулахыг даалгах
 - Эд хөрөнгийн маргааныг тусгаарлан хянан шийдвэрлэх
7. Шүүх гэрлэлт цуцлах үед насанд хүрээгүй хүүхдийг хэний асрамжинд үлдээх вэ? гэдгийг шийдвэрлэхэд насны байдлыг харгалзан хүүхдээс санал авах шаардлагатай юу?
- Шаардлагагүй. Хуульд энэ тухай заагаагүй.
 - Шаардлагатай. 9 насанд хүрсэн бол.
 - Шаардлагатай. 7 ба түүнээс дээш настай бол.
 - Шаардлагагүй. Хуульд эхийн асрамжинд хүүхдийг үлдээх зохицуулалттай.
8. Шүүхээс гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээ авах боломжит хугацааг тодорхойлно уу?
- 6 сар хүртэл
 - 3 сар хүртэл
 - 4 сар хүртэл
 - 2 сар хүртэл
9. Гэрлэлт цуцлахыг хориглох шаттгаанд аль нь хамаарагдахгүй вэ?
- Эхнэр нь жирэмсэн
 - Нэхэмжлэгч хүндээр өвчилсөн
 - Хүүхэд нь нэг нас хүрээгүй
 - Хариуцагч хүндээр өвчилсөн
10. Шүүх гэрлэлт цуцлах нэхэмжлэлийг шүүх хуралдаанаар хэлэлцэхдээ гэрлэгчдийг заавал байлцуулах зорилгоор шүүх хуралдааныг нэг удаа хойшлуулав. Энэ тохиолдолд:
- Гэрлэгчдийн төлөөлөгч, өмгөөлөгч хуралдаанд ирсэн тул янз нь буруу
 - Гэрлэгчид нь шүүх хуралдаанд ирэх үүрэгтэй
 - Гэрлэгчдийг байлцуулалгүйгээр хэргийг хянан шийдвэрлэх боломжтой
 - Энэ тухай хуульд тодорхой заагаагүй
11. Гэрлэгчдэд эвлэрэх хугацаа өгч болохгүй нөхцөлийг нэрлэнэ үү?
- Хүүхдийн хүмүүжилд ноцтой хохирол учирч болзошгүй
 - Гэрлэгчид эцэг байх эрхээ хасуулсан
 - Гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг зөвшөөрөлгүйгээр худалдан борлуулсан гэдэг нь тогтоогдсон
 - Эхнэр, нөхөр 3 жилээс доошгүй хугацаанд хамт амьдраагүй



Бодлого

1. СБД-ийн шүүхэд тус дүүргийн оршин суугч Б нөхөр С-ээс гэрлэлтээ цуцлуулж, хүүхдийн тэтгэлэг тогтоолгох тухай нэхэмжлэл гаргасан. Тэрээр нөхөр С нь Дархан-Уул аймагт өөр эмэгтэйтэй хамт амьдардаг. Б нэхэмжлэлдээ 5 настай охин, 1 настай хүүгийн хамт амьдардаг бөгөөд С-ийн оршин суугаа газрын харъяа шүүхэд нэхэмжлэл гаргахад хүндрэлтэй байгаа тул өөрийн оршин суугаа газрынхаа шүүхэд хандсан тухайгаа бичжээ.

Энэ тохиолдолд:

- Шүүх нэхэмжлэлийг хүлээн авах боломжтой эсэхэд дүгнэлт хийнэ үү?
2. Төв аймгийн сум дундын шүүхэд гэрлэлт цуцлуулах тухай Г-гийн нэхэмжлэлтэй Д-д холбогдох хэргийг хянан хэлэлцээд гэрлэлт цуцлуулах ноцтой шалтгаангүй гэж дүгнээд эвлэрүүлэх 3 сарын хугацаа өгчээ. Уг хугацаанд зохигч эвлэрсэн тул шүүх хэргийг хэрэгсэхгүй болгосон захирамж гаргасан байна.

Энэ тохиолдолд:

- Шүүгчийн ажиллагаанд дүгнэлт хийнэ үү?
 - Шүүгч ямар эрхийн акт гаргах вэ?
3. Иргэн Г гэрлэлт цуцлуулах нэхэмжлэлдээ түүний эхнэр Э сургуульд хамт сурч байсан залуутайгаа гэр бүл болохоор 2 хүүхдийнхээ хамт намайг орхиод явснаас хойш нэг жил өнгөрлөө. Иймд гэрлэлтээ цуцлуулж, 7, 9 настай 2 охиноо өөрийн асрамжиндаа авах шаардлага бүхий нэхэмжлэл гаргасан. Эд хөрөнгийн талаар маргаангүй гэжээ.

Энэ тохиолдолд:

- Шүүх хэргийг хэрхэн шийдвэрлэх вэ?



Даалгавар:

Гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлийн үлгэрчилсэн загварыг үндэслэн гэрлэлтээ цуцлуулахыг хүссэн 3-аас доошгүй хэргийн материалтай танилцан нэхэмжлэл бичих / Нэхэмжлэлийн загварыг хавсаргав./

.....шүүхэд

Гэрлэлт цуцлуулах тухай

Нэхэмжлэгч...../овог, нэр/

Хаяг, холбогдох утас

Хариуцагч/овог, нэр /

Хаяг, холбогдох утас

Би хариуцагчтайоны ...сарынөдөр хууль ёсоор гэрлэлтээ бүртгүүлснээр бидний хооронд гэрлэгчдийн эрх, үүрэг үүссэн билээ. Энэ үеэс эхлэн бид хамт амьдарсан бөгөөд хамтын амьдралын явцад охин, хүү

.....
/хүүхдийн нэр, төрсөн он, сар, өдөр, насыг тодорхой бичнэ/ нарыг төрүүлэн

өсгөж байна. Хамт амьдарсан эхний жилүүдэд бид биедээ халамжтай, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхэд хоёулаа оролцож, бидний амьдрал болж байсан юм. Гэтэл сүүлийн жилүүдэд бид үзэл бодол, зан байдлын хувьд хоорондоо таарч тохирохоо больж, үргэлж маргалдаж хэрэлдэх болсон./ Гэрлэлт цуцлах болсон шалтгаанаа тодорхой заана/

Энэ байдал нь хүүхдүүдийн эрх ашиг, хүмүүжилд муугаар нөлөөлөх болсон учраас цаашид хамт амьдрах ямарч боломжгүй болж байна.

Иймдоны тоот гэрлэлтийн гэрчилгээтэй бидний гэрлэлтийг цуцалж өгнө үү? Би хүү, охиннарыг өөрийнхөө асрамжинд авахыг хүсэж байгаа бөгөөд хүүхдүүддээ хууль заасны дагуу тэтгэлэг гаргуулахыг хүсэж байна.

Гэрлэлтийн явцад бий болсон эд хөрөнгийн талаар маргах зүйлгүй болохыг харгалзан үзнэ үү? /..... эд хөрөнгийн талаар маргаантай тул хуулийн дагуу шийдвэрлэж өгнө үү./

Нэхэмжлэлд хавсаргасан баримт:

1. Гэрлэлтийн гэрчилгээний хуулбар /нотариатаар гэрчлүүлсэн/
2. Хүүхдүүдийн төрсний гэрчилгээний хуулбар /нотариатаар гэрчлэгдсэн/
3. Засаг даргын тодорхойлолт
4. Хүүхдийн эрүүл мэндийн байдлыг илэрхийлсэн өрхийн эмчийн тодорхойлолт
5. Нэхэмжлэгч, хариуцагчийн цалин хөлс, орлогын тодорхойлолт
6. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт
7. Эд хөрөнгийн талаарх нотлох баримт /байрны гэрчилгээ, машин гэх мэт/
8. Дундын эд хөрөнгийн жагсаалт болон үнэлгээ

Нэхэмжлэл гаргасан:

- Оюутнууд багшийн өгсөн гэрлэлт цуцлуулах хэрэг дээр ажиллан мини шүүх хуралдаанд бэлтгэх

**Эх сурвалж:**

- ИХШХШТХ-ийн 125-432-р зүйл/
- Гэр бүлийн тухай хууль 1999 он
- Иргэний хууль 2002 он



ГЭРЛЭЛТ ЦУЦЛАХ ХЭРГИЙГ ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭХ ШҮҮХ ХУРАЛДААН

Сэдвийн зорилго: Шүүхийн журмаар гэрлэлт цуцлах асуудлыг шүүх хуралдаанаар хэрхэн шийдвэрлэх журам, дэг, дарааллыг **мэдэж**, хэргийн нөхцөл байдалд зөв дүгнэлт хийх, нотлох баримтыг дотоод итгэлээрээ үнэлэх, мэтгэлцэх, бие дааж шийдвэр гаргах ур **чадвар** эзэмшинэ.

Сэдвийн агуулга:

- Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай ойлголт
- Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэхдээ анхаарах зүйлс, шүүх хуралдааны дарааллыг зөв ойлгож мэдэх
- Гэр бүлийн үнэт зүйлсийн талаар ойлголт авах



Нэр томъёоны тайлбар

Тэжээн тэтгүүлэх хүн тэжээн тэтгүүлэх эрх үүссэн цагаас хойш хугацаа харгалзахгүйгээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.
/Гэр бүлийн тухай хууль 34.1/

Гэр бүлийн гишүүн гэдэг нь гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл, садангийн хүнийг хэлнэ.

Семинар үндсэн 3 үе шатаас бүрдэнэ.

Тохиолдол шийдэх /хугацаа 60 мин/:

Оюутнууд 4 багт хуваагдан зааврын дагуу тохиолдлыг шийднэ.

1. Дүрд тоглох:

Шүүгч-1

Нэхэмжлэгч

Хариуцагч

1, 2-р баг нэхэмжлэгчийн өмгөөлөгч

3, 4-р баг хариуцагчийн өмгөөлөгч

/Шүүх хуралдааныг ИХШХШТХ-ийн 98-р зүйлээс 115 зүйлд заасан дэг дараалалын дагуу явуулна./

Тохиолдол №1:

Х.Цэцэгээгийн нэхэмжлэлтэй О.Баатарт холбогдох гэрлэлт цуцлуулж, эд хөрөнгө хуваалгах, хүүхдийн тэтгэлэг тогтоолгох тухай иргэний хэргийг шүүх иргэний хэрэг үүсгэн хянан шийдвэрлэсэн. Х.Цэцэгээ, О.Баатар нар нь 1998 оноос хууль ёсоор гэрлэлтээ бүртгүүлсэн бөгөөд цаашид хамтран амьдрах боломжгүй болсон байна. Нэхэмжлэлийн хувийг гардан авсан О.Баатар Х.Цэцэгээгийн гэрлэлт цуцлуулах шаардлагыг хүлээн зөвшөөрч, эд хөрөнгө хуваах, 5 настай охиноо өөрийн асрамжинд авч тэтгэлэг тогооолгох нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөөгүй

байна. Тэрээр 1998 онд гэр бүл болохоосоо өмнө О.Баатар өөрийн хөрөнгөөр хувийн компани байгуулсан ба Улсын бүртгэлд бүртгүүлж өмчлөх эрхийн гэрчилгээгээ авсан. Гэрчилгээн дээр ганцхан О. Баатарын нэр байгаа ба “үүсгэн байгуулагч нь О.Баатар ганц гишүүнтэй компани” гэж бичигдсэн. Компани ашигтай ажиллаад 46 охин компанитай болсон. О.Баатар нэгэн томоохон компанийн хувьцааг гэр бүлийн гишүүд эзэмшдэг нэртэйгээр хөрөнгийн биржээр дамжуулан худалдан авсан.

/1 хүнд 40-60 ш хувьцаа/

Хариуцагч хариу тайлбартаа: Компаниуд гэр бүлийн эд хөрөнгө биш учраас Цэцэгээд компанийн хөрөнгөөс олгох ёсгүй, мөн охиноо өөрийн асрамжинд авна гэсэн тайлбар гаргасан байна.

Хэрэгт холбогдох нотлох баримтууд:

1. Гэрлэлтийн баталгааны хуулбар
2. Гэр бүлийн эд хөрөнгийн жагсаалт
3. Компаниудын улсын бүртгэлийн гэрчилгээ
4. Эд хөрөнгийн үнэлгээ
 - Нэхэмжлэгч болон хариуцагчийн өмгөөлөгчийн байр сууринаас хууль зүйн үндэслэлтэй тайлбар хийх
 - Компаний хөрөнгө гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын өмч мөн эсэх

Тохиолдол №2

Л.Навчаа А.Тогтох нар нь 2001.1.10-ний өдөр гэр бүл болсноо 2002.5.10-нд бүртгүүлж, хамтран амьдрах болсон. Энэ хугацаандаа 2002.1.25-ний өдөр хүү Т.Бадрахыг төрүүлсэн. 2004 онд А.Тогтох нь гэрээсээ явж 3 жил тусдаа амьдрах болсон. А.Тогтох нь өөр хүнтэй хамтын амьдралтай болж, хүүхэдтэй болсон.

Нэхэмжлэгч А. Тогтох нь гэрлэлтээ цуцлуулахыг хүссэн нэхэмжлэл гаргасан.

Хариуцагчийн тайлбар: Бидний таарамжгүй байдлын гол нь А. Тогтохоос өөрөөс нь болсон бөгөөд тэр өөрөө гэрээсээ явснаас хойш бид 3 жил тусдаа байгаа нь үнэн. Энэ хугацаанд хүүгээ асарч, анхаарч байсан зүйл огт байхгүй. Ирээд хүүтэйгээ уулзаач, санаад байна гэхэд ч ирдэггүй байсан. Одоо гэрлэлтээ цуцлуулахад татгалзах зүйлгүй, хүүгээ өөрийнхөө асрамжинд авч, Хүүхдээ харж хандаагүй 3 жилийнх нь тэтгэлэгийг мөн 18 нас хүртэлх хугацаанд олгогдох ёстой тэтгэвэрийг дундажаар бодож бөөнд нь 4 сая 860000 төгрөгийг гаргуулж олгоно уу гэсэн сөрөг нэхэмжлэлийг гаргасан байна.

Энэ тохиолдолд шүүх хэргийг хэрхэн шийдвэрлэх шүүх хуралдааныг дүрээр харуулна уу?

1. Багууд шүүх хуралдааны дэгийг дүрээр үзүүлсний эцэст дараах сэдвээр ярилцлага хийж болно. /хугацаа 20 мин/
 - Гэр бүлийн үнэт зүйл
 - Гэр бүлийн аз жаргал
 - Гэр бүлийн бахархал
 - Гэр бүлийн гишүүдийн эрхэм зүйл



Хяналтын асуулт

1. Гэрлэлт цуцлуулах хэргийг хэлэлцэх шүүх хуралдааны онцлогийг тодорхойлно уу?
2. Гэр бүлийн хуваарьт өмчийг дундын өмчөөс хэрхэн ялгаж үзэх вэ?
3. Хүүхдийн тэтгэлэгийг ямар хувь хэмжээгээр хэрхэн гаргуулах вэ?
4. Гэрлэлт цуцлах хэргийг шүүхээр шийдвэрлүүлэх нэхэмжлэлд тавигдах шаардлагыг тайлбарлана уу?
5. Насанд хүрээгүй хүүхдийг хэний нь асрамжинд үлдээх асуудлыг шүүх шийдвэрлэхдээ анхаарах асуудлуудыг тодорхойлно уу?
6. Хүүхдийн тэтгэврийн хувь хэмжээг тодорхойлж тайлбарлана уу,
7. Гэрлэгсэдийн эд хөрөнгө /түүнтэй холбоотой маргааныг шүүх шийдвэрлэхэд баримтлах Иргэний хуулийн холбогдох заалтыг тайлбарлана уу?
8. Гэрлэлтийг шүүх шууд цуцлах үндэслэлийг хуулийн холбогдох заалтаар тайлбарлана уу?



Даалгавар:

- Гэрлэгчид харилцан бие биеэ, мөн түүнчлэн хүүхдээ тэжээн тэтгэхтэй холбоотой тохиолдол нэг нэгийг зохиож, шийдвэрлэх



Эх сурвалж:

- ИХШХШТХ-ийн 125-132-р зүйл
- Гэр бүлийн тухай хууль 34- 42-р зүйл
- Иргэний хууль 125-127-р зүйл

ХІ БҮЛЭГ. ОНЦГОЙ АЖИЛЛАГААНЫ ЖУРМААР ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

ОНЦГОЙ АЖИЛЛАГААНЫ ЖУРМААР ШИЙДВЭРЛЭГДЭХ ХЭРГҮҮД, ОНЦЛОГ

Сэдвийн зорилго: Онцгой ажиллагааны журмаар шүүх хэргийг шийдвэрлэхдээ баримтлах журам, бусад хэрэг шийдвэрлэх ажиллагаанаас ялгагдах онцлог, ач холбогдлыг ойлгож мэдэх, бусдад энэ асуудлаар эрх зүйн туслалдаа үзүүлэх, хууль хэрэглэх, шийдвэр гаргах, дадал чадвар эзэмших.

Сэдвийн агуулга:

- Хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагааны тухай ойлголт, шийдвэрлэх хэрэг
- Хүсэлт гаргах харъяалал
- Хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагааны журам, онцлог
- Хэрэг тус бүрийн онцлог



Нэр томъёоны тайлбар

ИХШХША-ны нэг төрөл бол хүсэлтээр үүсэх ажиллагаа буюу онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх хэргүүд юм.

Онцгой ажиллагааны журмаар шүүх хэрэг хянан шийдвэрлэх журам, онцдогийг ИХШХШТХ-ийн 133-р зүйлд тодорхойлсон.

Онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх хэргүүд: -ИХШХШТХуулийн 133.1-д заасан хэргүүдийг шүүх онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэнэ. /Энэ тухай бүдүүвчээс харна уу/

Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдал: -Иргэн, Хуулийн этгээдийн эдийн ба эдийн бус баялагтай холбоотой эрх үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болоход шууд хамаарах үйл явдлыг эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдал гэнэ.



Хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагаа гэдэг нь эрх зүйн үйл явдал болон үйлдлийг шүүхээс тогтоох үйл ажиллагаа юм.

Иргэн, хуулийн этгээдээс гаргасан хүсэлтэд үүснэ

Хариуцагч байдаггүй.

Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдал болон иргэний эрх зүйн байдлыг тогтооно.

Шийдвэрлэх хэрэг:

Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоох

Хүнийг сураггүй алга болсонд тооцох буюу нас барсан гэж зарлах

Чадамж хязгаарлах

Хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох

Асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцох

Эрх олгосон бичиг баримтыг үрэгдүүлснээс алдагдсан эрхийг сэргээх

Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд буруу бичигдсэнийг тогтоох

Хэргийн буюу шийдвэр гүйцэтгэлийн үрэгдсэн материалыг сэргээх

Нэхэмжлэгчээс гаргасан хүсэлтийн дагуу хариуцагчийг эрэн сурвалжлах

Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоох:

Иргэн, хуулийн этгээдийн эдийн ба эдийн бус баялагтай холбоотой эрх үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болоход шууд хамаарах үйл явдлыг **эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдал гэнэ.**



Садан, төрлийн холбоо тогтох - Хууль ёсоор өв залгамжлах, тэжээгчээ алдсаны тэтгэвэр, нөхөн олговор авах зэрэг эрх нь үүснэ


Бусдын асрамжинд байгаа эсэхийг тогтоох - Материаллаг тусламжийг нэг иргэн нөгөөдөө үзүүлэхийг ойлгоно.

Төрөлт, үрчлэлт, гэрлэлт, гэрлэлт цуцлалт, нас баралтыг бүртгүүлсэн байдлыг тогтоох - Иргэний гэр бүлийн бүртгэлийн байгууллагад энэ тухай баримт байхгүй, түүнийг гарган өгөхөөс татгалзсан тохиолдолд шүүхээс тогтооно.

Эрх олгосон баримт бичгийн жинхэнэ эзэмшигч мөн эсэхийг тогтоох - Уг баримт бичигт бичигдсэн овог, эцэг эхийн нэр, нэр, төрсөн огноо иргэний үнэмлэх, төрсөний гэрчилгээтэй тохирохгүй байгаа тохиолдолд шүүхээс мөн эсэхийг нь тогтооно.


Осол гэмтэл гарсан эсэхийг тогтоох - үйлдвэрлэлийн осол гэж ажилтан хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн болон түүнтэй адилтгах хүчин зүйлийн нөлөөлөлд өртөхийг хэлнэ.

Хүний ажилалж байсан байдлыг тогооох - Өөрийн оршин суугаа газрын шүүхэд гаргаж, нотлох баримтыг хавсаргана.
Хүүхдийн эцэг эхийг тогтоох - Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, 14 насанд хүрсэн хүүхэд өөрөө, хүүхдийн эрх ашгийг хамгаалдаг байгууллага гаргана.
Хүүхдээ тэжээн тэтгэх - Гэр бүлийн хууль заасан журмаар явагдана.
Тэтгэлгийн хэмжээг өөрчлөн тогтоох - Хөдөлмөрийн чадвар, амьжиргааны түвшин зэргийг харгалзана.
Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус, гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох - Гэрлэлтийн харилцаа дуусгавар болно.
Хүний эд хөрөнгийг эрхлэн хамгаалагчид хариуцуулах - Асран хүмүүжүүлэх байгуулгад шилжсэн хүүхдийн - Асран хүмүүжүүлэгчид шилжсэн хүүхдийн - Нийгмийн халамжийн байгууллагад шилжсэн иргэний
Эцэг эх байх эрхийг хасах, хязгаарлах, сэргээх - Хүүхдийн эрх, ашиг сонирхолыг хамгаалах үүднээс эрх бүхий байгууллагаас хуулийн дагуу авч байгаа арга хэмжээ юм.
Нас тогтоох - Төрсөний гэрчилгээ, иргэний үнэмлэх, бусад баримт бичигт иргэний төрсөн огноо, нас нь тухайн иргэний жинхэнэ төрсөн он сар, өдөртэй зөрж байгаа тохиолдолд түүний насыг тогтооно.






Хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох



Иргэнийг хязгаарлагдмал чадамжтай, эсхүл эрх зүйн чадамжгүй гэж тооцох



Асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцох




Эрх олгосон бичиг баримтыг үрэгдүүлснээс алдагдсан эрхийг сэргээх






Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд буруу бичигдсэнийг тогтооох



Хэргийн буюу шийдвэр гүйцэтгэлийн үрэгдсэн материалыг сэргээх




Нэхэмжлэгчээс гаргасан хүсэлтийн дагуу хариуцагчийг эрэн сурвалжлах

Иргэний эрх зүйн маргаанд хариуцагчаар оролцвол зохих этгээд оршин суугаа газар нь мэдэгдэхгүй бол түүнийг эрэн сурвалжлуулах тухай хүсэлтийг хүсэлт гаргагч өөрийн оршин суугаа газрын шүүхэд гаргана.

Хариуцагчийг эрэн сурвалжлах шаардлага бий болсон тохиолдол нь иргэний хэрэг үүсгэж, түүнийг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж байх явцад үүснэ.

Хүсэлтэд хариуцагчийн овог, нэр, хаана, ямар газарт хэзээ оршин сууж байсан, иргэний эрх зүйн маргаанд ямар учраас хариуцагчаар оролцвол зохих болсон, зэргийг тусгана.

Шүүх хүсэлтийг хянаад эрэн сурвалжлах тухай шийдвэр гаргана. Шийдвэрт хариуцагчаар оролцвол зохих этгээдийг эрэн сурвалжлах ажиллагааг цагдаагийн байгууллагад даалгана.

Хэрэг хянан шийдвэрлэх онцгой шийдвэрлэх онцгой ажиллагааны журам:

Хүсэлт гаргасан этгээдийн хүсэлтийн дагуу онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотойгоор өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөдөгдөнө гэж үзсэн иргэн, хуулийн этгээд нь хэрэгт гуравдагч этгээдээр оролцож болно.

**Хяналтын асуулт**

1. Хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагааны гол ялгаа нь юу вэ?
2. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагааны үед сөрөг нэхэмжлэл гаргах, оалуудыг сонгох, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагаас татгалзах хүлээн зөвшөөрөх, эвлэрэн хэлэлцэх зэрэг ажиллагаа хийгдэх үү?
3. Шүүх онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэдэг хэргүүдийн төрлийг нэрлэнэ үү?
4. Хүсэлт гаргагч, хүсэлт гаргах харъяалалын талаарх ойлголтоо тодруулж, эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоолгох, сураггүй алга болсонд тооцуулах, нас барсан гэж зарлуулах тухай хүсэлтүүдийг шүүхэд гаргах харъяалалыг тус бүр тодорхойлно уу?
5. Иргэнийг хязгаарлагдмал чадамжтайд тооцох, эрх зүйн бүрэн чадамжгүйд тооцох тухай хүсэлтийг хэнээс ямар харъяаллаар гаргах вэ? Шүүх энэ асуудлыг шийдвэрлэхдээ юуг үндэслэл болгох вэ?
6. Хүүхэд үрчилснийг хүчингүйд оооцуулах хүсэлтийг ямар харъяалалаар гаргах вэ? Шүүх уг асуудлыг хэрхэн шийдвэрлэх журмыг тайлбарлана уу?



Сорил

1. Онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шүүгч
 - а. Дангаараа шийдвэрлэнэ
 - б. 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй
 - в. 3 шүүгч, иргэдийн төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй шийдвэрлэнэ
2. Онцгой ажиллагааны журмаар хэргийг шийдвэрлэхэд :
 - а. Заавал шүүх хуралдаанаар хэргийг шийдвэрлэх шаардлагагүй
 - б. Хэргийг заавал шүүх хуралдаанаар шийдвэрлэх шаардлагатай
 - в. Хариуцагч хүсэлтийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд шүүх хуралдаанаар хэргийг хэлэлцэх шаардлагагүй
3. Онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх хэргийг шүүх ямар хугацаанд шийдвэрлэх вэ?
 - а. 60 хоногт багтаан
 - б. 30 хоногийн дотор
 - в. Ердийн журмаар шийдвэрлэнэ.
4. Дараахаас аль нь эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдалд хамаарах вэ?
 - а. Садан төрлийн холбоо тогтоолгох
 - б. Эрх зүйн чадамжгүйд тооцуулах
 - в. Сураггүй алга болсонд тооцуулах
5. Онцгой ажиллагааны журмаар шүүх хэргийг шийдвэрлэхэд мэтгэлцэх зарчим хэрэгжих үү?
 - а. Хэрэгжинэ
 - б. Хэрэгжихгүй
 - в. Зарим тохиолдолд хэрэгжинэ. /Хариуцагч оролцох тохиолдолд/



Бодлого

1. Сэлэнгэ аймгийн Модны үйлдвэрт 1979-1982он хүртэл ажиллаж байсан иргэн Ц тэтгэвэрт гарахад хэрэгтэй байсан учраас ажиллаж байснаа тогтоолгохоор одоо өөрийн оршин сууж буй СХД-ийн шүүхэд хандахад шүүх хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэхээс татгалзсан байна.
Энэ тохиолдолд:
 - Шүүхийн татгалзлал үндэслэлтэй эсэх?
 - Хүсэлтийг аль шүүх шийдвэрлэж болох вэ?
2. 5 жилийн хорих ял шийтгүүлсэн хоригдол эмэгтэй Ч өөрийн 5 настай хүүгээ бусдад үрчлүүлснийг хүчингүй болгуулахаар хүсэлт гаргах болсон.
Энэ тохиолдолд:
 - Хүсэлтээ ямар шүүхэд хандаж гаргах вэ?

- Энэ нь онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх иргэний хэрэгт хамаарах уу?

3. Иргэн Д С-д 1 жилийн өмнө 3000000 төгрөг 3 сарын хугацаатай сарын 3.5% хүүтэйгээр зээлдүүлсэн байна. С зээлсэн мөнгөө өгөлгүй хугацаа хэтэрсэнд Д хаягаар очиж мөнгөө нэхэх гэтэл уг хаягандаа байдаггүй болох нь тогтоогдсон. Д шүүхэд С-ийг эрэн сурвалжлуулахаар хүсэлт гаргасан . Шүүх хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх үү?

- Энэ нь онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх хэрэг мөн үү?

**Даалгавар:**

- Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдал тус бүр дээр бодлого зохиох
- Хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагааны талаар бүдүүвч бэлтгэх

**Эх сурвалж:**

1. ИХШХШТХ-ийн 133-155-р зүйл
2. Шүүгчийн гарын авлага 2004 он
3. ИХШХШЭЗ сурах бичиг 2006 он



ЭРХ ЗҮЙН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ҮЙЛ ЯВДЛЫГ ШҮҮХЭЭС ТОГТООХ, БУСАД ХЭРГҮҮДЭЭС ЯЛГАГДАХ ОНЦЛОГ

Сэдвийн зорилго: Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдалд ямар үйл явдлууд хамаардаг болох, түүнийг шүүхээр сэргээлгэх шаардлага, ач холбогдлыг **ойлгож мэдэх**, шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэх онцлог, журмыг бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай харьцуулан дүгнэх, цаашдаа уг асуудлаар шийдвэр гаргах, дүгнэлт хийх, эрх зүйн туслалцаа үзүүлэх **чадвар эзэмшихэд** оршино.

Сэдвийн агуулга:

- Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлын тухай ойлголт
- Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг шүүхээр тогтоолгох хэргийн төрлүүд
- Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоолгох хүсэлт, түүнийг гаргах шүүхийн харъяалал
- Хүсэлтийг шүүх хүлээн авахаас татгалзах үндэслэл, журам
- Хүсэлтийг хянан шийдвэрлэх ажиллагаа, онцлог
- Шүүхээс гарах шийдвэр, хүсэлтийг хангах, хангахаас татгалзах /
- Хэргийг шүүхээр шийдвэрлүүлсний ач холбогдол, үр дагавар, бусад хэргээс ялгагдах тал
- Хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагааны талаархи ойлголт
- Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдалын талаархи ойлголт, ялгааг зөв тодорхойлох



Нэр томъёоны тайлбар

/Өмнөх сэдвээс нэр томъёог тодруулж харна уу/

Онцгой ажиллагааны журмаар шүүх хянан шийдвэрлэх хэргийг бусад хууль болон энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол энэ хуулиар тогтоосон ерөнхий журмын дагуу шийдвэрлэнэ.

Семинар 4 үе шатаас бүрдэнэ.

1. “Аригранг” /хугацаа 30 мин/

Оюутнууд 3 багт хуваагдан онооны түвшинтэй асуултанд хариулна. Зөв хариулсан баг 18 асуулттай 2, 4, 6 гэсэн оноотой асуултаас сонгоно. Зөв хариулбал 0.5 оноогоо авна. Буруу хариулбал 0.5 оноогоо алдана.

2 онооны асуулт

1. **Онцгой ажиллагаа нь эрх зүйн ямар нэгэн**
а. Маргаантай байдаг б. Маргаангүй байдаг
2. **Онцгой ажиллагаа нь үндэслэнэ.**
а. Хүсэлт б. Гомдол в. Тайлбар г. Санал
3. **Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдал гэдэг нь**
а. Эдийн болон эдийн бус баялагтай холбоотой хууль зүйн факт бий болоход шууд хамаарах үйл явдал юм.
б. Тухайн субъектийн хууль ёсны эрх ,ашиг нь зөрчигдсөн бөгөөд түүнийгээ сэргээлгэхийг хүссэн үйл явдал юм.
в. Ажиллаж байсан явдлаа тогтоолгохыг хүссэн үйл явдал.
4. **Үрэгдсэн баримт бичгийг сэргээх боломжгүй тохиолдолд түүнийг**
а. Шинээр олгоно б. ИББ шийднэ в. Шүүх шийднэ
5. **Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийн зээ нь өөрийгөө түүнтэй садан төрлийн холбоотой гэдгийг тогтоолгохоор хүсэлт гаргажээ. Энэ нь**
а. Урьдчилсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
б. Захиргааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
в. Онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

4 онооны асуулт

1. **Шүүх гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж шийдсэн нь**
а. Захиргааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
б. Онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
в. Урьдчилсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
2. **Хорих ял эдэлж байгаа А нь эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоолгож өгөх тухай хүсэлт гаргах**
а. Эрхтэй б. Эрхгүй
3. **ИЭЗ-н чадамжийг хязгаарлуулах тухай хүсэлтийг дараах субъектүүдээс хэн нь гаргах эрхтэй вэ?**
а. ИТХ б. Байгууллагын дарга в. Нийгмийн ажилтан
4. **ИЭЗ-н чадамжийг хязгаарлуулах тухай хүсэлтийг дараах субъектүүдээс хэн нь гаргах эрхгүй вэ?**
а. Засаг дарга в. Гэр бүлийн гишүүн
б. ЭМБ г. Зөв хариулт алга
5. **14 насанд хүрсэн хүүхэд үрчлэлтээ хүчингүйд тооцуулах тухай хүсэлт гаргах эрхтэй юу?**
а. Эрхтэй
б. Эрхгүй
в. Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан гаргах эрхтэй
г. Харгалзан дэмжигчийн зөвшөөрлөөрөө гаргах эрхтэй



6. Хариуцагчийн эрэн сурвалжлах шаардлага бий болсон нь хариуцагчийг эрэн сурвалжилахаас ялгаатай ойлголт уу?

- а. Үгүй нэг ижил ойлголт
- б. Тийм /Хариуцагчийг эрэн сурвалжлах шаардлага бий болсон нь иргэний хэрэг үүсгэж, хянан шийдвэрлэх явцад гарна./

6 онооны асуулт

1. Онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэж байгаа явдал нь ИЭЗ-н хамгаалалт мөн үү?

- а. Тийм
- б. Үгүй
- в. Зарим тохиолдолд

2. А нь АНУ-руу явахаар болжээ. Түүний иргэний үнэмлэх дээр эцгийнх нь нэрийг Шидэнсүх гэж бичсэн байтал гадаад паспортон дээр нь Чидэнсүх гэж бичсэн байв.

- А-д хууль зүйн туслалцаа үзүүл

3. Хэргийг БЗД-ийн шүүх шийдвэрлэжээ. Шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэлийг СХД-т явуулжээ. Хэргийн материалыг сэргээх шаардлагатай бол аль шүүхэд хүсэлт гаргах?

- а. СХД
- б. БЗД
- в. УДШ
- г. Хүсэлт гаргагчийн сонгосон шүүх

4. А нь ҮХЭХ өмчлөгчийнхөө эрхийн гэрчилгээг алдсан байна. Тэрээр шүүхэд үрэгдсэн баримт бичгийг устгагдсанд тооцож алдагдсан эрхийг сэргээхийг хүссэн хүсэлт гаргажээ. Шүүх хүсэлтийг хүлээн авахаас татгалзсан нь хууль зүйн үндэслэлтэй юу?

5. Хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллаж байснаа тогтоолгож болох уу?

- а. Болно
- б. Болохгүй
- в. Онцгой ажиллагааны журмаар хэргийг хянан шийдвэрлэж болохгүй бусад шүүхийн ажиллагаагаар болно

2. Дуудлага худалдаа /хугацаа 40 мин/

/Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдал тогтоох/

Багш дуудлага худалдаанд 5 асуулт оруулна. Багууд үнэ хаялцан хариултыг авна.

1. Хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагаанд гуравдагч этгээд

- а. Заавал оролцоно
- б. Зайлшгүй тохиолдолд оролцоно
- в. Шаардлагагүй

2. Хэргийн буюу шийдвэр гүйцэтгэлийн материалыг сэргээх талаар нотлох баримт хангалтгүй бавал шүүх хэргийг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд

- а. Нотлох баримтаа бүрдүүлж дахин гаргаж болно
- б. Дахин шүүхэд хандах эрхгүй
- в. Шүүх /шүүгч/ шийдвэртээ хугацаа заан тусгасан тохиолдолд хэргийг дахин хянан хэлэлцэнэ

3. Хэргийн буюу шийдвэр гүйцэтгэлийн материал үрэгдсэн байвал шүүх санаачилгаараа түүнийг бүрэн буюу хэсгийг сэргээж
 - а. Болно
 - б. Болохгүй
 - в. Хэргийн оролцогч санал гаргавал
4. Онцгой ажиллагааны журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шийдвэрт гомдол гаргаж болох уу
 - а. Болно
 - б. Болохгүй
 - в. Зарим хэрэгт /сөрөг нэхэмжлэл гаргах, талуудыг сонгох/
5. Хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагаа нь материаллаг эрх зөрчигдсөнтэй холбоотой
 - а. Байдаг
 - б. Байдаггүй



Сорил

1. Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтооход хамаарахгүйг нь олно уу?
 - а. Осол гэмтэл гарсан эсэх
 - б. Хүүхдээ тэжээн тэтгэх
 - в. Хүнийг сураггүй алга болсонд тосцох буюу нас барсан гэж зарлах
 - г. Нас тогтоох
2. Иргэнийг сураггүй алга болсонд тооцуулах буюу нас барсан гэж зарлуулах тухай хүсэлт хүлээн авсан шүүгчийн нэн тэргүүнд хийх ажиллагаа:
 - а. Мэдээлэл цуглуулах
 - б. Нотлох баримтыг үнэлэх
 - в. Эд хөрөнгөд эрхлэн хамгаалалт тогтоох
3. Хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцуулах тухай хүсэлтийг шүүхэд гаргана.
 - а. Үрчлэгчийн оршин суугаа газрын шүүхэд
 - б. Хүүхдийн оршин суугаа газрын шүүхэд
 - в. Нэхэмжлэгчийн оршин суугаа газрын шүүхэд
4. Хувийн компанид хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байснаа тогтоолгож болох уу?
 - а. ТБд ажиллаж байсан тохиолдолд болно
 - б. Болохгүй
 - в. Болно
5. Асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцуулах тухай хүсэлтийг шүүхэд гаргана.
 - а. Нэхэмжлэгчийн оршин суугаа газрын шүүхэд
 - б. Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн оршин суугаа газрын шүүхэд
 - в. Асран хамгаалуулагч, харгалзан дэмжүүлэгчийн оршин суугаа газрын шүүхэд



Хяналтын асуулт

1. Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдал гэдгийг тодорхойлж, үүнд хамаарах шүүхээр шийдвэрлэгддэг үйл явдлуудыг нэрлэж тайлбарлана уу?
2. Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явлыг тогтоолгох тухай хүсэлт бичиж, харъяалалыг тодорхойлно уу?
3. Бусад төрлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас ялгагдах онцлогийг тайлбарлана уу?
4. Өгөгдсөн тус бүр нэг тохиолдлыг багууд хуулийн дагуу шийдвэрлэж, үндэслэлээ тайлбарлана уу?
5. Хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагаа явуулж өгөх талаар хэн хүсалт гаргах вэ?



Даалгавар:

- Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдал хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог тус бүрийг схем хийж ойлгох
- Тус бүр дээр нэг нэг жишээ олж тайлбарла



Эх сурвалж:

- ИХШХШТХ-н 133-155-р зүйл

ХИ БҮЛЭГ. ГОМДЛООР ҮҮСЭХ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

ГОМДЛООР ҮҮСДЭГ ХЭРГИЙН ОНЦЛОГ, ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

Сэдвийн зорилго: Гомдол гаргах журам, гомдолд тавигдах шаардлага, гомдлыг шүүх хүлээн авч, хянан шийдвэрлэх журам, шүүх хуралдааны онцлогийг **ойлгож мэдэх**, гомдлыг шүүх хэрхэн шийдвэрлэсэн шийдвэрт хууль зүйн үүднээс дүгнэлт хийх, бусдын зөрчигдсөн эрхийг сэргээхэд эрх зүйн туслалцаа үзүүлэх **чадвар эзэмших**.

Сэдвийн агуулга:

- Шүүхэд гомдлоор авч хэлэлцэх хэргүүд, захиргааны шүүхээс ялгаж үзэх нь
- Гомдолд дурьдах зүйл, гомдол гаргах харъяалал,
- Урьдчилан шийдвэрлүүлэх журам
- Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгч, прокурорын хууль зөрчсөн ажиллагаа, түүнээс учирсан хохирлыг нөхөн төлүүлэх талаарх гомдол, түүнийг шүүх шийдвэрлэх ажиллагааны онцлог
- Тендэрийн хорооны шийдвэр, үйл ажиллгааны талаарх гомдлыг шүүх шийдвэрлэх журам
- Бусад гомдол, гомдлыг шүүх хянан шийдвэрлэх ажиллагаа
- Шүүхээс гарах шийдвэр, түүний агуулга



Нэр томъёоны тайлбар

Гомдол гэдэг нь төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлтийг хэлнэ.

Гомдол гаргах эрх: - Захиргааны болон аж ахуйн нэгжийн албан тушаалтаны буруутай үйл ажиллагаанаас бож эрх, ашиг сонирхол нь зөрчигдсөн иргэн, хуулийн этгээд гомдол гаргах эрхтэй.

Гомдол гаргах харъяалал: - Хуулиар өөр харъяалал тогтоогоогүй бол шийдвэр гаргасан буюу үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгж байгууллага, тэдгээрийн албан тушаалтаны оршин байгаа газрын шүүхэд гомдлоо гаргана.



- **Гомдолын агуулга, хэлбэр түүнийг гаргах**

Гомдолд дараах зүйлийн тусгана.

- ямар аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн албан тушаалтаны шийдвэр, үйл ажиллагаанд гомдол гаргаж байгаа
- тухайн шийдвэр үйл ажиллагаа нь ямар хууль тогтоомжид харшилж байгаа, түүнийг хууль бус гэж үзсэн үндэслэл нотолгоог заана.

Гомдолд тавигдах шаардлага:

- Гомдлыг шүүхээс гадуур урьдчилсан шийдвэрлүүлэхээр хуульд заасан бол уг шаардлагыг хангасан нөхцөлд шүүх хүлээн авч хэлэлцэнэ.
- Гомдлыг бичгээр гаргана.
- Гомдолд гомдол гаргагчийн хаяг тодорхой байх ёстой.

Шүүх дараахь хэргийг гомдлоор авч хэлэлцэнэ:

Төрийн захиргаа, шүүх, прокурор, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон бусад аж ахуйн нэгж, байгууллага тэдгээрийн албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуульд заасны дагуу тендерийн хорооны шийдвэр, үйл ажиллагаа

Гомдлыг хянан хэлэлцэх ажиллагааны журам

Хэргийг хэлэлцэхдээ шүүх гомдол гаргагч болон холбогдох аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөгчийг оролцуулна.



Гомдол гаргагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй бол гомдлыг буцаах тухай шүүгчийн захирамж гаргана.

Шүүх



Шүүх аж ахуйн нэгж, байгууллага тэдгээрийн албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа хуульд нийцэж буй эсэх, шийдвэрийг эрх бүхий этгээд гаргасан, гомдол үндэслэлтэй эсэхийг тогтооно.

Шийдвэр гаргана



• Шүүхээс гарах шийдвэр түүний агуулга:

Шүүх нь гомдлыг хэлэлцээд байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа хуульд нийцэж буй эсэх, шийдвэрийг зохих эрх бүхий этгээд гаргасан эсэх, гомдол үндэслэлтэй эсэхийг тогтоон шийдвэр гаргана.

Шийдвэрийн агуулга:

Байгууллага, аж ахуйн нэгж, тэдгээрийн шийдвэр үйл ажиллагааг хүчингүй болгох

Тодорхой үйл ажиллагаа явуулахыг үүрэг болгох

Шийдвэр үйл ажиллагаанаас учирсан хохирлыг гомдол гаргагчид нөхөн олгох

Гомдлыг хэргэсэхгүй болгох

Шүүхийн шийдвэрийг байгууллага, албан тушаалтан заавал биелүүлнэ.

**Хяналтын асуулт**

1. Иргэний хэргийн журмаар шүүхэд шийдвэрлэгддэг гомдлоор авч хэлэлцэх хэргүүд, түүнийг захиргааны хэргийн шүүхийн харъяалалаас ялгаж ойлгох талаар ярилцаж тайлбарлана уу?
2. Гомдол нь нэхэмжлэл болон хүсэлтээс ялгагдах ялгаа, онцлогийг тайлбарлана уу?
3. Хуулиар тодорхойлсон гомдлын 3 төрөл тус бүр дээр нэг, нэг жишээ гаргаж тохиолдол зохионо уу? /3 багаар ажиллана./
4. Багууд тохиолдолоо харилцан солилцож шүүх гомдлыг хэрхэн шийдвэрлэхийг хэлэлцээд шийдвэр гаргана уу?
5. Гомдлоор авч хэлэлцэх хэрэг нь захиргааны хэргийн шүүхийн авч хэлэлцэх хэргээс юугаараа ялгаатай вэ?
6. Гомдлоор авч хэлэлцэх хэргийг шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэж болох уу? үндэслэл.



Сорил

1. Төрийн захиргааны байгууллагад ажилладаг байсан С ажлаас үндэслэлгүй халагдсан тухай гомдлыг аль шүүхэд хандаж гаргах
 - а. Иргэний шүүхэд
 - б. Захиргааны хэргийн шүүхэд
 - в. Аль ч шүүхэд гаргаж болно
2. Гомдлоор авч хэлэлцэх хэрэгт Улсын тэмдэгтийн хураамж төлөх үү?
 - а. Төлнө
 - б. Чөлөөлөгдөнө
 - в. 250 төгрөгний хураамж төлдөг
3. Гомдлыг ямар харъяалалаар гаргах вэ?
 - а. Гомдол гаргагч өөрийн оршин суугаа газрын харъяа шүүхэд
 - б. Эрхийг нь зөрчсөн гэж үзэж буй байгууллага, албан тушаалтаны оршин байгаа газрын шүүхэд
 - в. Захиргааны хэргийн шүүхэд
4. Гомдлоор авч хэлэлцэх хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд дараах зүйлийн аль нь хамаарах вэ?
 - а. Гомдол гаргагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй нь хэргийг хэлэлцэхэд саад болохгүй
 - б. Гомдол гаргагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол гомдлыг буцаана
 - в. Гомдол гаргагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол гомдлыг хэрэгсэхгүй болгоно.
 - г. Гомдол гаргагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол хариуцагчийн хүсэлтээр шүүх хуралдаанаар хэлэлцэнэ.
5. Хариуцагч шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол:
 - а. Ирээгүй явдал нь хэрэг хэлэлцэхэд саад болохгүй
 - б. Хойшлуулна
 - в. Заавал байлцуулна



Бодлого

1. Булган аймгийн Хялганат хорооны сургуулийн барилга бариулах тендерийг аймгийн боловсролын газраас зарласан ба тендерийн хорооны шийдвэрт тендерт оролцсон С компани гомдол гаргасан байна.
Энэ тохиолдолд:
 - Энэ нь гомдлоор авч хэлэлцэх хэрэгт хамаарах уу?

2. Хүний амь санаатайгаар бүрэлгэсэн хэрэгт иргэн Л сэжиглэгдэж 1 жил 3 сар хоригдсон боловч уг хэргийг хийгээгүй гэдгээ хүлээн мэдүүлсээр байсан. Гэтэл тухайн хэргийг зэргэлдээх сумын М гэгч үйлдсэн болохоо хүлээсэн тул Л олон жил сараар цагдан хоригдож хийгээгүй хэргийг хүлээлгэх гэсэн мөрдөн байцаагчийн буруутай ажиллагаанд гомдол гаргаж шүүхэд хандаж 12 сая төгрөг нэхэмжилсэн байна.

Энэ тохиолдолд:

- Гомдлоор авч хэлэлцэх хэрэгт хамааруулан хэргийг шийдвэрлэх үү?

3. Завхан аймгийн Тосонцэнгэл сумын их эмч Э нь 1 нас 2 сартай нялх хүүхэдтэй байхад шөнийн цагаар дуудлаганд явуулж албан хүчээр ажиллуулдаг гэж эмнэлэгийн даргынхаа шийдвэрийг эсэргүүцэж шүүхэд гомдол гаргажээ.

Энэ тохиолдолд:

- Гомдлыг шүүх хүлээн авч шийдвэрлэх үндэслэлтэй юу?
- Гомдлыг хэрхэн шийдвэрлэх вэ?



Даалгавар:

- Оюутнууд 3 хэсэгт хуваагдан гомдолоор авч хэлэлцэх хэргийн төрлөөр тус тус гомдол бичих
- Шүүх шийдвэрлэхээр хуульд заасан бусад гомдлын талаар мэдэх



Эх сурвалж:

- ИХШХШТХ-ийн 156 -160-р зүйл



ХИШ БҮЛЭГ. ШИНЭЭР ИЛЭРСЭН НӨХЦӨЛ БАЙДЛЫН УЛМААС ХЭРГИЙГ ДАХИН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

ШИНЭЭР ИЛЭРСЭН НӨХЦӨЛ БАЙДЛЫН УЛМААС ХЭРГИЙГ СЭРГЭЭЖ, ДАХИН ХЯНАН ХЭЛЭЛЦЭХ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ

Сэдвийн зорилго: Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг сэргээлгэх хүсэлт түүнийг гаргах харъяалал, шинэ илэрсэн нөхцөл байдалд хамаарах үндэслэлүүд, шүүхээр хүсэлтийг хянан шийдвэрлэх журам, шүүхээс гарах шийдвэрийн талаар ойлголт мэдлэгийг олж авч, уг асуудлаар шүүхэд хандаж эрх зүйн туслалцаа үзүүлэх, шүүхээс гарсан шийдвэрт эрх зүйн дүгнэлт хийх чадвар эзэмших.

Сэдвийн агуулга:

- Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг хянах үндэслэл
- Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах шүүхийн ажиллагаа
- Шүүхээс гарах тогтоол, түүний төрөл



Нэр томъёоны тайлбар

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах хүсэлт гаргах эрхтэй этгээд - Энэхүү хүсэлтийг зохигч, гуравдагч этгээд болон тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч гаргах эрхтэй. Шүүхийн шийдвэрт давж заалдах болон хяналтын гомдол гаргах эрхтэй этгээдүүд шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах хүсэлт гаргана.

Биелэгдсэн шийдвэр, түүнийг цуцлах - Энэ нь гэдэг нь шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах хүсэлтийг шүүх хангасан тохиолдолд хүчингүй болсон шүүхийн шийдвэрээр шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн болон төлбөр төлөгч сайн дурын үндсэн дээр уг шүүхийн шийдвэр бүрэн буюу зарим хэсэг нь биелэгдсэн байхыг ойлгоно.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах хүсэлтийг хангасан бол уг шийдвэрээр биелэгдсэн шийдвэрийг цуцлах тухай асуудлыг тухайн хэргийг анх хянан шийдвэрлэсэн шүүхээр шийдвэрлүүлэхээр шилжүүлнэ.

Хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гэдэг нь анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах болон хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн магадлал, тогтоол, хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамжийг хэлнэ.

Биелэгдсэн шийдвэр гэдэг нь шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах хүсэлтийг шүүх хангасан тохиолдолд хүчингүй болсон шүүхийн шийдвэрээр шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн болон төлбөр төлөгч сайн дурын үндсэн дээр уг шүүхийн шийдвэр бүрэн буюу хагас гүйцэтгэгдсэнийг хэлнэ.

Дараахь үндэслэл байвал шинээр илэрсэн нөхцөл байдал гэж үзнэ.

Шүүхийн шийдвэр гарах үед хэргийн оролцогчид мэдэгдээгүй буюу мэдэгдэх боломжгүй байсан нотлох баримт илэрвэл

Шүүхийн шийдвэр гаргах үндэслэл болсон нотлох баримт хуурамч, эсхүл шүүгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, гэрч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, хэргийн оролцогчийн уг хэргийг хянан шийдвэрлэх үед гаргасан үйлдэл /эс үйлдэхүй/ эрүүгийн гэмт хэрэг болох нь шүүхийн хуулийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор тогтоогдсон

Шүүхийн шийдвэр гарах үндэслэл болсон шүүхийн шийтгэх тогтоол буюу шийдвэр, эсхүл төр, захиргааны болон бусад байгууллагын шийдвэр нь хууль бус байсны улмаас хүчингүй болсон

Гомдол гаргах эрхтэй субъект

Хэргийн оролцогч

Хамгийн сүүлд шийдвэр гаргасан шүүх

Хүсэлтийг хянах үндэслэл байгааг мэдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдол гаргана

Хүсэлт.



Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах шүүхийн ажиллагаа:

Шүүхийн шийдвэрийг хамгийн сүүлд шийдвэрлэсэн шүүх шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай хүсэлтийг хэлэлцэнэ.

Шүүх хуралдаанаар зөвхөн шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах хүсэлтийг хэлэлцэнэ.

Хүсэлт гаргасан этгээд шүүх хуралдаанд оролцохыг хүсвэл түүнд мэдэгдэх байхгүй хүсэлт гаргасан этгээд хүрэлцэн ирээгүй явдал хүсэлтийг шийдвэрлэхэд саад болохгүй.

Шүүх хуралдаанаар шинээр илэрсэн нөхцөл байдлыг баталж байгаа шинэ нотлох баримтыг үндэслэн шинээр илэрсэн нөхцөл байдлыг тогтоох, уг нөхцөл байдал нь шийдвэрийг гаргахад хэрхэн нөлөөлсөн, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг дахин хянан шийдвэрлэх хууль ёсны үндэслэл байгаа эсэхийг шийдвэрлэнэ.

Шүүхээс гарах тогтоол, түүний төрөл:

Бүх шатны шүүх шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах хүсэлтийг хэлэлцээд тогтоол гаргана.

- Хүсэлтийг хангах боломжгүй гэж дүгнэсэн бол уг хүсэлтийг хангахаас татгалзаж, хэргийг анхан шатны шүүхэд буцаана.
- Хүсэлтийг хангасан тохиолдолд шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр, магадлал, тогтоол, захирамжийг хүчингүй болгож, анхан шатны шүүхэд ердийн журмаар хэлэлцүүлэхээр үүрэг болгон буцаана



Хяналтын асуулт

1. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг сэргээх үндэслэлүүдийг нэрлэнэ үү?
2. Шинээр илэрсэн нөхцөл байдлын талаарх хүсэлтийг хаана ямар хугацаанд гаргах вэ?
3. Тухайн шатны шүүх гэдгийг тайлбарлана уу?
4. Хэргийг шүүх шийдвэрлэх үед мэдэгдээгүй буюу мэдэгдэх боломжгүй нөхцөл байдалд хамаарах жишээ хэлнэ үү?
5. Хуурамч нотлох баримтыг тогтооход юуг үндэслэл болгох ёстой вэ?
6. ШИНБУлмаас хэргийг дахин хэлэлцэх шүүх хуралдааны журам, онцлогийг тайлбарлана уу?
7. Шүүхээс гарах шийдвэр түүний агуулгыг тодорхойлно уу
8. Хүсэлт гаргах үндэслэл, хугацаа
9. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах шүүхийн ажиллагааны онцлог

**Даалгавар:**

- Оюутан бүр шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг дахин хянуулах тухай хүсэлтийг бичих
- Үндэслэл тус бүр дээр 3 жишээ зохиох

**Эх сурвалж:**

- ИХШХШТХ-ийн 179-182-р зүйл

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хэлэлцэх

Сэдвийн зорилго: Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг сэргээлгэх хүсэлттүүнийг гаргах харъяалал, шинэ илэрсэн нөхцөл байдалд хамаарах үндэслэлүүд, шүүхээр хүсэлтийг хянан шийдвэрлэх журам, шүүхээс гарах шийдвэрийн талаар ойлголт мэдлэгийг олж авч, уг асуудлаар шүүхэд хандаж эрх зүйн туслалцаа үзүүлэх, шүүхээс гарсан шийдвэрт эрх зүйн дүгнэлт хийх чадвар эзэмших.

Сэдвийн агуулга:

- Шинээр илэрсэн нөхцөл байдлын талаар ерөнхий ойлголт
- Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хэлэлцэх журам

**Нэр томъёоны тайлбар****Шинээр илэрсэн нөхцөл байдал гэдэгт дараах зүйлийг ойлгоно:**

- шүүхийн шийдвэр гарах үед хэргийн оролцогчид мэдэгдээгүй буюу мэдэгдэх боломжгүй байсан нотлох баримт илэрвэл;
- шүүхийн шийдвэр гаргах үндэслэл болсон нотлох баримт хуурамч, эсхүл шүүгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, гэрч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, хэргийн оролцогчийн уг хэргийг хянан шийдвэрлэх үед гаргасан үйлдэл /эс үйлдэхүй/ эрүүгийн гэмт хэрэг болох нь шүүхийн хуулийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор тогтоогдсон;
- шүүхийн шийдвэр гарах үндэслэл болсон шүүхийн шийтгэх тогтоол буюу шийдвэр, эсхүл төр, захиргааны болон бусад байгууллагын шийдвэр нь хууль бус байсны улмаас хүчингүй болсон.



1. Оюутнууд 4 багт хуваагдан “Айл хэсэх” аргаар бусаддаа мэдээлэл өгнө.
/хугацаа 40 мин /

- Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянах үндэслэл
- Шийдвэрийг хянуулах тухай хүсэлт гаргах
- Хүсэлтийг шийдвэрлэх
- Биелэгдсэн шийдвэрийг цуцлах

2. Хэрэг шийдвэрлэх: /хугацаа 40мин/

1-р баг шүүхийн шийдвэр дээр дүгнэлт хийх

2-р баг шүүхийн шийдвэр дээр дүгнэлт хийх

3-р баг өөрсдөө тохиолдол зохиож, түүнийгээ шийдэх

/шинээр илэрсэн нөхцөл байдалтай холбоотой/

4-р баг баг өөрсдөө тохиолдол зохиож, түүнийгээ шийдэх

/шинээр илэрсэн нөхцөл байдалтай холбоотой/



Хяналтын асуулт

- Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хэлэлцэхийн ач холбогдол
- Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хэлэлцэхдээ анхаарах зүйл



Сорил

- 1. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг хянан үзэх үндэслэл**
а. Гомдол б. Тогтоол в. Тушаал г. Дүгнэлт
- 2. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг хянуулах тухай хүсэлт гаргах хугацаа**
а. 30 хон б. 14 хон в. 10 хон г. 1 жил
- 3. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг хянуулах тухай хүсэлтийг хаана гаргах вэ?**
а. Анхан шаоны шүүх
б. Давж заалдах шатны шүүх
в. Тухайн шатны шүүх
г. Хяналтын шатны шүүх д. Аль нь ч биш
- 4. Шүүх хэргийг хянан шийдвэрлээд шинээр илэрсэн нөхцөл байдал гэж үзсэн тохиолдолд хэргийг**
а. Хүчингүй болгоно
б. Анхан шатны шүүхэд хэргийг буцаана
- 5. Шүүх шинээр илэрсэн нөхцөл байдлыг тогтоохдоо үндэслэх зүйл**
а. Шүүхийн шийдвэр
б. Хүсэлт в. Нотлох баримт



Сорил

1. Хан-Уул дүүргийн шүүх “Санчир” ХХК-ний нэхэмжлэлээр тус компаний харъяа хүнсний дэлгүүрийн худалдагч Норжмааг 200000 төгрөгийн эд зүйл дутагдуулсан буруутай гэдэг нь тогтоогдсон гэж үзээд дутагдуулсан барааны үнийг гаргуулах тухай шийдвэр гаргажээ. Гэтэл 2 сарын дараа дээрхи дутагдсан барааг Лантуу гэгч хулгайлсан болох нь тогтоогджээ.

Энэ тохиолдолд:

- Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг дахин хянах, үндэслэл байгаа эсэхийг тодорхойлно уу?



Даалгавар:

- Оюутан бүр шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хэлэлцэх үндэслэл дээр жишээ зохиох



Эх сурвалж:

- ИХШХШТХ-ийн 179-182-р зүйл